



МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

МОНГОЛ УЛСЫН АРВАН НЭГДҮГЭЭР БУЮУ 2016 ОНЫ НЭГТГЭЛИЙН ТАЙЛАН

2017 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

АГУУЛГА

Нэр томъёоны тайлбар	8
1 Танилцуулга	11
1.1 Танилцуулга	11
1.1.1 Оршил	11
1.1.2 Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг	11
1.2 МОҮИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайлангийн мэдээллийн баталгаажуулалт	12
1.3 МОҮИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайланд оролцсон талууд	12
1.4 Талархал	12
2 Гүйцэтгэлийн хураангуй	13
2.1 Арга хандлага болон нэгтгэлийн үр дүнгийн талаарх тойм мэдээлэл	13
2.2 Нэгтгэгдсэн ЗГ-ын орлогын хураангуй мэдээлэл	14
2.2.1 ЗГ-ын хүлээн авсан нийт орлого	14
2.2.2 Нэгтгэлийн дараах ЗГ-ын орлогын урсгалууд	17
2.3 Олж илрүүлсэн гол зүйлс	18
2.3.1 Нэгтгэлийн хамрах хүрээ	18
2.3.2 Баталгаажуулалт	18
3 Нэгтгэлийн цар хүрээ ба аргачлал	20
3.1 Танилцуулга	20
3.2 Нэгтгэлийн аргачлал	22
3.2.1 Мэдээлэл цуглуулалт	22
3.2.2 Мэдээллийн харьцуулалт	24
3.2.3 Мэдээллийн нэгтгэл	24
3.2.4 Мэдээллийн задаргааны түвшин (ША 4.7)	26
3.2.5 Нууцлалтай мэдээллийг хамгаалах	26
3.3 Нэгтгэлийн арга хандлага	27
3.3.1 Компаниудын материаллаг байдлын босго	27
3.3.2 Үндсэн орлогын урсгалыг сонгосон материаллаг байдлын босго	28
3.3.3 Жижиг зөрүүнд тооцох босго	28
3.3.4 Баталгаажуулах горимууд (ША 4.9)	29
3.4 Тайлагнагч байгууллагууд болон хамрагдсан орлогууд	37
3.4.1 Төрийн байгууллагууд	37
3.4.2 Компаниуд	38
4 Нэгтгэлийн үр дүн	39
4.1 Нэгтгэлийн үр дүн	39
4.1.1 Нэгтгэл болон зөрүүний хураангуй	39
4.1.2 Нэгтгэлийн хамрах хүрээ (ША 4.9)	40
4.1.3 Өгсөн мэдээллийн иж бүрэн болон найдвартай байдал (ША 4.9б)	44
4.2 Шийдвэрлэгдээгүй зөрүү ба тайлагнаагүй компаниуд (ША 4.9)	45
4.2.1 Шийдвэрлэгдээгүй зөрүү – сонгогдсон гол орлогын урсгалаар:	45
4.2.2 Тайлагнаагүй байгууллагууд	46
4.2.3 Асуудал, бэрхшээлүүд болон шийдвэрлэх аргууд	47
4.2.4 Гүйцэтгэсэн ажилд тавигдах хязгаарлалтууд	48
4.3 Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, хөндлөнгийн аудит	49
4.3.1 Нийт компаниудын аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн олон нийтэд нээлттэй эх сурвалж, хэрэв тохиромжтой бол (ША 4.9а)	49

5	Монгол Улс дахь олборлох үйлдвэрлэлийн салбар	50
5.1	Олборлох үйлдвэрлэлийн тойм мэдээлэл	50
5.1.1	Олборлох үйлдвэрлэлийн Монгол Улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр (ША 6.3)	50
5.1.2	Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (ША 2.1)	56
5.1.3	Ашигт малтмалын тойм мэдээлэл	69
5.1.4	Газрын тосны тойм мэдээлэл	80
5.1.5	Ураны тойм мэдээлэл (ША 3.1)	84
5.2	ОУ-ийн тусгай зөвшөөрөл	86
5.2.1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	88
5.2.2	Газрын тосны тусгай зөвшөөрөл	99
5.3	Орлогын хуваарилалт	105
5.3.1	Төрийн санхүүгийн тогтолцоо (ША 5.1)	105
5.3.2	Улсын нэгдсэн төсөвтэй холбоотой хууль тогтоомж (ША 5.1)	105
5.3.3	ОУ-ийн орлогыг улсын төсөвт хуваарилах нь (ША 5.1)	106
5.3.4	Орон нутгийн шилжүүлэг (ША 5.2) болон тусгай сангуудын орлого (ША 5.3а)	107
5.3.5	Улсын төсөв, аудитын үйл ажиллагаа болон улсын төсвийн тухай ЗГ-ын таамаглал (ША 5.3б,в)	114
5.4	ОУ дэх төрийн оролцоо	116
5.4.1	ОУ-тэй холбоотой ЗГ-ын байгууллагууд	116
5.4.2	ТӨААН-үүдийн хураангуй танилцуулга (ША 2.6б)	120
5.4.3	ЗГ ба ТӨААН-үүдийн санхүүгийн харилцаа (ША 2.6а)	124
5.4.4	ЗГ-ын эзэмшлийн түвшин, зээл болон зээлийн баталгаа (ША 2.6б)	127
5.4.5	ТӨААН-тэй холбоотой гүйлгээ (ША 4.5)	129
5.4.6	Төсвийн шинжтэй зарцуулалт (ША 6.2)	130
5.4.7	Орон нутагт хийгдэж буй төлбөр (ША 4.6)	133
5.5	Бусад асуудлууд	134
5.5.1	Бенефициар өмчлөгч (ША 2.5)	134
5.5.2	Гэрээний ил тод байдал (ША 2.4)	136
5.5.3	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцоо (ША 4.3)	140
5.5.4	Нийгмийн хөрөнгө оруулалт (ША 6.1)	142
5.5.5	Тээвэрлэлтийн орлого (ША 4.4)	146
5.5.6	Уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт болон нөхөн сэргээлт	147
6	Зөвлөмжүүд	153
6.1	Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжилт (ША 7.3)	153
6.2	Хараат бус хянан-нэгтгэгчийн цаашдын МОУИТБС-ын тайланд өгөх зөвлөмжүүд	154
6.2.1	Төрийн байгууллагуудаас тайлагнасан мэдээллийн баталгаажуулалт	154
6.2.2	ОУИТБС-ын тайлангийн ач холбогдлыг төрийн байгууллагуудад онцлох	154
6.2.3	ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартуудын талаарх ТӨААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх	154
	Лавлагаа материалуудыг сургалтын материалуудтай харилцан уялдаатай боловсруулах хэрэгтэй бөгөөд энэ нь дээрхи “ОУИТБС-ын тайлангийн ач холбогдлыг төрийн байгууллагуудад онцлох” талаарх зөвлөмжийн нэгэн адил ТӨААН-үүдийн боловсон хүчин өөрчлөгдсөн ч мэдлэгийн тасралтгүй залгамж шинж чанарыг бий болгох ач холбогдолтой.	155
6.2.4	Цахим тайлагналын системээр дамжуулан цуглуулах орлогын урсгал	155
6.2.5	ОУ-ийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагааны бусад төрлөөс ялгах тухай	155
6.2.6	Кадастрын мэдээлэл	156
	ОУИТБС-ын стандартаар шаардсан наад захын шаардлагуудад нийцсэн мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлэх үүднээс тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг АМГТГ-ын зүгээс сайжруулах арга хэмжээг авах нь зүйтэй. ОУИТБС-ын стандартаар шаардсан БХГ-ний талаархи мэдээллийг олон нийт цахим орчинд харах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Мөн ОУИТБС-ын стандартын холбогдох шаардлагыг дагаж мөрдөхөд үр дүнтэй шийдэл, зохистой арга хандлагыг тодорхойлох үүднээс ОТАХ нь АМГТГ-ын төлөөлөлтэй тулгарч буй асуудлын талаар цаашид хэлэлцэх нь зүйтэй.	156
6.2.7	Бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдал	156

6.2.8	Төслийн түвшин дэх тайлагнал	157
6.2.9	Тусгай зөвшөөрөл олгох, баримтжуулахтай холбогдох журмыг дагаж мөрдөх	157
6.3	ОТАХ-ээс өгөх зөвлөмжүүд	158
6.3.1	Мэдээлэл ирүүлээгүй компаниуд болон ТӨААН-үүд	158
6.3.2	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилт	158
6.3.3	Гэрээний ил тод байдал	158
7	Хавсралтууд	159

Хэрэглээ болон уламжлалт хязгаарлалтууд

Энэхүү тайлан нь 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулагдсан гэрээт ажлын захидалд тусгагдсан зорилгын дагуу МОҮИТБС-ын хэрэгцээнд зориулагдсан бөгөөд гэрээт ажлын захидалд тусгагдсанаас бусад аливаа хэрэглээнд зориулагдаагүй болно. Энэхүү тайлан нь илүү өргөн цар хүрээнд түгээгдэж болох боловч түүнийг ашиглаж буй аливаа бусад этгээдийн тайланг ашиглахтай холбоотой хариуцлага нь зөвхөн тухайн этгээдэд хамаарна.

Энэхүү тайлан нь гэрээт ажлын захидалд тусгагдсан нөхцлүүдийн дагуу бэлтгэгдсэн болно. Гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээ нь тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажилд хамаарах бөгөөд Аудит болон Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан баталгаажуулалт болон бусад стандартуудад хамааралгүй ба баталгаажуулалт илэрхийлэх зорилгын хүрээнд дүгнэлт тайлбарыг хийгээгүй болно.

Бид талбарын ажлыг 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ тайланд 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс хойш тохиолдох үйл явдал, нөхцөл байдлуудыг хамрахгүй болно. Хуулийн болон үйл ажиллагааны орчны өөрчлөгдөж болзошгүй байдалтай уялдан бидний олж илрүүлсэн үр дүнгийн үнэн зөв байдал нь тайланг өдрөөс хойшхи үйл явдалтай хамааралтайгаар өөрчлөгдөж болзошгүй бөгөөд энэхүү өөрчлөлт нь тайлангийн үнэн зөв байдалд нөлөөлөхгүй болохыг анхаарна уу.

Энэхүү тайланг бэлтгэхэд бидний ашигласан мэдээллийн эх сурвалж нь нийтэд ил, маягтын тусламжтайгаар олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниуд болон төрийн байгууллагуудаас авсан тоо баримт, ОТАХ болон МОҮИТБС-ын Ажлын Албыг оролцуулаад МОҮИТБС, Засгийн Газрын яам, агентлаг, холбогдох газар, хэлтсүүд, компани, иргэний нийгмийн байгууллага болон өөр бусад сонирхлын бүлгүүдтэй уулзсан уулзалт зэрэг юм. Ашигласан материал, эх сурвалжийн жагсаалтыг хавсралт 33-т тусгав. Хүлээж авсан дээрх мэдээллүүдтэй холбоотой ямар нэгэн хариуцлагыг манай байгууллага хүлээхгүй бөгөөд уг хариуцлага нь мэдээллээр хангасан компани, төрийн байгууллага, Засгийн Газрын яамдуудын удирдлагад үлдэнэ. Бид мэдээллийн эх сурвалжийн найдвартай, бодитой байдлыг хангахын тулд өөр ямар нэгэн нотлох баримтыг иш татаж тайлбар болгон оруулаагүй ба бидэнд ирсэн мэдээллийн үнэн зөв байдлыг шалгаагүй болно. Энэхүү ажлын цар хүрээ нь аудитын ажлаас ялгаатай тул хийж гүйцэтгэсэн горимд үндэслэн ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэгдэхгүй.

Тайлан нь Англи болон Монгол хэлээр бэлтгэгдсэн бөгөөд Англи болон Монгол хэл дээрх хувилбаруудад агуулгын ямар нэгэн ялгаа гарвал Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛГА

Нэр томъёоны тайлбар	8
1 Танилцуулга	11
1.1 Танилцуулга	11
1.1.1 Оршил	11
1.1.2 Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг	11
1.2 МОҮИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайлангийн мэдээллийн баталгаажуулалт	12
1.3 МОҮИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайланд оролцсон талууд	12
1.4 Талархал	12
2 Гүйцэтгэлийн хураангуй	13
2.1 Арга хандлага болон нэгтгэлийн үр дүнгийн талаарх тойм мэдээлэл	13
2.2 Нэгтгэгдсэн ЗГ-ын орлогын хураангуй мэдээлэл	14
2.2.1 ЗГ-ын хүлээн авсан нийт орлого	14
2.2.2 Нэгтгэлийн дараах ЗГ-ын орлогын урсгалууд	17
2.3 Олж илрүүлсэн гол зүйлс	18
2.3.1 Нэгтгэлийн хамрах хүрээ	18
2.3.2 Баталгаажуулалт	18
3 Нэгтгэлийн цар хүрээ ба аргачлал	20
3.1 Танилцуулга	20
3.2 Нэгтгэлийн аргачлал	22
3.2.1 Мэдээлэл цуглуулалт	22
3.2.2 Мэдээллийн харьцуулалт	24
3.2.3 Мэдээллийн нэгтгэл	24
3.2.4 Мэдээллийн задаргааны түвшин (ША 4.7)	26
3.2.5 Нууцлалтай мэдээллийг хамгаалах	26
3.3 Нэгтгэлийн арга хандлага	27
3.3.1 Компаниудын материаллаг байдлын босго	27
3.3.2 Үндсэн орлогын урсгалыг сонгосон материаллаг байдлын босго	28
3.3.3 Жижиг зөрүүнд тооцох босго	28
3.3.4 Баталгаажуулах горимууд (ША 4.9)	29
3.4 Тайлагнагч байгууллагууд болон хамрагдсан орлогууд	37
3.4.1 Төрийн байгууллагууд	37
3.4.2 Компаниуд	38
4 Нэгтгэлийн үр дүн	39
4.1 Нэгтгэлийн үр дүн	39
4.1.1 Нэгтгэл болон зөрүүний хураангуй	39
4.1.2 Нэгтгэлийн хамрах хүрээ (ША 4.9)	40
4.1.3 Өгсөн мэдээллийн иж бүрэн болон найдвартай байдал (ША 4.9б)	44
4.2 Шийдвэрлэгдээгүй зөрүү ба тайлагнаагүй компаниуд (ША 4.9)	45
4.2.1 Шийдвэрлэгдээгүй зөрүү – сонгогдсон гол орлогын урсгалаар:	45
4.2.2 Тайлагнаагүй байгууллагууд	46
4.2.3 Асуудал, бэрхшээлүүд болон шийдвэрлэх аргууд	47
4.2.4 Гүйцэтгэсэн ажилд тавигдах хязгаарлалтууд	48
4.3 Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, хөндлөнгийн аудит	49
4.3.1 Нийт компаниудын аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн олон нийтэд нээлттэй эх сурвалж, хэрэв тохиромжтой бол (ША 4.9а)	49

5	Монгол Улс дахь олборлох үйлдвэрлэлийн салбар	50
5.1	Олборлох үйлдвэрлэлийн тойм мэдээлэл	50
5.1.1	Олборлох үйлдвэрлэлийн Монгол Улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр (ША 6.3)	50
5.1.2	Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (ША 2.1)	56
5.1.3	Ашигт малтмалын тойм мэдээлэл	69
5.1.4	Газрын тосны тойм мэдээлэл	80
5.1.5	Ураны тойм мэдээлэл (ША 3.1)	84
5.2	ОУ-ийн тусгай зөвшөөрөл	86
5.2.1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	88
5.2.2	Газрын тосны тусгай зөвшөөрөл	99
5.3	Орлогын хуваарилалт	105
5.3.1	Төрийн санхүүгийн тогтолцоо (ША 5.1)	105
5.3.2	Улсын нэгдсэн төсөвтэй холбоотой хууль тогтоомж (ША 5.1)	105
5.3.3	ОУ-ийн орлогыг улсын төсөвт хуваарилах нь (ША 5.1)	106
5.3.4	Орон нутгийн шилжүүлэг (ША 5.2) болон тусгай сангуудын орлого (ША 5.3а)	107
5.3.5	Улсын төсөв, аудитын үйл ажиллагаа болон улсын төсвийн тухай ЗГ-ын таамаглал (ША 5.3б,в)	114
5.4	ОУ дэх төрийн оролцоо	116
5.4.1	ОУ-тэй холбоотой ЗГ-ын байгууллагууд	116
5.4.2	ТӨААН-үүдийн хураангуй танилцуулга (ША 2.6б)	120
5.4.3	ЗГ ба ТӨААН-үүдийн санхүүгийн харилцаа (ША 2.6а)	124
5.4.4	ЗГ-ын эзэмшлийн түвшин, зээл болон зээлийн баталгаа (ША 2.6б)	127
5.4.5	ТӨААН-тэй холбоотой гүйлгээ (ША 4.5)	129
5.4.6	Төсвийн шинжтэй зарцуулалт (ША 6.2)	130
5.4.7	Орон нутагт хийгдэж буй төлбөр (ША 4.6)	133
5.5	Бусад асуудлууд	134
5.5.1	Бенефициар өмчлөгч (ША 2.5)	134
5.5.2	Гэрээний ил тод байдал (ША 2.4)	136
5.5.3	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцоо (ША 4.3)	140
5.5.4	Нийгмийн хөрөнгө оруулалт (ША 6.1)	142
5.5.5	Тээвэрлэлтийн орлого (ША 4.4)	146
5.5.6	Уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт болон нөхөн сэргээлт	147
6	Зөвлөмжүүд	153
6.1	Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжилт (ША 7.3)	153
6.2	Хараат бус хянан-нэгтгэгчийн цаашдын МОҮИТБС-ын тайланд өгөх зөвлөмжүүд	154
6.2.1	Төрийн байгууллагуудаас тайлагнасан мэдээллийн баталгаажуулалт	154
6.2.2	ОҮИТБС-ын тайлангийн ач холбогдлыг төрийн байгууллагуудад онцлох	154
6.2.3	ТӨААН-үүдтэй холбоотой ОҮИТБС-ын стандартуудын талаарх ТӨААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх	154
6.2.4	Цахим тайлагналын системээр дамжуулан цуглуулах орлогын урсгал	155
6.2.5	ОУ-ийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагааны бусад төрлөөс ялгах тухай	155
6.2.6	Кадастрын мэдээлэл	156
6.2.7	Бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдал	156
6.2.8	Төслийн түвшин дэх тайлагнал	157
6.2.9	Тусгай зөвшөөрөл олгох, баримтжуулахтай холбогдох журмыг дагаж мөрдөх	157
6.3	ОТАХ-ээс өгөх зөвлөмжүүд	158
6.3.1	Мэдээлэл ирүүлээгүй компаниуд болон ТӨААН-үүд	158
6.3.2	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилт	158
6.3.3	Гэрээний ил тод байдал	158
7	Хавсралтууд	159

Нэр томъёоны тайлбар

\$	Америк Доллар
₮	Монгол Төгрөг
ААН	Аж ахуйн нэгж
А ангилал	Баталгаажуулсан ашигт малтмалын нөөц (АМГТГ-т хэрэглэгддэг)
Б ангилал	Тооцоолсон ашигт малтмалын нөөц (АМГТГ-т хэрэглэгддэг)
В ангилал	Боломжит ашигт малтмалын нөөц, нэмэлт судалгаагаар баталгаажуулах (АМГТГ-т хэрэглэгддэг)
II ангилал	Таамагт ашигт малтмалын нөөц (АМГТГ-т хэрэглэгддэг)
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АД	Ажлын даалгавар
АМГ	Ашигт Малтмалын Газар (хуучнаар)
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БГАОУС	Баталгаажуулах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
БОНХАЖЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам (хуучнаар)
БУ	Бичил уурхай
БУНДХ	Бичил Уурхайн Нэгдсэн Дээвэр Холбоо
БУУ	Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уул уурхай
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
БХХ	Байгаль хамгаалах хөтөлбөр
Га	Га
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ГТГ	Газрын Тосны Газар (хуучнаар)
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДААН	Жижиг Дунд Аж Ахуйн Нэгжүүд
ЖНХ	Жилийн нийлмэл хүү
ЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МИ	Мэдээллээ ирүүлээгүй
МОУИТБС	Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар

НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОТ	Оюу Толгой
ОТАХ	Олон талт ажлын хэсэг
ОУХААХС	Олон Улсын Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Сан
ОУ	Олборлох үйлдвэрлэл
Сая	Сая
СТОУС	Санхүүгийн Тайлангалын Олон Улсын Стандарт
СЯ	Сангийн Яам
ТАН	Төлсөн Авсанаа Нийтэл
ТБУ	Тогтвортой бичил уурхай
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ТӨААН	Төрийн өмчийн аж ахуйн нэгж
ТӨХ	Төрийн Өмчийн Хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УМХГ	Улсын Мэргэжлийн Хяналтын Газар
УУЯ	Уул Уурхайн Яам
УУХУЯ	Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яам
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХБ	Хөгжлийн Банк
ХГ	Хамааралгүй
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОУ	Хамтын хөрөнгө оруулалттай үйлдвэр
ХҮОУС	Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт
ХШҮСМХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн мэдээллийн хэлтэс
ЦЭК	Цөмийн Энергийн Комисс
ША	ОҮИТБС-ын Стандартын Шаардлага
ШХХАА	Швейцарын Хөгжил, Хамтын Ажиллагааны Агентлаг



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод
Байдлын Санаачилга (МОҮИТБС)-ын Ажлын Хэсэг**
МОҮИТБС-ын Ажлын Алба
Туушин ХХК-ийн байр, 314 тоот
Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж
Монгол Улс, Улаанбаатар хот

2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (цаашид “МОҮИТБС” гэх) болон Кэй Пи Эм Жи Аудит ХХК, Кэй Пи Эм Жи Францын хамтарсан Консорциум (цаашид хамтад нь “Кэй Пи Эм Жи” гэх)-ын хооронд 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулагдсан гэрээний дагуу Кэй Пи Эм Жи нь МОҮИТБС-ын 2016 оны нэгтгэлийн болон үндсэн мэдээллийн тайланг бэлтгэх Хараат бус хянагч-нэгтгэгчээр томилогдсон юм. Энэхүү ажлын хүрээнд Кэй Пи Эм Жи нь материаллаг төлбөр хийгээд орлогын нэгтгэлийг хийж, МОҮИТБС-ын арван нэг дэх удаагийн тайланг бэлтгэх үүрэг хүлээсэн болно.

Гэрээт ажил нь 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулагдсан гэрээ болон ажлын даалгаврын дагуу 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд үргэлжилсэн ба олж илрүүлсэн зүйлсийг дагалдах тайлан болон хавсралтуудад хураангуйлан оруулав.

Энэхүү гэрээт ажлыг бид тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажилтай хамааралтай Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400-гийн дагуу хийж гүйцэтгэв. Гүйцэтгэсэн горимууд нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аудитын стандартууд, эсвэл нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлах гэрээт ажлын стандартуудын дагуу хийгдэх аудит, нягтлах гэрээт ажилд хамаарахгүй болохыг энэ дашрамд дурьдах нь зүйтэй гэж үзлээ.

Хэрэв бид нэмэлт горимууд гүйцэтгэж, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аудитын стандартууд эсвэл нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлах гэрээт ажлын стандартуудын дагуу аудит эсвэл нягтлах гэрээт ажил хийсэн бол та бүхэнд тайлагнах бусад асуудлуудад бид анхаарах боломжтой байсан гэдгийг үүгээр мэдэгдэж байна. Иймд энэхүү тайлангийн үндсэн мэдээлэл болон бусад хэсэгт тусгагдсан ажил гүйлгээний үнэн зөв байдлын талаар бид ямар нэгэн баталгаа өгөхгүй болно.

Бидний бэлтгэсэн тайлан нь зөвхөн энэхүү захианы эхний хоёр хэсэгт заасан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд өөр бусад зорилгоор ашиглагдах зориулалтгүй, нөгөө талаар санхүүгийн тайлан, түүний үзүүлэлтүүдтэй ямар нэгэн байдлаар хамааралгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Марк Эбэрст
Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот

1 Танилцуулга

1.1 Танилцуулга

1.1.1 Оршил

Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС) нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай олон улсын стандартыг гаргасан бөгөөд ОУИТБС-ын ерөнхий зарчмыг баталсан анхны хурлаасаа хойш 13 жилийн дараа буюу 2016 онд энэхүү стандартыг дахин шинэчилсэн юм.

ОУИТБС-ын Стандарт болон түүний зарчмын хүрээнд уг байгууллага нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дэмжиж, олон нийтэд энэ салбарын үйл ажиллагааг ил тодоор хүртээх буюу уг үйлдвэрлэлээс Засгийн Газарт орж ирсэн орлогыг хэрхэн зөв зохистой зарцуулж буйг харуулах зорилготой юм. ОУИТБС нь ил тод байдлыг бий болгох, олборлох салбарын хүрээнд болж буй үйл явдлуудын талаар олон нийтэд мэдээлэл түгээх, тайлангийн төсөлд нийт оролцогчдын хувь нэмрийг оруулан зохион байгуулах зэрэгт оршдог билээ.

ОУИТБС-ын Стандарт нь Хараат бус хянагч-нэгтгэгчийг олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төлсөн төлбөрийг Засгийн Газрын хүлээн авсан холбогдох орлоготой харьцуулан нэгтгэхийг шаарддаг бөгөөд энэхүү стандартын дагуу тайлангаа бэлтгэхийн тулд Хараат бус хянагч-нэгтгэгч нь тухайн орны олборлох үйлдвэрлэлийн талаарх үндсэн мэдээллийг мөн багтаах ёстой байдаг.

Монгол Улс нь анх 2006 онд ОУИТБС-ын Стандартыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ удаагийн тайлангаас өмнө нийт арван тайлан бэлтгэгдсэн юм. Кэй Пи Эм Жи нь МОУИТБС-ын арван нэг дэх удаагийн тайлан болон орлогын нэгтгэлд Хараат бус хянагч-нэгтгэгчээр томилогдсон.

Шинэчилсэн стандарт нь 2016 оны 02 дугаар сард Лима хотод болсон хурлын үеэр батлагдсан (<https://eiti.org/document/standard>) бөгөөд уг шинэчлэлийн хүрээнд ОУИТБС-ын нэг хэсэг болох үндсэн мэдээллийн талаарх шаардлага нэлээд нэмэгдсэн бөгөөд энэ жилийн хувьд шинэчилсэн стандартыг хэрэгжүүлж, тогтоосон нөхцлүүдийг аль болох дагаж мөрдөхийг зорьсон болно. Үндсэн мэдээлэл нь энэхүү тайлангийн 5 дугаар хэсэгт тусгагдсан болно.

1.1.2 Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг

Хараат бус хянагч-нэгтгэгчийн ерөнхий үүрэг нь:

- ОТАХ-тэй тохиролцсон горимуудыг хэрэгжүүлэх;
- Тайлангийн маягтуудыг бэлтгэж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд болон төрийн байгууллагуудад хүргүүлэх;
- Боломжит хэмжээгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон төрийн байгууллагуудаас тайлангийн мэдээллийг олж авах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон төрийн байгууллагуудын тайлангийн мэдээллийг нэмж цуглуулах;
- Нэгтгэлийг эмхэтгэж, боломжит хэмжээгээр үүссэн зөрүүг шийдвэрлэх;
- Төлбөр болон Монгол Улсын ОУ-ийн үйл ажиллагаанаас олсон орлогын талаарх ойлголттой холбоотой нэгтгэгдсэн төлбөр болон орлого, аливаа зөрүү болон бусад асуудлаас бүрдсэн тайлан бэлтгэх, нийтлэх;
- Төрийн байгууллагууд, компаниуд болон бусад олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хүссэн болон тэдний тайлагнасан мэдээлэлтэй хамт олон нийтэд нээлттэй мэдээллийн эх үүсвэр ашигласан үндсэн мэдээллээс бүрдсэн тайлан бэлтгэн, нийтлэх;

Бидний мэдээлэл цуглуулах болон нэгтгэх үйл ажиллагаа нь 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Эхлэлтийн семинар болон 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр болсон ОТАХ-ийн хурлын үр дүнд бэлтгэгдсэн Эхлэлтийн тайланг ОТАХ хүлээн зөвшөөрсний дараа эхэлсэн. Эхлэлтийн семинараар бид ОТАХ-тэй нягт хамтран ажиллаж, өөрсдийн ажлын төлөвлөгөөгөө боловсруулсан бөгөөд Монгол Улсын ОУ-ийн хэтийн төлөв болон ОТАХ-ийн саналыг харгалзан ОТАХ-тэй гүйцэтгэх горимын нарийн цар хүрээг харилцан зөвшилцсөн. ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас Монгол Улсад зохион байгуулахаар төлөвлөсөн баталгаажуулалтын ажилд энэ жил илүү анхаарал хандууллаа. Эхлэлтийн семинарын үр дүнг горим гүйцэтгэж эхлэхээс өмнө ОТАХ-ийн зөвшөөрлийг авахаар хүргүүлсэн. Энэхүү үйл явцын туршид ОТАХ нь төвийг сахиж, өөрийн саналаа оруулах байдлаар ажилласан тул тайлан бичих горим болон ажлын цар хүрээний хувьд аливаа нөлөөллөөс ангид байсан. Кэй Пи Эм Жи нь хараат бус байх үндсэн үүргээ баталгаажуулж, чандлан сахиж ажилласан болно.

1.2 **МОУИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайлангийн мэдээллийн баталгаажуулалт**

Анхны үнэлгээ: Хараат бус хянагч-нэгтгэгч нь компаниуд, ТӨААН-үүд болон төрийн байгууллагуудын тайлагнасан мэдээллийн “Баталгаажуулалтын Анхны Үнэлгээ”-г тодорхойлох зорилгоор тэдгээрийн “Одоогийн хяналтууд ба аудитын цар хүрээ”-нд хэр хэмжээнд итгэл үзүүлэх боломжтойг өөрсдийн мэргэжлийн үнэлэмжид тулгуурлан үнэлсэн. Тайлан гаргагч байгууллагуудын хувьд “Баталгаажуулалтын Анхны Үнэлгээ” болон “Одоогийн хяналтууд ба аудитын цар хүрээ” багаас дунд түвшинд байна гэж Хараат бус хянагч-нэгтгэгч үнэллээ.

Эцсийн үнэлгээ: ОТАХ-ийн тохиролцсон мэдээллийн баталгаажуулалтын журмын дагуу Хараат бус хянагч-нэгтгэгч “Баталгаажуулалтын Эцсийн Үнэлгээ”-г тулган баталгаажуулалтын дараах санхүүгийн мэдээлэл дээр тулгуурлан хийсэн. Нэгтгэлд хамрагдсан компаниуд, ТӨААН-үүдийн тулган баталгаажуулсан нийт орлогын 41.9% нь сайн дүнтэй гарсан бол 57.16% нь дунд дүнтэй үнэлэгдэж, 0.94% нь муу үнэлгээтэй гарсан. Төрийн байгууллагуудын хувьд “Баталгаажуулалтын Эцсийн Үнэлгээ” багаас дунд түвшинд хэвээр үнэлэгдсэн хэдий ч, компаниуд, ТӨААН-үүдийн төлсөн дүнг төрийн байгууллагуудын хүлээн авсан орлогын дүнтэй тулган баталгаажуулах явцад компаниуд, ТӨААН-үүдийн мэдээллийн баталгаажуулалт нэмэгдэхийн хэрээр төрийн байгууллагуудын мэдээллийн баталгаажуулалт нэмэгдэх зарчим үйлчилсэн болно. Тиймээс Хараат бус хянагч-нэгтгэгч компаниуд, ТӨААН-үүд болон төрийн байгууллагуудын тулган баталгаажуулалтын дараах санхүүгийн мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлын эцсийн үнэлгээг шаардлага хангасан гэж үзсэн. Баталгаажуулалттай холбоотой дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн 3.3.4.1 болон 3.3.4.2 хэсгээс харна уу.

1.3 **МОУИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайланд оролцсон талууд**

Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас материаллаг орлого хүлээн авсан төрийн байгууллагууд болон тус төлбөрийг төлсөн олборлох үйлдвэрлэлийн нэгтгэлд сонгогдсон компаниудад нэгтгэлд оролцох болон үндсэн мэдээллийг танилцуулах хүсэлт тавьсан.

Нэгтгэлийн тайланд оролцсон төрийн байгууллагууд болон компаниудыг энэхүү тайлангийн 3.4.1, 3.4.2 хэсгүүд болон хавсралтуудад тус тус жагсаав.

1.4 **Талархал**

МОУИТБС-ын Ш. Цолмон тэргүүтэй Ажлын Албаны хамт олонд төрийн байгууллагууд болон олборлох үйлдвэрлэлийн компаниудтай уулзалт зохион байгуулах, захидал илгээх, хүлээн авах, болон бусад үйл ажиллагаанд дэмжлэг, тусалцаа үзүүлсэнд Кэй Пи Эм Жи Аудит ХХК гүнээ талархал илэрхийлье.

2 Гүйцэтгэлийн хураангуй

2.1 Арга хандлага болон нэгтгэлийн үр дүнгийн талаарх тойм мэдээлэл

Кэй Пи Эм Жи нэгтгэлийн ажлыг эхлэхдээ анх ЗГ-ын тайлагнасан орлогыг авч үзсэн. Энэхүү ЗГ-ын тайлангаас харахад 2016 онд нийт 2,079 компаниудаас хүлээн авсан орлого бүртгэгдсэн байна. Эрсдэлд суурилсан аргачлал болон ЗГ-ын тайлагнасан гол орлогын дүнгүүдийг харгалзан үзсэнээр эдгээр компаниудаас нэгтгэлд хамруулахаар нийт 213 компанийг сонгосон. ЗГ-ын анх тайлагнасан мэдээллээс үзэхэд эдгээр 213 компанийн төвлөрүүлсэн орлого 2016 онд гол орлогын урсгалын нийт 95.6%-ийг бүрдүүлсэн байна.

Нэгтгэлээрх сонгогдсон гол орлогын урсгалын ЗГ болон компаниудын тайлагнасан дүнгийн хоорондох анхны зөрүү нь 105 тэрбум төгрөг байсан. Нэгтгэлийн дараах байдлаар энэхүү тайлангийн өдрөөрх цэвэр зөрүү 74 сая төгрөг болж буурсан.

Сая төгрөгөөр

	Анхны тайлангаар	Залруулга	Залруулсан дүн
ЗГ-ын тайлагнасан	1,167,123	(80,975)	1,086,148
Компаниудын тайлагнасан	1,061,847	9,484	1,071,331
<i>ЗГ-аас илүү тайлагнасан компаниуд</i>	(42,561)	47,981	5,420
<i>ЗГ-аас дутуу тайлагнасан компаниуд</i>	147,837	(138,440)	9,397
Цэвэр зөрүү	105,276	(90,459)	14,817
Хасах нь: Нэгтгэлийн мэдээллийн маягтыг ирүүлээгүй компаниуд *	(2,250)	55	(2,195)
Хасах нь: Нэгтгэлийн мэдээллийн маягтыг ирүүлээгүй ЗГ-ын нэгжүүд **	(59,707)	47,159	(12,548)
Тайлагнаагүй компаниудын дараах цэвэр зөрүү	43,319	(43,245)	74

* Үүнд, нэгтгэлийн залруулгын маягтыг явуулаагүй боловч анх цахим тайлагналын системд тайлагнасан компаниуд, мөн нэгтгэлийн залруулгын маягтыг явуулаагүй бөгөөд анх цахим тайлагналын системд тайлагнаагүй компаниуд аль аль нь багтсан болно. Аль аль тохиолдолд нь мэдээлэл ирүүлээгүйгээс болж мэдээллийг нэгтгэх боломжгүй байсан учраас эцсийн цэвэр нэгтгээгүй зөрүүг тодорхойлоход нэгтгэлийн залруулгын маягтыг ирүүлээгүй компаниудыг оруулаагүй болно.

** Үүнд, нэгтгэлийн залруулгын маягтыг явуулаагүй боловч анх цахим тайлагналын системд тайлагнасан Гаалийн Ерөнхий Газар багтсан болно. Нэгтгэлийн залруулгын маягтаар нэгтгэлийн мэдээллийг ирүүлээгүй учраас мэдээллийг нэгтгэх боломжгүй байсан. Тиймээс анхны тайлагналын дүн их байна.

2.2 Нэгтгэгдсэн ЗГ-ын орлогын хураангуй мэдээлэл

2.2.1 ЗГ-ын хүлээн авсан нийт орлого

Нэгтгэлд хамрагдсан төрийн байгууллагуудын тайлагнасан нийт орлогыг доорх хүснэгтэд харуулав:

Сая төгрөгөөр

Төрийн байгууллага	Анхны тайлангаарх гол орлогын урсгал	Нэгтгэлийн дараах гол орлогын урсгал	Өөрчлөлтийн хувь
Татварын Ерөнхий Газар	577,534	533,374	-8%
Ашигт Малтмал, Газрын Тосны Газар	154,365	173,283	12%
Гаалийн Ерөнхий Газар	249,740	150,002	-40%
Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар	138,897	131,621	-5%
Бусад төрийн байгууллагууд	25	200	700%
Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газар	4,984	7,784	56%
Дэд дүн: Улсын хэмжээ	1,125,545	996,264	-11%
Аймгууд	41,077	88,710	116%
Улаанбаатарын дүүргүүд	501	1,174	134%
Дэд дүн: Орон нутгийн хэмжээ	41,578	89,884	116%
Нийт	1,167,123	1,086,148	-7%

Хараат бус хянагч-нэгтгэгчийг ажлаа эхлэхээс өмнө буюу 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө компани болон ЗГ-ын байгууллагууд анхны гол орлогын урсгалуудыг МОУИТБС-ын цахим системд тайлагнасан байсан. Нэгтгэлийн дараах гол урсгалууд нь 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаарх нэгтгэлийн дараах үр дүнг илэрхийлнэ.

Ашигт Малтмал, Газрын Тосны Газар, бусад төрийн байгууллагууд, Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газар, аймгууд болон Улаанбаатарын дүүргүүдийн орлогын өсөлт нь ЗГ-ын анхны тайлангаарх мэдээлэлд ороогүй байсан боловч нэгтгэлийн ажлын явцад илэрсэн дүнгүүдтэй холбоотой. Татварын Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий Газар, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын орлогын бууралт нь ЗГ-ын тайлагнасан мэдээлэл уул уурхайн үйл ажиллагаа явуулдаггүй компаниудыг оруулсантай холбоотой болно. Мөн, Гаалийн Ерөнхий Газар нэгтгэлийн мэдээллийг ирүүлээгүй тул цэвэр эцсийн дүнг харуулахын тулд уг байгууллагын анхны тайлагналын зөрүүтэй өндөр дүнг нэгтгэлээс хассан.

Нэгтгэгдсэн орлогын урсгалууд (сонгогдсон гол орлогууд)-ыг улсын хэмжээний төрийн байгууллагуудаар хуваан доорх графикт харуулав:



Нэгтгэгдсэн гол орлогын урсгалыг орон нутгийн хэмжээний төрийн байгууллагуудаар хуваан доорх графикт харуулав:



Нэгтгэгдсэн гол орлогын урсгалыг улсын хэмжээний болон орон нутгийн хэмжээний төрийн байгууллагуудаар хуваан доорх графикт харуулав:



2.2.2 Нэгтгэлийн дараах ЗГ-ын орлогын урсгалууд

Нэгтгэлд сонгогдсон ЗГ-ын гол орлогын урсгалууд нэгтгэлийн дараах байдлаар, ангилал тус бүрээр:

Сая төгрөг

#	Улсын/ Орон нутгийн	Орлогын урсгал	Нэгтгэлд хамрагдсан дүн
1	Улс	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	228,768
2	Улс	Гаалийн албан татвар	32,453
3	Улс	Нэмэгдсэн өртгийн албан татвар	118,029
4	Улс	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	2,111
5	Улс	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	235,926
6	Улс	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	14,793
7	Улс	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	7,784
8	Улс	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	1,149
9	Улс	Агаарын бохирдлын төлбөр	17,684
10	Улс	Аж ахуйн нэгжээс төлсөн ажилчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	131,621
11	Улс	Гаалийн үйлчилгээний хураамж	48,405
12	Улс	БХГ-ний дагуу тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	994
13	Улс	БХГ-нд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	2,050
14	Улс	БХГ-ний дагуу ЗГ-т ногдох газрын тосны орлого	133,698
15	Улс	Рояльти	20,599
16	Улс	БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	-
17	Улс	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	200
18	Орон нутаг	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	18,907
19	Орон нутаг	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,410
20	Орон нутаг	Газрын төлбөр	12,257
21	Орон нутаг	Ус ашигласны төлбөр	36,587
22	Орон нутаг	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	739
23	Орон нутаг	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	417
24	Орон нутаг	БХГ-ний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	1,084
25	Орон нутаг	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	100
26	Орон нутаг	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	18,383
Нийт			1,086,148
Төрийн байгууллагуудын тайлагнасан дүн			1,086,148
Компаниудын тайлагнасан дүн			1,071,331

2.3 Олж илрүүлсэн гол зүйлс

2.3.1 Нэгтгэлийн хамрах хүрээ

2.3.1.1 Материаллаг байдлын босго

Нэгтгэлийн үйл явцын үр ашиг болон үр дүнтэй байдлыг сайжруулах үүднээс Кэй Пи Эм Жи материаллаг байдлын босго болон эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглан нэгтгэлд хамрагдах компаниудыг сонгосон. Материаллаг байдлын босго нь улсын болон орон нутгийн түвшний ЗГ-ын хүлээн авсан орлогын аль алинд нь тавигдсан. Энэхүү аргачлал нь ОУИТБС-ын стандартад тулгуурласан ба урьдчилан хийсэн уулзалтуудын үеэр хүлээн авсан саналууд, ялангуяа орон нутгийн засаг захиргааны төлөөллүүдийн санал бодлууд, мөн ОТАХ-ийн зөвлөмж, шийдвэрүүдэд тусгасан гол зөвлөмжүүдэд үндэслэсэн болно.

Улсын хэмжээнд нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах компаниудын материаллаг байдлын босго нь 250 сая төгрөг байсан болно. Эрсдэлд суурилсан түүврийн аргаарх нэгтгэлд 50 сая төгрөгөөс их болон 250 сая төгрөгөөс бага орлогын урсгал бүхий компаниудыг багтаасан. Нэг бүрчлэн болон түүврийн аргаарх нэгтгэлийн аргачлалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 3.3 хэсэгт тусгасан.

Орон нутгийн хэмжээнд нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах компаниудын материаллаг байдлын босго нь 100 сая төгрөг байсан болно. Түүврийн аргаарх нэгтгэлд 30 сая төгрөгөөс их болон 100 сая төгрөгөөс бага орлогын урсгал бүхий компаниудыг багтаасан.

2.3.1.2 Компаниудын сонголт

МОУИТБС-ын Ажлын Албаны нэгтгэсэн ЗГ-ын тайланд 2,079 компани, компанийн тайланд 1,113 компани тус тус хамрагдсан. Дээрх 2 тайлангийн аль аль нь ижил орлогын болон төлбөрийн хамрах хүрээг агуулсан бөгөөд ОУИТБС-д заавал тайлагнах 44 гол орлогын урсгал, мөн сайн дураар тайлагнах 19 орлогын урсгалыг хамруулсан. Эдгээр 44 гол орлогын урсгалын 13-ыг нь орон нутгийн төрийн байгууллагууд тайлагнасан. Бусад бүх орлогын урсгалыг улсын хэмжээний төрийн байгууллагууд тайлагнасан.

ЗГ-ын тайлагнасан мэдээлэл нь компанийн тайлагнасан мэдээллээс илүү иж бүрэн байсан тул Кэй Пи Эм Жи компаниудыг сонгохдоо ЗГ-ын тайлагнасан мэдээлэл дээр үндэслэсэн болно.

2.3.2 Баталгаажуулалт

2.3.2.1 Удирдлагын төлөөлөл

ОУИТБС-ын стандартын гол шаардлага нь мэдээллийн найдвартай байдал юм. Кэй Пи Эм Жи нэгтгэлд орсон компани тус бүрээс МОУИТБС-ын Ажлын Албанд тайлагнасан мэдээлэл болон бусад холбогдох нэмэлт тайлангийн маягтуудыг бүрэн бүтэн ба үнэн зөв бөглөсөн гэдгийг баталгаажуулсан Төлөөлөн Удирдах Зөвлөл эсвэл тэргүүлэх албан тушаалтны аль тохиромжтойгоор нь гарын үсэг зуруулсан удирдлагын төлөөллийн захидлыг хүссэн. Нийт 213 компаниас 192 компани нь энэхүү төлөөллийн захидлыг ирүүлж, 21 компани ирүүлээгүй. Эдгээр ирүүлсэн болон ирүүлээгүй компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг 3.3.4 хэсэгт харуулсан болно.

2.3.2.2 Компаниудын аудит болон баталгаажуулалтын тайлан

ОУИТБС-ын стандарт нь тухайн улс орны аудит эсвэл баталгаажуулалтын тогтолцоог анхааран үзэж, компаниуд болон төрийн байгууллагуудаас авч буй мэдээллийн бүрэн бүтэн, үнэн зөв байдалд үндэслэлтэй баталгаажуулалтыг олж авахыг шаарддаг.

Баталгаажуулалтын горимын хураангуйг доор харуулав:

- 130 компани төлөөллийн захидал болон хараат бус аудиторын тайлангаа ирүүлсэн;
- 43 компани төлөөллийн захидал ирүүлсэн боловч хараат бус аудиторын тайлангаа ирүүлээгүй; мөн
- 16 компани хараат бус аудиторын тайлангаа ирүүлсэн боловч төлөөллийн захидлыг ирүүлээгүй;
- 24 компани төлөөллийн захидал болон хараат бус аудиторын тайлангийн аль алийг ирүүлээгүй;
- Түүнчлэн нэг компани ОҮИТБС-д тайлагнасан дүнгээ нотлох тохиролцсон горимуудыг гүйцэтгэсэн гэрээт ажлын тайланг ирүүлсэн.

Баталгаажуулах горимын дэлгэрэнгүйг 3.3.4 хэсгээс, компаниудаас хүлээн авсан хариултын дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс, компаниудаас ирүүлсэн аудитын тайлангуудын дэлгэрэнгүйг Хавсралт 12-оос харна уу.

2.3.2.3 ЗГ-ын мэдээллийн баталгаажуулалт

Төрийн байгууллагуудын мэдээллийн найдвартай байдалд ЗГ-аас гаргасан мэдээллүүдийн баталгаажуулалт чухал байдаг. СЯ гаргаж өгсөн мэдээллийн хамт гарын үсэг зурж өгсөн боловч тодорхой төлөөлөл эсвэл баталгаажуулалт гаргаж өгөөгүй.

Кэй Пи Эм Жи нэмэлт мэдээллийн маягтын бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг баталгаажуулах үүднээс төрийн байгууллагуудын удирдлагын гарын үсэгтэй төлөөллийн захидлыг гаргаж өгөхийг хүссэн. Төрийн байгууллагуудаас авсан хариунуудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-аас харна уу.

Баталгаажуулалтын горимын дэлгэрэнгүйг 3.3.4 хэсгээс харна уу.

3 Нэгтгэлийн цар хүрээ ба аргачлал

3.1 Танилцуулга

МОҮИТБС-ын 2016 оны тайлангийн хувьд ОТАХ-тэй хийсэн Эхлэлтийн семинарын явцад харилцан зөвшилцсөн аргачлалын дагуу Кэй Пи Эм Жи нь улсын болон орон нутгийн түвшинд тусдаа босгыг тодорхойлсон. Улсын болон орон нутгийн түвшинд тусдаа босго тогтоох талаар Эхлэлтийн семинарын явцад харилцан зөвшилцсөн ба энэ нь орон нутгийн оролцогчдын МОҮИТБС-ын тайлангийн мэдээллийг ашиглах нь чухал ач холбогдолтой талаар ОТАХ-ийн зарим гишүүдийн гаргасан санал, хүсэлтээс үүдэлтэй юм.

Кэй Пи Эм Жи нь 2016 оны МОҮИТБС-ын тайлангийн нэгтгэлд орох компаниудыг 2 бүлэгт хуваах санал дэвшүүлсэн. Үүнд:

- Эхний бүлэгт уламжлалт босго тогтоох аргачлалыг ашиглан сонгосон нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах илүү материаллаг компаниуд.
- Дараагийн бүлэгт эхний бүлэгтэй харьцуулахад материаллаг байдлаараа харьцангуй бага компаниуд орсон ба эдгээр компаниудаас түүвэрлэн аудитын нэгтгэлд хамрагдах компаниудыг сонгосон. Энэ бүлэгт багтсан компаниудаас эрсдэлд суурилсан аргачлалыг Кэй Пи Эм Жи-ийн түүврийн аргатай хавсран хэрэглэж түүвэрлэсэн. Эрсдэлд суурилсан аргачлалд Эхлэлтийн семинарын явцад ОТАХ-ийн гаргасан хүсэлтийн дагуу компанийн энэ жилийн орлогын урсгалыг өмнөх жилийнхтэй харьцуулах, А буюу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудад илүү анхаарал хандуулах зэрэг шалгуурууд багтсан ба зөвхөн үүгээр хязгаарлагдаагүй.


МОҮИТБС-ын Ажлын Албанаас 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр илгээсэн төрийн байгууллагуудын тайланг бүрэн жагсаалт гэж үзээд (нийт 2,079 компанийн мэдээлэл багтсан) нэгтгэлд орох компанийн тоог гаргахдаа уг мэдээллийг ашигласан:

- Бүлэг 1-ийн хувьд нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдсан компаниудад зөвшилцсөн материаллагийн босгыг ашигласан ба үүний үр дүнд улсын хэмжээний гол орлогын урсгалын 96.3%, орон нутгийн хэмжээний орлогын урсгалын 92.6%-ийг хамарсан.
- Бүлэг 2-ын хувьд нэмэлтээр зөвшилцсөн компаниудыг эрсдэлд суурилсан түүврийн аргаар түүвэрлэн нэгтгэлд хамруулахад нийт орлогын урсгалын 98.6%-ийг хамарсан.

Доорх хүснэгтээр компаниудыг сонгосон байдлыг харуулав. Ашигласан босгын талаарх мэдээллийг 3.3 хэсэгт харуулсан.

Нэгтгэлийн төрөл	Компанийн тоо		Гол орлогын урсгалууд (тэрбум төгрөгөөр)			Хамрах хувь %
	Улсын	Орон нутгийн	Улсын	Орон нутгийн	Нийт	
Нэг бүрчлэн нэгтгэх (Бүлэг 1)	128	43	1,124	50	1,173	96.0%
Түүвэрлэн нэгтгэх (Бүлэг 2)	255	39	29	2	31	2.6%
Үлдсэн	1,696	1,997	14	2	16	1.4%
Нийт	2,079	2,079	1,167	54	1,221	100.0%

Улсын болон орон нутгийн нэгтгэл тус бүрийн босгын хувьд зарим компаниуд давхардсан байдлаар аль аль нэгтгэлд хамрагдсан. Доорх хүснэгтээр нэгтгэлийн давхцалыг устгасны дараах компаниудын тоог харуулав.



Нэгтгэлд хамрагдсан 213 компаниудаас төрийн байгууллагын тайлагнасан гол орлогын урсгал нь 1,167 тэрбум төгрөг буюу нийт орлогын урсгалын 95.6%-ийг хамарсан.

3.2 Нэгтгэлийн аргачлал

3.2.1 Мэдээлэл цуглуулалт

ОУИТБС-ын Үндэсний Зөвлөлөөс өмнө нь боловсруулсан ОУИТБС-ын заавал дагаж мөрдөх үндсэн 7 тайлангийн маягтуудыг сүүлийн хэдэн жилийн турш компани болон төрийн байгууллагын тайлагналд ашиглаж ирсэн. Энэхүү үндсэн 7 маягтуудыг Хараат бус хянагч-нэгтгэгчээр Кэй Пи Эм Жи-тэй хамтарч ажиллахаас өмнө цахим тайлангийн системд цахимаар мэдээлэл хүлээж авахад ашигласан.

Компаниуд болон төрийн байгууллагуудын анхдагч мэдээллийг цахим тайлангийн мэдээллийн технологийн платформоос татаж авсан ба дараа нь Кэй Пи Эм Жи-ийн зүгээс дээр дурьдсан үндсэн 7 маягтуудад үндэслэн төрийн байгууллагууд болон компаниудын мэдээллийг нэгтгэсэн.

ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу зөрүүг нэгтгэх болон нэмэлт мэдээлэл олж авахын тулд МОУИТБС-ын Ажлын Албатай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Кэй Пи Эм Жи нэмэлт маягтууд боловсруулсан. Уг маягтуудыг Кэй Пи Эм Жи-ийн зүгээс тайлагналд оролцогч талуудад шууд хүргүүлж, мөн хариуг шууд хүлээн авсан. Ирүүлсэн дутуу эсвэл ойлгомжгүй мэдээллүүдийг Кэй Пи Эм Жи-ийн зүгээс нэгтгэлд хамрагдсан компаниудтай шууд холбогдон тодруулсан.

3.2.1.1 Компаниудын болон төрийн байгууллагуудын тайланд ашигласан мэдээллийн технологийн платформ


Цахим тайлангийн платформд суурилсан цахим хуудсыг тайланд оролцогч байгууллагуудын мэдээллийг цуглуулахад ашигласан. Энэхүү мэдээлэл цуглуулах цахим тайлангийн платформыг 2014 онд шинээр нэвтрүүлсэн бөгөөд 2014 оны мэдээллийн тайлагналд анх удаа энэ системийг ашигласан. ОУИТБС-ыг нэвтрүүлж байгаа 50 орноос энэхүү платформуыг Монгол Улс анхлан туршилтаар нэвтрүүлсэн.

Цахим тайлангийн системийн олон давуу талуудын хамгийн чухал нь энэхүү системээс мэдээлэл олж авах боломжийг олон нийтэд олгосон явдал юм. Үүнээс гадна, цахим систем нь монгол, англи хэл дээр боловсруулагдсан тул зөвхөн дотоодын хэрэглэгчид бус гадаадын төлөөлөгчид ч гэсэн сонирхсон мэдээллээ олж авах боломжтой болсон. Үүний үр дүнд, МОУИТБС-ын тайлангийн ил тод байдал сайжрах юм. Цаашлаад, цахим тайлангийн систем нь мэдээлэл цуглуулахад зарцуулах цаг хугацааг хэмнэж, тайлангийн явцад тайланд оролцогчдын зүгээс гаргаж болох алдаа болон системийн ачааллыг бууруулах юм.

Нөгөө талаас, цахим тайлангийн системийг суурилуулах болон мэдээллийг тайлагнах хүсэлтийг илгээх хугацааны хувьд Хараат бус хянагч-нэгтгэгч уг процесст оролцвол зохих байсан хугацаанаас хожуу оролцсон. Түүнчлэн, цахим хуудаст суурилсан мэдээллийн технологийн платформыг ашиглах нь мэдээллийн үнэн зөв, нууцлалтай болон хараат бус байх зэрэгт онцгойлон анхаарал хандуулахыг шаарддаг.

Одоогийн цахим тайлангийн мэдээлэл цуглуулах үйл явц нь тайлагнагч компаниуд болон төрийн байгууллагууд мэдээллийн системд нэвтрэх эрхээ авсанаар эхэлдэг. Дараа нь тайлагнасан мэдээллүүд нь цахим тайлангийн өгөгдлийн санд цуглардаг. Мэдээлэл цуглуулах үйл явцын тасалбар болох өдөр МОУИТБС-ын Ажлын Албаны Мэдээллийн Технологи хариуцсан мэргэжилтэн өгөгдлийн сангаас нэгтгэлийн мэдээллийг бэлтгэж Microsoft Excel форматаар Хараат бус хянагч-нэгтгэгчид хүргүүлдэг. Хараат бус хянагч-нэгтгэгч нэгтгэлийн мэдээллийг бэлтгэж дууссаны дараа нэгтгэлийн мэдээллийг цахим тайлангийн системд дахин оруулдаг. Эцэст нь, бүх хэрэглэгчид компани тус бүрийн анх тайлагнасан болон нэгтгэлийн дараах орлогын урсгалын мэдээллийг харах боломжтой болно.

Дараах диаграммаар цахим тайлангийн платформоор мэдээлэл хэрхэн дамжих үйл явцыг харуулав:



3.2.1.2 Тайлагналын маягтууд (ША 4.1)

Тайлагналын маягтууд нь 2 ангилалд хуваагдаж байна:

1. Заавал ашиглах үндсэн 7 маягтыг уул уурхай, газрын тосны хайгуул болон олборлогч компаниудын үйл ажиллагаа, үйлдвэрлэл, борлуулалт болон холбогдох орон нутгийн болон улсын төсвийн орлого зэрэг орлогын урсгалын мэдээллүүдийг цуглуулах зорилгоор загварчилсан. 2016 оны нэгтгэлийн үйл явцад эдгээр маягтуудыг цахим хэлбэрээр авах боломжийг МОҮИТБС-ын Ажлын Албанаас олгосон бөгөөд тайланд хамрагдсан компаниуд, төрийн байгууллагууд нь цахим тайлангийн системд хандан маягтыг шууд бөглөсөн.

Маягт бүр нь холбогдох хаяг, үндсэн мэдээлэл ба бусад тайлангийн мэдээлэл гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг. Анхны нэгтгэлийг хийж эхлэхэд ойролцоогоор 1,113 орчим компани 2016 оны тайлант жилийн мэдээллээ өөрсдөө ирүүлсэн бол 2,079 компанийн мэдээлэл төрийн байгууллагуудаар дамжин цахим хэлбэрээр тайлагнагдсан. Эдгээр тайлангуудын зарим нь төлөөллийн захидал, аудитын тайлан эсвэл баталгаажуулалтын тайланг агуулсан байсан. Кэй Пи Эм Жи нь Эхлэлтийн семинарын

үр дүнд ОТАХ-тэй харилцан зөвшилцсөн ажлын цар хүрээнд үндэслэн эцсийн тайланд хамрагдах төлбөрийн болон орлогын мэдээллүүдийг хянасан.

2. Сонгогдсон компаниуд болон төрийн байгууллагуудаас нэмэлт мэдээллийг хүссэн. 2017 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн урьдчилсан уулзалтууд болон Эхлэлтийн семинарын явцад нэмэлт мэдээллийн цар хүрээг тодорхойлсон ажил нь Хараат бус хянагч-нэгтгэгчийн эхлэлтийн ажлын хэсэгт багтаж байсан. Үүний дараагаар 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ОТАХ-тэй дараагийн уулзалт болсон.

Стандартаар шаардсанаар болон семинарт оролцогчдын шаардсан нэмэлт мэдээллийн талаарх зөвшилцлийг Кэй Пи Эм Жи-ийн зүгээс хураангуйлан, тохиромжтой маягт болон холбогдох босгыг санал болгосон. МОҮИТБС-ын Ажлын Алба санал болгосон маягтуудыг хүлээн зөвшөөрснөөр Кэй Пи Эм Жи нь нэгтгэлийн ажилд сонгогдсон байгууллагуудад маягтуудыг илгээж хариуг хүлээн авсан.

Нэгтгэлд сонгогдсон компаниуд болон төрийн байгууллагуудад илгээсэн тайлагналын маягтын бүтцийг Хавсралт 1 болон Хавсралт 2-г харуулав.

3.2.2 Мэдээллийн харьцуулалт

Тайлангийн 3.2.1.1-д дурьдсанчлан, Кэй Пи Эм Жи нь компанийн болон төрийн байгууллагуудын анхны нэгтгэлийн мэдээллийг МОҮИТБС-аас хоёр Excel хүснэгтээр авсан. Эдгээр хүснэгтүүд нь МОҮИТБС-ын шаардсанаар заавал тайлагнах 44 гол орлогын үзүүлэлт, сайн дураар тайлагнах 19 орлогын үзүүлэлтүүдийг багтаасан. Кэй Пи Эм Жи нь санамсаргүй түүврийн аргаар 15 компани, 10 төрийн байгууллага сонгож цахим тайлангийн системээс татаж авсан Excel тайланд шалгалт хийж, цахим тайлангийн систем болон Excel тайлангийн хоорондын эдгээр компаниуд болон төрийн байгууллагуудын тайлагнасан гол орлогын урсгалууд гэх мэт мэдээллийг харьцуулсан.

Кэй Пи Эм Жи нь нэгтгэлийн эхний алхмыг хийж анхны зөрүүг тодорхойлох зорилгоор эхлээд тайланд хамрагдахаар сонгогдсон 213 компани бүрийн сонгогдсон орлогын төрөл болох улсын хэмжээний 17, орон нутгийн хэмжээний 9 үзүүлэлтээр төрийн байгууллагуудын тайлагнасан болон компанийн тайлагнасан мэдээллийг хооронд нь нэг бүрчлэн харьцуулсан.


3.2.3 Мэдээллийн нэгтгэл

Мэдээллийн харьцуулалт хийсний дараа анхны нэгтгэлийн зөрүүг тодорхойлсон. Кэй Пи Эм Жи нь нэгтгэлд сонгогдсон байгууллага бүрийн анх тайлагнасан дүнг харуулсан нэгтгэлийн залруулгын маягтыг компани болон төрийн байгууллагуудад илгээсэн бөгөөд маягт дахь дүнгүүдийг байгууллага бүрийн анхны тайлагнасан дүнтэй нь таарч байгаа эсэхийг баталгаажуулж өгөх хүсэлт гаргасан (ингэснээр зарим мэдээллийг баталгаажуулалтаар хангасан).

Түүнчлэн, Кэй Пи Эм Жи нь тайланд хамрагдаж буй компани болон төрийн байгууллагуудаас тайлагнасан мэдээллийн дүн нь хоорондоо зөрсөн тохиолдолд зөрүүний талаарх нэмэлт мэдээллээр хангаж өгөх хүсэлтийг гаргасан. Төлөлтийн талаарх мэдээлэлтэй маягт тус бүрт хариуцаж бөглөсөн хүн гарын үсэг зурж, мэдээллийг баталгаажуулах хүсэлтийг мөн гаргасан.

Кэй Пи Эм Жи нь төлөлтийн талаарх мэдээллийг агуулсан хариуг компани болон төрийн байгууллагуудаас шууд цуглуулж авсан бөгөөд анхны зөрүүг төлөлтийн нэмэлт мэдээлэл болон байгууллагын өгсөн тайлбарын дагуу залруулсан.

Нэгтгэлийн үйл явцыг доорх хүснэгтийн дагуу бэлтгэсэн.



Компанийн тайлагнасан болон төрийн байгууллагын тайлагнасан мэдээллийн нэгтгэлд гарсан зөрүүний тайлбар нь дараах төрлүүдэд хуваагдаж байна:

- Компани төлбөрөө МОУИТБС-ын цахим тайланд тайлагнаагүй;
- Компани төлбөрөө илүү тайлагнасан;
- Төлбөрүүд буруу орлогын ангилалд тайлагнагдсан;
- Буцаагдсан төлбөрүүд нь компанийн тайланд залруулагдаагүй;
- Төлбөрүүд өөр компанийн нэр дээр хийгдсэн;
- Олборлолтоос бусад үйл ажиллагаатай холбоотой төлбөрүүд (жишээ нь: барилга багтсан);
- Тооцоо хаасан дүнгүүдийг төлбөрт оруулсан;
- Төрийн байгууллагын тайланд хамрагдсан компаниуд 2016 онд олборлох үйл ажиллагаа явуулаагүй;

- Зарим төрийн байгууллагууд нь анхны маягтаар хүссэн мэдээллийг мянган төгрөгөөр илэрхийлэхээр заасан байхад төгрөгөөр тайлагнасан;
- Өмнөх жилүүдэд хийгдсэн төлбөрийг компаниуд энэ жилд оруулан бүртгэсэн.

3.2.4 Мэдээллийн задаргааны түвшин (ША 4.7)

Мэдээлэл нь компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгалын төрөл нэг бүрээр задлан харуулах боломжтой байх ёстой. Энэ тайланд гол орлогын урсгалыг ОТАХ-ийн хүсэлтээр улсын болон орон нутгийн түвшинд задалсан. Кэй Пи Эм Жи нь ОУИТБС-ын Ажлын Албанаас шаардлагатай үед мэдээллийг шүүн харахад хялбар байх үүднээс тайлангийн мэдээллийг дүүрэг, аймгаар задлан харуулсан.

ОУИТБС-ын стандарт нь төслийн түвшинд тайлан шаарддаг. Монгол Улсын компаниуд болон төрийн байгууллагууд нь ихэвчлэн ЗГ-ын төлбөрийг төсөл бүрээр нь хуваадаггүй. Тиймээс энэхүү тайлангийн мэдээлэл нь төслийн түвшинд тайлагнагдаагүй.

Үндсэн мэдээлэл нь орон нутгийн түвшинд илүү анхаарал хандуулсан бөгөөд аймаг, сумдаар нь дэлгэрэнгүй оруулсан.

3.2.5 Нууцлалтай мэдээллийг хамгаалах

Кэй Пи Эм Жи нь тайлагнаж буй компаниудаас хүлээн авсан мэдээ мэдээллийн нууцлал болон аюулгүй байдлыг хангах үүднээс дараах шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлсэн.

- Компани болон төрийн байгууллагуудтай зөвхөн ОУИТБС-ын төсөлд зориулан үүсгэсэн тусгай электрон шуудангаар харилцсан бөгөөд энэхүү электрон шууданд нэвтрэх ажилчдын тоо хязгаартай байсан.
- Байгууллагуудаас хүлээж авсан бүх электрон мэдээллүүд нь нэвтрэх эрхийн хязгаарлалттай фолдерт хадгалагдсан.
- Цаасаарх бичиг баримтуудыг хэрэглээгүй үед цоожтой аюулгүй газар хадгалж байсан.
- Байгууллагатай хийгдсэн бүх утасны дуудлагууд нь хязгаарлагдмал орчинд хийгдсэн.
- ОУИТБС-ын төсөл дээр ажилласан бүх ажилчдад мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар удирдамж өгсөн.
- Кэй Пи Эм Жи-ийн бодлого, мэргэжлийн үүрэг хариуцлага, ёс зүйн шаардлагаар бүх ажилчид мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.

3.3 Нэгтгэлийн арга хандлага

3.3.1 Компаниудын материаллаг байдлын босго

МОҮИТБС-ын 2016 оны тайлангийн хувьд ОТАХ-тэй хийсэн Эхлэлтийн семинарын явцад харилцан зөвшилцсөн аргачлалын дагуу Кэй Пи Эм Жи нь улсын болон орон нутгийн түвшинд тусдаа босгыг тодорхойлсон. Улсын болон орон нутгийн түвшинд тусдаа босго тогтоох талаар Эхлэлтийн семинарын явцад харилцан зөвшилцсөн ба энэ нь орон нутгийн оролцогчдын МОҮИТБС-ын тайлангийн мэдээллийг ашиглах нь чухал ач холбогдолтой талаар ОТАХ-ийн зарим гишүүдийн гаргасан санал, хүсэлтээс үүдэлтэй юм. Материаллаг байдлын босгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2.3.1.1 хэсгээс харна уу.

3.3.1.1 Нэг бүрчлэн нэгтгэх сонголт

Энэ бүлэгт компани бүрийн хувьд нэг бүрчлэн нэгтгэл хийх нь зохимжтой гэж үзсэн хамгийн өндөр төлбөр тайлагнасан компаниуд орсон.

Доорх мэдээлэл нь Засгийн Газрын мэдээлсэн тоо баримтан дээр үндэслэсэн болно.

Түвшин	Материаллаг байдлын босго (Төгрөг)	Компаниудын тоо
Улсын	250 сая болон түүнээс дээш	128
Орон нутгийн	100 сая болон түүнээс дээш	43

Нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах улсын хэмжээний компаниуд: нийт улсын түвшний гол орлогын урсгал нь 250 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй компаниуд нь нийт орлогын урсгалын 96.3%-ийг эзэлж байна. Нийт 128 материаллаг компаниуд байгаа бөгөөд эдгээр компаниудыг нэг бүрчлэн нэгтгэлд хамруулсан. Материаллагийн босгыг тодорхойлсон ангиллын дэлгэрэнгүйг 3.1 хэсгээс харна уу.

Нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах орон нутгийн хэмжээний компаниуд: нийт орон нутгийн түвшний гол орлогын урсгал нь 100 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй компаниуд нь нийт орлогын урсгалын 92.6%-ийг эзэлж байна. Нийт 43 материаллаг компаниуд байгаа бөгөөд эдгээр компаниудыг нэг бүрчлэн нэгтгэлд хамруулсан. Материаллагийн босгыг тодорхойлсон ангиллын дэлгэрэнгүйг 3.1 хэсгээс харна уу.

3.3.1.2 Түүврийн сонголт

Түүврийн аргаар арай бага материаллаг төлбөртэй компаниудыг хамруулсан бөгөөд нэгтгэлийг түүврийн аргаар хийсэн. Кэй Пи Эм Жи компаниудыг сонгохдоо эрсдэлд суурилсан аргыг ашигласан. Эрсдэлд суурилсан аргачлалын хүрээнд компанийн тайлант жилийн орлогыг өмнөх жилийнхтэй харьцуулсан. Доорх мэдээлэл нь ЗГ-ын тайлангийн мэдээлэлд үндэслэсэн.

Түвшин	Босго (Төгрөг)	Компанийн тоо
Улсын	50 саяас 250 сая хүртэл	255
Орон нутгийн	30 саяас 100 сая хүртэл	39

Улсын хэмжээнд түүврийн аргаар түүвэрлэн нэгтгэлд хамрагдах компаниуд: улсын түвшний нийт гол орлого нь 50 сая төгрөгөөс 250 сая төгрөг хүртэлх төгрөгийн дүнтэй компаниудаас эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгон нэгтгэлд хамруулсан. Энэхүү бүлэгт багтаж байгаа нийт 255 компани байсан. Материаллаг байдлын босгыг тодорхойлсон ангиллын дэлгэрэнгүйг 3.1 хэсгээс харна уу.

Дээрх 3.3.1.1 хэсэгт дурьдсан 128 компани дээр нэмээд нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах 255 компани байгаа бөгөөд улсын хэмжээнд нийт орлогын 98.8%-ийг эдгээр 383 компани бүрдүүлсэн.

Сонгогдсон олонлогоос нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах компаниудыг сонгохдоо Кэй Пи Эм Жи нь дараах зүйлсийг харгалзан үзсэн бөгөөд Кэй Пи Эм Жи нь 2016 болон 2015 оны үндэсний хэмжээний материаллаг орлогуудыг харьцуулсан бөгөөд бизнесийн үйл ажиллагаатай (Жишээлбэл: ААНОАТ, НӨАТ, Ашигт

малтмал ашигласны төлбөр, Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгал) холбоотой орж ирсэн орлого нь 10%-аас дээш хувиар буурсан, компаниудын цахим бүртгэлийн системд тайлагнасан дүн Засгийн Газрын тайлангаас 50%-аас илүү зөрүүтэй компаниудыг сонгосон ба А буюу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудад илүү анхаарал хандуулсан. Эдгээр шалгуурын дагуу нийт 67 компани нэгтгэлд нэг бүрчлэн хамрагдахаар болсон.

Бүлэг 2-т багтаж буй 255 компаниас 43 нь нэг бүрчлэн нэгтгэгдэхээр сонгогдсон.

Орон нутгийн хэмжээнд түүврийн аргаар түүвэрлэн нэгтгэлд хамрагдах компаниуд: нийт орон нутгийн түвшний гол орлого нь 30 сая төгрөгөөс 100 сая хүртэлх төгрөгийн дүнтэй компаниудаас эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгон нэгтгэлд оруулсан. Энэхүү бүлэгт багтаж буй нийт 39 компани байсан. Материаллаг байдлын босгыг тодорхойлсон ангиллын дэлгэрэнгүйг 3.1 хэсгээс харна уу.

Тайлангийн 3.3.1.1 хэсэгт дурдсан нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах 43 компани дээр нэмээд (нийтдээ 82 компани) эдгээр компаниудын орон нутгийн орлогын урсгалын нэгтгэлийн ажил нь Засгийн Газрын тайлагнасан нийт орон нутгийн орлогын урсгалын 96.3%-ийг бүрдүүлж байна.

Нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах компаниудыг сонгоходоо Кэй Пи Эм Жи нь дараах зүйлсийг харгалзан үзсэн бөгөөд Кэй Пи Эм Жи нь 2016 болон 2015 оны орон нутгийн хэмжээний материаллаг орлогуудыг харьцуулсан бөгөөд бизнесийн үйл ажиллагаатай (Жишээлбэл: Ус ашигласны төлбөр, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэх мэт) холбоотой орж ирсэн орлого нь 10%-аас дээш дүнгээр буурсан болон компаниудын МОҮИТБС-ын цахим тайлангийн системд тайлагнасан дүн нь засгийн газрын тайлагнасан дүнгээс 50%-аас дээш хэлбэлзэлтэй компаниудыг сонгосон. Мөн А төрлийн лиценз (ашиглалтын) эзэмшдэг компаниудад илүү анхаарал хандуулсан бөгөөд энэхүү шалгуурын дагуу нийт 13 компани нэгтгэлд нэг бүрчлэн хамрагдахаар болсон.

Бүлэг 2-т багтаж буй 39 компаниас 13 нь нэг бүрчлэн нэгтгэгдэхээр сонгогдсон.

Хэдийгээр нэгтгэлд хамрагдах компаниудын тоог эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгоход компани нэг бүр нэгтгэлд хамрагдахгүй боловч эрсдэлд суурилсан сонголт нь компаниудыг илүү өргөн хүрээгээр илүү үр бүтээлтэйгээр хамруулдаг. Учир нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй (ашиглалтын А тусгай зөвшөөрөлтэй) өндөр эрсдэлтэй компаниудыг хамруулахад энэ аргачлал чиглэгддэг юм. Энэ нь Хараат бус хянагч-нэгтгэгч нэгтгэлийн ажлын ерөнхий зорилго, чанарыг алдагдуулалгүйгээр илүү олон тооны компаниудыг хамруулж нэгтгэлийн ажлын цар хүрээг үр бүтээлтэйгээр өргөжүүлэх боломжийг олгодог.

3.3.2 Үндсэн орлогын урсгалыг сонгосон материаллаг байдлын босго

Нэгтгэлд хамрагдах компаниудыг тодорхойлоход ашигласан аргачлалтай ижил аргачлалын дагуу Кэй Пи Эм Жи нь гол орлогын ангиллыг сонгох босго тогтоохын тулд нийт орлогын 99%-ийг хамрах зорилго тавьсан. Сонголт хийх явцад компанийн болон төрийн байгууллагын тайланг ашигласан бөгөөд зарим төрийн байгууллагууд цахим тайлагналын зарим горимыг гүйцэтгээгүйн улмаас тодорхой төрлийн орлогын мэдээлэл нь төрийн байгууллагын мэдээлэлд дутагдалтай байсан.

Дээр дурдсан 44 гол орлогын мэдээллээс улсын хэмжээнд 31 гол орлогын мэдээлэл, орон нутгийн хэмжээнд 13 гол орлогын мэдээлэл цугласан байна. Улсын хэмжээний хамгийн том 17 орлогын урсгал нь нийт улсын хэмжээний гол орлогын урсгалын 99%-ийг бүрдүүлж байна. Орон нутгийн хэмжээний хамгийн том 9 орлогын урсгал нь нийт орон нутгийн хэмжээний гол орлогын урсгалын 99%-ийг бүрдүүлж байна.

3.3.3 Жижиг зөрүүнд тооцох босго

Орлогын төрөл бүрт компанийн болон төрийн байгууллагын мэдээлэл хоорондын зөрүү нь 500 мянган төгрөгөөс доош тохиолдолд материаллаг бус гэж үзсэн бөгөөд өөрөөр хэлбэл дэлгэрэнгүй шинжилгээг зөвхөн 500 мянган төгрөгөөс дээш зөрүүтэй тохиолдолд гүйцэтгэсэн.

3.3.4 Баталгаажуулах горимууд (ША 4.9)

ОУИТБС-ын стандарт нь олон улсын стандартын дагуу итгэл үнэмшилтэй баталгаажуулалтын процессыг хэрэгжүүлэхийг шаарддаг.

2016 оны процессын хувьд Кэй Пи Эм Жи нь компаниудын тайлагнасан мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг баталгах зорилгоор хэд хэдэн төрлийн удирдлагын төлөөллийн захидлууд болон аудитын тайлангуудыг ирүүлэх хүсэлт гаргасан. Кэй Пи Эм Жи-ийн гүйцэтгэсэн баталгаажуулалтын горимуудын талаарх дэлгэрэнгүй тайлбарыг доор үзүүлэв.

2016 оны МОУИТБС-ын тайланд хэрэглэсэн арга барил нь Монгол Улсад оршин байгаа хязгаарлалтууд, өмнөх нэгтгэлийн үед ажиглагдсан сул доголдолтой зүйлс болон 2014 оны МОУИТБС-ын тайлангийн баталгаажуулалтын үр дүн зэргийг хамарсан. Баталгаажуулалтын талаарх ОУИТБС-ын шаардлагад нийцсэн дараах гурван үндсэн зорилтыг тавьсан. Үүнд:

- ОУИТБС-ын тайлагналын үйл явцад оролцогч компаниуд болон төрийн байгууллагуудын аудит болон баталгаажуулалтын горимуудыг шалгах, шалгалтын үр дүнд үндэслэн мэдээллийн найдвартай байдлыг баталгаажуулахын тулд компаниуд болон төрийн байгууллагуудаас ямар мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгчид бэлтгэж өгөхийг тохирно.
- Хараат бус хянагч-нэгтгэгч нь санхүүгийн мэдээллийн дэлгэрэнгүй, ойлгомжтой байдал болон үнэн зөв байдалд хийсэн үнэлгээг өөрийн гүйцэтгэсэн ажлын хураангуй мэдээллийн хамт ОУИТБС-ын тайландаа тусгах ба үнэлгээний хязгаарлалтуудыг мөн тусгасан байна.
- Хараат бус хянагч-нэгтгэгч нь бүхий л материаллаг аж ахуйн нэгжүүд нь хүссэн мэдээллийг ирүүлсэн эсэх үнэлгээг тусгана. Тайлагналын аливаа зөрүү болон сул талуудыг толилуулах шаардлагатай бөгөөд үүнд тавьсан шаардлагад нийцээгүй аж ахуйн нэгжүүдийг нэрлэх, энэ нь бүрэн хэмжээний дэлгэрэнгүй тайлан бэлтгэхэд материаллаг нөлөө үзүүлсэн эсэхэд хийсэн үнэлгээ зэрэг хамаарна.

Энэхүү арга хандлага нь 2015 оны тайлангаар өгсөн зөвлөмж (баталгаажуулалтыг авч үзэх асуудлын талаар)-ийн хэрэгжилт гэж үзэн хараат бус хянагч-нэгтгэгчийн Эхлэлийн Семинарын үеэр хэлэлцсэн. Аргачлалын агуулгыг 2017 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Эхлэлийн Семинарын дараа МОУИТБС-ын Ажлын Албанд танилцуулсан.

2016 оны МОУИТБС-ын тайлангийн ОУИТБС-ын стандартад үндэслэн боловсруулсан дэлгэрэнгүй арга хандлага нь Эхлэлийн Семинарын явцад ОТАХ дараах дэд хэсгүүдэд дурьдсанаар харилцан зөвшилцсөн.

3.3.4.1 Алхам 1 – Одоогийн хяналтууд болон Аудитын цар хүрээний анхны үнэлгээ, Баталгаажуулалтын анхны үнэлгээ

Хараат бус хянагч-нэгтгэгч нь (i) компани, (ii) төрийн өмчит аж ахуйн нэгж болон төрийн байгууллагуудын одоогийн хяналтууд ба аудитын цар хүрээ /"ОХАЦХ"/-нд хэр хэмжээнд итгэл үзүүлэх боломжтойг үнэлэхдээ мэргэжлийн үнэлэмж ашигласан ба энэхүү алхам нь тайлагнагч аж ахуйн нэгж / компани, төрийн өмчит аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн байгууллагууд/-ийн Баталгаажуулалтын Анхны Үнэлгээг /"БАҮ"/ тодорхойлоход тусладаг.

Үнэлгээний хувьд, товчхондоо ОХАЦХ бага байх үед БАҮ бага түвшинд байдаг. (өөрөөр хэлбэл, бага түвшний баталгаажуулалт)

БАҮ нь НББ-ийн стандартууд / ОУ-ын стандартууд, орон нутгийн стандартууд, бусад стандартууд/, одоогийн байгууллагын засаглал болон дотоод хяналт, аудит хийлгэсэн компанийн хувьд хэрэглэсэн аудитын стандарт, тухайн аудиторын найдвартай байдал зэрэг үндсэн хүчин зүйлүүд дээр үндэслэдэг.

Ихэнх улс оронд улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын ОХАЦХ маш бага байдаг тул БАҮ ч мөн адил бага түвшинд байдаг.

Улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын хувьд дээрх шалгуурууд нь ерөнхийдөө бага түвшинд байдаг тул ОХАЦХ болон БАҮ нь бага түвшинд байна. Кэй Пи Эм Жи болон ОТАХ нь 2016 оны ҮАГ-ын ажлын цар хүрээг авч үзсэн бөгөөд (ҮАГ-ын ажлын цар хүрээ хязгаарлагдмал байсан тул) энэ нь ОХАЦХ-ний бага үнэлгээтэй нийцнэ гэсэн дүгнэлтэд хүрсэн боловч ҮАГ-ын үүрэг хариуцлага ирээдүйд нэмэгдэх ёстой гэж үзсэн. Сангийн Сайдын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 43 тоот тушаалын дагуу Сангийн Яамны Төрийн Нарийн Бичгийн Дарга болон Төсвийн Бодлого Төлөвлөлтийн Газрын Дарга нь ОУИТБС-ын цахим тайлангийн системд тайлагнасан орлогын урсгалын анхны дүнг хянаж, гарын үсэг зурж баталгаажуулахыг шаардсан. Түүнчлэн, нэгтгэлийн үйл явцад улсын болон орон нутгийн төрийн байгууллагууд нь хараат бус хянагч-нэгтгэгчид ирүүлсэн маягт дээр гарын үсэг зурж баталгаажуулахыг шаардсан. Улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын гарын үсэг зурсан маягтуудын явцыг Хавсралт 5-д харуулсан.

Дээрх арга хандлагад үндэслэн хараат бус хянагч-нэгтгэгч нь дараах дүгнэлтэнд хүрсэн:

- Дараах улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын хувьд гарын үсэг зурж баталгаажуулсан маягтуудыг бүрэн хүлээж аваагүй учир ОХАЦХ болон БАҮ-г бага түвшинд байна гэж үзсэн: Гаалийн Ерөнхий Газар болон Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
- Бусад улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын хувьд ОХАЦХ болон БАҮ-г бага түвшнээс дунд түвшин хүртэл байна гэж үзсэн.

ТӨААН-үүдийн хувьд хэрэглэсэн НББ-ийн стандартууд / ОУ-ын стандартууд, орон нутгийн стандартууд, бусад стандартууд/, одоогийн байгууллагын засаглал болон дотоод хяналт, аудит хийлгэсэн компанийн хувьд хэрэглэсэн аудитын стандарт, тухайн аудиторын найдвартай байдал зэрэг үндсэн хүчин зүйлүүд дээр үндэслэн ангилсан.

Кэй Пи Эм Жи нь 11 ТӨААН-үүдээс дараах мэдээллүүдийг хүлээж авсан:

- Хоёр ТӨААН (Оюу Толгой ХХК болон Эрдэнэт Үйлдвэр ХХК) СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Олон Улсын аудитын компаниар аудит хийлгэсэн.
- Есөн ТӨААН СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Үндэсний Аудитын Газраар аудит хийлгэсэн бөгөөд эдгээр 9 ТӨААН-үүдээс 2 ТӨААН (Шивээ-Овоо ХК болон Багануур ХК) нь аудитлагдсан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт олон нийтэд нээлттэй байршуулсан байна.

Дээрхи ТӨААН-үүдийн ОХАЦХ болон БАҮ нь дунд түвшинд байна гэж үзсэн.

Кэй Пи Эм Жи нь Гурвансайхан ХХК гэх ТӨААН-тэй холбогдож чадаагүй тул энэ компанийн хувьд ОХАЦХ болон БАҮ-г бага түвшинд байна гэж үзсэн.

Түүврээр сонгогдсон компаниудын хувьд хэрэглэсэн НББ-ийн стандартууд / ОУ-ын стандартууд, орон нутгийн стандартууд, бусад стандартууд/, одоогийн байгууллагын засаглал болон дотоод хяналт, аудит хийлгэсэн компанийн хувьд баримталсан аудитын стандарт, тухайн аудиторын найдвартай байдал зэрэг үндсэн хүчин зүйлүүд дээр үндэслэн ангилсан.

Кэй Пи Эм Жи нь 213 компаниудаас дараах мэдээллүүдийг хүлээж авсан:

- 13 компани нь СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа Олон Улсын аудитын компаниар аудит хийлгэсэн бөгөөд эдгээр компаниас 6 компани нь аудитлагдсан санхүүгийн тайлангаа аудитын дүгнэлтийн хамт олон нийтэд нээлттэй байршуулсан байсан.
- 133 компани нь санхүүгийн тайландаа дотоодын аудитын компаниар аудит хийлгэсэн байсан.

Дээрх компаниудын хувьд ОХАЦХ болон БАҮ нь дунд түвшинд байна гэж үзсэн.

Бидэнд аудитын тайлангаа танилцуулаагүй 34 компанийн хувьд ОХАЦХ болон БАҮ-г бага түвшинд байна гэж үзсэн.

ОХАЦХ болон БАҮ-ний шалгуурууд		
Засгийн Газрын агентлаг	Гарын үсэг зурсан маягтууд	
	Тийм	Үгүй
Таамагласан ОХАЦХ болон БАҮ	Муугаас дунд	Муу
Компани/ТӨААН	Аудитлагдсан	
	Тийм	Үгүй
ОХАЦХ болон БАҮ	Дунд	Муу

ОУИТБС-ын цахим тайлангийн системд аудитын тайлангаа илгээсэн компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 12-с харна уу.

3.3.4.2 Алхам 2 – Баталгаажуулалтын эцсийн үнэлгээ

Эхлэлийн Семинарын явцад Кэй Пи Эм Жи-ээс санал болгож ОТАХ зөвшөөрсний дагуу нэгтгэлд сонгогдсон компаниуд дараах баталгаажуулалтын нотолгоог танилцуулна.

Бүх компаниуд, улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын хувьд ОУИТБС-ын цахим тайлангийн системд байршуулсан мэдээлэл болон нэмэлт маягтууд дээр бөглөсөн мэдээлэл нь “иж бүрэн, үнэн зөв бөгөөд 2016 оны тайлант жилд хамаарах ажил гүйлгээн дээр тулгуурласан” гэдгийг баталгаажуулсан удирдлагын төлөөллийн захидал ирүүлэхийг хүссэн.

Хараат бус хянагч-нэгтгэгч болон ОТАХ нь нэгтгэлд сонгогдсон компаниудын илгээсэн мэдээлэл болон удирдлагын захидал дээр тусгайлан хөндлөнгийн аудиторын гарын үсэг авах сонголтыг бүрэн шинжилж үзсэн. Зарим ОУИТБС орнууд нь эдгээр горимуудыг Баталгаажуулах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт эсвэл БГАОУС 3000 Баталгаажуулалтын тайлангийн хэлбэрээр тохиролцсон горим гүйцэтгэх стандартуудад тулгуурлан амжилттай хэрэгжүүлсэн байдаг. Кэй Пи Эм Жи уг шинэлэг санааг Монгол Улсын 2014 оны ОУИТБС-ын тайланд нэвтрүүлэх саналыг Эхлэлийн Семинарын явцад харилцан зөвшилцсөн боловч 2014 болон 2015 оны ОУИТБС тайланд хэрэгжүүлэх хүсэлт амжилтгүй болсон юм. Компаниудын тайлбарласнаар баталгаажуулалтын тайлангийн төлбөрийг төлөх төсөв байхгүй, найдвартай аудитын компаниуд нь шаардлагатай баталгаажуулалтын горимуудыг гүйцэтгэхгүйгээр баталгаажуулалтын тайлан гаргаж өгөх боломжгүй байдагтай холбоотой юм.

Монгол Улс дахь уг туршлага дээр үндэслэн, ОТАХ нь 2016 оны хувьд хөндлөнгийн аудиторын баталгаажуулалтын тайлан болон удирдлагын төлөөллийн захидал дээр аудитор гарын үсэг зурж баталгаажуулах горимын аль аль нь Монгол Улсын бодит байдалтай нийцэхгүй тул эдгээр мэдээллийг хүсэх шаардлагагүй гэж үзсэн.

Материаллаг хэмжээний төлбөр төлж буй бүх ТӨААН-үүд, (жишээ нь нэгтгэлд сонгогдсон) нь байгууллагын хамгийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт танилцуулах ёстой ба 2016 оны аудитласан санхүүгийн тайлан илүү тохиромжтой. ТӨААН-үүд нь СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан болон дотоодын хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг аль алийг нь аудитласан бол дотоодын хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан эсвэл дотоодын

аудитын байгууллагаар аудитлагдсан аудитын тайлангаас илүү Олон Улсын аудитын байгууллагаар аудитлагдсан СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг илүү найдвартай гэж үзнэ.

Тиймээс сонгогдсон ТӨААН-үүдэд аудитлагдсан санхүүгийн тайлангаа аудитын дүгнэлтийн хамт ОУИТБС-ын цахим тайлангийн системд байршуулах хүсэлтийг тавьсан. Олон Улсын аудитын байгууллагаар санхүүгийн тайлангийн аудитаа хийлгэсэн нь мэдэгдэж байсан ТӨААН-үүдийг тухайн аудитын тайлангаа танилцуулахыг хүссэн.

Тайландаа аудит хийлгэсэн сонгогдсон бүх компаниуд нь компанийн хамгийн сүүлийн аудитын тайланг танилцуулах ёстой ба 2016 оны аудитласан санхүүгийн тайлан илүү тохиромжтой. Компаниудын СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан болон дотоодын хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аль аль нь аудитласан бол дотоодын хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан эсвэл дотоодын аудитын байгууллагаар аудитлагдсан аудитын тайлангаас илүү Олон Улсын аудитын байгууллагаар аудитлагдсан СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг илүү найдвартай гэж үзнэ.

Хараат бус хянагч-нэгтгэгч нь нэгтгэлд сонгогдсон хувийн компаниудаас аудитлагдсан санхүүгийн тайланг авах сонголтыг авч үзсэн боловч мэргэжлийн туршлага дээр үндэслэн харахад хувийн компаниудын санхүүгийн тайлангийн зүйлс нь хоорондоо нилээд нэгтгэгдсэн байдаг тул нарийвчилсан гүйлгээ болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг шинжлэхгүйгээр ОУИТБС-ын цар хүрээнд танилцуулсан мэдээлэлд мэдээллийн баталгаажуулалт болох нь харьцангуй бага байдаг. Тиймээс энэхүү мэдээлэл нь мэдээллийг баталгаажуулах үйл явцад үр өгөөжгүй гэж дүгнэсэн.

Тиймээс сонгогдсон компаниудад аудитлагдсан санхүүгийн тайлангаа аудитын дүгнэлтийн хамт ОУИТБС-ын цахим тайлангийн системд байршуулах эсвэл хараат бус хянагч-нэгтгэгчид хүргүүлэх хүсэлтийг тавьсан. Олон Улсын аудитын байгууллагаар санхүүгийн тайлангийн аудитаа хийлгэсэн нь мэдэгдэж байсан компаниудын хувьд тухайн аудитын тайлангаа танилцуулахыг хүссэн.

Эхлэлийн Семинарын явцад Кэй Пи Эм Жи нь эрсдэлтэй гэж үзсэн тодорхой байгууллагуудын (ОТАХ-ийн тодорхойлсноор) хувьд аудиторуудын тусгай баталгаажуулалт танилцуулах хүсэлт гаргах, тусгай ярилцлага хийх, тухайн байгууллагуудын дансдын тусгай ажил гүйлгээний шинжилгээ хийх зэрэг илүү нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй гэсэн санал гаргасан. Харин энэхүү горим нь эрсдэлтэй аж ахуйн нэгжийн жагсаалт (ОТАХ-ийн тодорхойлсноор) байхгүйн улмаас эцсийн үе шатанд хэрэгжээгүй юм.

Кэй Пи Эм Жи нь дээр дурьдсан Засгийн Газрын агентлагууд болон компаниудаас ирүүлсэн мэдээллийг шинжилж, баталгаажуулалтын дараах шалгууруудыг хэрэгжүүлсэн:

- Удирдлагын төлөөллийн захидлыг зохих ёсоор ирүүлсэн эсэх, загварын дагуу иж бүрэн эсэх, ТУЗ-ийн төлөөлөгч, эсвэл Ерөнхийлөгч, эсвэл Гүйцэтгэх Захирал, эсвэл компани болон ТӨААН-ийн гүйцэтгэх удирдлагаар зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсан эсэх, Ерөнхий Удирдлагын төлөөлөл, эсвэл Сайд, эсвэл төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгч, эсвэл орон нутгийн захиргааны байгууллагын удирдлагаар зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсан эсэх.

Удирдлагын төлөөллийн захидал ирүүлээгүй, “дэлгэрэнгүй”, “үнэн зөв” болон “бодит ажил гүйлгээн дээр үндэслэсэн” зэрэг гол шалгууруудыг орхигдуулсан тохиолдолд баталгаажуулалтын түвшин буурсан.

- ТӨААН болон компаниудын хувьд аудитын тайлан оршин байгаа эсэх, аудитор, түүний хэрэгжүүлсэн аудитын болон НББ-ийн стандартуудын чанар.

Аудитын тайлан байхгүй, эсвэл олон улсын стандартаас өөр стандартын дагуу тайлагнасан бол баталгаажуулалтын түвшин буурсан.

Дээрх схемьг 2017 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Эхлэлийн Семинарын явцад ОТАХ-тэй хэлэлцэн зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын нөхцлийг харгалзан эрсдэлд суурилсан арга хандлагаар Кэй Пи Эм Жи-д боловсруулсан.

Алхам 2-ын төгсгөлд, сонгосон аж ахуйн нэгж бүрийн баталгаажуулалтын түвшинд зэрэглэл тогтоосон:

- Доод түвшний баталгаажуулалт – санхүүгийн тайлангийн аудит хийлгээгүй болон удирдлагын төлөөллийн захидал ирүүлээгүй аж ахуйн нэгжүүд, 3-р зэрэглэлийн дотоодын аудитын байгууллагаар санхүүгийн тайлангийн аудит хийлгэсэн, удирдлагын төлөөллийн захидал ирүүлээгүй эсвэл дутуу бөглөсөн удирдлагын төлөөллийн захидлыг ирүүлсэн аж ахуйн нэгжүүд
- Дунд түвшний баталгаажуулалт
- Дээд түвшний баталгаажуулалт – дээр дурьдсан холбогдох төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулсан зөрчилгүй удирдлагын төлөөллийн захидал ирүүлсэн аж ахуйн нэгж, Олон Улсын аудитын байгууллагаар аудит хийлгэн зөрчилгүй дүгнэлтийн хамт ирүүлсэн аж ахуйн нэгжүүд. (ТӨААН-үүдийн хувьд СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг тусгайлан танилцуулна)

2016 оны баталгаажуулалтын эцсийн үнэлгээг доорх хүснэгтээр харуулав:

Компаниуд болон ТӨААН-үүд	2016			
	Компанийн тоо	Орлогын нийт урсгал, сая төгрөгөөр	Хувь, орлогын урсгалд тулгуурласан	Баталгаажуулалтын эцсийн үнэлгээ
Аудитын тайлан болон төлөөллийн захидал ирүүлээгүй	24	5,356	0.50%	Муу
Төлөөллийн захидал ирүүлсэн боловч аудитын тайлан ирүүлээгүй	43	91,969	8.58%	Дунд / Муу
Төлөөллийн захидал ирүүлсэн ба 1-р зэрэглэлийн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн зөрчилгүй дүгнэлт ирүүлсэн	14	448,848	41.90%	Сайн
Төлөөллийн захидал болон 2,3-р зэрэглэлийн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн зөрчилгүй дүгнэлт ирүүлсэн	112	333,790	31.16%	Дунд
1,2-р зэрэглэлийн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн зөрчилгүй дүгнэлт ирүүлсэн, төлөөллийн захидал ирүүлээгүй	6	2,635	0.25%	Дунд / Муу
3-р зэрэглэлийн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн зөрчилгүй дүгнэлт ирүүлсэн, төлөөллийн захидал ирүүлээгүй	10	4,759	0.44%	Муу
Төлөөллийн захидал болон хязгаарлалттай аудитын тайлан ирүүлсэн	4	183,974	17.17%	Дунд / Муу
Нийт компанийн тоогоор 15.96%	34	10,115	0.94%	Муу
Нийт компанийн тоогоор 77.47%	165	612,368	57.16%	Дунд / Муу

Компаниуд болон ТӨААН-үүд	2016			
Компаниудын ирүүлсэн мэдээлэл	Компанийн тоо	Орлогын нийт урсгал, сая төгрөгөөр	Хувь, орлогын урсгалд тулгуурласан	Баталгаажуулалтын эцсийн үнэлгээ
Нийт компанийн тоогоор 6.57%	14	448,848	41.90%	Сайн
	213	1,071,331	100%	Нийт

2016 оны шаардлагад нийцээгүй аж ахуйн нэгжүүдийн хураангуй:

- 24 компани аудитын тайлан болон төлөөллийн захидал ирүүлээгүй. Хавсралт 4 болон Хавсралт 12-ыг харна уу;
- 16 компани төлөөллийн захидал ирүүлээгүй боловч зөрчилгүй дүгнэлт бүхий аудитын тайлан ирүүлсэн. Хавсралт 4 болон Хавсралт 12-ыг харна уу;
- 4 компани төлөөллийн захидал ирүүлсэн боловч хязгаарлалттай дүгнэлт бүхий аудитын тайлан ирүүлсэн. Хавсралт 4 болон 12-ыг харна уу;
- 11 компани зөрчилтэй төлөөллийн захидал ирүүлсэн. Хавсралт 4-ийг харна уу.

2015 оны МОУИТБС-ын тайлангийн мэдээлэлд үндэслэсэн 2015 оны баталгаажуулалтын тооцоолсон үнэлгээний хураангуйг харьцуулах зорилгоор доорх хүснэгтээр харуулав:

Компаниуд болон ТӨААН-үүд	2015			
Компаниудын ирүүлсэн мэдээлэл	Компанийн тоо	Орлогын нийт урсгал, сая төгрөгөөр	Хувь, орлогын урсгалд үндэслэсэн	Үнэлгээ
Нийт компанийн тоогоор 21.78%	44	257,952	18.53%	Муу
Нийт компанийн тоогоор 72.28%	146	1,107,609	79.57%	Дунд / Муу
Нийт компанийн тоогоор 5.94%	12	26,477	1.90%	Сайн
	202	1,392,037	100%	Нийт

2014 оны МОУИТБС-ын тайлангийн мэдээлэлд үндэслэсэн 2014 оны баталгаажуулалтын тооцоолсон үнэлгээний хураангуйг харьцуулах зорилгоор доорх хүснэгтээр харуулав:

Компаниуд болон ТӨААН-үүд	2014			
Компаниудын ирүүлсэн мэдээлэл	Компанийн тоо	Орлогын нийт урсгал, сая төгрөгөөр	Хувь, орлогын урсгалд үндэслэсэн	Үнэлгээ
Нийт компанийн тоогоор 25.85%	61	59,920	3.79%	Муу
Нийт компанийн тоогоор 72.03%	170	1,504,010	95.05%	Дунд / Муу
Нийт компанийн тоогоор 2.12%	5	18,298	1.16	Сайн
	236	1,582,228	100%	Нийт

3.3.4.3 Алхам 3 – Тайлагналын сайжруулалтыг үнэлж, танилцуулах

Эхлэлтийн Семинарын явцад дараах зорилтуудыг ОТАХ-тэй хэлэлцсэн:

- Дээр тайлбарласны дагуу Баталгаажуулалтын Эцсийн Үнэлгээ (БЭҮ)-ний жигнэсэн дундаж тооцоололд үндэслэн мэдээллийн чанарыг үнэлэх;
- Хүснэгт 3.3.4.2-д заасан компаниудын нийт орлогод эзлэх компанийн төрөл тус бүрийн эзлэх хувийн жинд үндэслэн жигнэсэн дундаж БЭҮ-г тооцоолох;
- Баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх замаар жил бүрийн баталгаажуулалтын жигнэсэн дундаж өсөлтийг нэмэгдүүлэх - БЭҮ-ний доод түвшний үнэлгээг бууруулах;
- Өмнөх хоёр жилийн ОУИТБС-ын тайланд үндэслэн жигнэсэн дундаж БЭҮ-г тооцоолох. 2014 болон 2015 оны МОУИТБС-ын тайлангаас сонгогдсон түүврээр Кэй Пи Эм Жи боловсруулсан арга зүйг ашиглан мэдээллийн баталгаажуулалтыг дахин үнэлсэн;
- Эхлэлийн Семинарын явцад тодорхойлсон эрсдэлтэй компаниудыг орлогын урсгал дахь эрсдэлд үндэслэн тусгайлан үнэлэх. Энэхүү горим нь эрсдэлтэй аж ахуйн нэгжийн жагсаалт байхгүйн улмаас эцсийн үе шатанд хэрэгжээгүй.

Эхлэлийн Семинарын явцад ОТАХ-ээс МОУИТБС албанд жигнэсэн дундаж БЭҮ-ний жил бүрийн өсөлтийн мэдээлэл хэрэгтэй гэж шийдсэн.

- Жигнэсэн дундаж муу БЭҮ-ний хувьд: энэ харьцааны жил бүрийн бууралтын үзүүлэлтийг зайлшгүй олж авах нь зүйтэй. Аж ахуйн нэгжүүдийн хязгаарлалттай түүвэрт үндэслэсэн жигнэсэн дундаж муу БЭҮ-г нийт орлогод үндэслэн ойролцоогоор тооцоолоход 2014 оны МОУИТБС-ын тайлангийн хувьд 3.79% бөгөөд 2015 оны МОУИТБС-ын тайлангийн хувьд 18.53% байна. 2016 оны МОУИТБС-ын тайлангийн хувьд муу түвшиний баталгаажуулалтын зорилтот хувь нь 2015 оны МОУИТБС-ын тайлантай харьцуулахад буурах бөгөөд нийт компанийн тоонд үндэслэн үзэхэд хамгийн ихдээ 18% байна.
- Бодит муу түвшний жигнэсэн дундаж БЭҮ нь 17.59%-иар буурсан бол бодит сайн түвшний жигнэсэн дундаж БЭҮ нь 40%-иар өссөн байна. Бодит муу түвшиний жигнэсэн дундаж БЭҮ нь 2016 оны хувьд нийт компанийн тоонд үндэслэн үзэхэд 15.96% байна.

3.3.4.4 Дүгнэлт – Тулган баталгаажуулсан мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлын ерөнхий үнэлгээ

Анхны үнэлгээ: Хараат бус хянагч-нэгтгэгч нь компаниуд, ТӨААН-үүд болон төрийн байгууллагуудын Баталгаажуулалтын Анхны Үнэлгээг /"БАҮ"/ хийх зорилгоор Одоогийн хяналтууд ба аудитын цар хүрээ /"ОХАЦХ"/-нд хэр хэмжээнд итгэл үзүүлэх боломжтойг өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд тулгуурлан үнэлсэн. Хараат бус хянагч-нэгтгэгч нь БАҮ болон ОХАЦХ-г дараах байдлаар үнэлсэн. Үүнд:

- Улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудын хувьд (ГЕГ болон БОАЖЯ-аас бусад) ОХАЦХ болон БАҮ-г багаас дунд түвшинд байна гэж үнэлсэн. Харин ГЕГ болон БОАЖЯ-ыг бага түвшинд байна гэж үзсэн.
- ТӨААН-үүдийн хувьд ОХАЦХ болон БАҮ-г дунд түвшинд байна гэж үзсэн.
- Компаниудын хувьд, аудитын тайлангаа танилцуулаагүй 34 компанид ОХАЦХ болон БАҮ-г муу түвшинд, бусад 179 компанид ОХАЦХ болон БАҮ-г дунд түвшинд байна гэж үзсэн.

Эцсийн үнэлгээ: ОТАХ-ийн тохиролцсон мэдээллийн баталгаажуулалтын журмын дагуу Хараат бус хянагч-нэгтгэгч Баталгаажуулалтын Эцсийн Үнэлгээ /"БЭҮ"/-г тулган баталгаажуулалтын дараах санхүүгийн мэдээлэл дээр хийсэн. Нэгтгэлд хамрагдсан компаниуд, ТӨААН-үүдийн тулган баталгаажуулсан нийт орлогын 41.9% нь сайн дүнтэй гарсан бол 57.16% нь дунд дүнтэй гарч, 0.94% нь муу үнэлгээтэй гарсан. Төрийн байгууллагуудын хувьд "Баталгаажуулалтын Эцсийн Үнэлгээ" багаас дунд

түвшинд хэвээр үнэлэгдсэн хэдий ч, компаниуд, ТӨААН-үүдийн төлсөн дүнг төрийн байгууллагуудын хүлээн авсан орлогын дүнтэй тулган баталгаажуулах явцад компаниуд, ТӨААН-үүдийн мэдээллийн баталгаажуулалт нэмэгдэхийн хэрээр төрийн байгууллагуудын мэдээллийн баталгаажуулалт нэмэгдэх зарчим үйлчилсэн болно. Тиймээс Хараат бус хянагч-нэгтгэгч компаниуд, ТӨААН-үүд болон төрийн байгууллагуудын тулган баталгаажуулалтын дараах санхүүгийн мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлын эцсийн үнэлгээг шаардлага хангасан гэж үзсэн. Баталгаажуулалттай холбоотой дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн 3.3.4.1 болон 3.3.4.2 хэсгээс харна уу.

3.4 Тайлагнагч байгууллагууд болон хамрагдсан орлогууд

3.4.1 Төрийн байгууллагууд

3.4.1.1 Нэгтгэлд хамрагдсан төрийн байгууллагуудын жагсаалт (ША 4.2в)

Кэй Пи Эм Жи нь ОУ-ийн компаниудаас материаллаг төлбөр хүлээн авсан төрийн байгууллагуудыг тодорхойлж жагсаасан. Доорх жагсаалтаар тайлангийн 3.3.2 хэсэгт дурьдсан нэгтгэлд сонгогдсон гол орлогын урсгалыг бүрдүүлсэн төрийн байгууллагуудыг харуулав.

Төрийн байгууллагууд	Орлогын урсгал
ГЕГ	Гаалийн албан татвар, гаалийн үйлчилгээний хураамж, автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар
ТЕГ	ААНОАТ, НӨАТ, АМНАТ, агаарын бохирдлын төлбөр
Орон нутгийн засаг захиргаа	Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн орлогын 50%, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал, гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр, ус ашигласны төлбөр, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АМГ	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, БХГ-ний дагуу тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал, БХГ-нд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр, БХГ-ний дагуу ЗГ-т ногдох газрын тосны орлого, Рояльти
БОАЖЯ	Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн орлогын 50%
ХХҮЕГ	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
НДЕГ	Аж ахуйн нэгжээс төлсөн ажилчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл
Бусад төрийн байгууллагууд	Хандив, дэмжлэг хүлээн авсан төрийн байгууллагуудад

3.4.1.2 Гол орлогын урсгалууд (ША 4.1б)

Кэй Пи Эм Жи нь 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр МОУИТБС-аас ЗГ-ын тайлан болон компанийн тайлан гэсэн 2 төрлийн тайланг хүлээн авсан. ЗГ-ын тайланг төрийн байгууллагуудаас ирүүлсэн маягтуудыг хураангуйлсан өгөгдлийн сангаас МОУИТБС-ын Ажлын Алба татаж авсан. Компанийн тайланг ирүүлсэн маягтуудыг нэгтгэсэн өгөгдлийн сангаас МОУИТБС-ын Ажлын Алба татаж авсан.

ЗГ-ын тайланд 2,079 компани хамрагдсан бол компанийн тайланд зөвхөн 1,113 компани хамрагдсан. Хоёр тайлан нь заавал тайлагнах үндсэн 44 гол орлогын урсгал, мөн сайн дураар тайлагнах 19 орлогын урсгалыг хамруулсан. Эдгээр үндсэн 44 орлогын урсгалаас (заавал тайлагнах) 13-ыг нь орон нутгийн төрийн байгууллагууд тайлагнасан.

Материаллаг байдлын түвшинг тодорхойлох, зайлшгүй нэгтгэгдэх орлогын урсгалын босгыг тогтооход ЗГ-ын тайланг ашиглах нь иж бүрэн байдлын хувьд илүү тохиромжтой байсан ба доорх хүснэгтээр дэлгэрэнгүйг харуулав:

Тайлан	Компанийн тоо	Заавал нэгтгэх орлогын урсгал		Нийт орлогын урсгал
		Тоо	(Сая төгрөг)	(Сая төгрөг)
Төрийн байгууллагын тайлан	2 079	44	1 214 670	1 222 010
Компанийн тайлан	1 113	44	1 092 223	1 098 957
Улсын хэмжээний орлогын урсгалууд		31		
Орон нутгийн орлогын урсгалууд		13		
Нийт		44		

Кэй Пи Эм Жи нь тайлангийн 3.3.2 хэсэгт дурдсан материаллаг байдлын босгыг тогтоохдоо ЗГ-ын тайлангийн мэдээг ашигласан ба уг тайланд заавал тайлагнах 44 гол орлогын урсгал бүхий 1,167 тэрбум төгрөгийн орлого багтсан.

Улсын хэмжээний 31 гол орлогын урсгал, орон нутгийн 13 гол орлогын урсгал байна. Улсын хэмжээний болон орон нутгийн орлогын урсгалуудын жагсаалтыг Хавсралт 3-с харна уу.

3.4.1.3 Материаллаг орлогын урсгалууд (ША 4.16)

Тайлангийн 3.3.2 хэсэгт тодорхойлсон аргыг ашиглан дараах орлогын урсгалуудыг нэг бүрчлэн нэгтгэж нэгтгэлд оруулахаар сонгосон.

#	Босгын түвшин	Орлогын урсгал	Эх сурвалж
1	Улс	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	ЗГ болон компани
2	Улс	Гаалийн албан татвар	ЗГ болон компани
3	Улс	Нэмэгдсэн өртгийн албан татвар	ЗГ болон компани
4	Улс	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	ЗГ болон компани
5	Улс	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	ЗГ болон компани
6	Улс	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	ЗГ болон компани
7	Улс	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	ЗГ болон компани
8	Улс	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	ЗГ болон компани
9	Улс	Агаарын бохирдлын төлбөр	ЗГ болон компани
10	Улс	Аж ахуйн нэгжээс төлсөн ажилчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	ЗГ болон компани
11	Улс	Гаалийн үйлчилгээний хураамж	ЗГ болон компани
12	Улс	БХГ-ний дагуу тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	ЗГ болон компани
13	Улс	БХГ-нд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	ЗГ болон компани
14	Улс	БХГ-ний дагуу ЗГ-т ногдох газрын тосны орлого	Компани
15	Улс	Рояльти	ЗГ болон компани
16	Улс	БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	ЗГ болон компани
17	Улс	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	Компани
18	Орон нутаг	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	ЗГ болон компани
19	Орон нутаг	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	ЗГ болон компани
20	Орон нутаг	Газрын төлбөр	ЗГ болон компани
21	Орон нутаг	Ус ашигласны төлбөр	ЗГ болон компани
22	Орон нутаг	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	ЗГ болон компани
23	Орон нутаг	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	Компани
24	Орон нутаг	БХГ-ний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	ЗГ
25	Орон нутаг	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	ЗГ болон компани
26	Орон нутаг	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	Компани

3.4.2 Компаниуд

3.4.2.1 Нэгтгэлд хамрагдах компаниуд

Давхардсан компаниудыг хассаны дараа 2016 оны нэгтгэлд нийт 213 компанийг нэг бүрчлэн нэгтгэхээр сонгосон. Нэгтгэлд хамрагдахаар сонгогдсон компаниудын дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзнэ үү.

4 Нэгтгэлийн үр дүн

4.1 Нэгтгэлийн үр дүн

4.1.1 Нэгтгэл болон зөрүүний хураангуй

Нэгтгэлийн үр дүнгийн хураангуйг доор үзүүлэв:

Тайлан гаргагч:	Компанийн тоо	Сонгогдсон гол орлогын урсгалууд (сая төгрөгөөр)		
		Улсын хэмжээнд	Орон нутгийн хэмжээнд	Нийт
Анхны тайлан				
ЗГ-ын байгууллага	213	1,125,545	41,578	1,167,123
Компани	173	968,583	93,264	1,061,847
Анхны нэгтгэлийн зөрүү	40	156,962	(51,686)	105,276
Нэгтгэл				
ЗГ-ын залруулга		(129,281)	48,306	(80,975)
Компанийн залруулга		12,184	(2,700)	9,484
ЗГ-ын тайлан залруулгын дараа		996,264	89,884	1,086,148
Компанийн тайлан залруулгын дараа		980,767	90,564	1,071,331
Нэгтгэлийн зөрүү (нэгтгэлийн маягт ирүүлэхээс татгалзсан компаниудыг оруулаад)		15,497	(680)	14,817
Хасах нь: нэгтгэлийн залруулгын маягт ирүүлээгүй компанийн дүн		(2,232)	37	(2,195)
Хасах нь: нэгтгэлийн залруулгын маягт ирүүлээгүй ЗГ-ын нэгжүүдийн дүн		(12,548)	-	(12,548)
Эцсийн нэгтгэгдээгүй цэвэр зөрүү		717	(643)	74

Цэвэр зөрүү болох 74 сая төгрөг нь анх ЗГ-ын тайлагнасан сонгосон гол орлогын урсгалын (1,167,123 сая төгрөг) 0.006% байна. Компанийн болон төрийн байгууллагын мэдээллийн нэгтгэлийн зөрүү дараах үндсэн шалтгаануудаас үүдэлтэй:

- Компани нь МОҮИТБС-ын Ажлын Албаны цахим тайланд тайлангаа ирүүлээгүй;
- Компаниуд төлбөрөө хэтрүүлэн мэдээлсэн;
- Төлбөрийг буруу төлбөрийн ангилалд мэдээлсэн;
- Буцаагдсан төлбөрүүдийг компанийн тайланд тохируулаагүй;
- Төлбөрүүд нь өөр компанийн өмнөөс хийгдсэн;
- ОҮ-ээс бусад үйл ажиллагаатай холбогдсон төлбөрүүдийг тайлагнасан (жишээ нь, барилга);
- Төлбөрүүд цэвэр дүнгээр бичигдсэн;
- ЗГ-ын тайланд орсон компаниуд нь 2016 онд олборлох үйл ажиллагаа явуулаагүй;
- Анхны тайлангийн маягтад мянгачилсан оронгоор тайлагнах байсан ч зарим ЗГ-ын байгууллагууд нэгж төгрөгөөр тайлагнасан;
- Компани өмнөх жилийн төлсөн төлбөрийг энэ жилийн тайланд оруулсан.

4.1.2 Нэгтгэлийн хамрах хүрээ (ША 4.9)

Кэй Пи Эм Жи нь улсын болон орон нутгийн хэмжээнд 213 компанийн тайланд нэг бүрчлэн нэгтгэл хийсэн. Эхлэлтийн семинарын үеэр ОТАХ-тэй гол орлогын урсгалын 98.6%-ийг хамруулахаар тохиролцсон. Үүнд, нэг бүрчлэн нэгтгэлд хамрагдах Бүлэг 1-ийн компаниуд болон эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгогдсон Бүлэг 2-ын компаниуд орсон. Энэ тохиролцсон арга зүйгээр компаниудад тавигдсан материаллаг байдлын босгын талаарх дэлгэрэнгүйг 3.3.1.1 (нэг бүрчлэн нэгтгэсэн) болон 3.3.1.2 хэсгүүдээс (түүвэрлэн нэгтгэсэн) үзнэ үү.

Улсын хэмжээний гол орлогын урсгалын хамрах хүрээ:

Улсын хэмжээнд			Гол орлогын урсгалын хамрах хүрээ	
Нэгтгэлийн төрөл	Босго (Төгрөг)	Компанийн тоо	Хувь	Сая төгрөг
Нэг бүрчлэн нэгтгэх	250 сая болон түүнээс дээш	128	96.32%	1,123,696
Түүвэрлэн нэгтгэх	50 саяас 250 сая хүртэлх	255	2.50%	29,177
Нийт		383	98.82%	1,152,873

Орон нутгийн гол орлогын урсгалын хамрах хүрээ:

Орон нутгийн хэмжээнд			Гол орлогын урсгалын хамрах хүрээ	
Нэгтгэлийн төрөл	Босго (Төгрөг)	Компанийн тоо	Хувь	Сая төгрөг
Нэг бүрчлэн нэгтгэх	100 сая болон түүнээс дээш	43	92.59%	49,588
Түүвэрлэн нэгтгэх	30 саяас 100 сая хүртэлх	39	3.70%	2,488
Нийт		82	96.29%	52,076

4.1.2.1 Улсын болон орон нутгийн хэмжээний давхардсан хэсэг:

Түүвэрлэлтэд улсын болон орон нутгийн хэмжээнд хэд хэдэн компаниуд давхардан орсон тул хэдийгээр улсын хэмжээнд 383 компани, орон нутгийн хэмжээнд 82 компани сонгогдсон ч давхардсан компаниудыг хасаад нийт 321 компани нэгтгэлд хамрагдсан. Энэ арга барил болоод үүнээс гарсан нийт компаниудыг доор хураангуйлан үзүүлж байна:

Нэгтгэлд авч үзсэн нийт компанийн тоо		
Төрөл	Авч үзсэн	Нэгтгэсэн
Улсын хэмжээнд		
Нэг бүрчлэн нэгтгэх (Бүлэг 1)	128	128
Түүвэрлэн нэгтгэх (Бүлэг 2)	255	67
Дэд дүн	383	195
Орон нутгийн хэмжээнд		
Нэг бүрчлэн нэгтгэх (Бүлэг 1)	43	43
Түүвэрлэн нэгтгэх (Бүлэг 2)	39	13
Дэд дүн	82	56
Хасах нь: давхардсан компанийн тоо	(144)	(38)
Бүлэг 1, 2-т авч үзсэн компанийн тоо	321	213

Эрсдэлд суурилан түүвэрлэх Бүлэг 2-ын хүрээнд бид улсын хэмжээний 255 компани, орон нутгийн хэмжээний 39 компанийг авч үзэн, эдгээрээс эрсдэлд суурилсан түүвэрлэлт хийсэн.

4.1.2.2 Улсын хэмжээний нэгтгэлийн үр дүн - орлогын урсгалаар:

Сая төгрөгөөр

#	Орлогын урсгалууд	Анхны зөрүү			Залруулга		Залруулгын дараа			Мэдээлэл ирүүлэггүй компаниудын зөрүү	Мэдээлэл ирүүлэггүй ЗГ-ын нэгжүүдийн зөрүү	Залруулга хийгээгүй цэвэр зөрүү
		ЗГ	Компаниуд	Зөрүү	ЗГ	Компаниуд	ЗГ	Компаниуд	Зөрүү			
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	224,919	226,488	(1,569)	3,849	2,322	228,768	228,810	(42)	10	-	(32)
2	Гаалийн албан татвар	41,879	54,181	(12,302)	(9,426)	(2,537)	32,453	51,644	(19,191)	(12)	(19,191)	(12)
3	Нэмэгдсэн өртгийн албан татвар	162,574	96,683	65,891	(44,545)	3,185	118,029	99,868	18,161	(9)	25,894	(7,742)
4	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	65,564	1,299	64,265	(63,453)	15	2,111	1,314	797	-	-	797
5	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	266,222	239,885	26,337	(30,296)	(4,869)	235,926	235,016	910	(917)	-	(7)
6	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	16,211	10,250	5,961	(1,418)	3,803	14,793	14,053	740	(923)	-	(183)
7	Гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөр	4,984	9,022	(4,038)	2,800	(1,232)	7,784	7,790	(6)	-	-	(6)
8	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	1,149	470	679	-	181	1,149	651	498	(76)	-	422
9	Агаарын бохирдлын төлбөр	17,679	17,671	8	5	13	17,684	17,684	-	-	-	-
10	Аж ахуйн нэгжээс төлсөн ажилчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	138,897	122,557	16,340	(7,276)	8,976	131,621	131,533	88	(81)	-	7
11	Гаалийн үйлчилгээний хураамж	48,436	40,694	7,742	(31)	1,865	48,405	42,559	5,846	-	5,845	1
12	БХГ-ний дагуу тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	994	595	399	-	240	994	835	159	(159)	-	-
13	БХГ-нд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	2,050	1,772	278	-	359	2,050	2,131	(81)	(67)	-	(148)
14	БХГ-ний дагуу ЗГ-т ногдох газрын тосны орлого	263	126,105	(125,842)	133,435	-	133,698	126,105	7,593	-	-	7,593

#	Орлогын урсгалууд	Анхны зөрүү			Залруулга		Залруулгын дараа			Мэдээлэл ирүүлээгүй компаниудын зөрүү	Мэдээлэл ирүүлээгүй ЗГ-ын нэгжүүдийн зөрүү	Залруулга хийгээгүй цэвэр зөрүү
		ЗГ	Компаниуд	Зөрүү	ЗГ	Компаниуд	ЗГ	Компаниуд	Зөрүү			
15	Рояльти	133,698	20,116	113,582	(113,100)	-	20,598	20,116	482	-	-	482
16	БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	-	623	(623)	-	(166)	-	457	(457)	2	-	(455)
17	Төрийн байгууллагад өгсөн хандив дэмжлэг	26	172	(146)	175	29	201	201	-	-	-	-
Нийт		1,125,545	968,583	156,962	(129,281)	12,184	996,264	980,767	15,497	(2,232)	(12,548)	717

4.1.2.3 Орон нутгийн хэмжээний нэгтгэлийн үр дүн – орлогын урсгалаар

Сая төгрөгөөр

#	Орлогын урсгалууд	Анхны зөрүү			Залруулга		Залруулгын дараа			Мэдээлэл ирүүлээгүй компаниудын зөрүү	Залруулга хийгээгүй цэвэр зөрүү
		ЗГ	Компаниуд	Зөрүү	ЗГ	Компаниуд	ЗГ	Компаниуд	Зөрүү		
1	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	7,490	18,415	(10,925)	11,417	502	18,907	18,917	(10)	-	(10)
2	Авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	317	1,381	(1,064)	1,093	59	1,410	1,440	(30)	(1)	(29)
3	Газрын төлбөр	8,758	14,068	(5,310)	3,499	(1,802)	12,257	12,266	(9)	(1)	(8)
4	Ус ашигласны төлбөр	19,980	35,543	(15,563)	16,607	1,052	36,587	36,595	(8)	(2)	(6)
5	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	3,309	2,833	476	(2,570)	(2,035)	739	798	(59)	(28)	(31)
6	Гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөр	1	1,935	(1,934)	416	(1,568)	417	367	50	-	50
7	БХГ-ний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	690	166	524	394	813	1,084	979	105	-	105
8	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	43	472	(429)	57	(319)	100	153	(53)	(2)	(51)
9	Төрийн байгуулагад өгсөн хандив дэмжлэг	990	18,451	(17,461)	17,393	598	18,383	19,049	(666)	(3)	(663)
Нийт		41,578	93,264	(51,686)	48,306	(2,700)	89,884	90,564	(680)	37	(643)

4.1.3 Өгсөн мэдээллийн иж бүрэн болон найдвартай байдал (ША 4.9б)

Кэй Пи Эм Жи компаниуд болон ЗГ-ын Excel дээрх хянагдсан тайланг Ажлын Албанаас дахин хүлээн авсны дараа нэгтгэлийн зарим дүнгүүдийг МОҮИТБС-ын цахим тайлангийн систем дэх эх мэдээлэлтэй таарч байгаа эсэхийг тогтоох зорилгоор түүвэрлэн тулгаж шалгасан. Түүвэрлэсэн дүнгүүдийн хувьд зөрүү илрүүлээгүй болно.

Кэй Пи Эм Жи нь өгөгдсөн мэдээллийн иж бүрэн болон найдвартай байдлыг шалгах үүднээс төлөөллийн захидал болон баталгаажуулалтын тайланг хүсэх, компаниудын аудитын тайлангуудыг хянах зэрэг нэмэлт ажлуудыг хийсэн ба дэлгэрэнгүйг тайлангийн 3.3.4.1 хэсгээс харна уу.

4.2 Шийдвэрлэгдээгүй зөрүү ба тайлагнаагүй компаниуд (ША 4.9)

Компанийн болон төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэсний эцэст зарим нэг дүнгүүдийн зөрүү шийдвэрлэгдээгүй үлдсэн. Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүний нийт дүн нь 14,817 сая төгрөг ба энэ нь сонгогдсон гол орлогын урсгалуудын 1.3%-ийг эзэлж байна. Нэгтгэлийн дараах ЗГ-ын дүн нь нэгтгэлийн дараах компанийн дүнгээс 14,817 сая төгрөгөөр их байсан.

Энэ зөрүүнд нэгтгэлийн залруулгын маягтад компаниуд хариу өгөөгүйгээс нэгтгэж чадаагүй дүн орсон болно. 14,743 сая төгрөг нь нэгтгэлийн залруулгын маягтад хариу ирүүлээгүй компаниудаас үүдэлтэй.

Эдгээр компаниудаас шалтгаалсан зөрүүнүүдийг хасвал үлдсэн шийдвэрлээгүй зөрүү **74 сая төгрөг** байна. Нэгтгэлийн залруулгын маягтад хариу ирүүлээгүй компаниудын дүнг хасахад нэгтгэлийн дараах ЗГ-ын цэвэр дүн нь нэгтгэлийн дараах компанийн цэвэр дүнгээс 74 сая төгрөгөөр их байна.

4.2.1 Шийдвэрлэгдээгүй зөрүү – сонгогдсон гол орлогын урсгалаар:

Тайлангийн энэ хэсэгт нэгтгэлийн явцад анхны зөрүүнд тохируулга хийгдсэнээс хойших шийдвэрлэгдээгүй зөрүүг сонгогдсон гол орлогын урсгалаар харууллаа.

		<i>Сая төгрөг</i>		
Сонгогдсон гол орлогын урсгалууд		Анхны зөрүү	Залруулга	Шийдвэрлэгдээгүй зөрүү
Улсын	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	(1,569)	1,527	(42)
	Гаалийн албан татвар	(12,302)	(6,889)	(19,191)
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	65,891	(47,730)	18,161
	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	64,265	(63,468)	797
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	26,337	(25,427)	910
	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	5,961	(5,221)	740
	Гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөр	(4,038)	4,032	(6)
	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	679	(181)	498
	Агаарын бохирдлын төлбөр	8	(8)	-
	Аж ахуйн нэгжээс төлсөн ажилчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	16,340	(16,252)	88
	Гаалийн үйлчилгээний хураамж	7,742	(1,896)	5,846
	БХГ-ний дагуу тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	399	(240)	159
	БХГ-нд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	278	(359)	(81)
	БХГ-ний дагуу ЗГ-т ногдох газрын тосны орлого	(125,842)	133,435	7,593
	Роялти	113,582	(113,099)	483
	БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	(623)	166	(457)
	Төрийн байгууллагад өгсөн хандив дэмжлэг	(145)	145	-
Орон нутгийн	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	(10,925)	10,915	(10)
	Авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	(1,064)	1,034	(30)
	Газрын төлбөр	(5,310)	5,301	(9)
	Ус ашигласны төлбөр	(15,563)	15,555	(8)
	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	476	(534)	(58)
	Гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөр	(1,934)	1,983	49

Сонгогдсон гол орлогын урсгалууд		Анхны зөрүү	Залруулга	Шийдвэрлэгдээгүй зөрүү
	БХГ-ний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	524	(419)	105
	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	(429)	376	(53)
	Төрийн байгуулагад өгсөн хандив дэмжлэг	(17,462)	16,795	(667)
	Нийт	105,276	(90,459)	14,817
	Хасах нь: Нэгтгэлийн залруулгын маягтаа ирүүлээгүй компанийн дүн*	(2,250)	55	(2,195)
	Хасах нь: Нэгтгэлийн залруулгын маягтаа ирүүлээгүй ЗГ-ын нэгжүүдийн зөрүү дүн	(59,707)	47,159	(12,548)
	Хасалтын дараах цэвэр зөрүү	43,319	(43,245)	74

* ЗГ-ын тайлангаас тайлагнаагүй компаниудын дүнг хасав.

Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн гол шалтгаанууд:

- ЗГ болон компаниудын тайлагнасан мөнгөн бус хандив дэмжлэгийн зөрүү нь уг хандив дэмжлэгийг мөнгөн дүн рүү шилжүүлэн тооцох аргачлалын зөрүүнээс үүдэлтэй ба улмаар нэгтгэлийн үр дүнд нөлөөлж, компани болон ЗГ-ын дүнгүүд нэгтгэгдэхгүй болох шалтгаан болж байна;
- Одоогоор МОҮИТБС-д тайлагнах хууль, эрх зүйн шаардлага байхгүй гэх шалтгаанаар компаниуд тайлангаа гаргаагүй эсвэл нэмэлт тодруулга өгөхөөс тагталзсан;
- Аймаг, дүүргүүдээс ЗГ-ын мэдээллийг олон дахин хүссэн ч нэгтгэл хийхэд хангалттай нарийвчлалтайгаар ирээгүй.

Компаниудаас хүлээн авсан хариу мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс, мөн ЗГ-аас хүлээн авсан хариу мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас харна уу.

4.2.2 Тайлагнаагүй байгууллагууд

4.2.2.1 Тайлагнаагүй засгийн газрын агентлагууд

Доор жагсаалт нь МОҮИТБС-д анхны байдлаар тайлагнаагүй эсвэл дараа нь хараат бус хянагч-нэгтгэгчид тайлагнаагүй засгийн газрын агентлагууд болно.

№	Засгийн газрын агентлаг	Тайлагналын явц
1	Гаалийн Ерөнхий Газар	Хараат бус хянагч-нэгтгэгчид нарийвчлан тайлагнаагүй
2	Байгаль Орчин, Аялал Зуучлалын Яам	МОҮИТБС-д анхны байдлаар тайлагнаагүй болон хараат бус хянагч-нэгтгэгчид нарийвчлан тайлагнаагүй

Тайлбар: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн албан бичигт банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17.4 зүйлд банк нь гүйлгээ хийсэн дансны хуулгыг данс эзэмшигчийн хүсэлтээр данс эзэмшигчид өгнө гэж заасан байгаа тул компаниудын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50%-н хэмжээний мэдээллийг гуравдагч этгээдэд өгөх боломжгүй гэж мэдэгдсэн.

Засгийн газрын агентлагуудаас хүлээн авсан хариу мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас харна уу.

4.2.2.2 Тайлагнаагүй компаниуд

Доор жагсаасан компаниуд нь нэгтгэлд багтсан боловч МОУИТБС-д анхны байдлаар тайлагнаагүй бөгөөд хожим нь хараат бус хянагч-нэгтгэгчид тайлагнаагүй компаниуд болно.

Сая төгрөг

#	Улсын бүртгэлийн дугаар	Компанийн нэр	ЗГ-ын хүлээн авсан гол орлогын урсгалын хэмжээ
1	2059681	Хандгайтгол ХХК	1
2	2863847	Анхай-Интернэшнл ХХК	974
3	5132053	Бэрх Ресорсиз ХХК	310
4	5210402	Ган-Илч ХХК	318
5	5586119	Эйкүсора ХХК	264
6	2562219	Бум-Арвай-Инвест ХХК	1
7	2672731	Тэсийн хурд ХХК	16
8	25000000	Монголиа шин ий Энержи ХХК	302
Нийт			2,186

* Төлбөрөө тайлагнаагүй компаниудын сонгогдсон гол орлогын урсгалын мэдээллийг ЗГ-ын тайлангаас авав.

Дээр дурьдсан компаниудын зарим нь бидний горим гүйцэтгэх өдрөөр татан буугдсан, эсвэл холбоо барих мэдээлэл олдоогүйгээс холбогдож чадаагүй компаниуд болно.

Компаниудаас хүлээн авсан хариу мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс харна уу.

МОУИТБС-ын Ажлын алба нь МХЕГ-аас хуулиар (“Ашигт малтмалын тухай” хуулийн 48 дугаар зүйлийн 48.10 дахь заалт) хүлээсэн тайлагнах үүргээ биелүүлээгүй аж ахуй нэгжүүдэд “Зөрчлийн тухай” хуулийн 7.11 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох арга хэмжээ авахыг хүссэн байна.

4.2.3 Асуудал, бэрхшээлүүд болон шийдвэрлэх аргууд

Энэ хэсэгт шийдвэрлэгдээгүй асуудлууд, ажлын явцад тулгарсан саад бэрхшээлүүд болон эдгээрийн багасгахаар авсан арга хэмжээг нэгтгэн харуулав. Энэ тал дээр өгсөн зөвлөмжүүдийг тайлангийн 6 хэсгээс харна уу.

4.2.3.1 МОУИТБС-ын Ажлын Албанд төлбөрийн мэдээг тайлагнахад өгөх удирдамж

Зарим байгууллагууд ОУИТБС-ын тайлагналын үйл явц болон анхан шатны цахим тайлагналын маягтуудын зарим орлогын урсгалуудад юуг тайлагнах шаардлагатай талаар тодорхой ойлголтгүй байдаг болохыг Кэй Пи Эм Жи ажигласан. Үүнээс шалтгаалан ЗГ болон зарим компаниудын тайлангийн хооронд их хэмжээний зөрүү үүсч байсан. Түүнчлэн, зарим компаниуд ижил шалтгааны улмаас МОУИТБС-д тайлагнадаггүй гэдгээ бидэнд мэдэгдсэн.

Нэгтгэлд сонгогдсон компаниуд руу нэмэлт мэдээллийн маягтуудыг хүргүүлсний дараагаар Кэй Пи Эм Жи нь яагаад нэмэлт мэдээлэл авах хүсэлтэй байгааг тодруулах олон тооны дуудлага хүлээн авсан. Кэй Пи Эм Жи нь нэмэлт мэдээллийн маягтуудыг хэрхэн бөглөх талаар дэлгэрэнгүй зааварчилгааг компаниудад өгсөн бөгөөд энэхүү ажил нь цаг хугацаа, хүчин чармайлт их шаардсан ажил болсон.

4.2.3.2 ОУ-ийн компаниудад ОУИТБС-ын тайлангийн ач холбогдлыг онцлох нь

Нэлээд ОУ-ийн компаниуд ОУИТБС-ын тайлангийн ач холбогдол, ОУИТБС-ын стандартын шаардлага болон Хараат бус хянагч-нэгтгэгчид мэдээлэл яагаад өгөх ёстой талаар сайн ойлголтгүй байгаа нь ажиглагдсан. 2016 онд 966 гаруй компани тайлангаа МОУИТБС-ын Ажлын Албанд ирүүлээгүй байна. Нэгтгэлийн эхэнд зарим компаниуд бидний хүсэлт гаргасан мэдээллийг өгөхөөс татгалзаж байсан ба ОУИТБС-ын стандартын шаардлагууд, ОУИТБС-ын тайлангийн ач холбогдол болон нэгтгэлийн үйл ажиллагааны зорилгыг тайлбарласны дараагаар татгалзсан компаниудын тоо эрс буурсан.

Нийт нэгтгэлд оролцсон 213 компаниас:

- 8 компани анхны тайлан болон хожим нь бидний нэгтгэлийн залруулгын маягтад хариу өгөөгүй;
- 5 компани анхны тайлангаа гаргасан боловч нэмэлтээр нэгтгэлийн залруулгын маягтад хариу өгөөгүй;
- 16 компани нэмэлт үндсэн мэдээллийн маягтад хариу ирүүлээгүй боловч нэгтгэлийн залруулгын маягтад хариу өгсөн.

Энэхүү хэсэгт бид мөн ихээхэн хэмжээний хүчин чармайлт гаргасан. 4.2.3.3 дугаар хэсэгт дурдсан асуудлуудтай ижлээр, нэгтгэлийн үйл явц нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хэмжээний цаг хугацаа, нөөц хүчийг шаардсан.

4.2.3.3 Олборлолтын үйл ажиллагаатай холбоотой төлбөрийг ялгах

Дараах үндсэн шалтгаануудын улмаас зарим ЗГ-ын тайлангийн дүн компанийн дүнгээс өндөр гарсан байна:

- ЗГ-ын тайлан нь 2016 онд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй ч ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй бүхий л компаниудын мэдээллийг багтаасан байсан. Харин ийм үйл ажиллагаа явуулаагүй компаниуд МОУИТБС-д тайлангаа ирүүлээгүй байсан.
- ЗГ-ын зүгээс компанийг ОУ-ийн компани (ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй) гэж ангилсан бол тухайн компанийн үндсэн үйл ажиллагаа нь олборлолт биш байсан ч тус компанийн бүхий л орлого ЗГ-ын тайланд багтсан байдаг. Тиймээс ОУ-ийн салбарын үйл ажиллагаатай холбоогүй орлогууд ч багтсан байх боломжтой юм.
- Анхны тайлангийн маягтад мянгачилсан оронгоор тайлагнах байсан ч зарим ЗГ-ын байгууллагууд тайлангаа нэгж төгрөгөөр гаргасан байсан.

Дээрх 3 хүчин зүйл нь ЗГ болон компанийн тайлангийн анхан шатны харьцуулалтын явцад их хэмжээний зөрүүг бий болгож байсан. Зөрүүг нэгтгэхийн тулд Кэй Пи Эм Жи нэгтгэлд сонгогдсон компаниуд болон холбогдох төрийн байгууллагуудад нэгтгэлийн залруулгын маягт явуулсан.

4.2.4 Гүйцэтгэсэн ажилд тавигдах хязгаарлалтууд

Кэй Пи Эм Жи нь 2016 оны нэгтгэлийн тайлантай холбоотойгоор компаниудаас 2016 оны аудитын болон санхүүгийн тайлангийн хуулбар, мөн хараат бус хянагч нэгтгэгчийн боловсруулсан загварын дагуу гарын үсэг зурж баталгаажуулсан төлөөллийн захидлыг ирүүлэх хүсэлт гаргасан.

Нэгтгэлд сонгогдсон 213 компаниас 146 компани нь аудитын болон санхүүгийн тайлангийн хуулбараа ирүүлсэн бол 166 компани нь зөрчилгүй төлөөллийн захидал ирүүлсэн. Монгол Улсад компаниудад ОУИТБС-ын зорилгоор БГАОУС 3000-ын дагуу баталгаажуулалтын тайлан гаргуулах эсвэл ОУИТБС-ийн үйл явцад оролцох ямар нэгэн хуулийн шаардлага байдаггүй. Гэхдээ нэг компани ОУИТБС-д тайлагнасан дүнгээ нотлох тохиролцсон горимуудыг гүйцэтгэсэн гэрээт ажлын тайланг ирүүлсэн.

Компаниудаас хүлээн авсан хариунуудын дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс харна уу.

2017 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Эхлэлтийн Семинарын үеэр СЯ төрийн байгууллагуудын ирүүлсэн мэдээллийг МОУИТБС-ын цахим тайлагналын системээр тайлагнаж байгаатай холбогдуулан нарийвчлан шалгах цаг хугацааны боломжгүй байгааг илэрхийлсэн. Гэсэн хэдий ч, СЯ-ны төрийн нарийн бичгийн дарга ямар нэгэн тусгай баталгаажуулалт, төлөөлөлгүйгээр нэгдсэн мэдээлэл дээр гарын үсэг зурж баталгаажуулсан.

Кэй Пи Эм Жи нь нэмэлт мэдээллийн маягтад орсон мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг баталгаажуулсан төлөөллийн захидлыг холбогдох төрийн байгууллагын дарга нараар гарын үсэг зуруулан баталгаажуулж авах хүсэлт гаргасан. Уг төлөөллийн захидлыг 8 дүүргийн 3 дүүрэг, 21 аймгаас 13 аймаг ирүүлсэн. Төрийн байгууллагуудаас хүлээн авсан хариунуудын дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас харна уу. Түүнчлэн, Кэй Пи Эм Жи нь мөн СЯ-аас МОУИТБС-ын Ажлын Албанд анх тайлагнасан мэдээллийн үнэн

зөв бүрэн бүтэн байдлыг баталгаажуулсан төлөөллийн захидлаар хангахыг хүссэн боловч СЯ нь тайлагнасан орлогын урсгалуудад нарийвчилсан хяналт тавьдаггүй учир төлөөллийн захидал ирүүлэх боломжгүй гэсэн хариу өгсөн.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, хөндлөнгийн аудит

Кэй Пи Эм Жи нь нэгтгэлд хамрагдсан компаниудад 2016 оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангаа түүнд өгсөн аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх хүсэлт тавьсан. Нэгтгэлд хамрагдсан нийт 213 компаниас 146 компани нь санхүүгийн болон аудитын тайланг хүргүүлсэн.

Нийт 146 компаниас 4 компанийн дүгнэлт хязгаарлалттай байсан ба нийт компанийн 97-оос дээш хувь нь хязгаарлалтгүй дүгнэлттэй байна.

Хязгаарлалттай аудитын дүгнэлтийн нэгтгэлийн дүнд нөлөөлж болохуйц үр дүнг бид харгалзан үзсэн.



4.3.1 Нийт компаниудын аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн олон нийтэд нээлттэй эх сурвалж, хэрэв тохиромжтой бол (ША 4.9а)

Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй гаргадаг компаниудын цахим хуудсын лавлагааг Хавсралт 13-аас харна уу.

5 Монгол Улс дахь олборлох үйлдвэрлэлийн салбар

5.1 Олборлох үйлдвэрлэлийн тойм мэдээлэл

5.1.1 Олборлох үйлдвэрлэлийн Монгол Улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр¹ (ША 6.3)

5.1.1.1 ОУ-ийн хэмжээ (ША 6.3а)

ОУ нь Монгол Улсын эдийн засгийн томоохон хэсгийг бүрдүүлдэг салбар бөгөөд 2016 онд ОУ-ийн ДНБ-д эзлэх хувь 20% байсан. 2016 онд Монгол Улсын ДНБ-ний бодит өсөлт 1%-д хүрсэн нь 2015 оны 2.4%-ийн бодит өсөлттэй харьцуулахад буурсан үзүүлэлт юм. ОУ-ийн ДНБ-д оруулж буй хувь нэмэр бусад салбартай харьцуулахад хамгийн өндөр байгаа ба хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, мөн барилга ба үл хөдлөх хөрөнгийн салбарууд удаалж байна. 2016 онд ОУ 21 хувиар өссөн нь ихэвчлэн нүүрсний үйлдвэрлэл болон экспортын өсөлтөөс шалтгаалсан байна. Тус салбарын албан бус үйл ажиллагааны талаар 5.1.1.5 дугаар хэсгээс үзнэ үү.

Монгол Улсын хэмжээнд салбарын албан бус үйл ажиллагааны талаарх мэдээллийн албан ёсны эх сурвалж байхгүй боловч ОУ-ийн салбарт нийт 60-70 мянган уурхайчид хувиараа ажиллаж байгаагийн 10 гаруй хувь нь ямар нэгэн байгууллагын дор үйл ажиллагаагаа явуулж байна гэсэн тоо мэдээ бий.

ОУ-ийн ДНБ-д оруулсан хувь нэмэр			
Тэрбум төгрөг	2014	2015	2016
Бусад салбарын ДНБ-д оруулсан хувь нэмэр (мөнгөн дүнгээр)	18,566	19,194	19,118
ОУ-ийн ДНБ-д оруулсан хувь нэмэр (мөнгөн дүнгээр)	3,661	3,956	4,768
ДНБ-д ОУ-ийн эзлэх хувь	16.5%	17.1%	20.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.1.1.2 2016 оны ОУ-ийн оруулсан орлогын хувь нэмэр (ША 6.3б)

2016 онд ОУ-ийн салбараас ЗГ нийт 1,086 тэрбум² төгрөгийн орлого хүлээн авсан ба энэ нь тухайн жилийн нийт орлогын 19%-ийг бүрдүүлж байна. 2016 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 257 тэрбум төгрөг, татвараас (үүнд, ААНОАТ, НӨАТ, Гаалийн албан татвар болон Орон нутгийн албан татвар багтана) 367 тэрбум төгрөгийн орлогыг тус тус хүлээн авсан байна. ОУ-ээс ЗГ-ын хүлээн авсан орлогын дийлэнх хэсгийг буюу 34%-ийг татвар бүрдүүлж байгаа бол 24%-ийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр бүрдүүлж байна. 2016 оны ЗГ-ын орлогын томоохон хэсгийг Эрдэнэт Үйлдвэр ХХК, Оюу Толгой ХХК-ууд бүрдүүлсэн байна. Дараах хүснэгтэд 2016 онд ОУ-ийн оруулсан хувь нэмрийг харуулав.

¹ Тэмдэглэл: Олборлох үйлдвэрлэлийн эдийн засагт оруулсан хувь нэмэрт Монгол Улс дахь БУУ-н үйл ажиллагааг оруулаагүй болно. БУУ-н салбарын тойм мэдээллийг 5.1.1.5 хэсгээс харна уу.

² Тэмдэглэл: Энд тайлагнасан Монгол Улсын ЗГ-ын нийт орлогын мэдээлэл нь Сангийн Яамны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй тавигдсан мэдээлэл болно. ЗГ-ын нийт орлого болон орлогын урсгалын хуваарилалт нь тайлангийн 3 болон 4 дүгээр хэсэгт дурьдсан нэгтгэлийн үйл явцын мэдээлэлд үндэслэгдсэн бөгөөд нэгтгэлийн зарлуулгаар зарлуулсан ЗГ-ын орлогыг илэрхийлнэ. Нэгтгэлийн үйл явцад хамрагдсан зарим компаниуд нь ОУ-ээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг болохыг анхаарна уу.

2016 онд олборлох үйлдвэрлэлээс ЗГ-ын нийт хүлээн авсан орлого

Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	
ЗГ-ийн нийт орлого*	5,852	
ОУ-ийн нийт орлого		18.6%
АМНАТ		4.4%
ААНОАТ		3.9%
Газрын тосны орлого		2.3%
ААН-ийн төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		2.2%
НӨАТ		2.0%
Гаалийн албан татвар, үйлчилгээний хураамж		1.4%
Бусад		2.3%

Тайлбар: *Засгийн Газрын нийт орлого нь 2016 онд хүлээн авсан буцалтгүй тусламжийг багтаасан.

5.1.1.3 ОУ-ийн экспорт (ША 6.3в)

2016 онд экспортын бүтээгдэхүүний үнэ болон ОУ-ийн экспорт нь өмнөх онтой харьцуулахад 5.3% болон 3.6% -аар тус тус өссөн байна. 2016 онд нүүрс болон мөнгөжөөгүй алтны үнэ цэнийн өсөлт нь экспортын 16%-ийг эзэлсэн бөгөөд энэ нь зэсийн хүдэр, баяжмалын экспортын 14%-ийн бууралтаас шалтгаалан хэсэгчлэн цэвэрлэгдсэн дүн юм. 2016 онд ОУ-ийн нийт экспортод эзлэх хувь 1.4%-аар буурсан нь хүнд, хөнгөн үйлдвэрлэл гэх мэт бусад салбаруудын эзлэх хувь 54.3% болж өссөнтэй холбоотой.

ОУ-ийн экспорт			
Сая ам.доллар	2014	2015	2016
ОУ-ийн экспорт	5,184	4,092	4,238
Бусад экспорт	590	577	678
Нийт экспортод ОУ-ийн эзлэх хувь	89.8%	87.6%	86.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ОУ-ийн экспортод ашигт малтмалуудын эзлэх ам доллараарх үнэ цэнэ



Эх сурвалж: Монгол Банк

Экспортын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 5.1.3.2 хэсгээс харна уу.

5.1.1.4 ОУ дэх хөдөлмөр эрхлэлт (ША 6.3г)

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2016 онд нийт 38.0 мянган хүн ОУ-ийн салбарт ажилласан байна. Үүнд БУУ-н мэдээлэл хамрагдаагүй болно. Хэдийгээр 2016 онд экспорт нэмэгдсэн ч ОУ-ийн ажиллагсдын тоо 43 мянгаас 38 мянга хүртэл 11.6%-аар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь ОУ-ийн компаниудын хайгуул, хөрөнгө оруулалт буурсан гэх мэт эдийн засаг голчилсон олон хүчин зүйлээс шалтгаалсан. Нийт ажил эрхэлж байгаа хүн амд ОУ-ийн салбарт ажил эрхэлж буй хүн амын эзлэх хувь 2016 онд 0.4% -аар буурч 2015 онтой харьцуулахад 3.7%-аас 3.3% болж буурсан байна.

ОУ-ийн хөдөлмөр эрхлэлт			
Мянган ажлын байр	2014	2015	2016
ОУ-ийн хөдөлмөр эрхлэлт	41	43	38
Бусад салбарын хөдөлмөр эрхлэлт	1,070	1,109	1,110
ОУ-ийн нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь	3.7%	3.7%	3.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хараат бус хянагч-нэгтгэгчийн илгээсэн нэмэлт мэдээллийн маягтад нийт 148 компани ажилчдынхаа статистикийн дэлгэрэнгүй мэдээллийг тайлагнасан. Уг мэдээлэлд дурьдсанаар одоогийн байдлаар олборлох үйлдвэрлэлийн салбарт нийт 26,410 ажилчид ажиллаж байгаагийн 24,481 нь монгол ажилчид, 1,929 нь гадаад ажилчид байна. Нийт 24,481 монгол ажилчдаас 16,910 нь тухайн сумын ажилчид байгаа бөгөөд 21,479 үндсэн ажилчид, 2,050 гэрээт ажилчид байна гэж мэдээлсэн. Компанийн ажилчдын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 13-с харна уу.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас тайлагнасан ОУ-д ажил эрхэлж буй нийт гадаад ажилчид:

ОУ-д ажиллаж буй гадаад ажилчид					
Байршил	2012	2013	2014	2015	2016
Архангай	33	53	-	-	6
Баян-Өлгий	33	176	37	70	38
Баянхонгор		50	4	27	15
Булган	19	1	1	-	-
Өвөрхангай	-	1	-	-	-
Говь-Алтай	46	90	21	3	-
Говь-Сүмбэр	6	16	2	-	6
Дархан-Уул	-	10	-	-	1
Дорноговь	828	1,514	820	533	546
Дорнод	2,066	2,348	2,254	1,879	1,020
Дундговь	29	35	46	87	16
Завхан	-	3	2	4	-
Өмнөговь	1,048	329	336	95	530
Орхон	6	-	-	-	-
Сүхбаатар	455	326	347	136	85
Сэлэнгэ	-	450	299	104	81
Төв	452	39	488	545	277
Увс	68	-	-	26	30
Хөвсгөл	9	-	-	4	-
Ховд	4	4	47	22	13
Хэнтий	-	50	86	61	29
Улаанбаатар					
Багануур	-	-	2	-	-
Багахангай	57	-	-	-	-
Баянгол	46	127	61	76	13

ОУ-д ажиллаж буй гадаад ажилчид					
Байршил	2012	2013	2014	2015	2016
Баянзүрх	47	110	43	112	21
Налайх	13	22	12	12	2
Сонгинохайрхан	3	1	1	1	1
Сүхбаатар	398	139	69	85	67
Хан-Уул	23	82	73	60	6
Чингэлтэй	5	52	3	3	18
Нийт	5,694	6,028	5,054	3,945	2,821

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

5.1.1.5 Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уул уурхай

Ерөнхий тойм

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу Бичил уул уурхай (БУУ) гэдэг нь өргөн утгаараа Монгол Улсын нутаг дэвсгэрт нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн (ихэвчлэн хууль бус) эрхэлж буй ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хэлнэ. БУУ-н үйл ажиллагааны улирлын шинж чанар, тогтворгүй байдал болон албан ёсны статистик мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан энэхүү тайланд БУУ-н салбарыг Монгол Улсын голлох олборлох салбарын тоймоос тусад нь авч үзсэн.

Монгол Улсад БУУ-н үйл ажиллагаа 1990-ээд оноос эрс ихэссэн, ядуурал, ажилгүйдэл болон цаг уурын хагуу ширүүн нөхцлөөс үүдэн олон айл өрхийн орлогын өөр нэг эх үүсвэр хэлбэрээр бий болсон гэж үздэг бөгөөд бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь “зуд” гэж нэрлэгддэг өвлийн хүнд хэцүү нөхцөлд малаа алдсан малчид байсан юм. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (ХААХОУС)-ийн хийсэн олон улсын хөдөө орон нутгийн ядуурлын судалгаанд мэдээлснээр Монгол Улс 1999 оноос 2001 онуудад жил дараалан үргэлжилсэн зудаар 7 сая орчим тоо толгой мал алдсанаас үүдэн хөдөө орон нутгийн иргэдийн орлогод асар их сөрөг нөлөө үзүүлсэн гэжээ.

Хууль, эрх зүй

Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулж байсан 2010 оны ЗГ-ын 308-р тогтоолыг өөрчилж 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр ЗГ-ын 151-р тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” – ийг баталсан. Энэхүү 151-р тогтоолд Монгол Улсад БУУ-н үйл ажиллагаанд оролцдог төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор байгууллага хоорондын бичил уурхайн зөвлөл байгуулах тухай дурьдсан. Түүнчлэн, уг тогтоолд аймгуудын засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхээр заасан. Тухайлбал, сумын засаг захиргаа нь БУУ-тай холбоотой үйл ажиллагааг тухайн жилийн тайландаа тусган өмнө нь үйлчилж байсан тогтоолын 3.10-д заасны дагуу төв захиргааны байгууллагад тайланг шууд илгээдэг байсан бол шинэ тогтоолд аймгийн засаг захиргаа нь сумын БУУ-н үйл ажиллааны тайланг нэгтгэн Геологи, Уул уурхайн салбарыг хариуцаж буй АМГТГ-т хүргэхээр үүрэг болгосон.

АМГТГ-аас дээр дурьдсан тогтоолын дагуу илгээсэн БУУ эрхлэгчид, олборлосон ашигт малтмалын дэлгэрэнгүй мэдээллийг доор харуулав:

АМГТГ-аас ирүүлсэн БУУ-н үйл ажиллагааны мэдээлэл								
Аймаг	Сум	Талбайн нэр	Ашигт малтмалын нэр	Ашиглаж байгаа талбай (га)	Эвдрэлд орсон талбай (га)	Нөхөн сэргээлтэд орсон талбай (га)	БУУ эрхлэгчдийн тоо	
							Эрэгтэй	Эмэгтэй
Дундговь	Өлзийт	Шарангад	Жонш	5	2	0	28	44
Увс	Тариалан	Бор Хавцал	Алт	5	5	0	49	13
Хэнтий	Хэрлэн	Ихэрт Уул	Жонш	4.67	0.5	0	5	0
Дорнод	Баяндун		Жонш	Талбайн мэдээлэл ирүүлээгүй			40	6
	Баянтүмэн	Цагаан үе	Улаан шавар	2	0.1	0.1	5	7

АМГТГ-аас ирүүлсэн БУУ-н үйл ажиллагааны мэдээлэл									
Аймаг	Сум	Талбайн нэр	Ашигт малтмалын нэр	Ашиглаж байгаа талбай (га)	Эвдрэлд орсон талбай (га)	Нөхөн сэргээлтэд орсон талбай (га)	БУУ эрхлэгчдийн тоо		
							Эрэгтэй	Эмэгтэй	
Говь-Алтай	Есөнбулаг	Шаврын гол	Алт	1.5	1.5	0	109	54	
		Жаргалантын булаг							
		Зүрх толгойн урд судаг	Алт	1.2	1.2	0			
		Жамбий	Алт	1.6	1.6	0			
		Дөтийн давааны ам, Гүүрний баруун талын хойт 2 жалга	Алт	3	3	0			
		Өндөр дэнжийн ар салаа	Алт	1.5	1.5	0			
Дорноговь	Айраг	Монголросцветмет ХХК Хайртын уурхай	Жонш	1.6	1	0	109	54	
		Тагт	Жонш	5	0.1	11			
		Монголросцветмет ХХК Хайртын Уурхай	Жонш	5	5				
		2-р багийн нутаг Алтат	Жонш	0.04	0.04	0			
		2-р багийн нутаг Алтат	Жонш	0.02	0.02	0			
		2-р багийн нутаг Алтат	Жонш	0.02	0.02	0			
		2-р багийн нутаг Алтат	Жонш	0.02	0.02	0			
		Хонгорын уурхай, МРЦ-ийн ашиглагдаагүй талбай	Жонш	5	3	0			
		2-р багийн нутаг Алтат	Жонш	0.01	0.01	0			
		1-р багийн нутаг Цагаан дэл	Жонш	0.01	0.01	0.01			
		Ихэт	БУУ-н үйл ажиллагаа эрхлэдэг нөхөрлөл байхгүй						
Завхан	Ургамал	Цагаан толгой	Алт	0.5	0.2	0	26	0	
Архангай	Цэцэрлэг	Нөхөрлөл байхгүй талаар албан тоот ирүүлсэн							
Баянхонгор	Заг							13	11
Нийт				43.79	26.92	11.71	275	135	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Түүнчлэн, Кэй Пи Эм Жи нь аймгуудаас 2016 оны БУУ-н үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэмэлт мэдээллийн маягтын дагуу ирүүлэхийг хүссэн. Үүнээс, нийт 10 аймаг БУУ-н үйл ажиллагаа эрхэлж байгаа 29 нөхөрлөлийн мэдээ ирүүлсэн бөгөөд Баян-Өлгий, Булган, Хөвсгөл, Говьсүмбэр, Сүхбаатар болон Орхон аймгууд БУУ-н үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, нөхөрлөл байхгүй гэж тайлагнасан.

Аймгуудаас ирүүлсэн БУУ-н үйл ажиллагааны мэдээлэл						
Аймаг	Сум	Ашигт малтмалын төрөл	БУУ эрхлэгчдийн тоо	Нөхөрлөлийн тоо	Гэрээний нэр	
Дархан-Уул	Шарын гол	Алт	15	4	БУУ-н олборлолт	
Дорнод	Баянтүмэн сум, Цул	Жонш	17	1		
	Баянтүмэн сум, Цагаан үе	Шавар	12	1		
Дундговь	Хулд	Жонш	120	4	БУУ-н гэрээ	
Говь-Алтай	Баяндун сум, Нүхт	Алт	20	3		

Аймгуудаас ирүүлсэн БУУ-н үйл ажиллагааны мэдээлэл					
Аймаг	Сум	Ашигт малтмалын төрөл	БУУ эрхлэгчдийн тоо	Нөхөрлөлийн тоо	Гэрээний нэр
	Есөнбулаг	Алт	230	6	Байхгүй
	Тайшир	Алт	50		Байхгүй
	Алтай	Алт	30		Байхгүй
Хэнтий	Норовлин	Алт	40	3	БУУ-н гэрээ
	Батноров	Жонш	10	1	
	Баян-Адрага	Жонш	16		
	Дархан	Жонш	4	3	
	Хэрлэн	Жонш	5	1	
Ховд	Мөст	-	10	1	БУУ-н гэрээ
Төв	Заамар	Алт	19	-	БУУ-н гэрээ
	Угтаалцайдам	Квартын чулуу			
	Сэргэлэн	Алт	6	1	
Өмнөговь	Баяндалай, Сэврэй, Номгон, Манлай, Мандал-Овоо, Гурвантэс, Ноён, Цогт-Овоо	Жонш			
	Гурвантэс	Улаан шавар	Байхгүй		
	Тариалан	Алт	Байхгүй		
	Түргэн	Алт	300-500		
	Өмнөговь	Алт	30-50		
	Ургамал	Алт	23		
Увс	Дөрвөлжин	Алт	5		
	Тариалан	Алт	300-50		
	Түргэн		30-50		
Завхан	Өмнөговь		50-100		
	Ургамал	Алт	-	-	
	Дөрвөлжин	Алт	-	-	

Эх сурвалж: Аймгуудаас ирүүлсэн мэдээлэл

Монголд хэрэгжиж буй Тогтвортой Бичил Уурхайн Төсөл

Тогтвортой Бичил Уурхайн (ТБУ) төслийг 2005 онд АМГ (хуучнаар) болон Швейцарийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Агентлаг хамтран үүсгэн байгуулсан. Төслийн зорилго нь гар аргаар ашигт малтмал олборлогчдыг албан ёсны аж ахуйн нэгж болгон тогтвортой үйл ажиллагааг нь зохицуулах хууль, эрх зүйн таатай орчинг бий болгох явдал юм. Мөн уг төсөл нь иргэдийн ядуурлыг бууруулж, хөдөө орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой юм. Төслийн үр дүнд БУУ-г албажуулах үйл ажиллагаа нэмэгдэж, гар аргаар ашигт малтмал олборлогчид тогтвортой байнгын үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн. Энэхүү төсөл нь одоогоор 4 дэх үе шатандаа явж байгаа бөгөөд 2018 оны эцэс хүртэл үргэлжлэх юм.

5.1.2 Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (ША 2.1)

5.1.2.1 Төсвийн бодлого, холбогдох хууль тогтоомж, журмын тодорхойлолт

Эхлэлтийн семинарт хэлэлцэний дагуу ОТАХ нь МОҮИТБС-ын 2016 оны тайланд орох хуулийн мэдээллийн цар хүрээг тодорхойлсон бөгөөд тэрхүү хуулиудын хураангуйг энэхүү хэсэгт оруулсан. Эдгээр хуулиудын хамрах хүрээг 2016 оны эцэс хүртэл үйлчилж байсан хууль тогтоомжууд, 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд гарсан хууль тогтоомжууд болон ойрын ирээдүйд батлагдах магадлалтай МОҮИТБС-д чухал ач холбогдолтой хууль тогтоомжууд байхаар тохирсон.

2016 оноос 2017 оны 6 дугаар сар хүртэл холбогдох хуулиудад гарсан нэмэлт өөрчлөлтүүд болон хуулийн төслүүд

Уул уурхайн тухай хуулийн төсөл, 2017

Уул уурхайн тухай хуулийн зорилт нь уул уурхайтай холбоотой ашигт малтмалын нөөц тогтоохоос эхлээд уурхайг нээх, хаах хүртэл бүхий л асуудлууд болон салбарын үйл ажиллагааны үндсэн зохицуулалтыг тусгах юм. Уг хууль одоо хэрэгжиж буй 2014 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулж ирсэн энэ төрлийн асуудлуудаас илүү өргөн цар хүрээг хамрах юм.

Уул уурхайн хуулийн төсөл нь 14 бүлэгтэй.

- 1-2-р бүлэгт хуулийн зорилт, нэр томъёоны тодорхойлолт, хуулийн үйлчлэх хүрээ, төрийн байгууллагын бүрэн эрх, хяналтын тогтолцоо болон мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоо;
- 3-7-р бүлэгт геологийн судалгааны болон эрэл хайгуулийн ажлын зорилго, зорилт, санхүүжилт, үе шат, ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, тавигдах шаардлага, баяжуулах үйлдвэрийн зураг төслийн ажил, түүнд тавигдах шаардлага, ашигт малтмал ашиглахын өмнөх үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах, ашигт малтмалын олборлолт болон түүнтэй холбогдох үйл ажиллагаа, ашигт малтмалын олборлолт баяжуулалт, боловсруулалт, бүтээгдэхүүн гаргалт, хаягдлын аж ахуй зэрэгт холбогдох үйл ажиллагаа;
- 8-14-р бүлэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, авран хамгаалах ажиллагааны зохицуулалт, байгаль орчин, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалт, уурхайн хаалт, ил тод байдал, салбарын удирдлага, зохион байгуулалт, болон маргаан хянан шийдвэрлэх талаар тусгана.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдээлснээр Уул уурхайн тухай хууль нь уул уурхайн салбарт ил тод, хариуцлагатай систем бий болгох замаар эерэг өөрчлөлтийг авчиргахын зэрэгцээ тодорхой, тогтвортой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг урамшуулан дэмжиж, улс орны хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах болно гэж үзжээ.

Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийн явц

Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төсөл 4 бүлэг 17 зүйлээс бүрдсэн. УУЯ (хуучнаар), СЯ болон Хууль зүйн яамнаас (хуучнаар) баталсан зарчмын тайланд дурьдсанаар төсөлд тодорхойлсон заалтуудыг дараах байдлаар хураангуйлав:

- Нэгдүгээр бүлэгт төслийн зорилго ба хамрах хүрээ, ОУ-ийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмууд болон хуулийн томъёоллын тайлбаруудыг дурьдсан. Уг бүлгийн хүрээн дэх хуулийн зорилт нь ашигт малтмалын салбарт ОУ-ийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- Хоёрдугаар бүлэгт ОУ-ийн ил тод байдлын хэрэгжилтэд хариуцлага хүлээх байгууллагын засаг захиргааны бүтэц, удирдлага мөн ОУ-ийн ил тод байдлын тайланд оролцогч талуудын эрх болон үүргийг дурьдсан.

- Гуравдугаар бүлэгт ОУ-ийн ил тод байдлын тайлантай холбоотойгоор зохицуулалтыг хийх дэлгэрэнгүй журмуудыг багтаасан. Холбогдох зохицуулалтууд нь 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 - Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг хуулийн этгээд болон төрийн байгууллагуудын ил тод байдлын тайлан;
 - Үндэсний Зөвлөлөөр сонгогдсон хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагуудын илтгэсэн тайлан дээр үндэслэн бэлтгэсэн нэгтгэлийн тайлан;
 - Нэгтгэлийн тайлан бэлтгэгдэх хугацаа болон тайланд дурьдагдах мэдээллийн цар хүрээ;
 - Оролцогч талуудын илгээсэн тайлагнал хоорондын зөрүүний нэгтгэл.
- Дөрөвдүгээр бүлэгт ОУ-ийн ил тод байдлын хэрэгжилтийг хариуцаж буй байгууллагын санхүүжилт, хууль зөрчигдөх үед авах хориг арга хэмжээ болон хуулийн хэрэгжүүлэлтэд авах арга хэмжээнүүдийг тодотгосон байна.

Энэхүү хуулийн төсөл нь УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хороо болон УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байсан боловч 2015 онд төр солигдсонтой холбоотойгоор хугацаандаа хэлэлцэгдэж амжаагүй. 2016 оны намар Шинэ Засгийн Газар хэлэлцэх шатандаа байгаа болон батлагдаж амжаагүй хуулийн төслүүдийг татсан бөгөөд үүнд “Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төсөл мөн багтсан байна.

Хэдий тийм боловч уг хуулийн төслийн гол зүйлийг үлдээн, хураангуйлсан байдлаар “Уул уурхайн тухай” шинэ хуулийн төслийн 12-р бүлэгт оруулан, Улсын Их Хуралд 2017 оны 11 дүгээр сард өргөн барихаар ажиллаж байна.

Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт, 2016

Засгийн Газрын 409-р тогтоолын дагуу Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан. Энэхүү стандартын дагуу хайгуул болон олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагааны үе шатуудын хүрээнд үүссэн бүхий л ажил гүйлгээгээ нягтлан бодох бүртгэлийн тайландаа тусгаж өгөхийг шаардсан. Гэвч энэхүү стандартын хүрээнд газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэл хамаарахгүй.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд орсон 2016 оны нэмэлт өөрчлөлт (2001)

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр үүсмэл ордыг ашиглах үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл шаардагдах бизнесийн үйл ажиллагааны жагсаалтанд нэмэгдсэн. Үүсмэл орд гэдэг нь олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааны явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий, дахин боловсруулахад эдийн засгийн үр ашиг гаргаж болох чулуулгийг хэлнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд орсон 2017 оны нэмэлт өөрчлөлт (2012)

2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр энэхүү хуульд нэмэлт өөрчлөлт оруулан 101 дүгээр зүйлийг нэмсэн. 101 дүгээр зүйлд төрийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно гэж заасан. 101.4 дүгээр зүйлд зааснаар нэр дэвшигч албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол 3 сарын дотор арга хэмжээг авч, үүний талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд орсон 2016 оны нэмэлт өөрчлөлт (2013)

Татварын хувь, хэмжээг тогтворжуулах тухай энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг тухайн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох замаар тогтворжуулна. Тогтворжуулах гэрчилгээний хүрээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэргийг уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна. 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр энэхүү татварын тогтворжуулалтанд хамаарахгүй болсон.

Захиргааны ерөнхий хууль, 2015

Захиргааны ерөнхий хуулийн төсөл нь 2008 онд эхэлж, 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр УИХ-аас батлагдаж, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулийн зорилт нь захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах болон захиргааны шийдвэрийг олон нийтэд зарлах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино.

Энэхүү хуульд нэмэлт шинэ журмыг оруулсан нь “Сонсох” ажиллагаа юм. Энэ заалтын дагуу захиргааны байгууллагууд нь аливаа шийдвэр гаргахын өмнө уг шийдвэрийн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд уг шийдвэрийн агуулга, зорилгыг танилцуулж, санал гаргах боломжийг олгох үүрэгтэй болсон байна. Гэвч сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй байна. Саналыг тусгаагүй шалтгааныг тухайн саналыг гаргасан этгээдэд заавал бичгээр мэдэгдэж, ийнхүү мэдэгдсэнээ болон саналыг тусгаагүй үндэслэлийг Сонсох ажиллагааны тэмдэглэлд тусгана.

Хууль тогтоомжийн тухай хууль, 2015

Хууль тогтоомжийн тухай хууль нь 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-аас батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Хуулийн зорилт нь хууль тогтоомжийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд хуулийн төслийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ, хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх, олон нийтийн хэлэлцүүлэг хийж санал авах шаардлагыг хуульчилсан.

Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Засгийн Газрын тогтоол, 2016

ЗГ-аас жил бүр Монгол Улсад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тодорхойлсон тогтоол гаргадаг. Энэхүү тогтоол нь салбар бүрийн хувьд нийт ажилчдын хэдэн хувь нь гадаад ажилчид болон мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн тухай жагсаалтыг хавсралтаар заасан байдаг. Хэрэв тухайн нэг салбар энэхүү хавсралтад тусгагдаагүй байвал уг тогтоолын дагуу нийт ажилчдын 5-аас ихгүй хувь нь гадаадын ажилчид, мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн гэж ойлгоно.

2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн Газрын 432 тоот тогтоолоор 2016 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралтаар баталсан. Уг тогтоолд ОУ-ийн салбарт ажиллах нийт ажилчдын хэдэн хувь нь гадаадын ажиллах хүч, мэргэжилтнүүд байх тухай дараах байдлаар тусгажээ:

Хувь хэмжээ (Нийт ажилчдын тоонд эзлэх хувь)				
ОУ-ийн үйл ажиллагаа	Дүрмийн сан (Сая төгрөгөөр)			
	100 хүртэлх			101 болон түүнээс дээш
	15-аас 30 ажилчид	31-аас 50 ажилчид	51-аас 100 ажилчид	Ажилчдын тоо харгалзахгүй
Газрын тос болон байгалийн хийн хайгуул, олборлолт	10%	20%	60%	70%
Бусад ОУ-ийн үйл ажиллагаа	10%	20%	20%	25%

Эх сурвалж: ЗГ-ын 2015 оны 432 тоот тогтоол

2016 онд газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлох үйл ажиллагааны салбарын хувьд тухайн ажил олгогч аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн хэмжээ, нийт ажилчдын тооноос хамаараад нийт ажилчдын 10%, 20%, 60%, эсвэл 70% нь гадаадын ажиллах хүч, мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн. Бусад олборлох үйлдвэрлэлийн салбаруудын хувьд мөн тухайн ажил олгогч аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн хэмжээ, нийт ажилчдын тооноос хамаараад нийт ажилчдын 10%, 20% эсвэл 25% нь гадаадын ажиллах хүч, мэргэжилтнүүд байхыг зөвшөөрсөн.

Ирээдүйн өв сангийн тухай хууль

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг 5.3.4-р хэсгээс харна уу.

Одоо хэрэгжиж буй хуулиуд

Ашигт малтмалын тухай хууль, 2006

Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сард баталсан. Уг хууль нь ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхит болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалуудыг хамардаг. Түүнчлэн уг хууль нь Монгол Улсын ашигт малтмалын нөөцөд оруулах хөрөнгө оруулалттай холбогдох горим, зүйл заалтууд болон ашигт малтмалыг эрэх, хайх, уурхайтай холбоотой байгаль орчныг хамгаалах зэрэг журмуудын үндсэн суурь болдог. 11 бүлгээс бүрдсэн уг хуулиар ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох зэргийг багтаасан ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалттай холбогдсон харилцааг зохицуулдаг. Ашигт малтмалын тухай хууль нь 2008 оноос 2015 он хүртэл жил бүр өөрчлөгдсөн бөгөөд хамгийн сүүлийн өөрчлөлтүүдийг дор хураангуйлав.

Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд орсон өөрчлөлт, 2017

2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн УУХУЯ-ны сайдын А/40 дүгээр тушаалаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд өөрчлөлт орсон. Үүнд, орон нутгийн тусгай хэрэгцээний газартай эсхүл хууль бус олборлолтод өртсөн талбайтай сонгон шалгаруулалтын талбай нь давхцаж байвал тухайн газарт тусгай зөвшөөрлийг олгох хязгаарлагдмал сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүдийн эрхийг төрийн өмчийнх байсныг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд рүү шилжүүлсэн. Энэхүү өөрчлөлтийг батлагдсанаас хойш олон нийт болон иргэний нийгмүүдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарч байна.

Ашигт малтмалын тухай хуульд орсон өөрчлөлтүүд, 2015

2015 оны Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр “стратегийн ач холбогдол” бүхий ашигт малтмалын орд газрын төрийн өмчлөлтэй холбоотой дараах заалтууд орсон:

- Төр нь стратегийн ач холбогдол бүхий орд газар гэж үзсэн хэсэгт ашигт малтмалын эрэл, хайгуул хийж буй аливаа компаниас төрийн эзэмшлийн хувийг авах эрхтэй. Төрийн сонголтоор түүний эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно. Уг зохицуулалтыг баталгаажуулж баримтжуулахын тулд холбогдох талууд буюу компани болон төр хоорондоо тухайн ордыг ашиглах гэрээ хийж гарын үсэг зурж баталгаажуулна. Уг гэрээгээр төрийн эзэмшлийн хувь эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад асуудлуудыг тодорхойлно.

- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн эзэмшлийн хувь хэмжээ нь 50 хүртэл хувь байж болно.
- Улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтгүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувийг төр эзэмшиж болно.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан бүтээгдэхүүний борлуулалтаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Монгол Улсын Засгийн Газарт төлнө. Заасан борлуулалтын үнэлгээг дараах журмаар тооцно:

- экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн дундаж үнийг баримтлан;
- дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн;
- дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн.

Тодорхой нөхцлүүдээс шалтгаалан ашигт малтмалын нөөцийн төлбөрийг бүтээгдэхүүн бүрд тооцохоос гадна ашигт малтмалын нөөцийн үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь тооцно. Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлж, харин боловсруулалтын түвшингээс хамаарч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бууруулахаар тогтоосон.

Заасан нэмэлт төлбөрийн хувийг дараах байдлаар тодорхойлно:

Зөнхилох ашигт малтмалд тооцох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөрүүд								
Ашигт малтмалын төрөл	Нэгж	Тэмдэг -лэл	АМНАТ-ийн хувь	АМНАТ-ийн хэмжүүр	Нэгжийн зах зээлийн үнэ (ам.доллар)	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь		
						Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
Зэс	тн		5.0%	Борлуулсан, борлуулахаар ачуулсан, ашигласан бүтээгдэхүүний үнэлгээ	0-5 000	0.0%	0.0%	0.0%
					5 000-6 000	22.0%	11.0%	1.0%
					6 000-7 000	24.0%	12.0%	2.0%
					7 000-8 000	26.0%	13.0%	3.0%
					8 000-9 000	28.0%	14.0%	4.0%
				+9 000	30.0%	15.0%	5.0%	
Алт	унц	Монгол Банк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алт	2.5%	Борлуулалтын үнэлгээ	0-900	0.0%	0.0%	0.0%
					900-1 000	0.0%	0.0%	1.0%
					1 000-1 100	0.0%	0.0%	2.0%
					1 100-1 200	0.0%	0.0%	3.0%
					1 200-1 300	0.0%	0.0%	4.0%
				+1 300	0.0%	0.0%	5.0%	
Боловсруулаагүй нүүрс	тн	Дотоодод баяжуулсан нүүрс	2.5%	Борлуулсан, борлуулахаар ачуулсан, ашигласан бүтээгдэхүүний үнэлгээ	0-25	0.0%	0.0%	0.0%
					25-50	1.0%	0.0%	0.0%
					50-75	2.0%	0.0%	0.0%
					75-100	3.0%	0.0%	0.0%
					100-125	4.0%	0.0%	0.0%
				+125	5.0%	0.0%	0.0%	
Баяжуулсан нүүрс	тн		5.0%	Борлуулсан, борлуулахаар ачуулсан, ашигласан бүтээгдэхүүний үнэлгээ	0-100	0.0%	0.0%	0.0%
					100-130	0.0%	1.0%	0.0%
					130-160	0.0%	1.5%	0.0%
					160-190	0.0%	2.0%	0.0%
					190-210	0.0%	2.5%	0.0%
				+210	0.0%	3.0%	0.0%	
Бэлэн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	тн		5.0%	Борлуулсан, борлуулахаар ачуулсан, ашигласан бүтээгдэхүүний үнэлгээ	0-160	0.0%	0.0%	0.0%
					160-190	0.0%	0.0%	0.5%
					190-210	0.0%	0.0%	1.0%
					210-240	0.0%	0.0%	1.5%
					240-270	0.0%	0.0%	2.0%
				+270	0.0%	0.0%	2.5%	

Зонхилох ашигт малтмалд тооцох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөрүүд								
Ашигт малтмалын төрөл	Нэгж	Тэмдэг -лэл	АМНАТ-ийн хувь	АМНАТ-ийн хэмжүүр	Нэгжийн зах зээлийн үнэ (ам.доллар)	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь		
						Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
Мөнгө	унц		5.0%	Борлуулсан, борлуулахаар ачуулсан, ашигласан бүтээг-дэхүүний үнэлгээ	0-25	0.0%	0.0%	0.0%
					25-30	0.0%	0.0%	1.0%
					30-35	0.0%	0.0%	2.0%
					35-40	0.0%	0.0%	3.0%
					40-45	0.0%	0.0%	4.0%
					+45	0.0%	0.0%	5.0%

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль болон түүний нэмэлт өөрчлөлтүүд

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 01 дүгээр сард баталсан. Уг хууль нь хайрга, шавар, боржин чулуу, элсэн чулуу зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг хамардаг бөгөөд хайгуул, олборлолттой холбоотой байгаль орчныг хамгаалах, болон хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой бүхий л журмуудын үндсэн суурь болдог.

10 бүлгээс бүрдсэн уг хуулиар ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох зэргийг багтаасан ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулдаг.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.2.5-д зааснаар аймаг, нийслэлийн засаг дарга өөрсдийн харьяа нутаг дэвсгэрт хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Газрын тосны тухай хууль, 2014

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн тогтоолыг Монгол Улсын УИХ 2014 оны 7 дугаар сард баталсан. 1991 оны Газрын тосны тухай хуулийг өөрчлөхийн сацуу Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор уг шинэчлэлийг хийсэн. Өмнөх үеүдэд батлагдсан гэрээнд өөрчлөлт ороогүй боловч шинэчлэгдсэн хууль нь газрын тос олборлогчдод тодорхой хөнгөлөлтийг үзүүлсэн. Газрын тосны тухай хууль нь газрын тосны бүтээгдэхүүнийг дараах хоёр үндсэн төрөлд хувааж үздэг: тос – үүнд: түүхий нефть, байгалийн хий, боловсруулсан тос; уламжлалт бус газрын тос – үүнд: тослог элс, шатдаг занар зэрэг багтана.

Зонхилох газрын тосны ажиллагаа болон нэршлийн судалгаа, газрын тосны хайгуул болон олборлолтыг тодорхойлсны үндсэн дээр шинэчилсэн хуульд нилээдгүй өөрчлөлт оруулсан. Газрын тосны хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийн эрхийг заавал авна. Газрын тосыг хадгалах болон тээвэрлэх болон судалгааны ажил эрхлэх бол холбогдох төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Шинэчилсэн хуулийн дагуу уг зөвшөөрлийг АМГТГ-аас олгож байна. Хуучин журмаар бол дээр дурьдсан үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрлийн дагуу хэрэгждэг байсан.

Шинээр олгосон газрын тосны хайгуулын хугацаа нь найм хүртэл жил байх бөгөөд төрийн захиргааны байгууллага хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Газрын тосны ашиглалтын хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх (дэлгэрэнгүй мэдээллийг 5.2.2.1 хэсгээс харна уу) бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

Газрын тосны тухай хуулиар газрын тосны эрэл хийхээр төлөвлөсөн хуулийн этгээд нь АМГТГ-т хүсэлт гаргах үүрэгтэй байдаг. БХГ-нд оролцохоос өмнө эрэл хийж дууссан хуулийн этгээд нь гүйцэтгэлийн тайланг АМГТГ-т өгч дүгнэлт гаргуулах үүрэгтэй. Хайгуулын гэрээ болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дэлгэрэнгүйг 5.1.4.4 хэсгээс харна уу.

АМГТГ-тай БХГ-г шууд байгуулсан хуулийн этгээдэд УУХҮЯ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг олгоно. Түүнчлэн, ГТГ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох заалтын дагуу БХГ хийх боломжгүй ч хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгарсан бол уг компанид хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоно. УУХҮЯ-нд компанийн хайгуул хийхээр гаргасан тусгай зөвшөөрлийн хүсэлтэд холбогдох баримт бичиг, БХГ-ний хуулбар, үр дүнгийн тайлан мэдээ, тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэхэд шаардсан мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баталгаа зэргүүд багтана.

Газрын тосны тухай хуульд гэрээлэгч нь газрын тосыг арилжаалах ажиллагааг эхэлсэн тохиолдолд газрын тосны зардлыг нөхөн авах боломжтой. Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь хамаарна. Хайгуул, ашиглалт, боловсруулалтын зардлууд нь БХГ-ний заалтад дурьдагдсан дүнгээр бүрэн хэмжээгээр нөхөгдөх боломжтой.

Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу БХГ дуусгавар болох үед өртөг нөхөгдөх зардлаас нөхөгдөөгүй үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй. ЗГ гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардалд хүү төлөхгүй.

Газрын тосны хайгуулыг хэрэгжүүлэх боломжтой хуулийн орчин нь анх 1991 онд Газрын тосны тухай хууль батлагдах үед бүрэлдсэн ба үүний дараа 1993 онд анхны БХГ хийгдэж байсан.

1991 оны Газрын тосны тухай хууль нь 3 бүлэг 15 зүйлээс бүрдсэн маш хураангуй хууль байсан. Харин 2014 оны Газрын тосны тухай хуулийн шинэчлэл нь нэмэлт журам болон БХГ загварын зарим чухал дэгүүдийг оруулж ирсэн. БХГ-ний загварыг Засгийн Газрын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 104 тоот газрын тосны хайгуул болон эдэлбэр газрын тухай тогтоолоор баталсан.

БХГ-ний загварыг шинэчлэн баталсантай холбоотой гэрээний нууцлалд гарсан өөрчлөлтийг 5.5.2.1 хэсэгт харуулав.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005

Газрын тосны бүтээгдэхүүнтэй холбогдох үйл ажиллагааны дэд ангиллыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын УИХ Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг 2005 оны 7 дугаар сард баталсан. Эдгээр үйл ажиллагаа нь импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт болон хадгалалт зэрэг юм. Газрын тосны бүтээгдэхүүн гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг хэлнэ.

Импорт, үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаанд газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл шаардлагатай. Харин тээвэрлэлт болон хадгалалтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаардлагагүй боловч Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, ГТГ-аас гаргасан холбогдох дүрэм журмыг мөрдөх шаардлагатай.

Газрын тосны бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалах ажиллагаанд нэмэлт тусгай зөвшөөрөл шаардах заалт нь 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиар шинэчлэн батлагдсан бөгөөд өмнө нь энэхүү ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаарддаггүй байсан.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001

Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын УИХ-аас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг 2001 оны 02

дугаар сард баталсан. Ялангуяа ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд мөрдөх горимыг тодорхойлох, зохицуулахад онцгой анхаарал хандуулсан.

Хайгуулын тусгай зөвшөөрөл болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГ-аас авахаас гадна зөвшөөрөлд хамрагдах эдэлбэр газар харьяалагдаж буй аймгийн захиргаа нь тусгай зөвшөөрөл бүрийг батлах шаардлагатай. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хууль тогтоомж, дүрэм журмын мөрдөлтөд хяналт тавих геологи, уул уурхайн улсын хяналтын газар болон орон нутгийн захиргааны үүрэг, хариуцлагуудыг уг хуулиар тодорхойлсон.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулсан хязгаарлагдмал хариуцлагатай компани эсвэл хувьцаат компанид олгоно. Монгол Улсын иргэн эсвэл гадаадын иргэн буюу хувь хүн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгүүлэх эрхгүй.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсон бөгөөд уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул хийх болон ашиглах үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэйгөөр хийгдэх бизнесийн ажиллагааны жагсаалтад нэмэгдсэн.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012

“Hogan Lovells (Mongolia) LLP”-ын дурьдсанаар ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль нь аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, усны бохирдуулалтын хэмжээнээс хамааран усны бохирдуулалтын төлбөрийн дээд болон доод хэмжээг тодорхойлох, усны нөөцийг “бохирдуулсны төлбөр”-ийн зарчмыг хэрэгжүүлэх зорилготой.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл сав газрын захиргаа ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.

Уг хуулийн дагуу, ус бохирдуулсны төлбөр төлөгчийн гаргасан дараах хаягдал усанд ус бохирдуулсны төлбөр /цаашид “төлбөр” гэх/ ногдуулна:

- Хаягдал усны стандартад нийцүүлэн зөвшөөрсөн хязгаарын дотор байгальд шууд нийлүүлж байгаа хаягдал ус;
- Ариутгах татуургад нийлүүлэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламжийн стандартад нийцүүлэн ариутгах татуургад нийлүүлж байгаа хаягдал ус.

Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009

“Урт нэртэй хууль” гэх тодотголтой Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль нь 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан. Уг хууль нь усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох болон тухайн газарт байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хуулийн хориг нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийг Монгол Улсын Засгийн Газар тодорхойлох бөгөөд заасан бүс нутагт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно. Энэхүү хуулийн хүрээнд нэлээд ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Урт нэртэй хуулийг хэрэгжүүлэхээр үүнтэй хамт уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсан.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, 2015

Урт нэртэй хуулийн 4.6-д заасны дагуу цуцлагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Монгол Улсын Засгийн Газраас нөхөн төлбөр төлөх үүрэгтэй. “GTS Advocates LLP” хуулийн компанийн дүгнэсний дагуу уг хуулийн хэрэгжилтийг хангахад төрөөс зарцуулах зардлыг хэмнэх, тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан талбайд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагааг байгаль орчинд аль болох хохирол багатай хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газраас Урт нэртэй хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр дараах агуулга бүхий зохицуулалтуудыг баталжээ.

- Урт нэртэй хууль батлагдахаас өмнө буюу 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс өмнө тус хуулиар хориглосон талбайд тусгай зөвшөөрөл авсан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаас хойш 3 сарын дотор үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх тухай хүсэлтээ Ашигт Малтмалын Газарт гаргана.
- Өргөдөл гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам (БОНХАЖЯ), Ашигт Малтмалын Газар болон холбогдох аймгийн Засаг дарга гэрээ байгуулах бөгөөд Засгийн Газар энэхүү гэрээний загварыг батлахаар хуульчилжээ. Хуулийн дагуу гэрээний хэрэгжилтэд Мэргэжлийн Хяналтын Газар хяналт тавих үүрэгтэй.
- Хэрэв урт нэртэй хуулиар хориглосон талбайд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч тогтоосон хугацаанд гаргаагүй эсвэл зохих журмын дагуу дээр дурьдсанаар гэрээ байгуулаагүй тохиолдолд тухайн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах бөгөөд энэ тохиолдолд дахин тухайн талбайд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг аливаа этгээдэд олгохгүй.
- Урт нэртэй хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Засгийн Газар хүсэлт гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний загвараас гадна дор дурьдсан асуудлаар журам гаргахаар зохицуулжээ:
 - гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах;
 - усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс (усны сан бүхий газрын эргээс 200 метр)-д олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах; мөн
 - байгаль орчны нөхөн сэргээлт хийлгэх.
- Уг журам, гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тусгасан байна. Түүнчлэн, энэ нь байгаль орчин хамгаалах талаар УМХГ-ын эрх үүргийн нөхцлийг бүрдүүлдэг.
- Ойн сан бүхий газарт олгосон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ойн тухай хуулийн тодорхой зүйл, заалтуудыг дагаж мөрдөхөөр зохицуулсан. Харин хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй давхацсан тохиолдолд Усны тухай хууль, ойн сан бүхий газартай давхацсан тохиолдолд Ойн тухай хуулийн дагуу тус тус шийдвэрлэхээр хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгажээ.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд гарах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглалт явуулсан хугацаанд олсон орлоготой нь уялдуулан нөхөж гаргуулахаар тогтоосон байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012

Энэ хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино.

Уг хуулийн дагуу нийтийн албан тушаалтан /цаашид "албан тушаалтан" гэх/-д тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн шаардлагын үндэслэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, албан тушаалтан хувийн ашиг сонирхлын байдлаа мэдүүлэх болон түүнийг шалгах ажиллагаа, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг энэ хуулиар зохицуулна.

Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлт, 2015

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд гарсан өөрчлөлтийг 5.3.3. хэсгээс харна уу.

Татварын ерөнхий хууль, 2008

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Газрын тос ашигласны болон уламжлалт ба уламжлалт бус аргаар газрын тос олборлох тусгай зөвшөөрлийн төлбөр нь улсын албан татвар гэж шинээр тогтоогдсон. Татвар ногдуулах хувь хэмжээг ЗГ болон УИХ тогтоох бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр хэрэгжинэ.

Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013

УИХ-аас 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хууль нь тус оныхоо 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хууль батлагдсанаар 1993 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль /1993 оны/ болон Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай /2012 оны/ хуулиуд хүчингүй болж, хөрөнгө оруулалтыг зохицуулах эрх зүйн шинэ орчныг бүрдүүлсэн болно.

2012 онд батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль нь ерөнхийдөө эрдэс баялаг, банк, санхүү болон хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хамардаг байсан. Гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдүүд 30 хоногийн дотор гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл хүсэх тухай хүсэлтийг гаргах үүрэгтэй бөгөөд мөн тухайн хөрөнгө оруулагч нь гадаадын төрийн эзэмшлийн аж ахуйн нэгж байх тохиолдолд нэмэлт шаардлага буюу УИХ-аас стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл хүсдэг байсан. Энэ хууль нь хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтын эсрэг хууль мэтээр ойлгогддог байсан нь Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан гол шалтгаануудын нэг гэж үзсэн.

2013 оны Хөрөнгө Оруулалтын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн (хуулийн этгээд болон хувь хүн) хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино. 2013 оны Хөрөнгө Оруулалтын тухай хуулийн шинэ зүйл нь хувь хөрөнгө оруулагчийг өөрчлөн тодорхойлсон явдал юм. Уг хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч (хувь хүн), дотоодын хөрөнгө оруулагчдыг (хувь хүн) хооронд нь ангилахдаа тэдний үндэс угсаа гэхээсээ илүү оршин суугаа байршилд анхаарна хэмээн заасан. Тийм ч учраас Монгол Улсад байнга оршин суугч гадаадын хөрөнгө оруулагчийг дотоодын хөрөнгө оруулагч, харин гадаадад байнга оршин суугч Монгол Улсын иргэнийг гадаадын хөрөнгө оруулагч гэж үзэх болно.

Аудитын тухай хууль, 2015

Монгол Улсын Аудитын тухай хууль нь 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэгдэн найруулагдсан бөгөөд 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн. Голлох өөрчлөлтүүдийн нэг нь санхүүгийн тайландаа аудит хийлгэх шаардлагатай аж ахуйн нэгжүүдийн жагсаалт юм. Шинэчилсэн хуулийн дагуу санхүүгийн тайландаа аудит хийлгэх шаардлагатай компаниудын жагсаалт нь нэлээдгүй өөрчлөгдсөн. Өөрчлөлтүүдийн харьцуулалтыг дор харуулав:

Өмнөх хуулийн хүрээнд:

- Хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх төрлийн хувьцаат компани
- Хөрөнгийн биржид бүртгүүлэх зөвшөөрөл хүсч буй компани
- 50 сая, түүнээс дээш төгрөгийн актив бүхий аж ахуйн нэгж, байгууллага
- Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоо
- Банк, санхүү, даатгалын байгууллага
- Брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаг үнэт цаасны компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхэлдэг компани
- Улс төрийн нам
- Дээр дурьдсан хөрөнгийн биржэд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагатай адилтгах байгууллага

Одоогийн хэрэгжиж буй шинэчлэн найруулсан хуулийн хүрээнд:

- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг мөрддөг аж ахуйн нэгж, байгууллага
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг аж ахуйн нэгж, байгууллага
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага
- Монгол Улсын дагаж мөрддөг Олон Улсын гэрээ хэлэлцээрийн дагуу санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэхээр заагдсан бусад аж ахуйн нэгж, байгууллага.

2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай (2015) хуулийн 4.2-т заасны дагуу дараах аж ахуйн нэгж, байгууллагууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг зайлшгүй мөрдөх ёстой:

- Гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлсэн бүх төрлийн хувьцаат компани
- Гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлэхээр хүсэлт гаргасан компани
- Банкны үйл ажиллагаа, банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа, ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал ашиглах болон газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага
- Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгж
- Улс төрийн нам, Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага
- Арилжааны банкуудтай хамтарч ажилладаг тусгай зориулалтын компани, хөрөнгө оруулалтын сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага

Нягтлан Бодох Бүртгэлийн (2015) тухай шинэчилсэн хуулийн дагуу доор дурьдсан хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагууд нь жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө. Иймд тэд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагагүй.

- Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн

- Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
- Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
- Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 49-өөс дээшгүй бөгөөд 1 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
- Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн

2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсон өмнөх Аудитын тухай хуульд зааснаар, 50 сая ба түүнээс дээш төгрөгийн актив бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь хөндлөнгийн аудит хийлгэх зайлшгүй шаардлагатай. Гэхдээ 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зөвхөн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт мөрддөг аж ахуйн нэгжүүд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагатай болсон бөгөөд энэ шинэчилсэн хуулийн хүрээнд олон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч байгууллагууд тэдэнд зориулсан жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг мөрдөх болсон. Ингэснээр тэд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагагүй болсон. Бусад голлох өөрчлөлтүүд нь аудиторын зайлшгүй солигдох хугацаа, аудитын компаниудын бүтэц, тэдгээрийн өмчлөл болон аудитын тусгай зөвшөөрөл, холбогдох мэргэшлүүд болон өөр бусад өөрчлөлтүүд зэрэг болно.

5.1.2.2 Монгол Улсын ОУ-ийн салбарт холбогдох хуулиуд

Голлох хуулиуд болон голлох хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг доорх жагсаалтаар харуулав.

- Ашигт малтмалын тухай хууль, 2006;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014;
- Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, 2015;
- Газрын тосны тухай хууль, 2014;
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012;
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009;
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, 2015;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашигт сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012;
- Аудитын тухай хууль, 1997, 2015;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2001, 2015;
- Татварын ерөнхий хууль, 2008;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006;
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010;

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2008;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2012;
- Газрын хэвлийн тухай хууль, 1988;
- Газрын тухай хууль, 2002 ;
- Газрын төлбөрийн тухай хууль, 1997;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006, 2015;
- Ойн тухай хууль, 2012;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хууль, 2000;
- Цөмийн энергийн тухай хууль, 2009;
- Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2016;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль; болон
- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загвар, түүнийг баталсан ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоол.

5.1.3 Ашигт малтмалын тойм мэдээлэл

Монгол Улс нь нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт болон мөнгөний нөөцөөр баялаг орон билээ. Монгол Улс нь нүүрс, зэс болон бусад ашигт малтмалыг голлон БНХАУ уруу төмөр замаар дамжуулан экспортолдог ба багахан хэмжээний экспортыг Япон, Өмнөд Солонгос, Орос Улс, Англи Улс болон Австрали Улс руу тус тус хийдэг байна. Монгол Улсын өргөн уудам газар нутаг, сийрэг хүн ам зэрэг онцлог байдал нь дэд бүтцийг шийдвэрлэхэд хүндрэл учруулдаг боловч Монгол Улсын ЗГ экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор төмөр замыг өргөжүүлэх тогтоолыг баталсан.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,058 компани 3,579 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 63 төрлийн ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. 2016 онд ОУ салбар 4,257,163 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

5.1.3.1 Томоохон хэмжээний хайгуулын үйл ажиллагаа (ША 3.1)

АМГТГ-ын тайлагнаснаар 2016 онд 13 томоохон хайгуулын ажлын төслүүд хувийн компанийн санхүүжилтээр хийгдсэн ба улсын төсвийн хөрөнгөөр ямар ч хайгуулын төсөл хэрэгжээгүй байна.

Хувийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлууд

2016 онд дараах томоохон хайгуулын ажлын төслүүд хувийн компанийн санхүүжилтээр хийгдсэн байна.

2016 онд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн томоохон хайгуулын төслүүд					
	Хайгуулын төсөл	Ашигт малтмал	Байршил	Батлагдсан нөөц	Нөөцийн хэмжээ
1	Ураны төсөл /Дулаан Уул, Зөөвч Овоогийн орд/	Уран	Дорноговь аймаг, Улаанбадрах сум	Дулаан Уулын ураны орд. (B+C) зэрэглэлээр	Хүдрийн 58,117,825.63 тн буюу 217.69 г/т дундаж агуулгатай болон 11,896.44 тн металл ураны нөөц тогтоогдсон байна.
				Зөөвч Овоогийн ураны орд. Бодитой болон Боломжтой (B+C) зэрэглэлээр	Хүдрийн 288,698,781.25 тн буюу 234.52 eUppm дундаж агууламжтай болон 67,706.77 тн металл ураны нөөц тогтоогдсон байна.
2	“Сэлэнгэ” төмрийн хүдрийн төсөл	Төмөр	Сэлэнгэ аймаг, Ерөө сумаас 24 км	Бодит нөөц (B), Боломжит нөөц (C)	Бодит нөөц (B): Хүдэр 238.80 сая.тн, металл 39.3 сая.тн. Боломжит нөөц (C): Хүдэр 10.6 сая.тн, металл 1.8 сая.тн.
3	"Хармагтайн" төсөл	Алт-Зэс	Өмнөговь аймаг, Цогт Цэций сум	Эдийн засгийн үр ашиг багтай, бодит болон боломжтой (A+B+C)	Хүдрийн нөөц 18,031,254.0тн, алтны нөөц 13.428тн, зэсийн нөөц 88,475.0тн
				Тодорхой нөхцөлд үр ашигтай баттай, бодит болон боломжит нөөц (A+B+C)	Хүдрийн нөөц 68,535,851.0тн, алтны нөөц 25.008тн, зэсийн нөөц 259,525.0тн
4	“Хүрэл Үнэг” төсөл	Полиметал	Дорноговь аймаг, Мандах сум	Тогтоогдоогүй	Тогтоогдоогүй
5	Баян уулын орд	Алт	Төв аймаг, Дэлгэрхаан, Бүрэн сум	1-р орд биет бодит болон боломжит нөөц (B+C)	Алтны нөөц 24.29 тн
6	Улаанбулагийн орд	Алт	Сэлэнгэ,Төв аймаг, Мандал, Борнуур сум	Бодит нөөц (B) болон	Бодит нөөц (B): 2,841.5 мян.т хүдэрт 3,765.4 кг алт;
				Боломжит нөөц (C)	Боложит нөөц (C): 443 мян.т хүдэрт 478.4 кг алт.

2016 онд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн томоохон хайгуулын төслүүд					
	Хайгуулын төсөл	Ашигт малтмал	Байршил	Батлагдсан нөөц	Нөөцийн хэмжээ
7	Цагаан овоогийн орд	Алт-холимог метал	Дорнод аймаг, Цагаан Овоо сум	Эдийн засгийн үр ашигтай баттай, бодит болон боломжит нөөц (A+B+C)	Эдийн засгийн өгөөжийн үр ашигтай нийт нөөц: 19,308,574.0 тн хүдэр, 26,389.9 кг алт, 195,391.7 кг мөнгө, 105,466.1 тн хар тугалга, 193,966.3 тн цайр; Баттай (A) нөөц: 8,658,448.0 тн хүдэр, 13,551.7 кг алт, 69,471.9 кг мөнгө, 54,158.0 тн хар тугалга, 94,705.7 тн цайр; Бодит (B) нөөц 10,574,088.0 тн хүдэр, 12,749.1 кг алт, 125,585.6 кг мөнгө, 51,177.6 тн хар тугалга, 99,078.8 тн цайр; Боломжтой (C) нөөц 76,038.0 тн хүдэр, 89.1 кг алт, 334.2 кг мөнгө 130.4 тн хар тугалга, 181.8 тн цайр.
				Тодорхой нөхцөлд үр ашигтай баттай, бодит болон боломжит нөөц (A+B+C)	Тодорхой нөхцөлд үр ашигтай нийт нөөц: 2,609,660.0 тн хүдэр, 1,807.1 кг алт, 17,285.9 кг мөнгө, 23,475.9 тн хар тугалга, 40,836.2 тн цайр.
8	Улаан дэлийн төсөл	Циркон, хүнд газрын ховор элемент	Увс аймаг, Завхан сум	Тогтоогдоогүй	Тогтоогдоогүй
9	Хөх дэлийн литийн орд		Дундговь аймаг, Өлзийт сум	Баттай, бодит болон боломжит нөөц (A+B+C)	0.156%-ийн дундаж агууламжтай 283.9 сая тн хүдрийн нөөц болон 443.6 мян тн литийн нөөц тооцоологдсоноос: Баттай (A) хүдрийн нөөц 23.5 сая.тн, бодит (B) хүдрийн нөөц 98.7 сая.тн буюу литийн металлын нөөц 37.7мян тн, баттай (A) зэрэглэлээр, бодитой (B) зэрэглэлээр 151.3 мян тн гэж тооцоологдсон.
10	Мөнхтийн Цагаан Дөрвөлжингийн литийн орд	Лити	Говьсүмбэр, Дундговь аймаг, Шивээговь, Баянжаргалан сум	Бодит болон боломжит нөөц (B+C)	Li ₂ O-ийн 0.65%-ийн дундаж агууламжтай 2,276,989 тн хүдэр, химийн цэврээр 14,575 тн литийн, 0.15%-ийн агуулгатай Rb ₂ O-ийн 4,286.1 тн рубиди, 0.03%-ийн дундаж агуулгатай 0.622тн цезийн нөөц тогтоогдсон.
11	Мандалын орд	Молибден-вольфрамын	Хөвсгөл аймаг, Цагаан-Уул сум	Эдийн засгийн үр ашигтай байх баттай, бодит болон боломжит нөөц (A+B+C)	эквМо-1,124.0 г/тн, Мо-961.89 г/тн, W-242.12 г/тн-ын дундаж агуулгатай 294,949,392.65 тн хүдэрт 331,523.96 тн эквМо, 283,708.52 тн молибден, 71,412.67 тн вольфрам
				Тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай байх баттай, бодит болон боломжит нөөц (A+B+C)	эквМо-245.23 г/тн, Мо-151.14 г/тн, W-140.53 г/тн-ын дундаж агуулгатай 19,874,107.98 тн хүдэрт 4,873.66 тн эквМо, 3,003.68 тн молибден, 2,792.83 тн вольфрам
12	Өндөр-Цахирын орд	Молибден, вольфрам		Бодит болон боломжит нөөц (B+C)	Ордын хайгуулын ажлын үр дүнд 18,757.09 мян.тн хүдэрт агуулагдах 0,083%-ийн молибдений дундаж агуулгатай 156,453 мян.тн металл болон 0.04 г/т дундаж агуулгатай 7,465 мян.тн рений, 0,015%-ийн дундаж агуулгатай 28,887 мян.тн вольфрамын металлын нөөц тус тус тогтоогдсон.
13	Баянцогтын орд	Вольфрам, молибден	Хэнтий аймаг, Цэнхэрмандал сум	Бодит болон Боломжит нөөц (B+C)	WO ₃ 275.51 г/т, Мо 206.28 г/т, Sn 141.88 г/т, Ag 1.55 г/т буюу 511.1 г/т вольфрамын (Eq.WO ₃) дундаж агуулгатай 269.67 сая тонн хүдэр 74,296.4 тн метал вольфрам, 55,627.4 тн метал молибдени, 38,261.9 тн метал цагаан тугалга, 417.63 тн мөнгөний нөөц буюу нийт 137,831.2 тн метал вольфрамын дүйцүүлсэн нөөцтэй болохыг тогтоосон.

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.1.3.2 Гол нэр төрлийн ашигт малтмалын олборлолт, борлуулалт болон экспортын хэмжээ (ША 3.2, ША 3.3)

Олборлолт болон борлуулалт (ША 3.2)

Доорх хүснэгтэд 2016 оны ашигт малтмалын олборлолтын хэмжээг Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр харуулсан болно.

2016 оны ашигт малтмалын олборлолтын хэмжээ							
Ашигт малтмал	Нэгж	2013	2014	2015	2016	% өөрчлөлт	
1 Нүүрс	000' тонн	30,123	25,288	24,206	35,522	47%	
2 Газрын тос	000' баррель	5,129	7,405	8,769	8,250	-6%	
3 Зэсийн баяжмал, металл агуулгаараа	000' тонн	803	1,080	1,335	1,445	8%	
4 Молибдений баяжмал	тонн	3,732	4,054	5,207	5,174	-1%	
5 Алт	тонн	9	12	15	18	27%	
6 Хайлуур жонш	000' тонн	162	303	184	168	-9%	
7 Хайлуур жоншны баяжмал	000' тонн	76	72	47	34	-28%	
8 Төмрийн хүдэр	000' тонн	5,012	6,293	4,274	4,936	16%	
9 Төмрийн хүдрийн баяжмал	000' тонн	6,124	3,967	1,900	2,210	16%	
10 Цайрын баяжмал	000' тонн	104	93	90	100	12%	
11 Гянтболдын баяжмал	тонн	-	1,024	1,024	710	-31%	
12 Давс олборлолт	тонн	658	1,378	1,686	478	-72%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2016 оны статистикийн эмхэтгэл, хуудас 578

Доорх хүснэгтэд 2016 оны ашигт малтмалын олборлолтын мөнгөн дүнг Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр харуулсан байна.

2016 оны ашигт малтмалын олборлолтын мөнгөн дүн (сая төгрөг)					
Ашигт малтмал	2013	2014	2015	2016	% өөрчлөлт
1 Метал хүдрийн олборлолт	3,273,706	6,467,458	5,863,580	6,840,077	17%
2 Нүүрс олборлолт	1,461,125	1,081,738	952,492	1,690,459	77%
3 Газрын тос олборлолт	770,940	1,125,185	834,990	747,324	-10%
4 Бусад ашигт малтмал олборлолт	113,897	137,919	141,855	129,703	-9%
5 Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	480,088	458,987	361,648	435,810	21%
Нийт	6,099,755	9,271,286	8,154,564	9,843,373	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2016 оны статистикийн эмхэтгэл, хуудас 568

Доорх хүснэгтэд АМГТГ-аас ирүүлсэн 2016 оны ашигт малтмалын борлуулалтын хэмжээ, мөнгөн дүнг харуулсан. Энэ нь АМГТГ-т ОУ-ийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл дээр тулгуурласан учир бүрэн гүйцэд биш байж болзошгүйг анхаарна уу. Дэлгэрэнгүйг Хавсралт 14-өөс харна уу.

Ашигт малтмалын 2016 оны борлуулалтын хэмжээ, мөнгөн дүн (мөнгөн дүн сая төгрөгөөр)				
Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Борлуулалт хэмжээ	Борлуулалт дүн	Борлуулалт %
Зэсийн баяжмал	000' тонн	1,482.75	3,719,545	57.5%
Нүүрс	000' тонн	27,065.57	2,214,586	34.2%
Алт	кг	3,094.47	271,840	4.2%
Цайрын баяжмал	000' тонн	101.27	150,223	2.3%
Молибден баяжмал	000' тонн	5.78	58,639	0.9%
Гянтболдын баяжмал	000' тонн	3.70	13,505	0.2%
Цемент	000' тонн	81.80	11,083	0.2%
Жонш	000' тонн	13.66	6,802	0.1%
Дайрга	000' тонн	192.29	3,024	0.0%
	000' м3	156.46	3,113	0.0%
Жоншны баяжмал	000' тонн	9.47	5,295	0.1%
Шохойн чулуу	000' тонн	174.67	3,502	0.1%
Мөнгө	кг	2,476.88	3,035	0.0%
Хайрга	000' тонн	365.58	2,716	0.0%
Манганы хүдэр	000' тонн	28.08	2,096	0.0%
Жоншны хүдэр	000' тонн	11.15	1,030	0.0%
Тоосго	000' ш	6,175.50	847	0.0%
Гөлтгөнө	000' тонн	11.34	377	0.0%
Гантиг	000' тонн	18.26	162	0.0%
Элс	кг	19.72	133	0.0%
Цагаан тугалганы баяжмал	000' тонн	0.01	101	0.0%
Манганы баяжмал	000' тонн	0.67	95	0.0%
Нийт			6,471,748	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Тайлбар:

1. Борлуулалтын тоон мэдээлэлд Монгол Улсын БУУ-н салбарын мэдээллийг оруулаагүй болно.

2. Нүүрсний борлуулалтын дүнг бодоходоо нэгжийн үнийг экспортын нүүрс дээр тонн нь 93,856 төгрөгөөр буюу 37.7 ам.доллараар (ҮСХ-ын 2016 оны 12 сарын тайлан) болон дотоодын хэрэгцээний нүүрс дээр тонн нь 42,701 төгрөгөөр (Шарын шол ХК-ны Монголын хөрөнгийн бирж дээрх 2016 оны жилийн эцсийн тайлан) тус тус тооцон бэлтгэв.

Ашигт малтмалын экспорт (ША 3.3)


Доорх хүснэгтэд гол нэр төрлийн ашигт малтмалын экспортыг хэмжээ болон дүнгээр харуулав.

Сүүлийн 5 жилийн ашигт малтмалын экспорт							
Бүтээгдэхүүний нэр		2012	2013	2014	2015	2016	ЖНХ
Зэс	мян.тонн	574	650	1,379	1,478	1,562	28.4%
	сая ам.доллар	839	949	2,575	2,280	1,608	17.7%
Молибдены баяжмал	тонн	4,306	3,984	3,994	5,023	5,776	7.6%
	сая ам.доллар	38	29	35	29	26	(8.8)%
Нүүрс	мян.тонн	20,547	18,194	19,481	14,426	25,714	5.8%
	сая ам.доллар	1,880	1,116	849	555	972	(15.2)%
Төмрийн хүдэр	мян.тонн	6,416	6,724	6,325	5,065	6,085	(1.3)%
	сая ам.доллар	533	654	446	227	250	(17.2)%
Боловсруулаагүй алт	кг	2,797	7,559	10,041	11,343	19,169	61.8%
	сая ам.доллар	122	310	405	421	758	57.8%
Цайрын баяжмал	мян.тонн	141	131	99	84	126	(2.7)%
	сая ам.доллар	131	119	113	102	145	2.7%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

<http://www.customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info&pid=0&id=131>

Ашигт малтмалын экспорт (үнийн дүнгээр)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл дээр үндэслэн бэлтгэв.

2013 оноос 2014 онд зэсийн экспорт 112 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтийн гол шалтгаан нь Оюу Толгойн зэсийн олборлолт нэмэгдэж 2013 оны дунд үеэс борлуулалт хийж эхэлсэнтэй холбоотой. Энэхүү зэсийн экспорт нь 2016 он хүртэл өссөн боловч зэсийн үнийн бууралтаас хамаарч үнэ цэнийн бууралт бий болсон.

2012 оноос 2015 онуудад нүүрсний үнэ буурсан нь нүүрсний экспортын нийт хэмжээ, дүн буурахад гол нөлөө үзүүлсэн. 2016 оны экспортын нүүрсний 85%-аас илүү хувь нь коксжих, түүхий коксжих болон задгай коксжих нүүрс байсан. АМГТГ-аас бэлдэн гаргасан 2016 оны статистик тайлангаар, нүүрсний үнэ 2015 онд 1 тонн нь 106.3 ам.доллар байснаас 2016 онд 121.3 ам.доллар болж өссөн нь нүүрсний экспортын хэмжээ, үнийн дүнг 78% ба 75%-аар тус тус өсгөхөд хүргэсэн байна.

Мөн уг статистик тайланд дурьдсанаар төмрийн хүдрийн экспорт 2015 оныг хүртэл буурсан шалтгаан нь үнийн бууралттай холбоотой байна. 2016 онд төмрийн хүдрийн үнэ 1 тонн нь 49.8 ам.доллар байснаас 62 ам.доллар болж өссөн нь төмрийн хүдрийн экспортын хэмжээ, үнийн дүнг 20% ба 10%-аар тус тус өсгөхөд хүрсэн байна.

Алтны экспорт 2014 оноос өмнө бага байсан нь 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт (<http://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>) орж алт боловсруулалтад ногдуулах татварын хэмжээг 5 хүртэл хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч, Оюу Толгойн нэмэлт олборлолтоос үүдэн алтны экспорт 2013 болон 2014 онуудад 170.3% ба 32.8%-аар тус тус өссөн. Түүнчлэн, 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Ашигт малтмалын тухай хуулийн алт боловсруулалтад ногдуулах 5 хувийн нэмэлт татварыг хүчингүй болгох нэмэлт өөрчлөлт нь 2014 оны алтны экспортын өсөлтөд нөлөөлсөн. Ашигт малтмалын тухай хуулиар Монгол банкинд эсвэл Монгол банкны зөвшөөрсөн банкинд борлуулсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд тооцохгүй болсон.

2012 оноос 2016 онд экспортод гаргасан нийт зэс, молибден, нүүрс, төмрийн хүдэр болон цайрын баяжмалын ихэнх хэсэг нь Хятад улс руу экспортлогдсон бол алтыг гол төлөв Канад, Нэгдсэн Вант Улс болон Швейцарь улс руу экспортолсон байна.

Гол нэр төрлийн ашигт малтмал

Доор дурьдсан хэсэгт ОТАХ-ийн Эхлэлтийн семинарын үеэр дэлгэрэнгүй мэдээлэл хүссэн зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр болон мөнгө гэсэн 5 нэр төрлийн ашигт малтмал болон түгээмэл тархацтай ашигт малтмалыг хамруулсан болно.

Зэс

Олон Улсын Зэсийн Судалгааны Группын мэдээлснээр Ази тив 2016 онд дэлхийн зэсийн олборлолтын 60-аас илүү хувийг ашигласан. Си Эн Би Си-ийн тайлагнаснаар зэсийн гол хэрэглэгч Хятад улс 2020 он гэхэд

зэсийн үнийг 33% хүртэл өсгөх тооцоо байна. АМГТГ-ын бэлтгэн гаргасан 2016 оны статистик судалгаагаар Монгол Улс нь 53.6 сая тонн зэсийн бүртгэгдсэн нөөцтэй байна.

Уг статистик судалгаанд дурьдсанаар 2015 болон 2016 онд зэсийн үнэ 1 тонн нь дунджаар 5,501.00 ам.доллар болон 5,665.83 ам. доллар тус тус байсан байна.

Үнийн дүнгээр авч үзвэл 2016 онд Монгол Улсад хамгийн их олборлогдож борлуулагдсан ашигт малтмал зэс байжээ. Монгол Улс нийтдээ 3,772,641 сая төгрөгийн 1,504 мянган тонн зэс олборлож, 1,483 мянган тонн зэсийг 3,719,545 сая төгрөгөөр борлуулсан байна.

Оюу Толгой болон Эрдэнэт уурхай нь Монгол Улсын олборлох салбар дахь гол зэс олборлолтын уурхайнууд юм. Дэлгэрэнгүй мэдээллийг доор тайлбарласан болно.

Оюу Толгой уурхай

Оюу Толгой ХХК нь Монгол Улсын Засгийн Газар (34%) болон Туркойс Хилл Ресурс (66%) (Рио Тинтогийн охин компани)-ын хамтын эзэмшилд байдаг Монгол Улсын томоохон зэс болон алт олборлодог уул уурхайн компани юм. Оюу Толгойн уурхай нь 5,000 гаруй үндсэн болон гэрээт ажиллагсадтай бөгөөд дэлхий дээрх сайн чанарын зэсийн ашиглагдаагүй томоохон ордын нэгд тооцогддог. Оюу толгой нь бүтээн байгуулалтын эхний 2 үе шатандаа 10 тэрбум ам.долларын ГШХО-ыг оруулж ирсэн.

Оюу Толгойн түүх	
Жил	Тайлбар
2009	Аравдугаар сард хувь нийлүүлэгчдийн гурвалсан түншлэлийн гэрээнд ЗГ, Канадын Айвенхоу Майнз болон Рио Тинто компаниуд гарын үсэг зурсан. Энэхүү гэрээний дагуу хөрөнгө оруулалт нь 2 үе шаттайгаар хийгдэхээр болсон бөгөөд эхний үе шат нь ил уурхайн ашиглалт, баяжуулах үйлдвэр, холбогдох дэд бүтэц болон урьдчилсан уурхайн ам малтах ажлаас бүрдэх бөгөөд хоёр дахь үе шат нь далд уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрийн сайжруулалт болон хүдрийн далд уурхайн дэд бүтцийн ажлуудаас бүрдсэн байна.
2013	Зургадугаар сард зэсийн баяжмал болон алтны олборлолт эхлэв.
2013-2014	Рио Тинто болон ЗГ төслийн өртөг, удирдлагын зардал, татвар, усны хэрэглээ болон бусад асуудлууд дээр санал зөрөн зөвшилцөлд хүрч чадаагүй.
2014	Зургадугаар сард ЗГ-ын зүгээс ойролцоогоор 130 сая ам.долларын татварын нөхөн төлбөрийг шаардсан боловч Оюу Толгой үүнийг үндэслэлгүй гэж үзсэн. Энэ нь хөрөнгө оруулагчдад Оюу Толгой 2014 онд ямар нэгэн дэвшил гарахгүй гэсэн таамаглалыг бий болгожээ.
2015	Есдүгээр сард Татварын Маргаан Таслах Зөвлөлөөс татварын нэхэмжлэлийг 30 сая ам.доллар болгон бууруулсан. Анхны 33 маргаантай зүйлсийн жагсаалтыг нэг болгон багасгасан байна. Хоёрдугаар сард, 2013 оны зургадугаар сард олборлолт эхэлснээс хойш баяжмалын олборлолт 1 сая тоннд хүрсэн. Тавдугаар сард, ЗГ болон Рио Тинто хоорондын татварын маргаан болон зардлын асуудлуудаа шийдвэрлэн 5.4 тэрбум ам.долларын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлаа үргэлжлүүлэх гэрээнд гарын үсэг зурав.
2016	Гүний уурхайн налуу ам, үйлчилгээний порталын газар шорооны ажлыг, налуу нэвтрэлтийг 2017 оны 1 дүгээр сараас эхлүүлэх боломжтой болсон. 2016 оны сүүлээр гүний уурхайд 1.6 км-тэй тэнцэх хөндлөн нэвтрэлт гүйцэтгэжээ. 2016 онд Оюу Толгой нь 828,600 тонн баяжмалын борлуулалтаас 1.2 тэрбум ам.долларын орлого олж 210.6 сая ам.долларын цэвэр ашгийг бүртгэсэн байна.
Цаашид	2017 оны хувьд Оюу Толгой нь 130-аас 160 мянган тонн зэс болон 100-аас 140 мянган унц алт олборлох хүлээлттэй байгаа бөгөөд энэхүү таамаглалтай харьцуулахад, Оюу Толгой нь 2016 оны хувьд 201,300 тонн зэс болон 300,000 унц алт олборлосон байна.

Эх сурвалж: Оюу Толгойн цахим хуудас болон Туркойс Хилл Ресурсийн цахим хуудас
http://www.turquoisehill.com/s/oyu_tolgoi.asp?ReportID=379189

Эрдэнэт Уурхай

Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 51%-ийг Монгол Улсын ЗГ эзэмшдэг. Үлдсэн 49%-ийг 2016 оны зургадугаар сарын 28-ны өдөр Ростек Корпорациас Монголын Зэс Корпораци ХХК худалдан авсан билээ. Гэсэн хэдий ч, 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ЗГ-ын 23 дугаар тогтоолын дагуу Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 49%-ийг ЗГ-т шилжүүлэх шийдвэр гарсан. Үүний дагуу, Монголын Зэс Корпораци ХХК нь 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр ЗГ-ын эсрэг шүүхэд хандсан байна. Үүний хариуд, Нийслэлийн шүүхээс 2017 оны ЗГ-ын 23 дугаар тогтоолыг хууль бус гэж үзсэн ба энэхүү хуулийн зарга нь шийдэгдээгүй байна. Одоогийн байдлаар Эрдэнэт Үйлдвэр нь жилд 26 сая тонн хүдрийн биет боловсруулах хүчин чадалтай ба ойролцоогоор 530 мянган тонн зэсийн баяжмал болон 4.5 мянган тонн орчим молибдены баяжмал олборлох хүчин чадалтай юм. Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн уурхай нь 6,000 орчим ажиллагсадтай.

Эрдэнэт уурхайн түүх	
Жил	Тайлбар
1978	Анхны баяжмал гарган авч жилд 4 сая тонн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадал бүхий уулын баяжуулах үйлдвэрийн эхний хэсгийг ашиглалтад оруулав.
1980	Жилд 8 сая тонн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэрийн хоёрдугаар хэсгийг ашиглалтад оруулав.
1981	Үйлдвэрийн гурав болон дөрөвдүгээр хэсгүүдийг ашиглалтад оруулж, жилд 16 сая тонн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадалтай болов.
1989	Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн тавдугаар хэсгийг ашиглалтад оруулж, хүдэр олборлох, боловсруулах хүчин чадлыг жилд 20 сая тонн хүртэл нэмэгдүүлэв. Баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноос хойш нийт 1 сая тонн зэсийн агууламжтай баяжмал олборлов.
2000	Хам хөвүүлэн баяжуулах хэсгийг ашиглалтад оруулж, жилд 24 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай болов.
2012	Хүдэр боловсруулалтын хүчин чадлыг 26 сая тоннд хүргэв.
2013	Ашигт малтмал боловсруулах үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах 6 дугаар хэсгийг орлуулж эхлүүлсэн байна.
Цаашдын хандлага	Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 2020 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус компани нь байгаль орчинд ээлтэй, цахилгаан энерги бага зарцуулдаг шинэ технологи нэвтрүүлэх замаар үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулж, хүдэр боловсруулалтын хүчин чадлыг жилд 35 сая тонн болгон нэмэгдүүлж, нэгж бүтээгдэхүүний зардлыг бууруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорьж байна.

Эх сурвалж: Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн цахим хуудас
https://www.erdnetmc.mn/en/about_us/

Нүүрс

АМГТГ-аас бэлтгэн гаргасан 2016 оны статистик тайланд дурьдсанаар Монгол Улс нь 26,570 сая тонн нүүрсний бүртгэгдсэн нөөцтэй байна. Дэлхийд нийт илэрсэн нүүрсний нөөцийн 10% нь Монгол Улсад байдаг. Коксжих нүүрс Монгол Улсын газар нутгийн төв, зүүн болон уулархаг бүс нутгаар тархсан байдаг бол хүрэн нүүрс нь зүүн бүс нутгаар элбэг байдаг. Одоогийн байдлаар 294 нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Мөн уг тайланд мэдээлснээр 2016 оны экспортын нүүрсний 85%-аас илүү хувь нь коксжих, түүхий коксжих болон задгай коксжих нүүрс байсан. Нүүрсний үнэ 2015 онд 1 тонн нь 106.3 ам.доллар байснаас 2016 онд 121.3 ам.доллар болж өссөн. Монгол Улсын нүүрсний үнэ нь Хятад Улсын эдийн засгаас хамааралтай бөгөөд Монгол Улсын Гаалийн мэдээгээр 2012 оноос 2016 онуудын ихэнхи нүүрсний экспорт Хятад Улс руу хийгдсэн байна. Нүүрсний үнийн өсөлт нь уурхай дахь жилийн ажлын өдрүүдийн тоог бууруулах Хятадын Засгийн Газраас баталсан шинэ бодлоготой холбоотой гэж Блумберг мэдээлсэн байна.

2016 онд нийт 1,345,993 эрчим хүчний нүүрс, бор нүүрс, баяжуулсан нүүрс, чулуун нүүрс, задгай коксжсон нүүрс болон коксжоогүй нүүрсийг олборлож 792,933 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Молибден

АМГТГ-ын 2016 оны статистик тайланд мэдээлснээр Монгол Улс 650 мянган тонн молибдены бүртгэгдсэн нөөцтэй. Молибдены дундаж үнэ 2015 болон 2016 онуудад тус бүр 1 тонн нь 14,618 ам.доллар болон 15,000 ам.доллар байсан. Молибдены зах зээлийн тогтворгүй орчноос болж АНУ-д хэд хэдэн молибдены уурхай хаагдсан нь молибдены үнэ бага зэрэг өсөх шалтгаан болсон байна гэж mining.com сайт мэдээлжээ.

Монгол Улсад 2016 онд молибдены борлуулалт 58,639 сая төгрөгт хүрчээ.

Мөнгө

АМГТГ-ын 2016 оны статистик тайланд мэдээлснээр мөнгөний дундаж үнэ 2015 болон 2016 онуудад тус бүр 1 унц нь 15.7 ам.доллар болон 16.38 ам.доллар байсан байна. Форбсын мэдээлснээр мөнгө нь үйлдвэрлэлийн болон хөрөнгө оруулалтын хос үүрэгтэй металл юм. Си Эн Эн-ийн мэдээлснээр 2016 онд мөнгөний үнэ өссөн шалтгаан нь нарны зай хураагуурт хэрэглэгдсэн 10%-ийн хэрэглээ болон аж үйлдвэрлэлийн салбарын хэрэглээний эрэлтээс болсон байна.

Төмрийн Хүдэр

АМГТГ-ын 2016 оны статистик тайланд мэдээлснээр Монгол Улс 348,107 мянган тонн төмрийн хүдрийн бүртгэгдсэн нөөцтэй байна.

Төмрийн хүдрийн дундаж үнэ 2015 болон 2016 онуудад тус бүр 1 тонн нь 49.8 ам.доллар болон 62 ам.доллар байсан байна. Форбс-д мэдээлснээр 2016 онд төмрийн хүдрийн үнэ өссөн нь Хятад Улсаас ирэх төмрийн хүдрийн тогтмол эрэлт болон зах зээлийн гол нийлүүлэгчдийн төмрийн хүдэр нийлүүлэлтийн бууралтаас шалтгаалсан байна. Болд Төмөр Ерөө Гол болон Алтайн Хүдэр компаниуд нь Монгол Улс дахь төмрийн хүдрийн гол экспортлогч компаниуд юм.

Алт

АМГТГ-ын 2016 оны статистик тайланд мэдээлснээр Монгол Улс 591,244 мянган тонн алтны бүртгэгдсэн нөөцтэй байна. Алтны дундаж үнэ 2015 болон 2016 онуудад 1 унц нь тус бүр 1,160.1 ам.доллар болон 1,151.4 ам.долларын байсан байна. 2016 оны алтны үнийн бууралтын гол шалтгаан нь АНУ-ын хүүгийн түвшний өсөлттэй холбоотой юм.


Түгээмэл тархацтай ашигт малтмал (элс, хайрга, дайрга, шавар болон боржин чулуу)

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд (<http://www.legalinfo.mn/law/details/9750>) элс, хайрга, дайрга, шавар болон боржин чулууг түгээмэл тархацтай ашигт малтмалууд гэж авч үздэг ба эдгээр нь барилгын ажилд ихэвчлэн хэрэглэгддэг. МОҮИТБС-ын тусгай зөвшөөрлийн бүртгэл (<https://e-reporting.eitimongolia.mn/portalMap>) нь эдгээртэй холбоотой тусгай зөвшөөрлүүдийг барилгын материал дор нэгтгэдэг. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын хувьд нийт 311 барилгын материал олборлолтын тусгай зөвшөөрлүүд бүртгэгдсэн ба үүний 134 нь Улаанбаатар хотын орчим байрласан байна. Улаанбаатар, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул болон Дорноговь аймгуудад нийт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн 84% байдаг.

2016 онд Монгол Улс нь 401 мянган тонн буюу 6,306 сая төгрөгийн үнэ бүхий буталсан чулууг үйлдвэрлэж, 349 мянган тонныг 6,137 сая төгрөгөөр борлуулсан байна. Мөн ижил хугацаанд 260 мянган тонн буюу 1,936 сая төгрөгийн үнэ бүхий хайрга үйлдвэрлэж, 366 мянган тонныг 2,716 сая төгрөгөөр борлуулсан байна. Монгол Улс нь 9,185 мянган ширхэг тоосго үйлдвэрлэж, 6,176 мянган тонныг 847 сая төгрөгөөр борлуулсан байна.

5.1.3.3 Ашиглалтын гол бүс нутгууд болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд (ША 6.2д)

УИХ нь томоохон ордуудад хийгдсэн хайгуулын ажлуудын үр дүнг хянаж, тус ордын улс орны эдийн засаг, ДНБ, үндэсний аюулгүй байдал болон нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөг үндэслэн стратегийн ач холбогдол бүхий орд газрыг тодорхойлдог. Нийт 3,579 тусгай зөвшөөрөлтэй газар байгаагаас 16 ордыг УИХ стратегийн ач холбогдолтой хэмээн үзжээ:



Эх сурвалж: УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоол болон 2015 оны 11 дүгээр тогтоолыг ашиглан бэлтгэв.
<http://www.legalinfo.mn/law/details/6523?lawid=6523>
<http://www.legalinfo.mn/law/details/10875?lawid=10875>

Орон нутгийн (аймаг, сумдын) олборлолт болон борлуулалт

АМГТГ-аас авсан мэдээллээс үзэхэд нүүрс олборлогч компаниудыг оролцуулахгүйгээр 115 компани олборлолт, борлуулалтын тайлангаа АМГТГ-г тайлагнасан бөгөөд тэдгээрийг орон нутгийн бүсээр ангилсныг дараах хүснэгтээс харна уу:

Аймаг, сумдын олборлолт болон борлуулалт						
Аймаг	Сум	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Олборлолт хэмжээ	Борлуулалт хэмжээ	Борлуулалт дүн сая төг.
Архангай	Цэнхэр	Алт	кг	88.88	88.89	8,417
		Мөнгө	кг	19.49	25.60	30
Баян-Өлгий	Цэнгэл	Гянтболдын баяжмал	000' тонн	0.52	0.52	9,549
Баянхонгор	Баян-Овоо	Алт	кг	18.81	18.81	1,648
		Мөнгө	кг	1.37	1.37	1
	Баян-Овоо, Галуут	Алт	кг	0.96	0.96	89
		Мөнгө	кг	0.07	0.07	0
	Галуут	Нүүрс	000' тонн	49.6	49.6	2,117
		Алт	кг	30.10	30.10	2,691
	Гурванбулаг	Мөнгө	кг	0.92	1.30	1
		Алт	кг	134.05	134.05	11,851
Шинэжинст	Алт	кг	13.85	13.85	16	
	Нүүрс	000' тонн	0.4	0.4	17	
Булган	Бүрэгхангай	Алт	кг	385.22	406.00	35,909

Аймаг, сумдын олборлолт болон борлуулалт						
Аймаг	Сум	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Олборлолт хэмжээ	Борлуулалт хэмжээ	Борлуулалт дүн сая төг.
		Молибдены баяжмал	Кг	20.77	0	0
		Мөнгө	кг	31.44	32.92	35
Булган, Төв	Бүрэгхангай, Заамар	Алт	кг	493.93	493.98	43,273
		Мөнгө	кг	3.28	35.73	38
	Дашчилэн, Заамар	Алт	кг	67.24	67.24	6,355
		Мөнгө	кг	7.20	7.21	9
Говь-Алтай	Чандмань	Нүүрс	000' тонн	4	2.98	127.25
Дархан-Уул	Дархан	Тоосго	000' ш	1,104.60	970.54	172
	Хонгор	Хайрга	000' тонн	2.41	2.41	36
	Шарын гол	Нүүрс	000' тонн	761.90	753.70	32,184
		Алт	кг	39.49	39.50	3,523
		Мөнгө	кг	3.25	3.25	3
Дорноговь	Айраг	Манганы баяжмал	000' тонн	0.67	0.67	95
		Манганы хүдэр	000' тонн	28.08	28.08	2,096
	Даланжаргалан	Нүүрс	000' тонн	642.17	378.78	23,096
		Дайрга	000' тонн	144.51	144.50	2,874
		Жонш	000 м3	7.78	10.94	2,930
	Мандах, Хөвсгөл	Нүүрс	000' тонн	1.20	18.08	772
	Өргөн	Нүүрс	000' тонн	268.24	279.00	26,186
	Улаанбадрах	Шохойн чулуу	000' тонн	264.30	81.80	11,083
	Гөлтгөнө	000' тонн	0.65			
Дорнод	Баяндун	Алт	кг	31.34	31.34	2,861
		Мөнгө	кг	2.34	2.52	3
Дундговь	Баянтүмэн	Нүүрс	000' тонн	568.90	584.50	24,959
	Баянжаргал	Жонш	000' тонн	1.54	1.54	220
	Дэлгэрхангай	Гөлтгөнө	000' тонн	28.79	11.34	377
Завхан	Дөрвөлжин	Алт	кг	559.56	559.49	48,609
		Мөнгө	кг	1.85	2,233.29	2,533
Орхон	Баян-Өндөр, Жаргалант	Зэсийн баяжмал	000' тонн	657.35	657.35	1,173,466
		Молибдены баяжмал	000' тонн	5.78	5.78	58,639
Өвөрхангай	Нарийнтээл	Нүүрс	000' тонн	149.30	149.30	6,375
	Уянга	Алт	кг	27.77	27.77	2,481
		Мөнгө	кг	0.40	4.38	5
Өмнөговь	Гурвантэс	Нүүрс	000' тонн	11,183.10	11,916.37	1,118,337
	Ноён	Нүүрс	000' тонн	35.20	88.60	3,783
	Цогтцэций	Нүүрс	000' тонн	10,290.00	8,137.58	758,402
	Ханбогд	Зэсийн баяжмал	000' тонн	846.56	825.39	2,546,079
	Ханхонгор	Дайрга	000' тонн	11.97	11.96	239
Сүхбаатар	Сүхбаатар	Цайрын баяжмал	000' тонн	86.68	101.27	150,223
		Жонш	000' тонн	2.24	0.00	0
	Түмэнцогт	Жоншны хүдэр	000' тонн	8.00	8.15	300
		Жоншны баяжмал	000' тонн	9.00	9.47	5,295
	Эрдэнэцагаан	Нүүрс	000' тонн	0.00	7.73	395
Сэлэнгэ	Баянгол	Алт	кг	6.21	6.21	608
		Мөнгө	кг	0.24	0.24	0
	Орхонтуул	Алт	кг	2.66	2.66	252
		Мөнгө	кг	0.17	0.17	0
	Түшиг	Нүүрс	000' тонн	0.00	3.01	129
Төв	Алтанбулаг	Дайрга	000' тонн	128.74	156.39	1,563
		Хайрга	000' тонн	32.80	43.80	353
	Баян	Алт	кг	22.69	38.95	3,403
		Нүүрс	000' тонн	29.42	29.42	1,256
		Шохойн чулуу	000' тонн	141.25	143.48	3,182
		Гангиг	000' тонн	18.26	18.26	162
	Баянцагаан	Шохойн чулуу	000' тонн	5.00	5.00	46
	Баянчандмань	Гянтболдын баяжмал	000' тонн	0.32	3.16	3,667
		Алт	кг	1,095.30	1,110.72	96,375
	Заамар	Мөнгө	кг	93.91	111.91	102
		Алт	кг	36.88	36.88	3,413
Сэргэлэн	Мөнгө	кг	0.00	2.84	257	
	Эрдэнэ	Шохойн чулуу	000' тонн	23.77	23.78	238

Аймаг, сумдын олборлолт болон борлуулалт						
Аймаг	Сум	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Олборлолт хэмжээ	Борлуулалт хэмжээ	Борлуулалт дүн сая төг.
Төв, Улаанбаатар	Алтанбулаг, Хан-Уул	Хайрга	000' тонн	40	130.97	314
Улаанбаатар	Баянзүрх, Баяндэлгэр, Багануур	Дайрга	000' тонн	79.97	0.11	1,139
		Нүүрс	000' тонн	3,913.80	3,908.00	166,876
	Налайх	Тоосго	000' ш	1,320.00	3,388.04	374
		Хайрга	000' тонн	19.48	26.33	233
		Элс	кг	8.27	19.72	133
	Сонгинохайрхан	Тоосго	000' ш	6,760.00	1,816.93	301
	Хан-Уул	Дайрга	000' тонн	35.80	35.80	322
Хайрга		000' тонн	168.06	164.48	1,817	
Увс	Бөхмөрөн	Нүүрс	000' тонн	106.10	106.10	4,531
Ховд	Дарви	Нүүрс	000' тонн	1,073.49	610.13	43,238
Хэнтий	Баян-Овоо	Жоншны хүдэр	000' тонн	2.31	3.00	730
		Жоншны баяжмал	000' тонн	4.00	1.17	454
	Галшар	Жоншны хүдэр	000' тонн	1.00	0.00	0
		Алт	кг	0.00	0.90	84
	Цэнхэр	Мөнгө	кг	0.00	0.21	0
	Мөрөн	Нүүрс	000' тонн	42.01	42.28	1,805
	Цэнхэр	Жонш	000' тонн	0.00	0.01	3,198
	Цэнхэрмандал	Цагаан тугалганы баяжмал	000' тонн	0.01	0.01	101
Гянтболдын баяжмал		000' тонн	0.01	0.02	289	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.1.4 Газрын тосны тойм мэдээлэл

Монгол Улсад нийт 32 газрын тосны талбай байдгаас олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гурван талбай, хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 22 газар байгаа ба бусад талбайд эрлийн үйл ажиллагаа явуулж байна. Газрын тос олборлож буй 3 талбайд 2 компани үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ПэтроЧайнагийн охин компани болох ПэтроЧайна Дачин Тамсаг ХХК нь газрын тосны дийлэнхийг олборлож экспортод гаргадаг. Одоогийн байдлаар Монгол Улсад газрын тос боловсруулах тоног төхөөрөмж байхгүйн улмаас олборлосон газрын тосыг түүхий газрын тос хэлбэрээр экспортлож байна. Монгол Улс дотоодын хэрэгцээний газрын тосоо ихэвчлэн ОХУ-аас импортлодог.

5.1.4.1 Томоохон хэмжээний хайгуулын үйл ажиллагаа (ША 3.1)

Дараах хүснэгтэд АМГТГ-ын мэдээлсэн газрын тосны томоохон хэмжээний хайгуулын үйл ажиллагааг харуулав.

2016 онд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн газрын тосны хайгуулын төслүүд						
Талбайн нэр	Байршил	Техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байдал	Баталгаат нөөц	Нөөцийн хэмжээ	Хайгуул хийгдэх хугацаа	
1 Увс	Увс	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2015-2023 он	
2 Хар-Ус	Увс, Ховд, Завхан, Говь-Алтай	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2015-2023 он	
3 Богд	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2019 он	
4 Онги	Өвөрхангай, Дундговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2019 он	
5 Борзон	Өмнөговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2017 он	
6 Төхөм	Дундговь, Дорноговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2012-2020 он	
7 Галба	Өмнөговь, Дорноговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2019 он	
8 Эргэл	Дорноговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2016-2024 он	
9 Тариач	Дорноговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2007-маргаантай	
10 Нялга	Төв, Хэнтий, Дундговь, Говьсүмбэр	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2007-маргаантай	
11 Баянтүмэн	Дорнод	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2019 он	
12 Хөх Нуур	Дорнод	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2018 он	
13 Магад	Дорнод	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2007-2018 он	
14 Сулинхээр	Дорноговь	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2009-2018 он	
15 Дарьганга	Сүхбаатар	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2011-2019 он	
16 Сүхбаатар	Сүхбаатар	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2013-2021 он	
17 Хэрлэн Тохой	Дорнод, Сүхбаатар	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2015-2023 он	
18 Арбулаг	Дорнод, Сүхбаатар	үгүй	тогтоогдоогүй	тогтоогдоогүй	2016-2024 он	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

2016 онд Макс Ойл ХХК-тай Арбулаг (XXIX) талбайд болон Смарт Ойл Инвестмент ХХК-тай Эргэл (XIII) талбайд БХГ шинээр хийсэн ба харгалзах тусгай зөвшөөрлүүдийг 2017 онд авсан. Түүнчлэн, 2016 онд Буйр (XXII) БХГ-ний хугацаа дууссан.

Доорх хүснэгтэд ПэтроЧайна Дачин Тамсаг ХХК болон Дон Шен Жонгонг Петролиум Девелопмент Группын гүйцэтгэсэн хайгуулын ажлын дэлгэрэнгүйг АМГТГ-ын тайлагнасанаар харуулав:

Олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувийн хөрөнгөөр хийсэн газрын тосны хайгуулын ажлууд				
Тал бай	Талбайн нэр	БХГ Эзэмшигч	Геологи, хайгуулын ажил	Зарцуулсан өртөг (сая ам.доллар)
XIX	Тосон-Уул	ПэтроЧайна Дачин Тамсаг ХХК	<ul style="list-style-type: none"> - 21 цооног өрөмдөж, каротаж, цементаци хийсэн. (2500 м хүртэлх 12 цооног, 2500 м-ээс дээш гүнтэй 9 цооног) - 51 удаа 1,863 м-т перфораци хийсэн. - 45 цооногт шингэн хагалбар хийсэн. - 57,214.781 тонн тос шавхалтаар олборлосон. - Цооногоос шингэн хагалбарын 2,589.52 тонн шингэн шавхсан. - 5 цооногоос гүний тоног төхөөрөмж сугалах ажил хийгдсэн. - 8 гидрогеологийн судалгаа болон усны цооног өрөмдсөн. - 9000 м3 технологийн хаягдал буюу тостой шороог цэвэршүүлсэн. - 289 цооногт шахуурга суурилуулах болон цооногийн засвар үйлчилгээ ажил хийгдсэн. - Ашиглалтын 241 цооногт каротажийн ажил хийгдсэн. - Бусад ажил болон зардлууд 	82.75
XXI	Тамсаг	ПэтроЧайна Дачин Тамсаг ХХК	<ul style="list-style-type: none"> - 18 цооног өрөмдөж, каротаж, цементаци хийсэн. (2500м хүртэлх 18 цооног, 2500 м-ээс дээш гүнтэй 0 цооног) - 60 удаа 1679 м-т перфораци хийсэн. - 70 цооногт 143 үед шингэн хагалбар хийсэн. - 281 цооногт шахуурга суурилуулах болон цооногийн засвар үйлчилгээ ажил хийгдсэн. - Ашиглалтын 275 цооногт каротажийн ажил хийгдсэн. - Бусад ажил болон зардлууд 	85.41
БХГ 97	БХГ-97	Дон Шен Жонгонг Петролиум Девелопмент Групп	<ul style="list-style-type: none"> - 40 цооногт шахуурга суурилуулах болон цооногийн засвар үйлчилгээний ажил хийгдсэн. - Хуучин 4 цооногийг ус шахалтанд шилжүүлсэн. - Ус шахалтанд шилжүүлсэн 4 цооногт гадаргуйн тоног төхөөрөмж суурилуулсан. - Ус шахалтын 2 цооногт хэмжилт тохиргоо хийсэн. - Хуучин 4 цооногт бэхэлгээний яндан болон сүмбэ солих ажил хийсэн. - Бусад зардлууд. 	6.25


Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.1.4.2 Газрын тосны бүтээгдэхүүн (ША 3.2)

Түүхий нефть


Блүмберг Бизнесийн мэдээлснээр газрын тосны дундаж үнэ 2015 онд баррель нь 50.75 ам.доллар байсан ба 2016 онд 42.81 ам.доллар болж буурсныг Саудын Араб Улс болон Оросын Холбооны Улсын зүгээс хэт нийлүүлэлт хийсэнтэй холбоотой гэж тайлбарласан. Монгол Улсын хувьд, газрын тосны экспортын хэмжээ өссөөр байгаа боловч экспортод гаргасан газрын тосны үнийн дүн 2015 болон 2016 онуудад буурсан үзүүлэлттэй байна.

Түүхий нефтийн экспортын хэмжээ



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэлд суурилан бэлтгэв.

Түүхий нефтийн экспортын дүн



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэлд суурилан бэлтгэв.

5.1.4.3 Олборлолтын гол бүсүүд болон экспорт (ША 6.2, ША 3.3)

2016 онд олборлолтын гурван бүсэд 8.25 сая тонн газрын тос олборлож, 8.06 сая тонныг экспортод гаргасан байна. БХГ XIX болон БХГ XXI нь Дорнод аймгийн Матад, Халхгол сумуудад байршилтай байдаг бол БХГ-97 нь Дорноговь аймгийн Сайншанд суманд байршилтай.

2016 оны газрын тосны олборлолт болон экспорт			(мян. баррель)
Аж ахуйн нэгж	Талбайн дугаар	Олборлолт	Экспорт
Петрочайна Дачин Тамсаг ХХК		7,884	7,704
Тосон-Уул	XIX	4,041	3,819
Тамсаг	XXI	3,843	3,885
Доншен Жонгонг Петролиум Девелопмент Групп	97	369	358
Нийт		8,253	8,062

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.1.4.4 БХГ болон бусад бэлэн бус орлого (ША 4.2)

Газрын тосны тухай хуулиар БХГ болон бусад газрын тостой холбоотой асуудлуудыг зохицуулдаг. БХГ-ний маягтыг ГТГ-ын цахим хуудасны хууль, эрх зүйн орчин хэсгээс харж болно (<https://mrpam.gov.mn/article/18/>).

АМГТГ-ын мэдээлснээр 21 ОУ-ийн компаниудтай 25 БХГ байгуулсан байдаг ба эдгээрээс зөвхөн 4 БХГ олон нийтэд ил тод болсон байна. Дэлгэрэнгүйг 5.5.2.2 хэсгээс харна уу.

Петрочайна Дачин Тамсаг ХХК болон Доншен Газрын Тос Монголиа ХХК нь 3 талбайд газрын тос олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд юм. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь Тосон-Уул, Тамсагийн талбайд БХГ-тэй бөгөөд Доншен Газрын Тос Монголиа ХХК нь Зүүнбаянгийн талбайд БХГ-тэй.

Газрын тосны тухай хуульд зааснаар газрын тос олборлогч аж ахуй нэгжүүд нь газрын тосны орлогоо Засгийн Газартай хийсэн БХГ-нд заасан хувь хэмжээний дагуу хуваадаг. АМГТГ-ын мэдэгдсэнээр компаниуд нь одоогийн дагаж байгаа тохиролцооны дагуу Засгийн Газарт борлуулалтын ашгийг бэлэн мөнгөөр төлдөг.

БХГ-ний маягтанд тусгагдсанаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь ЗГ-т 2 төрлийн төлбөр төлөх ёстой ба тэдгээр нь газрын тосны борлуулалтын орлогын ЗГ-т өгөх хувь болон газрын тосны нөөц ашигласны төлбөр юм. 2016 онд борлуулалтын орлогын ЗГ-т өгөх хувь болон газрын тосны нөөц ашигласны төлбөр нь нийт 133.7 тэрбум төгрөг байсан.

2016 онд БХГ-ний дагуу ЗГ-т төлсөн төлбөр			<i>Сая төг.</i>
Компани	Борлуулалтын орлогын ЗГ-ын хувь	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	
Петрочайна Дачин Тамсаг ХХК	107,771	18,360	
Доншен Газрын Тос Монголиа ХХК	5,329	2,238	
Нийт	113,100	20,598	
Нийт борлуулалтын орлого болон газрын тосны нөөц ашигласны төлбөр			133,698

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.1.5 Ураны тойм мэдээлэл (ША 3.1)

Ураны гол хэрэглээ нь цөмийн цахилгаан станцыг эрчим хүчээр хангах юм. Ураны хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрлүүдийг Цөмийн Энергийн Комисс олгодог. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад уран олборлолтын 9 тусгай зөвшөөрөл 4 компанийн, хайгуулын 22 тусгай зөвшөөрөл 7 компанийн мэдэлд байна.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх ураны тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 22.а болон 22.б-ээс харна уу.

Ураны тусгай зөвшөөрөл						
Тусгай зөвшөөрлийн дугаар	Эзэмшигчийн регистр #	Эзэмшигч компанийн нэр	Аймаг	Сумдууд	Талбайн нэр	Талбайн хэмжээ/га/
MV-000247	2830213	Шинь Шинь	Дорнод	Баяндун, Дашбалбар	Улаан	101.58
MV-013555	5035902	Хунбөө	Дорнод	Дашбалбар	Мухар-1	25.09
MV-018914	5502977	Аревамайнс	Дорноговь	Улаанбадрах	Өмнөт	2464.93
MV-018915	5502977	Аревамайнс	Дорноговь	Улаанбадрах	Зөөвч овоо	18813.05
MV-018916	5502977	Аревамайнс	Дорноговь	Улаанбадрах	Дулаан уул	32014.45
MV-020629	2074737	Гурвансайхан	Дундговь	Өлзийт	Хайрхан	4628.42
MV-020631	2074737	Гурвансайхан	Дундговь	Гурвансайхан	Гурвансайхан	2810.44
MV-020633	2074737	Гурвансайхан	Дундговь	Баянжаргалан, Өндөршил	Чойр	10386.24
MV-020634	2074737	Гурвансайхан	Сүхбаатар	Түвшинширээ, Уулбаян	Өлзийт	10665.22
XV-003367	2672146	Адамасмайнинг	Дорнод	Гурванзагал, Дашбалбар	Эрхт овоот толгой	39694.34
XV-007856	5077834	Зараяа холдингс	Дорноговь	Улаанбадрах	Гарган толгой	11692.43
XV-009688	5633028	Лукрий	Төв	Баян	Энгэр ар	1647.48
XV-010081	5633028	Лукрий	Дорноговь	Айраг	Улаан нуур	1504.06
XV-011921	2078449	Кожеговь	Дорноговь	Улаанбадрах	Дулаан	8049.71
XV-011946	2078449	Кожеговь	Дорноговь	Улаанбадрах	Зөөвч овоо	2198.71
XV-012251	2078449	Кожеговь	Дорноговь	Улаанбадрах	Богд уул	12153.19
XV-012685	5530725	Алкали метал монголиа	Дундговь	Өлзийт	Хөх дэл	12410.94
XV-013082	5633028	Лукрий	Баянхонгор	Жинст	Сэвсүүлийн булаг	1538.44
XV-013387	5633028	Лукрий	Өмнөговь	Булган	Үнэгт	11050.33
XV-013871	2078449	Кожеговь	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Боролт ухаа	13147.56
XV-013907	2078449	Кожеговь	Сүхбаатар	Асгат, Дарьганга	Шүүт	26533.73
XV-013908	2078449	Кожеговь	Сүхбаатар	Онгон	Хар тойром	18055.98
XV-013912	2078449	Кожеговь	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Хөх нүдэн	13875.55
XV-014017	2078449	Кожеговь	Сүхбаатар	Дарьганга, Наран	Дунд нарт	52677.4
XV-014429	2078449	Кожеговь	Сүхбаатар	Онгон	Ухаа овоо	48915.7
XV-014478	2078449	Кожеговь	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Усан толгой	5374.65
XV-014722	2078449	Кожеговь	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Хайрхан	32010.01
XV-018243	5150884	Монгол ураниум ресурс	Дорноговь	Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах	Шувуун уул	117300.65
XV-018247	5150884	Монгол ураниум ресурс	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Хэрмийн цагаан өндөр	208135.06
XV-018953	5976723	Мончех ураниум	Хэнтий	Норовлин	Холбоо	23801.22
XV-020847	2078449	Кожеговь	Дорноговь	Улаанбадрах	Богд уул	4927.19

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Доорх графикт ураны тусгай зөвшөөрөлтэй бүсийг талбайн хэмжээгээр үзүүлэв.



Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэлд үндэслэв.

5.2 ОУ-ийн тусгай зөвшөөрөл

Ашигт малтмалын болон газрын тосны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг олгох үе шат нь хоорондоо ялгаатай байдаг. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үе шатыг 5.2.1 хэсэгт, газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үе шатыг 5.2.2 хэсэгт авч үзлээ.

Баянхонгор, Дорнод, Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Хэнтий, мөн Завхан аймгууд тусгай зөвшөөрлийн талбайн ихэнх хэсгийг буюу улсын хэмжээнд олгогдсон нийт талбайн 78.8%-тай тэнцэх хэмжээний талбайг хамраж байна. Дараах хүснэгтэд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн газар зүйн байршил 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харууллаа:


	Тусгай зөвшөөрлийн тоо			Талбай (га)			
	Хайгуул	Ашиглалт	Нийт	Хайгуул	Ашиглалт	Нийт	Талбай %
Архангай	15	21	36	66,071	12,442	78,513	0.6%
Өвөрхангай, Архангай	-	5	5	-	3,997	3,997	0.0%
Баян-Өлгий	63	25	88	320,892	10,628	331,520	2.5%
Баянхонгор	98	82	180	482,790	58,523	541,313	4.0%
Завхан, Баянхонгор	2	-	2	8,038	-	8,038	0.1%
Булган	63	44	107	391,586	13,610	405,196	3.0%
Булган, Орхон	3	1	4	192,846	54	192,900	1.4%
Булган, Сэлэнгэ	1	4	5	1,699	2,624	4,323	0.0%
Булган, Төв	2	16	18	1,587	8,101	9,688	0.1%
Говь-Алтай	146	43	189	1,238,017	66,198	1,304,215	9.7%
Завхан, Говь-Алтай	1	-	1	16,829	-	16,829	0.1%
Говь-Алтай, Ховд	2	-	2	6,282	-	6,282	0.0%
Говьсүмбэр	5	7	12	35,225	32,333	67,558	0.5%
Говьсүмбэр, Дорноговь	1	2	3	10,899	8,412	19,311	0.1%
Дундговь, Говьсүмбэр	1	2	3	16,413	505	16,918	0.1%
Төв, Говьсүмбэр	-	1	1	-	524	524	0.0%
Дархан-Уул	20	60	80	14,960	7,301	22,261	0.2%
Сэлэнгэ, Дархан-Уул	3	8	11	4,815	3,977	8,792	0.1%
Дорноговь	282	159	441	1,924,862	176,419	2,101,281	15.6%
Дундговь, Дорноговь	1	-	1	4,200	-	4,200	0.0%
Дорноговь, Өмнөговь	4	-	4	77,862	-	77,862	0.6%
Дорноговь, Сүхбаатар	1	-	1	12,901	-	12,901	0.1%
Дорноговь, Хэнтий	4	2	6	8,850	115	8,965	0.1%
Дорнод	130	67	197	616,128	55,135	671,263	5.0%
Дорнод, Сүхбаатар	1	-	1	21,397	-	21,397	0.2%
Дундговь	140	83	223	905,649	145,747	1,051,396	7.8%
Өвөрхангай, Дундговь	2	-	2	50,997	-	50,997	0.4%
Дундговь, Өмнөговь	1	-	1	14,369	-	14,369	0.1%
Дундговь, Төв	2	-	2	4,821	-	4,821	0.0%
Завхан	78	6	84	541,421	12,355	553,776	4.1%
Увс, Завхан	3	1	4	7,864	20	7,884	0.1%
Орхон	1	8	9	44	4,137	4,181	0.0%

	Тусгай зөвшөөрлийн тоо			Талбай (га)			
	Хайгуул	Ашиглалт	Нийт	Хайгуул	Ашиглалт	Нийт	Талбай %
Өвөрхангай	25	24	49	101,230	12,023	113,253	0.8%
Өмнөговь	156	91	247	1,546,122	491,613	2,037,735	15.1%
Сүхбаатар	58	58	116	809,801	48,358	858,159	6.4%
Сүхбаатар, Хэнтий	3	-	3	11,786	-	11,786	0.1%
Сэлэнгэ	59	117	176	121,227	26,230	147,457	1.1%
Сэлэнгэ, Төв	5	3	8	5,364	3,446	8,810	0.1%
Төв	152	257	409	376,470	125,043	501,513	3.7%
Улаанбаатар, Төв	2	13	15	200	5,434	5,634	0.0%
Увс	172	41	213	909,069	15,050	924,119	6.9%
Увс, Ховд	5	-	5	45,898	-	45,898	0.3%
Уланбаатар	20	160	180	2,224	8,031	10,255	0.1%
Ховд	105	28	133	491,498	11,403	502,901	3.7%
Хөвсгөл	17	18	35	103,381	7,629	111,010	0.8%
Хэнтий	166	101	267	539,137	34,149	573,286	4.3%
Нийт	2,021	1,558	3,579	12,063,721	1,411,566	13,475,287	100.0%

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Тайлбар: Нийт баганад тодруулан илэрхийлсэн дүнгүүд нь Монгол Улсын хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй нийт талбайн 78.8%-ийг хамарсан 10 аймгийг илэрхийлнэ.

Нийт 63 төрлийн ашигт малтмалд олборлолтын 1,558 тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Дараах диаграммд гол ашигт малтмалын төрлүүдийг харууллаа. Монгол Улсын хэмжээнд нийт 515 алт олборлох тусгай зөвшөөрөл байдаг ба энэ нь нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 33%-ийг эзэлдэг бол 311 барилгын материал олборлох тусгай зөвшөөрөл нь 20%-ийг, 289 нүүрс олборлох тусгай зөвшөөрөл нь 19%-ийг тус тус эзэлж байна.



Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэлд суурилан бэлтгэв.

5.2.1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл явцтай холбоотой харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар (<http://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>) хянан зохицуулдаг. АМГТГ-ын Кадастрын хэлтэс нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаар хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгодог.

5.2.1.1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц (ША 2.2)

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Доорх хүснэгтэд хайгуулын тусгай зөвшөөрлийг анх удаа олгох үйл явцыг хураангуйлан харууллаа. Энэ нь тухайн өргөдөл гаргасан талбайд өөр аж ахуйн нэгж байгууллага ямар нэгэн хайгуулын тусгай зөвшөөрөл өмнө нь эзэмшиж байгаагүй гэсэн утгатай болно.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц – анх удаа олгох		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1-р шат	АМГТГ	Өргөдөл гаргахаар бүртгүүлсэн этгээдэд дугаар олгоно.
2-р шат	АМГТГ	Өргөдлийг гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана: <ul style="list-style-type: none"> - Хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл; - Өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт; - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Хайгуул хийхээр хүсэлт гаргасан талбайн булангийн цэгүүдийн солбицол, байршил, хилийг буулгасан зураг (2 хувь); - Үйлчилгээний хөлс төлсөн баримт; - Хайгуулын ажил эрхлэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан талаарх мэдээлэл; - Монгол Улсад татвар төлөгч гэдгийг нотлох баримт; - Хайгуулын талбайд гүйцэтгэх ажлын төрөл, хэмжээ, өртгийг тусгасан урьдчилсан төсөл.
3-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Хүсэлтэд дурьдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, боломжтой эсэхийг тогтоох.
4-р шат	Орон нутгийн засаг захиргаа	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг аймгийн эсвэл хотын захиргаа руу 30 хоногийн дотор хариу авахаар хүргүүлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд АМГ тухайн орон нутгийн засаг захиргааг уг саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.
5-р шат	АМГТГ	Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө.
6-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгох бөгөөд дараа нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 удаа тус бүр 3 жилийн хугацаатайг сунгаж болно.

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тухайн байршилд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг байршилдаа ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бусад уг байршилд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргагчдаас илүү бүрэн эрхтэй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1-р шат	АМГТГ	Хүсэлт гаргах: <ul style="list-style-type: none"> - Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх; - Хайгуулын ажлын явцад төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай нутгийн засаг захиргаа, байгаль орчны болон усны хяналтын газрын нотлох баримт;

Хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
		<ul style="list-style-type: none"> - Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээж авсан Эрдэс Баялгийн Зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр; - Үйл ажиллагаа явуулах талбайн орших аймаг, сум, хот болон дүүргийн нэрийг бичсэн газрын зураг; - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Монгол Улсад татвар төлөгч гэдгийг нотлох баримт; - Үйлчилгээний хөлс төлсөн баримт; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.
2-р шат	АМГТГ-ын Хуулийн хэлтэс	Хуулиар хориглосон зүйлс байгаа эсэх эсвэл барагдуулаагүй төлбөр байгаа эсэхийг тодорхойлох.
3-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Кадастрын системд хайгуулын тусгай зөвшөөрөл нь бүртгэгдсэн эсэхийг шалгах.
4-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Ашиглалтын талбай нь бусад тусгай зөвшөөрлийн газар, усны нөөц, улсын тусгай хэрэгцээний газар болон нөөцөд авсан талбай зэрэг газруудтай давхацсан эсэхийг шалгах.
5-р шат	АМГТГ-ын Уул Уурхайн болон Нүүрсний хэлтэс	Хүсэлт гаргагч нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээх боломжтой эсэхийг шалгах.
6-р шат	АМГТГ-ын Хуулийн хэлтэс	Хүсэлт гаргагч нь Кадастрын хэлтсийн даргын гаргасан төлөвлөгөө болон бусад хууль дүрэм журмуудыг дагаж мөрдөж буй эсэх.
7-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Координатаар тогтоосон талбайн зургийг зөвшөөрөх: АМГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурьдсан хариут өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
8-р шат	АМГТГ	Мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө.
9-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгох бөгөөд дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2 удаа тус бүр 20 жилийн хугацаатай сунгаж болдог.

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах замаар олгох үйл явц

Дараах шалгууруудын аль нэгийг хангасан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг нийтэд нээлттэй болгож сонгон шалгаруулах замаар олгоно:

- Хайгуулын ажил хийсэн аж ахуйн нэгж нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй;
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн талбайд;
- Зохих хууль журмыг эсвэл шүүхийн шийдвэрийг зөрчсөнөөс үүдэн ашиглалтын тусгай зөвшөөрлийг буцаан авсан;
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан.

Сонгон шалгаруулах шалгууруудын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 18.в-ээс харна уу.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах үйл явц – дахин олгох		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1-р шат	АМГТГ	Сонгон шалгаруулах үйл явцыг эхлүүлж захирамж гаргах.
2-р шат	АМГТГ	Олон нийтэд сонгон шалгаруулалтыг зарлах.
3-р шат	АМГТГ	Сонгон шалгаруулалтын саналыг хүлээж авах. Сонгон шалгаруулалтыг анх зарласнаас хойш дуусах хугацаа нь 30 хоногоос багагүй байх ба сонгон шалгаруулалтад оролцогчид дараах баримт бичгийг хавсаргана. <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтад оролцох санал; - Санал гаргагчийн албан ёсны тодорхойлолт; - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо; - Сонгон шалгаруулалтын босго үнийг Монгол банкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай байршуулсан баталгаа;

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах үйл явц – дахин олгох		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
4-р шат	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	<ul style="list-style-type: none"> - Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын төрөл хэмжээ, хугацаа, өртөг, болон байгаль хамгаалахад зарцуулах зардлыг тоймлон тусгасан төсөл, төсвийн санал; - Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт; /баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна./; - Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал; /баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна./; - Хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах дэвшилтэт арга, аргачлал, технологийн шийдэл; - Байршил болон огтлолцлыг харуулсан талбайн зураг; - Үйлчилгээний хөлс төлсөн баримт.
5-р шат	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	<p>Сонгон шалгаруулалтын саналыг нээх (бүх эрх бүхий оролцогчдыг байлцуулна. Нэг оролцогч талаас нэг итгэмжлэгдсэн төлөөлөгч байна).</p> <p>Сонгон шалгаруулалтад оролцогчдыг дараах баримтад үндэслэн үнэлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Техникийн санал (55%) <ul style="list-style-type: none"> o Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын арга аргачлал, төрөл хэмжээ, хугацаа болон байгаль хамгаалах асуудлыг тусгасан төсөл, төсвийн санал; o Нотариатаар гэрчлүүлсэн хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт; o Нотариатаар гэрчлүүлсэн мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал; o Хайгуул, ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх дэвшилтэт техник, технологийн шийдэл; o Орон нутагтай хэрхэн хамтран ажиллах санал, төлөвлөгөө. - Санхүүгийн шалгуур (45%).
6-р шат	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад ирүүлсэн үнийн саналыг нээх.
7-р шат	АМГТГ	Сонгон шалгаруулах комиссын шийдвэрийг батлах. Сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор ялагчийг зарлана.
8-р шат	АМГТГ	Эхний жилийн төлбөрийг АМГТГ-ын даргын шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөх.
9-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГТГ-ын даргын болон сонгон шалгаруулах комиссын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг олгох.

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох журам

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд аж ахуйн нэгжийн хооронд бүрэн буюу хэсэгчлэн шилжүүлж болно:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно;
- Хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно;
- Аж ахуйн нэгж эрэл, хайгуулын талаарх анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг худалдан авч, зохих албан татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно;
- Аж ахуйн нэгж нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт худалдан авч зохих татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	<p>Шилжүүлэн өгч байгаа этгээд дараах баримт бичгийг бэлтгэнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Шилжүүлж байгаа тусгай зөвшөөрөл; - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - МУ-д татвар төлөгч болохыг нотлох баримт;

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
2-р шат	АМГТГ-ын Кадастрын болон Хуулийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрч буйг нотлох баримт бичиг; - Ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлж байгаа бол тухайн талбайд төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийсэн тухай тодорхойлолт; - Байгаль орчныг нөхөн сэргээхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50%-ийг холбогдох сум, дүүргийн засаг даргын нээсэн тусгай дансанд шилжүүлсэн баримт; - Хайгуулын ажлын хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, зардал, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг харуулсан төлөвлөгөө; - Үйлчилгээний хөлс төлсөн баримт. <p>Дараах зүйлийг тодруулна:</p> <ul style="list-style-type: none"> - Баримт бичиг иж бүрэн эсэх; - Шилжүүлэх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байгаа эсэх; - Шилжүүлэн авч байгаа этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, МУ-д албан татвар төлөгч эсэх; - Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь төлж байсан эсэх; - Хайгуулын ажилд хангалттай зардал гаргасан эсэх. Хангалттай байх доод хэмжээ нь: <ul style="list-style-type: none"> o 2-3 дахь жилд: га тутамд 0.5 ам.доллар o 4-6 дахь жилд: га тутамд 1 ам.доллар o 7-9 дахь жилд: га тутамд 1.5 ам.доллар o 10-12 дахь жилд: га тутамд 10 ам.доллар
3-р шат	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	<p>2-р шатны ажиллагааг дууссаны дараа ажлын 5 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:</p> <ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрөл шилжүүлснийг баталгаажуулах; - Өргөдөл нь шаардлага хангаагүй бол нэмэлт мэдээлэл ирүүлэхийг шаардах; - Шилжүүлэн авч байгаа этгээд уг тусгай зөвшөөрлийг эзэмших эрхгүй, эсхүл тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бус бол татгалзах.

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль

Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг шалгасан байдал

Эхлэлийн семинарын үеэр 2016 онд олгогдсон тусгай зөвшөөрлүүдийн олгох болон шилжүүлэх үйл явцыг хууль тогтоомж, дүрэм журамтай нийцсэн эсэхийг эрсдэлд суурилсан аргачлалаар шалгуулахаар ОТАХ зөвшилцсөн. Энэхүү аргачлалын дагуу ОТАХ нь эрсдэлтэй гэж үзсэн тусгай зөвшөөрлүүдийн жагсаалтыг гаргаж, Хараат бус хянан-нэгтгэгч 2016 онд олгосон болон шилжүүлсэн эрсдэлгүй зөвшөөрлүүдээс санамсаргүй түүврийн аргаар сонгосон юм.

2016 онд олгосон 6 тусгай зөвшөөрлүүд (XV-016319, XV-020580, XV-19691, XV-20704, MV-020875, MV-020877), шилжүүлсэн 2 тусгай зөвшөөрлүүдийг (MV-009515, MV-020419) ОТАХ эрсдэлтэй гэж үзэн Хараат бус хянан-нэгтгэгчээс шалгахыг хүссэн. Түүнчлэн, Хараат бус хянан-нэгтгэгч олгосон болон шилжүүлсэн эрсдэлгүй гэж үзсэн зөвшөөрлүүдээс түүврийн аргаар 44 зөвшөөрлүүдийг сонгосон. Ийнхүү нийт 52 тусгай зөвшөөрлийг шалгасан.

2016 онд олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүдээс Монголросцветмент ХХК-ийн XV-020580 (эрсдэлтэй гэж үзсэн тусгай зөвшөөрлүүдийн нэг) болон Монлаа ХХК-ийн XV-017130 дугаартай тусгай зөвшөөрлүүд дээр зөрүү байгааг бид олж тогтоосон. Монголросцветмент ХХК-ийн XV-020580 дугаартай тусгай зөвшөөрөл нь 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Засгийн Газрын 359 дүгээр тогтоолын дагуу олгогдсон байсан. Энэхүү тусгай зөвшөөрлийг олгоход холбогдох дүрэм журмаар шаардагдсан хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл, өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хайгуул хийхээр хүсэлт гаргасан талбайн булангийн цэгүүдийн солбицол, байршил, хилийг буулгасан зураг, хайгуулын ажил эрхлэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан талаарх мэдээлэл, МУ-ын татвар төлөгч гэдгийг нотлох баримт, хайгуул хийх талбайн өнцгийн координатууд, баримт, материалуудыг шалгах, болон ИТХ болон Орон нутгийн засаг захиргааны санал бодолтой холбоотой материалуудыг бүрдүүлээгүй байсан.

Монлаа ХХК-ийн хувьд XV-017130 тоот тусгай зөвшөөрөл нь 2010 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн Газрын 72 дугаар тогтоол, 2009 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн Газрын 189 дүгээр тогтоол болон Нийслэлийн захиргааны шүүхийн 2010 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 281 дүгээр

тогтоолын дагуу олгогдсон байсан. Хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл, өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт зэргийн бүрдүүлээгүй байсан.

Бидний шалгалтанд хамрагдсан 2016 онд олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдээс 11-г нь тусгай зөвшөөрлүүдийг олгосон тухай холбогдох байгууллагуудад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлсэн баримтууд дутуу байсан. Мөн бидний шалгалтанд хамрагдсан 2016 онд шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүдээс 6-д шилжүүлж буй болон үлдэж буй газрыг харуулсан жишиг баримтыг бүрдүүлээгүй байсан. Шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүдэд өөр ямар нэгэн зөрчил илрээгүй.

Дэлгэрэнгүйг Хавсралт 15-аас харна уу.

Тогтвортой хөгжлийн төлөөх уул уурхай судалгаа

Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагын (ТИОУБ) салбар байгууллага “Транспэрэнси Интернэшнл Монгол”-ын хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн төлөөх уул уурхай” (ТХТУУ) судалгааны хүрээнд уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох үйл явцад гарч болзошгүй авлигын эрсдлийг үнэлгээг хийсэн болно. Судалгааны тайлан 2017 онд гарсан ба судалгааны гол зорилго нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх, гэрээ байгуулах явцад авлигыг өдөөх хүчин зүйл болж буй тогтолцоо, зохицуулалт, холбогдох байгууллагуудын сул талыг тодорхойлж, эдгээр сул талын улмаас үүсч буй авлигын тодорхой эрсдлүүдийг үнэлэхэд оршино. Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)–аас тусгай зөвшөөрөл олгож буй механизм, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлага болон захиргааны тогтолцооны асуудлууд нь судалгааны хамрах хүрээ байсан. Энэхүү судалгааны ажлыг 6 гишүүнтэй зөвлөх баг хэрэгжүүлсэн юм.

Авлигын эрсдлийн шинжилгээгээр “Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох авлигын эрсдэлийн үнэлгээ”-ний аргачлалын арга зүйн дагуу сул талуудыг үнэлж, нийт 54 сул талаас үүдэн бий болсон нийт 14 авлигын эрсдлийг тодорхойлсон юм. Судалгаагаар 54 сул талыг эрх зүйн асуудал, технологийн асуудал, хариуцлага, хувийн үнэлэмжээр шийдвэр гаргах, магадлан шалгалт гэсэн таван ангилалд хувааж, тодорхойлсон 14 авлигын эрсдэл тус бүрд харгалзах зөвлөмжүүдийг өгсөн байна.

Тайлангийн эх хувилбарыг дараах холбоосоор орж үзнэ үү: <http://www.transparency.mn/content/17526.shtml>

5.2.1.2 2016 онд олгосон болон шилжүүлсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд

Тухайн уул уурхайн үйл явцаас хамааран уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай байдаг. 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,058 компани 3,579 хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 16-аас харна уу.

Тусгай зөвшөөрлийн тоо (төрлөөр)					
Төрөл	2015	2016	Нэмэгдсэн	Хасагдсан	Шилжүүлсэн
Хайгуул	2,018	2,021	623	(620)	52
Ашиглалт	1,489	1,558	93	(24)	96
Нийт	3,507	3,579	716	(644)	148

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Тусгай зөвшөөрлийн тоо нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 3,507-оос 3,579 болж 72-оор өссөн байна. 2015 оноос 2016 оны хооронд 644 тусгай зөвшөөрлийн зохих зөвшөөрлийн хугацаа дууссан болон, эсвэл арилжааны ашиггүй байдлаас шалтгаалан АМГТГ-г буцаагдсан байна. Цөөн тооны тусгай зөвшөөрөл нь санхүүжилтийн хангалтгүй байдал болон жилийн төлбөрөө төлөөгүй гэх шалтгаанаар буцаагдсан байна.

2016 онд олгосон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүд

Дараах хүснэгтэнд 2016 онд олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг харуулсан болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 17.а-с харна уу.

2016 онд олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл			
Аймаг	Талбайн хэмжээ (га)	Тусгай зөвшөөрлийн дугаар	
Баян-Өлгий	16,648	14	
Баянхонгор	3,233	7	
Булган	34,778	19	
Говь-Алтай	162,441	37	
Говьсүмбэр	19,588	4	
Дархан-Уул	4,389	2	
Дорноговь	646,690	114	
Дорнод	239,062	56	
Дундговь	461,943	67	
Завхан	149,873	19	
Өвөрхангай	-	1	
Өмнөговь	145,025	30	
Сүхбаатар	23,331	6	
Сэлэнгэ	40,620	27	
Төв	228,256	99	
Увс	39,308	5	
Ховд	43,479	22	
Хэнтий	303,204	94	
Нийт дүн	2,561,868	623	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

2016 онд олгосон ашигт малтмалын олборлолтын тусгай зөвшөөрлүүд

2016 онд 93 олборлолтын тусгай зөвшөөрлийг хэд хэдэн төрлийн ашигт малтмалд олгосон байна. Дараах хүснэгтэд гол ашигт малтмалын төрөл, талбайн хэмжээ болон тусгай зөвшөөрлийн нийт тоог бүсчилсэн байдлаар харуулсан болно. Олборлолтын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүйг Хавсралт 17.б-с харна уу.

2016 онд олгосон ашиглалтын тусгай зөвшөөрөл			
Аймаг	Ашигт Малтмал	Талбайн нийт хэмжээ (га)	Тусгай зөвшөөрлийн тоо
Баянхонгор	Алт, зэс	5,595.72	7
Булган	Алт, төмөр, барилгын материал	3,808.86	5
Говь-Алтай	Молибден, алт, зэс, нүүрс	40,676.79	15
Говьсүмбэр	Барилгын материал	129.35	1
Дархан-Уул	Барилгын материал	145.99	1

2016 онд олгосон ашиглалтын тусгай зөвшөөрөл			
Аймаг	Ашигт Малтмал	Талбайн нийт хэмжээ (га)	Тусгай зөвшөөрлийн тоо
Дорноговь	Барилгын материал, болор, жонш, лантан, цери, төмөр	2,106.91	6
Дорнод	Алт, нүүрс	14,861.24	5
Дундговь	Бал чулуу, барилгын материал, гөлтгөнө, уран	26,419.49	6
Завхан	Алт	1,639.24	1
Орхон	Барилгын материал	1,400.24	1
Өмнөговь	Бал чулуу, барилгын материал, зэс, цайр, нүүрс	24,498.78	10
Сүхбаатар	Барилгын материал, жонш, нүүрс, уран	11,670.07	4
Сэлэнгэ	Алт, зэс	909.89	2
Төв	Алт, бал чулуу, зэс, төмөр	16,208.68	14
Увс	Алт, барилгын материал	908.61	2
Улаанбаатар	Барилгын материал	478.64	7
Ховд	Алт, зэс, барилгын материал	3,600.19	4
Хэнтий	Алт, гянтболд, цагаан тугалга	737	2
Нийт дүн		155, 795.69	93

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

2016 онд сонгон шалгаруулалтаар олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд

АМГТГ-ын мэдээлснээр 2016 онд сонгон шалгаруулалтаар нийт 37 талбайд тусгай зөвшөөрөл олгосон. Сонгон шалгаруулалтанд сонгогдоогүй оролцогчдын тухай болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 18.а болон 18.б-ээс харна уу.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг зарлах үйл явц, хуулийн үндэслэл

Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Сонгон шалгаруулалтын журмаар олгох талбайн хил хязгаарыг шинээр баталсан ба 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор дээрх тогтоолоор баталсан хил хязгаарт нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэ нь сонгон шалгаруулалтаар олгох талбайг 2.0 сая гектараар нэмэгдүүлж сонгон шалгаруулалт явуулах талбайн хэмжээг нийт 10.6 гектар болгосон байна.

Үүнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/129 дугаартай тушаал гарч тус тушаалын 1 дүгээр хавсралтаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг, 2 дугаар хавсралтаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг, 3 дугаар хавсралтаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудсыг, 4 дүгээр хавсралтаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үнэлгээний талбайн нэгтгэлийг, 5 дугаар хавсралтаар Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үнэлгээний нийт нэгтгэлийг тус тус баталж, дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг УУХҮЯ-ны Геологийн бодлогын газрын дарга Д.Ганбат, АМГТГ-ын дарга Б.Баатарцогт нарт даалгасан байна.

Сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг нийтэд мэдээллэх, бүртгэх тухай Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/158 тоот тушаал батлагдсан.

2016 онд шилжүүлсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд

Доорх хүснэгтэд үзүүлснээр 2016 онд шилжүүлсэн хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нийт шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо хэмжээ, ашигт малтмалын төрлийг бүсчилсэн байдлаар харуулсан болно. Аймгуудад нийт 148 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэнээс 52 нь олборлолт, 96 нь хайгуулын тусгай зөвшөөрлүүд байсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 19-өөс харна уу.

2016 онд шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл			2016 онд шилжүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрөл	
Аймаг	Ашигт малтмал	Дүн	Аймаг	Дүн
Архангай	алт	1	Баянхонгор	5
Баян-Өлгий	алт	1	Булган	8
Баянхонгор	алт	1	Говь-Алтай	4
Булган	алт	4	Дархан-Уул	2
Булган, Төв	алт	2	Дорноговь	13
Говьсүмбэр	нүүрс	3	Дорноговь, Өмнөговь	2
Говьсүмбэр, Дорноговь	нүүрс	2	Дорнод	6
Дархан-Уул	алт	1	Дундговь	9
Дархан-Уул, Сэлэнгэ	алт	2	Завхан	5
Дорноговь	жонш	1	Өвөрхангай	1
Дорноговь	нүүрс	2	Өмнөговь	12
Дорнод	алт	2	Сүхбаатар	1
Дорнод	алт, зэс	1	Төв	9
Дундговь	гөлтгөнө	1	Увс	8
Дундговь	нүүрс	1	Улаанбаатар	1
Өвөрхангай	алт	1	Ховд	4
Өвөрхангай	зэс	1	Хэнтий	6
Өмнөговь	нүүрс	1		
Сэлэнгэ	алт	4		
Төв	алт	7		
Төв	базальт	1		
Төв	барилгын материал	1		
Төв	нүүрс	1		
Төв	төмөр	1		
Төв		1		
Төв, Улаанбаатар	барилгын материал	1		
Улаанбаатар	барилгын материал	4		
Улаанбаатар	(мэдээ ирээгүй)	1		
Хэнтий	нүүрс	2		
Дүн		52	Дүн	96
Нийт дүн				148

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.1.3 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олон нийтэд ил тод бүртгэл (ША 2.3б)

АМГТГ-ын Кадастрын хэлтэс нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар³ нийтэд үнэ төлбөргүй хүргэдэг бөгөөд нэмэлт мэдээлэл авахыг хүссэн аж ахуйн нэгжүүд албан хүсэлт гаргаж нэмэлт мэдээлэл бүхий цахим хуудсанд нэвтрэх онцгой эрх авч болдог. Энэ онцгой эрхээр ОУИТБС-ын Стандартад шаардсан тусгай зөвшөөрөл тус бүрийн олгосон болон дуусгавар болох хугацааг харах боломжтой.

АМГТГ-ын цахим хуудсан дахь олон нийтэд ил тод ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийн харьцуулалт	
Олон нийтэд ил тод тусгай зөвшөөрлийн бүртгэл	Онцгой эрхтэйгээр харах тусгай зөвшөөрлийн бүртгэл
Бүртгэлийн дугаар	Бүртгэлийн дугаар
Регистрийн дугаар	Регистрийн дугаар
Тусгай зөвшөөрлийг эзэмшигч	Тусгай зөвшөөрлийг эзэмшигч
Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн төрөл
Тусгай зөвшөөрлийн нөхцөл байдал	Тусгай зөвшөөрлийн нөхцөл байдал
Байршлын нэр	Байршлын нэр
Талбайн хэмжээ	Талбайн хэмжээ
Талбайн солбицол	Талбайн солбицол
Талбайн газрын зураг	Аймаг
	Олгосон өдөр
	Дуусах өдөр
	Компанийн төрөл
	Хот
	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Нөхцөл байдал (хүчинтэй эсвэл дууссан)

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтэс <https://cmcs.mram.gov.mn/cmcs#e=Map>

АМГТГ-ын Кадастрын хэлтэстэй адил МОУИТБС-ын Ажлын Алба цахим хуудсаараа⁴ дамжуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нийтэд үнэ төлбөргүйгээр ил тод болгож өөрсдийн цахим хуудсандаа мэдээлдэг бөгөөд үүнд тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын нэр, талбайн хэмжээ, бүтээгдэхүүн, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тусгай зөвшөөрлийн олгосон болон дуусах хугацааг багтаасан байдаг.

Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан огноо

ОУИТБС-ын 2.3.б дугаар стандартаар шаардагдсан тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан огноо нь АМГТГ-г тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийн улмаас АМГТГ-ын кадастрын хэлтэс болон ОУИТБС-ийн цахим хуудаст ил тод болоогүй. Саяханыг хүртэл, тусгай зөвшөөрлийн өргөдлийг цаасаар гаргаж түүрүүлж ирүүлсэн хүсэлтэд эхлэж үйлчлэх зарчмаар энэ үйл явц ажиллаж байв. Тиймээс хадгалагдсан цахим мэдээлэл байхгүй, мөн өмнөх цаасан өргөдлүүдийн ихэнх нь архивт хадгалагдаагүй байна.

2016 оны ОУ-ын салбарын орлогын 99%-ийг бүрдүүлж буй нэгтгэлд хамрагдсан 213 компанийн тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноог олохыг ОТАХ шийдсэн. Эдгээр 213 компани нь ашигт малтмалын 661 тусгай зөвшөөрөл, 11 БХГ-г эзэмшдэг. Эдгээр тусгай зөвшөөрлүүдийн хүсэлт гаргасан огноог олох зорилгоор цаасан өргөдлүүдийг шүүж олох ажлыг АМГТГ дотооддоо зохион байгуулсан бөгөөд 206 тусгай зөвшөөрөл дээр энэ мэдээллийг олж авч чадсан. Харин үлдсэн өргөдлүүдийн огноог олох боломжгүй талаар АМГТГ бидэнд мэдэгдсэн. АМГТГ-ын мэдээлснээр Кадастрын хэлтсийн бүртгэл 2010 оноос цахим системд шилжсэн бөгөөд энэ үеэс өмнөх үеийн бүртгэлийг цахим системд нөхөж бүртгээгүй ба

³ <http://cmcs.mram.gov.mn/cmcs#e=License>

⁴ <http://e-reporting.eitimongolia.mn/portalMap>

архивлагдаагүй. Тиймээс үлдсэн тусгай зөвшөөрлүүд дээр өргөдөл гаргасан огноог гаргаж өгөх боломжгүй гэсэн тайбар өгсөн болно.

Түүнчлэн ОУ-ийн салбарын 2016 оны нийт орлогын 95%-ийг бүрдүүлж буй 261 тусгай зөвшөөрлийг эзэмшигч 40 компани руу Кэй Пи Эм Жи тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноог гаргаж өгөх хүсэлт илгээсэн. Бид 66 тусгай зөвшөөрөл дээр өргөдлийн огноог хүлээн авсан. Дээр дурьдсан 40 компанийн дийлэнх нь дараах шалтгаануудын улмаас өргөдлийн огноог гаргах боломжгүй гэдгээ бидэнд мэдэгдсэн. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийг өөр компаниас худалдан авсан бөгөөд хүлээж авсан мэдээлэлд өргөдлийн огнооны талаар мэдээлэл байгаагүй (хамгийн их тусгай зөвшөөрөл эзэмшигч Монголын Алт Мак (20) болон Алтандорнод Монгол (48) мөн ийм хариу илгээсэн);
- Тусгай зөвшөөрлийг олон жилийн өмнө авсан бөгөөд энэ мэдээлэл архивт байхгүй;
- Эрдэнэс Монгол, Эрдэнэс Таван Толгой компаниудад тусгай зөвшөөрлүүдийг ЗГ-аас шууд өгсөн гэж мэдээлсэн.

АМГТГ-аас ирүүлсэн өргөдлийн огнооны мэдээлэл, бидний хүсэлт илгээсэн компаниудын ирүүлсэн мэдээлэлтэй нийлээд 109 компанийн 251 ашигт матмалын тусгай зөвшөөрөл, 7 компанийн 8 БХГ-ний хүсэлт гаргасан огноог олж авсан бөгөөд эдгээр 116 компани 2016 оны ОУ-ийн салбарын олсон орлогын 84.5%-ийг (газрын тосны тусгай зөвшөөрөлтэй компаниудын орлогыг оролцуулахгүй бол 98.8%-ийг) бүрдүүлж байна.

Мөн, АМГТГ нь 2016 онд олгосон хайгуулын бүх тусгай зөвшөөрөл дээр өргөдлийн огноог ирүүлсэн. Хуучин олгогдсон болон шинээр олгосон тусгай зөвшөөрлийн огноог Хавсралт 20 болон 22.а-с харна уу.

5.2.1.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ил бол байдал (ША 2.3в)

Хуулийн хүрээнд шаардсаны дагуу АМГТГ нь тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг ил тод байлгадаг ба тэдгээрийг өөрсдийн цахим хуудсандаа байршуулж олон нийтэд хүргэдэг (<https://cmcs.mram.gov.mn/cmcs#c=Map>). Үүнд, дараах мэдээллүүдийг багтаасан байна:

АМГТГ-ын тусгай зөвшөөрлийн ил тод байдал						
Хүчингэй тусгай зөвшөөрлийн жагсаалт	Захиалгатай талбай	Стратегийн орд газар	Шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбай	БУУ талбай	Улсын тусгай талбай	Тусгай бүс
Регистрийн дугаар	Регистрийн дугаар	Регистрийн дугаар	Регистрийн дугаар	Регистрийн дугаар	Регистрийн дугаар	Регистрийн дугаар
Тусгай зөвшөөрлийн дугаар	Код	Код	Код	Код	Код	Код
Талбайн нэр	Талбайн нэр	Талбайн нэр	Талбайн нэр	Талбайн нэр	Талбайн нэр	Талбайн нэр
Тусгай зөвшөөрлийн төрөл						
Хүлээн авагч/Өргөдөл гаргагч						
Талбай (га)	Талбай (га)	Талбай (га)	Талбай (га)	Талбай (га)	Талбай (га)	Талбай (га)
Солбицол	Солбицол	Солбицол	Солбицол	Солбицол	Солбицол	Солбицол
Газрын зураг	Газрын зураг	Газрын зураг	Газрын зураг	Газрын зураг	Газрын зураг	Газрын зураг
	Аймаг	Аймаг	Аймаг	Аймаг	Аймаг	Аймаг
	Төлөв	Төлөв	Төлөв	Төлөв	Төлөв	Төлөв
	Олгосон	Олгосон	Олгосон	Олгосон	Олгосон	Олгосон
	Хэрэгжилтийн огноо	Хэрэгжилтийн огноо	Хэрэгжилтийн огноо	Хэрэгжилтийн огноо	Хэрэгжилтийн огноо	Хэрэгжилтийн огноо

АМГТГ-ын тусгай зөвшөөрлийн ил тод байдал

Хүчинтэй тусгай зөвшөөрлийн жагсаалт	Захиалгатай талбай	Стратегийн орд газар	Шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбай	БУУ талбай	Улсын тусгай талбай	Тусгай бүс
	Шийдвэр гаргасан огноо	Шийдвэр гаргасан огноо	Шийдвэр гаргасан огноо	Шийдвэр гаргасан огноо	Шийдвэр гаргасан огноо	Шийдвэр гаргасан огноо
	Хүлээн авсан огноо	Хүлээн авсан огноо	Хүлээн авсан огноо	Хүлээн авсан огноо	Хүлээн авсан огноо	Хүлээн авсан огноо
	Дуусах огноо	Дуусах огноо		Дуусах огноо		
	Бүртгэлийн огноо	Бүртгэлийн огноо	Бүртгэлийн огноо	Бүртгэлийн огноо	Бүртгэлийн огноо	Бүртгэлийн огноо

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.2 Газрын тосны тусгай зөвшөөрөл

Газрын тосны эрэл, хайгуул болон олборлолт, үйлдвэрлэлтийн үйл явцтай холбоотой харилцааг Газрын тосны тухай хууль (<http://www.legalinfo.mn/law/details/10484>)-аар зохицуулдаг. Газрын тосны эрлийн үйл ажиллагаа нь тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг хэлнэ. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа нь газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг багтаадаг. Газрын тосны ашиглалт гэдэгт газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааг оруулна. Газрын тосны тухай хуулийн дагуу УУХҮЯ нь хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгодог бөгөөд АМГТГ эрлийн тусгай зөвшөөрлийг олгодог.

5.2.2.1 Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа (ША 2.2)

Газрын тосны 3 төрлийн тусгай зөвшөөрөл байдаг. Үүнд:

- Эрлийн тусгай зөвшөөрөл;
- Хайгуулын тусгай зөвшөөрөл – БХГ шаардлагатай;
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл – БХГ шаардлагатай.

Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Эрлийн тусгай зөвшөөрөл олгох үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
Үе шат 1	АМГТГ	Эрэл хийх хүсэлт АМГТГ -т гаргана. Хүсэлтэд, <ul style="list-style-type: none"> - Эрэл хийх талбайн байршил, хэмжээ; - Эрлийн хугацаанд хийх ажлын ерөнхий хөтөлбөр; - Техникийн хүчин чадал, хүний нөөцийн чадавх; - Төлөвлөсөн ажлыг санхүүжүүлэх санхүүгийн боломж, эх үүсвэр; - Тухайн жилд гүйцэтгэх эрлийн ажлын төлөвлөгөө, төсөл.
Үе шат 2	АМГТГ	Хүсэлтийг хүлээн авснаас хойш ГТГ 30 хоногийн дотор хариу өгнө. Хэрэв тухайн талбайд эрэл хийх хүсэлтийг хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд гаргасан тохиолдолд АМГТГ дараах нөхцлийг харьцуулсан дүгнэлт хийж, шийдвэр гаргана: <ul style="list-style-type: none"> - Хүсэлт гаргагчийн техник, технологи, мэргэжлийн болон санхүүгийн чадавх; - Эрлийн ажлын арга, аргачлал нь олон улсын жишигт нийцсэн эсэх; - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө.
Үе шат 3	АМГТГ	Газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх гэрээг АМГТГ -тай гурав хүртэл жилийн хугацаагаар байгуулна.

Эх сурвалж: Газрын тосны тухай хууль

БХГ байгуулах үйл явц

БХГ-г газрын тосны хайгуул ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргахын өмнө байгуулсан байх ёстой. Доорх хүснэгтэд БХГ байгуулах үйл явцыг харууллаа.

БХГ байгуулах үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
Үе шат 1	АМГТГ	АМГТГ -г ирүүлэх БХГ-ний төсөлд доорх нөхцлүүдийг тусгана: <ul style="list-style-type: none"> - Засгийн Газарт ногдох газрын тосны ашигт хувь; - Нөөц ашигласны төлбөрийн хувь; - Өртөгт газрын тосны хязгаарын хувь; - Хайгуулын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ; - Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ; - Сургалтын урамшууллын хэмжээ;

БХГ байгуулах үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
		<ul style="list-style-type: none"> - Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ; - Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ; - Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; - Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг; - ЗГ-т санал болгох бусад ашигтай нөхцөл.
Үе шат 2	АМГТГ	АМГТГ дээр дурьдсан нөхцөл бүхий төслийг хүлээн авмагц өргөдөл гаргагч этгээдтэй 60 хоногийн дотор гэрээний төслийн талаар хэлэлцээр хийж эцэслэн тохиролцсон төслийг УУЯ-нд хүргүүлнэ.
Үе шат 3	УУХҮЯ	Гэрээний төслийг 30 хоногийн дотор хянаж үзээд саналаа ЗГ-т хүргүүлнэ.
Үе шат 4	ЗГ	ЗГ уг саналыг хүлээж авснаас хойш 60 хоногийн дотор гэрээ байгуулах эсэх талаар шийдвэр гаргана.
Үе шат 5	АМГТГ	ЗГ гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд АМГТГ 30 хоногийн дотор БХГ байгуулна.
Үе шат 6	АМГТГ	АМГТГ энэ талаар нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

Эх сурвалж: Газрын тосны тухай хууль

Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
Үе шат 1	УУХҮЯ	УУХҮЯ -нд гаргах хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана: <ul style="list-style-type: none"> - БХГ-ний хуулбар; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; - Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө; - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг эскроу дансанд байршуулсан баримт.
Үе шат 2	УУХҮЯ	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох <ul style="list-style-type: none"> - Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. - Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. - БХГ-г байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно. - ГТГ нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

Эх сурвалж: Газрын тосны тухай хууль

Тэмдэглэл: Газрын тосны үйл ажиллагаанд газрын тостой холбоотой хайгуул болон олборлолтыг багтаана, харин уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаа нь байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийн элс, хийн занар болон нүүрсний метантай холбоотой.

Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Газрын тосны тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргахад бусад хүсэлт гаргагчдаас давуу эрх эдэлнэ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
Үе шат 1	УУХҮЯ	УУХҮЯ -нд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ: <ul style="list-style-type: none"> - Газрын тосны нөөц бүртгэсэн тухай УУХҮЯ -ны шийдвэр; - Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл; - Үйл ажиллагааны төлөвлөгөө; - Байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг тэмдэглэсэн зураг.
Үе шат 2	УУХҮЯ	Ажлын төлөвлөгөөний зөвшөөрөл.
Үе шат 3	УУХҮЯ	Гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор эскроу дансанд байршуулсныг нотлох баримт.
Үе шат 4	УУХҮЯ	Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
Үе шат 5	АМГТГ	<ul style="list-style-type: none"> - Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд тав хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. - Уламжлалт бус газрын тосны ашиглалтын хугацаа 30 хүртэл жил байх бөгөөд нэг удаа тав хүртэл жилээр сунгаж болно. <p>АМГТГ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.</p>

Эх сурвалж: Газрын тосны тухай хууль

Газрын тосны тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох үйл явц

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл УУХҮЯ-нд буцаагдсан үед УУХҮЯ нь энэхүү тусгай зөвшөөрлийг нийтэд нээлттэй болгож сонгон шалгаруулах журмаар олгодог. Дараах нөхцлүүдийн аль нэг нь үүссэн тохиолдолд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл нийтэд нээлттэй болно:

- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн тохиолдолд;
- Эрэл хийсэн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй тохиолдолд;
- Хайгуул хийсэн этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй тохиолдолд;
- Хайгуул эсвэл ашиглалтын үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээд үйл ажиллагаагаа зогсоохоор шийдвэрлэсэн;
- Хуулийн этгээд БХГ-нд гарын үсэг зурахаас татгалзсан;
- Тусгай зөвшөөрөл нь хуульд заасан шалтгаанаар эсвэл шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон;
- Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
- Хуулийн этгээд болон ГТГ хоорондоо БХГ-ний нөхцлийг тохиролцож чадаагүй.

Хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулах үйл явц – дахин олгох		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
Үе шат 1	АМГТГ	АМГТГ нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.
Үе шат 2	АМГТГ	<p>АМГТГ сонгон шалгаруулалтын материалыг 60 хоногийн хугацаанд хүлээн авах бөгөөд сонгон шалгаруулалтыг зарлаж эхний санал ирсэн өдрөөс хойш тав хоногийн дотор бичиг баримт хүлээн авах эцсийн хугацааг зарлана. Сонгон шалгаруулалтын бичиг баримтанд доорхийг бүрдүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Оролцогч, түүний хөрөнгө оруулагчийн танилцуулга; - Оролцогчийг төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт; - Оролцогчийн техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг; - Хайгуул болон ашиглалтад зарцуулах хөрөнгийн баталгаа; - Хайгуулын ажлын төсөв, төлөвлөгөө; - Үйлчилгээний хөлс болох 20,000 ам доллар төлсөн баримт; - Оролцогч нь бизнесийн түншлэлтэй бол түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ.
Үе шат 3	АМГТГ	АМГТГ өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүлээн авсан эсэхээ өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
Үе шат 4	УУХҮЯ ба АМГТГ	УУХҮЯ ба АМГТГ гэрээ байгуулах хүртэл оролцогчийн талаарх мэдээллийг нууцална.
Үе шат 5	АМГТГ	<p>АМГТГ нь дараах шалгууруудыг үндэслэн ЗГ-т хамгийн ашигтай санал ирүүлсэн оролцогчийг сонгоно:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн Газарт ногдох газрын тосны ашигт хувь; - Нөөц ашигласны төлбөрийн хувь; - Өртөгт газрын тосны хязгаарын хувь; - Хайгуулын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ; - Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ; - Сургалтын урамшууллын хэмжээ; - Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ; - Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ;

Хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулах үйл явц – дахин олгох		
Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
		<ul style="list-style-type: none"> - Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; - Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг; - ЗГ-г санал болгох бусад ашигтай нөхцөл.
Үе шат 6	АМГТГ	АМГТГ өргөдөл гаргагчид үр дүнг мэдээлнэ.
Үе шат 7	АМГТГ	АМГТГ дээр дурьдсан нөхцөл бүхий төслийг хүлээн авмагц өргөдөл гаргагч этгээдтэй 60 хоногийн дотор гэрээний төслийн талаар хэлэлцээ хийж эцэслэн тохиролцсон төслийг УУЯ-нд хүргүүлнэ.
Үе шат 8	УУХҮЯ	УУХҮЯ гэрээний төслийг 30 хоногийн дотор хянаж үзээд саналаа ЗГ-г хүргүүлнэ.
Үе шат 9	ЗГ	ЗГ уг саналыг хүлээж авснаас хойш 60 хоногийн дотор батлах эсвэл татгалзах эсэх талаар шийдвэр гаргана.
Үе шат 10	АМГТГ	ЗГ гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд АМГТГ 30 хоногийн дотор БХГ байгуулна.

Эх сурвалж: Газрын тосны тухай хууль

5.2.2.2 2016 оны газрын тосны тусгай зөвшөөрөл олголт болон шилжүүлэг

2016 онд Дарьганга ХХИВ БХГ-г 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн Газрын 41 тоот тогтоолоор Апедскро Инвэстмэнт ХХК-аас Монгол Шин Лью ХХК руу шилжүүлсэн. Монгол Шин Лью ХХК-тай хийсэн шинэ БХГ-д 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр гарын үсэг зурж, тусгай зөвшөөрлийг 2016 оны 7 дугаар сарын 04-ны өдөр олгосон.

Түүнчлэн, 2016 онд шинээр хоёр талбайд БХГ байгуулсан ба эдгээр БХГ-ний тусгай зөвшөөрлийг 2017 онд олгосон. Үүнд:

- Макс Ойл ХХК-тай байгуулсан Арбулаг ХХИХ талбайн БХГ нь 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн ЗГ-ын 337 тоот тогтоолын дагуу 2016 оны 7 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан.
- Смарт Ойл Инвэстмент Лимитед ХХК-тай байгуулсан Эргэл ХИ талбайн БХГ нь 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн ЗГ-ын 53 тоот тогтоолын дагуу 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан.

Түүнчлэн, энэ БХГ-үүд нь сонгон шалгаруулалтаар олгогдсон. Түвшин Интернэшнл ХХК болон Си Си Эф Петролиум ХХК нь Арбулаг ХХИХ талбайн сонгон шалгаруулалтад оролцож шалгараагүй бол Күнан Юаншинг Индистри, Трейд ХХК нь Эргэл ХИ талбайн сонгон шалгаруулалтад оролцож шалгараагүй байна.

Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг шалгасан байдал

Хараат бус хянан-нэгтгэгч 2016 онд олгосон 2 БХГ болон шилжүүлсэн 1 БХГ-ний олгох, шилжүүлэх үйл явц хууль тогтоомж, дүрэм журамтай нийцсэн эсэхийг шалгасан.

- Арбулаг ХХИХ талбайн БХГ-г Макс Ойл ХХК-тай байгуулсан үйл явц:
 - БХГ байгуулах үйл явцын эцсийн шатанд АМГТГ нутгийн захиргааны байгууллагад БХГ байгуулсан талаар мэдэгддэг. Бид энэ талаарх мэдээллийг олоогүй.
 - Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын эцсийн шатанд АМГТГ нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгддэг. Бид энэ талаарх мэдээллийг олоогүй.
- Эргэл ХИ талбайн БХГ-г Смарт Ойл Инвэстмент Лимитед ХХК-тай байгуулсан үйл явц:
 - БХГ байгуулах үйл явцын эцсийн шатанд АМГТГ нутгийн захиргааны байгууллагад БХГ байгуулсан талаар мэдэгддэг. Бид энэ талаарх мэдээллийг олоогүй.

- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг эскроу дансанд байршуулсан баримт шаардлагатай байдаг. Бид энэ баримтыг олоогүй бөгөөд тусгай данс тодорхойгүй тул тодорхой болмогц тушаана гэж тайлбарласан.
 - Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын эцсийн шатанд АМГТГ нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгддэг. Бид энэ талаарх мэдээллийг олоогүй.
 - Бид сонгон шалгаруулах үйл явцын 2 болон 3 дугаар үе шатанд шаардсан бичиг баримтыг АМГТГ-аас авч үзэж чадаагүй. Эдгээр бичиг баримтууд нь архивт байх ёстой. Архивын бичиг хэргийн ажилтан архивт өгөх хугацаа болоогүй байхад материал ирсэн тул хүлээж аваагүй, материал өгөх гэж байсан хүн ажлаас гарсан учраас материал хаана байгаа нь олдохгүй байна гэж тайлбарласан.
 - Бид мөн сонгон шалгаруулалтад тавигдсан шаардлагуудыг (сонгон шалгаруулах үйл явцын 5 дугаар үе шат) дээрх шалтгааны улмаас бичиг баримтууд нь дутуу байсан тул шалгаж чадаагүй.
- Дарьганга ХХIV БХГ-г Апедскро Инвэстмэнт ХХК-аас Монгол Шин Лью ХХК руу шилжүүлсэн үйл явц:
- БХГ шилжүүлэх үйл явцын 5 дугаар үе шатанд гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг шилжүүлэх Засгийн газрын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 34.7, 34.8-д заасан төлбөрийг төлнө гэсэн байдаг. Бид энэ төлбөрийн баримтыг олоогүй.
 - БХГ шилжүүлэх үйл явцын 6 дугаар үе шатанд гэрээлэгч болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээд эрх, үүрэг шилжүүлэхэд төлсөн төлбөрийн хэмжээг шударгаар мэдээлнэ гэж заасан байдаг. Бид үүнтэй холбоотой баримтыг олоогүй.

Хавсралт 21.в болон 21.г-ээс мэдээллийн дэлгэрэнгүйг харна уу.

5.2.2.3 Газрын тосны тусгай зөвшөөрлийн олон нийтэд ил тод байдал бүртгэл (ША 2.36, в)

АМГ, ГТГ нэгдсэнээс хойш АМГТГ-аас ОУИТБС-ын Стандарт 2.36-д шаардсан газрын тосны тусгай зөвшөөрөл мэдээлэл олон нийтэд нээлттэй байгаа болсон. Гэсэн хэдий ч, УУХҮЯ-ны цахим хуудсанд (<http://www.mmhi.gov.mn/public/more/id/121>) хүчин төгөлдөр бүх 25 БХГ-ний мэдээллийг ил тод болгосон байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн талбайн нэр болон талбайн кодууд
- Олгосон огноо
- Тусгай зөвшөөрлийн хугацаа
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч

МОУИТБС-ын цахим хуудсанд БХГ-тэй холбоотой тусгай зөвшөөрлийн талбайн нэр, талбайн дугаар, талбайн солбицол болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг (<http://www.eitimongolia.mn/mn/node/4922>) мөн, тусгай зөвшөөрөл олгосон болон дуусах огноог (<https://e-reporting.eitimongolia.mn/portalMap>) ил тод болгосон байна.

УУХҮЯ-ын цахим хуудсан дахь олон нийтэд нээлттэй болгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг доорх хүснэгтүүдээс үзнэ үү.

Газрын тосны олборлолтын тусгай зөвшөөрөл			
	Талбайн нэр	Эзэмшигч компани	Толгой компани
XIX	Тосон уул	Петрочайна Дачин Тамсаг ХХК	Петро Чайна Компани Лимитед
XXI	Тамсаг	Петрочайна Дачин Тамсаг ХХК	Петро Чайна Компани Лимитед
97	Зүүнбаян	Дон Шен Ойл Монгол ХХК	Синопек лимитед

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлүүд		
Талбайн дугаар	Талбайн нэр	Эзэмшигч компани
XX	Матад	Петроматад Инвест Лимитед ХХК
IV	Богд	Капкорп Монголиа ХХК
V	Онги	Капкорп Монголиа ХХК
XIII	Цагаан элс	Гоби Энержи Партнерс ХХК
XIV	Зүүнбаян	Гоби Энержи Партнерс ХХК
XVI	Нялга	Шэйман ХХК
XI	Галба	Зон Хэн Ю Тиан ХХК
XXIV	Дарьганга	Апекспро Инвестмент ХХК
XXIII	Сулинхээр	Шунхлай Энержи ХХК
VII	Борзон	Эмпайр Газ Монголиа ХХК
XVIII	Хөхнуур	Эн Пи Ай ХХК
X	Төхөм (Хойд)	Сансарын Геологи Хайгуул ХХК
XXVI	Цайдам	Сансарын Геологи Хайгуул ХХК
XVII	Баянтүмэн	Магнай Трейд ХХК
X	Төхөм (Өмнөд)	Монголын Алт Компани ХХК
XXVII	Сүхбаатар	Вульф Петролиум ХХК
IX	Номгон	Сансарын Геологи Хайгуул ХХК
I	Увс	Монголиа Гладвэлл Увс Петролиум ХХК
XXVIII	Хэрлэн-Гохой	Хонгконг Вэлпак Индастриал ХХК
II	Хар-Ус	Ренова Илч ХХК
XXIX	Арбулаг	Макс Ойл ХХК
XII	Эргэл	Смарт Ойл Инвестмент ХХК

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Хавсралт 21-ээс БХГ-тэй 25 талбайн тусгай зөвшөөрлийн мэдээллийн дэлгэрэнгүйг талбай тус бүрийн солбилцолтой нь харна уу.

5.3 Орлогын хуваарилалт

5.3.1 Төрийн санхүүгийн тогтолцоо (ША 5.1)

Монгол Улсын УИХ болон ЗГ нь төрийн санхүүгийн тогтолцооны удирдлагыг хянах гол байгууллагууд юм. ЗГ нь төрийн орлого болон зардлын төлөвлөгөөг тусгасан тухайн жилийн нэгдсэн төсвийн саналыг УИХ-д танилцуулдаг.

Жилийн нэгдсэн төсвийн санал нь дараах бүрэлдэхүүнтэй байдаг:

- ЗГ-ын орлого болон зардлыг тусгасан улсын төсөв;
- Нийслэл хот, дүүрэг, аймаг болон сумын төсвийг тусгасан орон нутгийн төсөв;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу хуримтлал үүсгэж зарцуулдаг Ирээдүйн өв сангийн төсөв; 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Хүний хөгжлийн сангийн төсвийг Ирээдүйн өв сангийн төсөв орлох болсон. Хүний хөгжлийн сангийн төсвийн үлдэгдэл хөрөнгийг Ирээдүйн өв сан руу шилжүүлсэн бөгөөд уг сангийн зорилго нь олборлох салбарын орлогоос тодорхой хэсгийг ирээдүйн хойч үеийнхэнд зориулан хуримтлуулах юм;
- Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулагддаг Нийгмийн даатгалын сангийн төсөв. Иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх нь тус сангийн гол зорилго юм;
- Нийгмийн даатгалын тухай хууль болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулдаг Эрүүл мэндийг даатгалын сангийн төсөв.

УИХ нь орон нутгийн төсвөөс бусад дээр дурьдсан төсвийг батлах бөгөөд орон нутгийн төсвийг тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар эцэслэн баталдаг.

Төсвийн тухай хуулийн дагуу, нэгдсэн төсвийн орлого нь татварын болон татварын бус орлогоос бүрддэг.

- Татварын орлогод:
 - Татварын ерөнхий хуулийн дагуу тогтоосон татвар болон төлбөр орно.
- Татварын бус орлогод:
 - Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр;
 - Төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээслэсний орлого;
 - Торгуулийн төлбөр;
 - Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого;
 - ЗГ-т олгосон зээл, тусламж;
 - Хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлсэн бусад орлого орно.

5.3.2 Улсын нэгдсэн төсөвтэй холбоотой хууль тогтоомж (ША 5.1)

Улсын төсөвтэй холбоотой хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу гаргасан бусад хууль тогтоомжийн актууд орно. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу УИХ нь жилийн нэгдсэн төсвийн санал болон түүний гүйцэтгэлийн тайланг батлах давуу эрх эдэлнэ. Улсын нэгдсэн төсөв нь Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг. Төсвийн тухай хуульд дурьдсанаар, хуулийн зорилт нь төсвийн зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн болон ангиллыг тогтоож; төсвийн тусгай шаардлагуудыг хэрэгжүүлэх; эрх баригчдыг болон

төсвийн үйл явцад оролцох талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох; төсвийг бэлтгэх, батлуулах, зарцуулах, бүртгэх, тайлагнах болон хянуулахтай холбоотой асуудлуудыг зохицуулахад оршино.

Улсын төсөвт ашигт малтмалын орлогыг хуваарилахтай холбоотой өөр нэг чухал хууль тогтоомж нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд дурьдсанаар, хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялагийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хууль нь төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн шаардлага болон тусгай шаардлагын зарчмыг тогтоож; эдгээр зарчим болон шаардлагуудыг хэрэгжүүлэх болон хянах төрийн байгууллагуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж; уг хуулийн зорилттой холбоотойгоор эсвэл үүний зорилтоос үүсч болох асуудлуудыг зохицуулдаг.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцоолно гэж заасан байдаг. Тэнцвэржүүлсэн орлого нь гол нэр төрлийн ашигт малтмалын үнийг тухайн ашигт малтмалын үнийг 24 жилийн хөдөлгөөнт дунджийн түвшинд байна гэж тооцоолсон арга юм. Тухайн хуульд тодорхойлсноор гол нэр төрлийн ашигт малтмал гэдэгт улсын төсвийн орлогын хамгийн багадаа 3 хувийг эзэлж байгаа ашигт малтмалыг хэлэх бөгөөд ашигт малтмалын 24 жилийн хөдөлгөөнт дундаж үнэ нь өнгөрсөн 20 жилийн бодит үнэ болон тухайн жил, ирэх гурван жилийн төлөвлөсөн үнээс бүрдэнэ. Гол нэр төрлийн ашигт малтмалын зах зээлийн үнээс олсон орлого нь тэнцвэржүүлж тооцоолсон орлогоос илүү гарсан тохиолдолд зөрүүг Төсвийн тогтвортой байдлын санд хуримтлуулдаг.

5.3.3 ОУ-ийн орлогыг улсын төсөвт хуваарилах нь (ША 5.1)

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд болох Төсвийн тухай хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хууль болон ЗГ-ын тусгай сангийн тухай хуулиудын дагуу ОУ-ээс олсон орлогыг дараах байдлаар хуваарилна:

ОУ-ээс олсон орлогын хуваарилалт, 2016 оны эцсийн байдлаар					
	Улсын төсөв	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	Хот болон аймгийн сан	Дүүрэг болон сумын сан	Хүний хөгжлийн сан
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	30%	5%	-	-	65%
Ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрлийн төлбөр	50%	50%	-	-	-
Газрын тосны хайгуул болон олборлолтын тусгай зөвшөөрлийн төлбөр*	70%	-	20%	10%	-
Газрын тосны нөөц ашигласны төлбөр*	70%	30%	-	-	-

Эх сурвалж: Сангийн Яам, Төсвийн тухай хууль

Тэмдэглэл: *Төсвийн тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн өөрчлөлтийг оруулав.

2015 оны 5 дугаар сард ОУ дэх орон нутгийн оролцоо болон ОУ-ийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор УИХ Төсвийн тухай хуулийн 60 дугаар бүлэг болон Хүний хөгжлийн сангийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Нэмэлт өөрчлөлтөөр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65%-ийг хүний хөгжлийн санд хуваарилж, 5%-ийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилах, ашигт малтмалын хайгуул болон олборлолтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс олсон орлогын 50%-ийг орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

СЯ-аас МОУИТБС-ын Ажлын Албанд ирүүлсэн мэдээллээр тухайн жилийн төсвийн бодлого болон Татварын ерөнхий хуулийн дагуу олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжээс авсан татвар ба хураамжийг зохих сангуудад хуваарилж байна.

5.3.4 Орон нутгийн шилжүүлэг (ША 5.2) болон тусгай сангуудын орлого (ША 5.3а)

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

Төсвийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаар орон нутгийн хөгжлийг дэмжих болон Монгол Улсын бүс хоорондын эрх тэгш байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсвүүдэд санхүүжилтийг хуваарилдаг бөгөөд энэ үндсэн дээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан /ОНХНС/ оршин тогтнодог. Аймаг, сум болгон өөрийн гэсэн хөгжлийн сантай байх бөгөөд эдгээрийг орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/ гэнэ. Эдгээр орон нутгийн хөгжлийн сангуудын орлогын гол эх үүсвэр нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан шилжүүлгүүд болон улсын төсвөөс хуваарилсан олборлох салбарын тодорхой хэмжээний орлого юм.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн төсөв нь эхлээд аймгуудын орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэгдэж, дараа нь аймгуудын төсвөөс холбогдох сумд руу шилжүүлэгддэг.

Төсвийн тухай хуулийн 59.1 дүгээр зүйлд зааснаар энэ сан нь дараах орлогын эх үүсвэртэй бөгөөд эдгээр нь 21 аймаг тус бүрийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэгддэг:

- Импортын бараа болон үйлчилгээнээс бусад бараа болон үйлчилгээнээс авсан НӨАТ-ийн 10%;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5%;
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%;
- Дотоодын төрийн бус байгууллагуудаас авсан тусламж болон хандив, мөн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авсан гадаадын албан ёсны буцалтгүй тусламж; болон
- Доод түвшний сангаас дээд түвшний санд өгсөн шилжүүлгүүд;

Эдгээр орлогын эх үүсвэрээс гадна улсын төсвөөс 21 аймаг тус бүрийн Орон нутгийн хөгжлийн санд дараах орлогыг шилжүүлдэг.

- Мега төслийн орлогын 30%
- Ашигт малтмалын нөөц ашиглах зөвшөөрлийн орлогын 50%

Доорх хүснэгтээр 2016 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд орлогын эх үүсвэр бүрээр төлөвлөсөн болон бодитоор орсон орлого болон энэхүү сангаас аймгуудын Орон нутгийн хөгжлийн санд бодитоор хуваарилсан дүнг харуулав.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төлөвлөсөн болон бодитоор орсон орлого болон энэхүү сангаас аймгуудын Орон нутгийн хөгжлийн санд бодитоор хуваарилсан дүн			
Сая төг.	Төлөвлөсөн орлого	Хуримтлагдсан орлого	ОНХС-д шилжүүлэн бодит шилжүүлэг
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан			
НӨАТ/Импортын бараа болон үйлчилгээний орлогоос бусад/	41,800.0	45,887.8	46,624.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	12,769.6	14,435.7	14,435.7
Газрын тосны нөөц ашигласны төлбөр	4,944.9	6,230.3	6,230.3
Тусламж болон хандив	-	-	-
Доод түвшний сангаас дээд түвшний санд өгсөн шилжүүлгүүд	16,141.6	16,141.6	16,141.6
Нийт /Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан/	75,656.1	82,695.4	83,431.6
Улсын төсөв			
Мега төслийн орлого	29,005.8	28,597.1	24,714.7
Ашигт малтмалын нөөц ашиглах зөвшөөрлийн орлого	15,605.8	17,404.8	12,121.4
Нийт /Улсын төсөв/	44,611.6	46,001.9	36,836.1
Нийт /Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Улсын төсөв/	120,267.7	128,697.3	120,267.7

Эх сурвалж: Сангийн яам болон Үндэсний аудитын газар

Кэй Пи Эм Жи-ээс хүссэн нэмэлт мэдээллийн маягтын дагуу Сангийн яамнаас 21 аймаг тус бүрийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэхээр төлөвлөсөн болон бодитоор хуваарилсан дүнг орлогын эх үүсвэр тус бүрээр ирүүлсэн болно. ОТАХ нь ил тод болгож буй мэдээлэлд ямар нэгэн материаллаг босго тогтоогоогүй учир бүх орлогын мэдээллүүдийг доор харуулав. Сумдын хэмжээнд нийт төлөвлөсөн болон бодитоор шилжүүлсэн мэдээллийг Хавсралт 23.б- ээс харна уу.

Аймгуудын Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэхээр төлөвлөсөн болон бодитоор хуваарилсан дүн														
Аймаг	НОАТ-10%		АМНАТ 5%		ГТНАТ 30%		Доод түвшний сангаас дээд түвшний санд		Мега төсөл 30%		Тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого 50%		Нийт дүн	
	Төлөв.	Шилж.	Төлөв.	Шилж.	Төлөв.	Шилж.	Төлөв.	Шилж.	Төлөв.	Шилж.	Төлөв.	Шилж.	Төлөв.	Шилж.
Сая төг.														
Архангай	1,762	1,878	343	422	208	222	680	605	6	6	180	47	3,180	3,180
Баян-Өлгий	1,481	1,656	356	466	175	235	572	606	347	101	330	197	3,260	3,260
Баянхонгор	2,065	2,358	312	430	244	224	797	719	545	233	774	774	4,738	4,738
Булган	1,563	1,627	225	338	185	217	604	646	468	468	506	254	3,550	3,550
Говь-Алтай	2,209	3,486	217	661	261	353	853	720	958	14	1,195	461	5,694	5,694
Дорноговь	1,826	1,886	241	376	216	250	705	756	638	438	1,953	1,874	5,580	5,580
Дорнод	1,877	1,940	280	396	222	259	725	776	286	275	751	495	4,141	4,141
Дундговь	1,721	1,881	166	310	204	234	665	610	442	442	917	637	4,115	4,115
Завхан	1,799	2,120	267	490	213	304	695	730	1,045	375	166	166	4,186	4,186
Өвөрхангай	1,843	1,780	417	505	218	259	712	765	48	48	207	88	3,444	3,444
Өмнөговь	2,052	2,507	706	1,160	243	390	792	828	13,003	13,003	4,720	3,627	21,515	21,515
Сүхбаатар	1,723	1,848	243	390	204	251	665	709	3,404	3,404	1,443	1,080	7,681	7,681
Сэлэнгэ	1,492	1,706	457	610	176	219	576	615	1,829	1,395	358	343	4,887	4,887
Төв	1,563	1,873	365	470	185	239	604	639	2,616	2,110	968	968	6,301	6,301
Увс	1,674	1,657	280	336	198	227	647	515	47	12	195	294	3,041	3,041
Ховд	1,838	1,707	302	374	217	249	710	764	266	266	331	303	3,664	3,664
Хөвсгөл	1,873	1,789	465	542	222	264	723	756	10	5	103	39	3,396	3,396
Хэнтий	1,770	2,237	277	487	209	229	683	602	1,159	544	318	318	4,417	4,417
Дархан-Уул	1,326	1,654	380	532	157	250	512	532	842	248	79	78	3,295	3,295
Улаанбаатар	5,621	6,558	5,164	4,099	665	1,012	2,171	2,157	729	526	43	43	14,394	14,394
Орхон	1,515	1,354	1,247	867	179	181	585	601	-	558	36	1	3,562	3,562
Говьсүмбэр	1,207	1,122	60	176	143	162	466	488	317	244	35	35	2,227	2,227
Нийт	41,800	46,624	12,770	14,437	4,944	6,230	16,142	16,139	29,005	24,715	15,608	12,122	120,268	120,268

Эх сурвалж: Сангийн яам

Орлогын эх үүсвэр тус бүрээс хуримтлагдсан бодит орлого нь анх төлөвлөсөн хэмжээтэй харьцуулахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувьд 13.3 хувиар, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хувьд 25.0 хувиар, НӨАТ-ын орлогын хувьд 11.5 хувиар тус тус өндөр байсан. Гэсэн хэдий ч, бодит орлого төлөвлөсөн хэмжээнээс мега төслийн хувьд 15 хувь, хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын хувьд 23 хувиар бага байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн дагуу тухайн санхүүгийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсвүүд рүү хийх шилжүүлгийг тодорхойлохдоо дараах үзүүлэлтүүдийг авч үздэг:

- Орон нутгийн хөгжлийн индекс;
- Хүн ам;
- Хүн амын нягтаршил, алслалт болон нутаг дэвсгэрийн хэмжээ; болон
- Орон нутгийн татварын идэвхи санаачлага.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуваарилахдаа, хүн ам тутамд ногдох дүнг уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаггүй бүс нутгаас 10 хүртэлх хувиар илүү хуваарилах ёстой. Дээр дурьдсан үзүүлэлтүүдийг харгалзан нийслэл, аймгууд нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилагдсан шилжүүлгийн 60 хувиас доошгүй хэсгийг дүүрэг болон сумдын хөгжлийн сангуудад шилжүүлнэ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хуримтлалаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан нийт дүнг (НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөр, хандив тусламж, болон доод түвшний сангаас дээд түвшний санд шилжүүлэг) дээр дурьдсан итгэлцүүрүүдэд тэнцүү хувааж, эдгээр хуваарилалтыг аймгууд руу шилжүүлэх орлогыг тооцох томьёонд ашигладаг.

Итгэлцүүр тус бүрт хуваарилсан мөнгөн дүн		
Сая төг.	Хувь	Нийт мөнгөн дүн *25%
Орон нутгийн хөгжлийн индекс	25%	15,721.6
Хүн ам	25%	15,721.6
Хүн амын нягтаршил, алслалт болон нутаг дэвсгэрийн хэмжээ	25%	15,721.6
Орон нутгийн татварын идэвхи санаачлага	25%	15,721.6
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хуримтлалаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан нийт дүн	100%	62,886.5

Эх сурвалж: Сангийн яам

2012 оны Засгийн Газрын 30 тоот тушаалын дагуу аймгууд руу хуваарилах шилжүүлгийг тооцох томьёонд холбогдох Засгийн Газрын агентлагуудаас гаргадаг тодорхой үзүүлэлтүүдийг ашигладаг:

Дараах үзүүлэлтүүдийг Сангийн яамнаас:

- Бүх 21 аймгийн орон нутгийн хөгжлийн индекс
- Улсын дундаж хөгжлийн индекс
- Алслалтын индекс
- Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт

Дараах үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн газраас:

- Бүх 21 аймгийн хүн амын тоо
- Бүх 21 аймгийн хүн амын нягтрал
- Бүх 21 аймгийн газар нутгийн хэмжээ

Дараах үзүүлэлтүүдийг Татварын ерөнхий газраас:

- Татварт хамруулалтын индекс
- Татварын барагдуулалтанд үндэслэсэн үзүүлэлт

Дараах үзүүлэлтийг аймгийн ИТХ-ын баталснаар:

- Татварын хувь хэмжээ

Доорх хүснэгтэд аймгуудад шилжүүлэхээр хуваарилсан орлогын томъёо болон бодолтыг итгэлцүүр тус бүрээр харуулав.

Итгэлцүүр тус бүрт хуваарилсан төлөвлөгөө																				
Аймаг	1. Орон нутгийн хөгжлийн индекс			2. Хүн ам		3. Хүн амын нягтаршил, алслалт болон нутаг дэвсгэрийн хэмжээ							4. Орон нутгийн татварын идэвхи санаачлага							Итгэлцүүрт үндэслэн хуваарилалтын дүн
	Орон нутгийн хөгж. индекс	Харьц. индекс	Хуваарил. / Сая төг./	Хүн ам. /мянга/	Хуваарил. / Сая төг./	Нягтрал индекс	Нягтрал индекс (урвуу)	Нягтрал -аас хамаарсан	Алс. индекс	Алслал -аас Хамаар.	Газар нутаг	Газар нутгаас хамаар.	Хуваарил. / Сая төг./	Орл. Төл. биелэл	Тат. хамру. индекс	Тат. бараг. индекс	Тат. орлогы н хувь хэмжээ	Тат. идэвх санаа.и индекс	Хуваарил / Сая төг./	
А	Б	Г	В	Д	Е	Ж	З	И	К	Л	М	Н	О	П	ИВ	И+П+ИИ+ИИИ				
	Улсын дунд. хөгж. индекс ¹ /А	Б/В ^{нийт} *хмд ²	В/В ^{нийт} *хмд ²	И/Г	Д/Д ^{нийт} * 33%* хмд ²	Ж/Ж ^{нийт} *33%* хмд ²	И / И ^{нийт} * 34%* хмд ²	Е+З+К	(Л+М +Н+О)/ 4	П / П ^{нийт} * хмд ²										
Архангай	0.23685	0.92214	649.7	93.1	488.6	1.68	0.59	139.2	0.7465	424.6	55.3	189.0	752.8	0.0489	0.0531	0.0544	0.0421	0.0496	780.2	2,671.2
Баян-Өлгий	0.19852	1.10019	775.1	95.2	499.6	2.08	0.48	112.5	0.1674	95.2	45.7	156.2	364.0	0.0481	0.0251	0.0382	0.0403	0.0379	596.2	2,234.9
Баянхонгор	0.21890	0.99775	702.9	83.0	435.6	0.72	1.40	327.6	1.0000	568.7	116	396.4	1,292.8	0.0488	0.0436	0.0441	0.0423	0.0447	702.7	3,134.0
Булган	0.23222	0.94053	662.6	60.5	317.5	1.24	0.80	188.7	0.5258	299.1	48.7	166.4	654.2	0.0435	0.0490	0.0492	0.0445	0.0466	731.9	2,366.2
Говь-Алтай	0.18015	1.21236	854.1	56.7	297.5	0.40	2.49	584.6	0.5712	324.9	141.4	483.2	1,392.7	0.0480	0.0433	0.0481	0.0445	0.0460	723.0	3,267.4
Дорноговь	0.17842	1.22416	862.4	63.8	334.8	0.58	1.72	402.3	0.0782	44.5	109.5	374.2	821.1	0.0407	0.0521	0.0514	0.0421	0.0465	731.7	2,750.0
Дорнод	0.23256	0.93919	661.7	75.2	394.6	0.61	1.64	385.3	0.3787	215.4	123.6	422.4	1,023.1	0.0444	0.0538	0.0536	0.0401	0.0480	754.3	2,833.7
Дундговь	0.19957	1.09444	771.1	44.4	233.0	0.59	1.68	394.4	0.4304	244.8	74.7	255.3	894.5	0.0431	0.0440	0.0483	0.0434	0.0447	702.4	2,600.9
Завхан	0.19937	1.09550	771.8	69.7	365.8	0.84	1.18	277.5	0.5634	320.4	82.5	281.9	879.8	0.0429	0.0375	0.0445	0.0398	0.0412	647.6	2,665.0
Өвөрхангай	0.22021	0.99186	698.8	113.0	593.0	1.80	0.56	130.5	0.6729	382.7	62.9	215.0	728.2	0.0452	0.0490	0.0525	0.0493	0.0490	770.2	2,790.2
Өмнөговь	0.27279	0.80065	564.1	59.7	313.3	0.36	2.77	649.5	0.5211	296.4	165.4	565.3	1,511.1	0.0406	0.0422	0.0487	0.0498	0.0453	712.3	3,100.7
Сүхбаатар	0.23494	0.92964	655.0	57.4	301.2	0.70	1.43	336.1	0.4491	255.4	82.3	281.3	872.8	0.0494	0.0503	0.0477	0.0498	0.0493	775.1	2,604.1
Сэлэнгэ	0.21241	1.02827	724.4	106.2	557.3	2.58	0.39	90.9	0.0376	21.4	41.2	140.8	253.1	0.0434	0.0512	0.0400	0.0462	0.0452	710.6	2,245.4
Төв	0.22308	0.97910	689.8	90.1	472.8	1.22	0.82	192.5	0.0673	38.3	74	252.9	483.7	0.0531	0.0442	0.0350	0.0476	0.0450	707.1	2,353.4
Увс	0.18045	1.21039	852.7	75.8	397.8	1.09	0.92	215.3	0.1815	103.2	69.6	237.9	556.4	0.0501	0.0451	0.0445	0.0433	0.0458	719.5	2,526.4
Ховд	0.19331	1.12986	796.0	81.5	427.7	1.07	0.93	218.9	0.6416	364.9	76.1	260.1	843.9	0.0463	0.0417	0.0400	0.0454	0.0434	682.1	2,749.7
Хөвсгөл	0.23301	0.93737	660.4	126.0	661.2	1.25	0.80	187.2	0.4397	250.1	100.6	343.8	781.1	0.0437	0.0418	0.0465	0.0521	0.0460	723.2	2,825.9
Хэнтий	0.20505	1.06515	750.4	71.2	373.6	0.89	1.13	264.4	0.5290	300.8	80.3	274.4	839.7	0.0431	0.0566	0.0366	0.0452	0.0454	713.3	2,677.1
Дархан-Уул	0.27086	0.80636	568.1	99.9	524.2	30.27	0.03	7.7	0.1878	106.8	3.3	11.3	125.8	0.0444	0.0422	0.0431	0.0469	0.0441	694.0	1,912.2
Улаанбаатар	0.25926	0.84245	593.5	1,363	7,152.6	290.00	0.00	0.8	0.0000	0.0	4.7	16.1	16.9	0.0424	0.0456	0.0382	0.0504	0.0442	694.2	8,457.2
Орхон	0.20295	1.07619	758.2	94.4	495.4	118.00	0.01	2.0	0.5837	332.0	0.8	2.7	336.7	0.0497	0.0396	0.0404	0.0499	0.0449	705.7	2,296.0
Говьсүмбэр	0.22020	0.99188	698.8	16.1	84.5	2.93	0.34	80.1	0.3490	198.5	5.5	18.8	297.4	0.0401	0.0491	0.0552	0.0449	0.0473	744.2	1,824.9
Нийт	4.80508	22.31546	15,721.6	2,995.9	15,721.6	460.9	22.11	5,188.1	9.1219	5,188.1	1564.1	5,345.4	15,721.8	1.0	1.0	1.0	1.0	1.00	15,721.5	62,886.5

Тайлбар: ¹Улсын дундаж хөгжлийн индекс (0.21841)

²хмд - Итгэлцүүр тус бүрт хуваарилсан мөнгөн дүн (Орон нутгийн хөгжлийн индекс, Хүн ам, Хүн амын нягтаршил, алслалт болон нутаг дэвсгэрийн хэмжээ, Орон нутгийн татварын санаачлагууд) - 15,721.6 сая төг
Эх сурвалж: Сангийн яам

Доорх хүснэгтэд аймгуудын ОНХС-д АМНАТ-ын орлогоос шилжүүлэхээр хуваарилсан томъёо, бодолт болон нийт төлөвлөсөн болон бодит шилжүүлгийг харуулав. СЯ-ны мэдээлснээр ОНХНС-аас аймгуудын ОНХС-руу хийсэн бодит шилжүүлгийг хуваарилахдаа доорх томъёоллыг мөн ашигласан байна.

Ашигт малтмалын нөөц ашиглалтын орлогыг хуваарилалт							Аймгуудын ОНХС-д хуваарилсан төлөвлөгөө болон бодит шилжүүлэг					
Аймаг	Хүн ам. /мянга/	1 хүнд ногдох	АМН АТ	1 хүнд ногдох (жинлэсэн)	Хүн амаар тооцсон	Хасагдуула х хувь	I. Хуваарилалт / Сая төг./	II. Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилах дүн / өмнөх хүснэгтийг харна уу/	III. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилах дүн I+II.	IV. Улсын төсвөөс хуваарилсан нийт дүн	ОНХНС болон Улсын төсвөөс ОНХС-д хуваарилсан нийт дүн III+ IV.	ОНХНС болон Улсын төсвөөс ОНХС нийт шилжүүлсэн бодит дүн
Сая төг.	А	Б	В	Г	Д	Е	Д*(I- E)					
		АМНА Т ¹ /А нийт		Б*(I+В/ В _{Төв} *10%)	Г*А	I-(АМНАТ ¹ / Д _{нийт})						
Архангай	93.1	4.2	0	4.2	396.8	13.52%	343.2	2,671.2	3,014.4	186.1	3,179.9	3,179.9
Баян-Өлгий	95.2	4.2	0.9	4.3	411.2	13.52%	355.6	2,234.9	2,590.5	676.8	3,260.1	3,260.1
Баянхонгор	83	4.2	1.4	4.3	361.2	13.52%	312.3	3,134.0	3,446.3	1,319.0	4,737.8	4,737.8
Булган	60.5	4.2	0.6	4.2	260	13.52%	224.8	2,366.2	2,591.0	973.8	3,550.5	3,550.5
Говь-Алтай	56.7	4.2	2.6	4.4	250.5	13.52%	216.6	3,267.4	3,484.0	2,153.3	5,693.7	5,693.7
Дорноговь	63.8	4.2	1.7	4.3	278.5	13.52%	240.9	2,750.0	2,990.9	2,591.1	5,579.9	5,579.9
Дорнод	75.2	4.2	0.7	4.3	324	13.52%	280.2	2,833.7	3,113.9	1,037.1	4,140.6	4,140.6
Дундговь	44.4	4.2	1.2	4.3	192.4	13.52%	166.4	2,600.9	2,767.3	1,359.2	4,114.7	4,114.7
Завхан	69.7	4.2	2.8	4.4	308.9	13.52%	267.1	2,665.0	2,932.1	1,211.5	4,185.8	4,185.8
Өвөрхангай	113	4.2	0.1	4.2	482.5	13.52%	417.3	2,790.2	3,207.5	254.5	3,444.4	3,444.4
Өмнөговь	59.7	4.2	156.9	13.7	816.2	13.52%	705.8	3,100.7	3,806.5	17,722.8	21,515.0	21,515.0
Сүхбаатар	57.4	4.2	10.6	4.9	281.3	13.52%	243.3	2,604.1	2,847.4	4,846.1	7,681.2	7,681.2
Сэлэнгэ	106.2	4.2	11.8	4.9	527.8	13.52%	456.5	2,245.4	2,701.9	2,186.5	4,887.3	4,887.3
Төв	90.1	4.2	7.1	4.7	422.4	13.52%	365.3	2,353.4	2,718.7	3,584.1	6,300.9	6,300.9
Увс	75.8	4.2	0.1	4.3	323.6	13.52%	279.9	2,526.4	2,806.3	241.8	3,040.6	3,040.6
Ховд	81.5	4.2	0.3	4.3	348.6	13.52%	301.5	2,749.7	3,051.2	596.6	3,664.1	3,664.1
Хөвсгөл	126	4.2	0	4.3	537.1	13.52%	464.5	2,825.9	3,290.4	113.0	3,395.6	3,395.6
Хэнтий	71.2	4.2	0.9	4.5	320.3	13.52%	277.0	2,677.1	2,954.1	1,477.7	4,417.2	4,417.2
Дархан-Уул	99.9	4.2	2.3	4.4	439.5	13.52%	380.1	1,912.2	2,292.3	920.9	3,295.3	3,295.3
Улаанбаатар	1,363.0	4.2	1.9	4.3	5,971.70	13.52%	5,165.3	8,457.2	13,622.5	772.1	14,393.7	14,393.7
Орхон	94.4	4.2	183.5	15.3	1,447.40	13.52%	1,246.5	2,296.0	3,542.5	35.6	3,562.0	3,562.0
Говьсүмбэр	16.1	4.2	0.8	4.3	69.4	13.52%	60.1	1,824.9	1,885.0	352.1	2,227.4	2,227.4
Нийт	2996	92.4	388.2	116.8	14771.3		12,770.2	62,886.5	75,656.7	44,611.7	120,267.7	120,267.7

Тайлбар: ¹АМНАТ – Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5% - 12,769.5 сая төг
Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгуудын Орон нутгийн хөгжлийн сан руу шилжүүлж буй төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор 2013 онд Орон нутгийн хөгжлийн сангийн цахим системийг байгуулсан (<http://tusuv-oronnutag.mof.gov.mn/>). Бүх 21 аймаг энэхүү цахим системд Орон нутгийн хөгжлийн сангаас хүлээн авсан шилжүүлгийг хэрхэн сумдууд руу хуваарилсан болон энэхүү төсвөөр хэрэгжүүлсэн төслүүдийн нэр, төрөл, санхүүжилт, захиалагч, гүйцэтгэгч, эхлэх болон дуусах өдрийн тухай мэдээллээ оруулдаг.

2016 оны Үндэсний аудитын газраас гаргасан “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан”-д хэд хэдэн асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн сангаас орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэж заасан байдаг. Гэвч нийт 21 аймгийн 10 аймаг нь энэхүү заалтыг зөрчсөн байна. Үүнд, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Завхан, Увс, Ховд аймгууд орсон байна. Дэлгэрэнгүйг уг тайлангийн 11 дүгээр хуудаснаас харна уу.
2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна. Орон нутгийн хөгжлийн санд 1 дүгээр улиралд 4,964.4 сая, 2 дугаар улиралд 7,654.4 сая төгрөгийг батлагдсан хуваариас дутуу шилжүүлсэн байна. Иймээс 3 дугаар улиралд 11,648.1 сая, 4 дүгээр улиралд 1,148.5 сая төгрөгийг батлагдсан хуваариас илүү шилжүүлсэн байна. Дэлгэрэнгүйг уг тайлангийн 11 дүгээр хуудаснаас харна уу.

“Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан”-г дараах линкээр орж харна уу: <http://www.audit.mn/wp-content/uploads/2017/06/oron-nutgin-hogjlin.pdf>

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төсөл

2016 оны УИХ-ын нэгдсэн чуулганаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг баталсан. Энэ хууль нь 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Хүний Хөгжлийн Сангийн хуулийг орлон хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулийн төслийн гол зорилго нь эрдэс баялгаас бий болсон орлогыг ирээдүй хойч үедээ үлдээх, урт хугацаанд баялагийг хуримтлуулах, арвижуулах бодлого, тогтолцоог бий болгох явдал юм.

Энэхүү хуулийн төслийн дагуу тус сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй төрийн өмчит аж ахуйн нэгж болон бусад аж ахуйн нэгжийн төрд ногдох ногдол ашиг болон хувьцааны борлуулалтын орлого;
- Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төсөвт цугларсан орлогын Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын санд хуваарилсанаас үлдэх хэсэг эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь;
- 2030 оноос эхлэн тус сангаас хийгдсэн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлсний дараах үлдэх хэсэг;
- Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр хууль батлах замаар татвар бий болгох, татварын хувь, хэмжээг өөрчилсөн тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д заасан ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс улсын төсөвт орох нэмэлт орлогын 50 хувь; болон
- 2018 оноос эхлэн тухайн жил улсын төсөвт орох, дээр дурьдсанаас бусад эрдэс баялагийн орлогын суурь жилийн орлогын гүйцэтгэлээс давсан хэсгийн 20 хувь.

Ирээдүйн өв сангийн тухай хууль нь 7 бүлэг, 33 зүйлээс бүрдэх Ирээдүйн өв сангийн үйл ажиллагаа болон уг сангийн хөрөнгийг удирдан, зохион байгуулах хуулийн этгээдийг зохицуулах үүрэгтэй.

Төсвийн тогтвортой байдлын сан

Тодорхой ашигт малтмалын зах зээлийн борлуулалтын үнэ төлөвлөсөн борлуулалтын үнээс доогуур байх үед улсын төсвийн төсөөлөлд нөлөөлж төлөвлөсөн орлогод хомсдол үүсгэдэг ба төсвийн тогтвортой байдлын сан нь энэ хомсдлыг нөхдөг. 2014 онд Тусгай сангийн тухай хуулийн дагуу Засгийн Газрын 2014 оны 396 дугаар тогтоолоор төсвийн тогтвортой байдлын сангийн хуримтлагдсан хөрөнгөөс 118.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлсэн. 2016 онд нийт 332.4 тэрбум төгрөгийг төсвийн тогтвортой байдлын санд хуримтлуулсан ба үүнээс хүүгийн орлого нь 10 тэрбум төгрөг, валютын ханшийн зөрүүний орлого нь 7.4 тэрбум төгрөг байна. 2016 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төсвийн тогтвортой байдлын санд орлого төвлөрөөгүй.

Төсвийн тогтвортой байдлын сан					Тэрбум төг	
Орлого	2011	2012	2013	2014	2015	2016
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	241.0	94.7	46.9	39.9	2.3	-
Нийт хуримтлал	241.0	335.7	383.5	307.3	314.5	332.4

Эх сурвалж: Сангийн яам

Ирэх 3 жилд Төсвийн тогтвортой байдлын санд жилд дунджаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 7 тэрбум, хүүгийн орлогоос 4.7 тэрбум төгрөг хуримтлагдахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн тогтвортой байдлын сан		Тэрбум төг		
Орлого	2017	2018	2019	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	7.8	6.1	7.1	
Хүүгийн орлого	4.7	4.6	4.7	
Нийт орлого	12.5	10.7	11.8	

Эх сурвалж: Сангийн яам

Хүний хөгжлийн сан

Хүний хөгжлийн сан нь ОУ-ийн орлогоос иргэдэд хувь тараах зорилготой хадгаламж болон өсөн нэмэгдэх байнгын нөөц бий болгохын тулд байгуулагдсан. Төсвийн тухай хуульд зааснаар Хүний хөгжлийн сан нь 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр УИХ-аар батлагдсан Хүнийн хөгжлийн сангийн тухай хуулийн дагуу олсон орлого болон зардлуудаас бүрддэг ба УИХ хүний хөгжлийн сангийн журмыг жил болгон шинэчилдэг. Тус сан нь дараах орлогын эх үүсвэртэй:

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниас ЗГ-ын авсан ногдол ашиг болон хувьцааны борлуулалтын орлого;
- Ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс авсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65%;
- Хүний хөгжлийн сангийн үнэт цаас болон бондын хөрөнгө оруулалтаас олсон цэвэр ашиг; болон
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласантай холбоотойгоор авсан зээл болон урьдчилж төлсөн төлбөрийн зарим хэсэг.

2016 оны Хүний хөгжлийн сангийн аудитлагдсан тайланд дурьдсанчлан, 189 тэрбум төгрөг тус санд хуваарилагдсан бөгөөд энэ нь нийт төлөвлөсөн 169 тэрбум төгрөгөөс 11.8%-аар их байна. Энэ хуваарилалтын 99.2% нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр юм.

Хүний хөгжлийн сан нь 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болж уг сангийн хөрөнгийн үлдэгдлийг Ирээдүйн өв сан руу шилжүүлсэн байна.

Кэй Пи Эм Жи нь бүх аймгуудаас Засгийн Газраас хүлээн авсан орон нутгийн шилжүүлэг болон орон нутгийн хөгжлийн сан, хүний хөгжлийн сан болон бусад сангуудаараа дамжуулан харгалзах сумдын сангууд руу хийгдсэн шилжүүлгүүдийг нэмэлт мэдээллийн маягтаар тодруулах хүсэлт хүргүүлсэн. Увс

аймгаас бусад бүх аймаг бидний нэмэлт мэдээллийн маягтын дагуу хариугаа ирүүлж, шилжүүлгээ мэдээлсэн. Мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 23.а -с харна уу.

5.3.5 Улсын төсөв, аудитын үйл ажиллагаа болон улсын төсвийн тухай ЗГ-ын таамаглал (ША 5.3б,в)

Төрийн Аудитын Байгууллага нь дараах зүйлсийн хувьд санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны гүйцэтгэлд Төрийн аудитын тухай хуулийн дагуу аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана:

- Улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд;
- Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоот байгууллагууд; болон
- Улс болон орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрүүд.

Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь УАГ, түүний харьяа орон нутаг дахь төрөлжсөн салбар байгууллагуудаас бүрдэнэ.

УАГ-ын цахим хуудсанд дурьдсанаар “УАГ төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулж ажиллах ба төлөвлөгөөг боловсруулахдаа иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн аудитын сэдвийг сонгож, хүний болон санхүүгийн нөөц, хугацаа, хүрэх үр дүнг тусган УИХ-ын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэр гаргуулна. Улсын төсвөөс санхүүжилт авсан болон төрийн оролцоот бүхий л байгууллагууд жил бүр УАГ-ын харьяа байгууллагаар богино аудит хийлгэх эсвэл УАГ-аар илүү өндөр хяналттай аудитын шалгалт хийлгэх ёстой.”

УАГ нь жил бүр өөрийн үйл ажиллагааны болон аудитын тайлангаа нийтэлдэг. УАГ-ын тайлагнал нь аудит хийх явцад гарсан асуудал, түүний шалтгаан болоод зайлшгүй биелүүлбэл зохих зөвлөмжүүдийг тусгасан байдаг. Өнгөрсөн жилийн зөвлөмжүүд нь тухайн байгууллагын дараагийн жилийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны гүйцэтгэлд тусгагдсан байх ёстой. Хэрэв УАГ-ын өгсөн зөвлөмжүүдийг дагаж мөрдөөгүй тохиолдолд тухайн байгууллагад тодорхой хугацааны дотор уг зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлага бүхий албан бичгийг хүргүүлдэг бөгөөд тухайн тулгараад буй асуудлын нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан хэрэгжүүлсэн байвал зохих эцсийн хугацааг тогтоодог. Хэрэв энэхүү албан бичгийн дагуу ямар нэгэн өөрчлөлт байгууллагын зүгээс хийгдээгүй тохиолдолд нэмэлт захиргааны арга хэмжээг авдаг.

УАГ-ын 2016 оны үйл ажиллагааны тайланг дараах холбоосоор харна уу: <http://www.audit.mn/?p=16743>

Улсын төсвийн 2016 оны төлөвлөлт болон гүйцэтгэлийн талаар доорх холбоосоор харна уу: <https://www.mof.gov.mn/category/budget/budgetof2016/>

ЗГ-ын Улсын төсвийн төсөөлөл

Олборлох үйлдвэрлэлээс олох орлогын хэмжээ ирэх 3 жилд өсөх хандлагатай байна. Энэхүү төсөөллийг боловсруулахдаа макро эдийн засгийн үзүүлэлтүүд, олон улсын зах зээл дээрх олборлох ашигт малтмалын төлөвлөгдсөн үнэ ханш болон Монгол Улсын ОУ-д үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө гэсэн 3 ерөнхий хүчин зүйл дээр тулгуурласан байна.

Нэгдсэн төсвийн төсөөлөл			
Тэрбум. төг	2018	2019	2020
Нийт төсвийн орлого	7,283.0	8,403.0	9,445.0
Уул уурхайн салбарын орлого	1,315.6	1,510.4	1,619.3
<i>Нийт төсөв дэх уул уурхайн салбарын орлогын эзлэх хувь</i>	<i>18%</i>	<i>18%</i>	<i>17%</i>

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2019-2020 оны төсөөлөл.

Доорх хүснэгтэд ирэх жилүүдэд төлөвлөсөн экспортын хэмжээг харуулав.

Төлөвлөсөн экспортын хэмжээ				
Мян.тн	2017	2018	2019	2020
Нүүрс	25,800.0	27,500.0	29,500.0	30,700.0
Зэсийн баяжмал	1,371.3	1,236.0	1,340.0	1,510.0
Төмрийн хүдэр	5,581.0	5,890.0	6,200.0	8,200.0
Жонш	268.6	288.6	300.6	300.6
Алт, тонн (Оюу Толгойгоос бусад)	17.0	16.9	17.0	18.5
Газрын тос ¹	8,100.0	8,100.0	8,100.0	8,100.0

Тайлбар:¹Газрын тосны хэмжилтийн нэгж нь баррель болно.

Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсөөлөл

Нүүрс, төмрийн хүдэр болон жоншны хэмжээ ирээдүйд өсөх төлөвтэй байна. Харин зэсийн баяжмалын хэмжээ 2018 онд өмнөх онтой харьцуулахад буурах төлөвтэй байна. Энэ нь Оюу Толгойн далд уурхайн ажилтай холбоотой юм. Газрын тосны хэмжээ тогтмол байх төлөвтэй байна.

Доорх хүснэгтэд түүхий эдийн төлөвлөгдсөн үнийн мэдээллийг харуулав.

Түүхий эдийн төлөвлөгдсөн үнэ				
ам.доллар/тонн	2017	2018	2019	2020
Нүүрс	37.9	32.7	37.0	34.3
Зэс				
Зах зээлийн үнэ	5,149.8	5,159.7	5,148.9	5,137.2
Тэнцвэржүүлсэн үнэ	4,599.4	4,658.9	4,725.5	4,725.5
Төмрийн хүдэр	38.5	40.0	40.0	40.0
Жонш	276.7	276.7	276.7	276.7
Алт ¹	1,212.0	1,225.0	1,251.0	1,274.0
Газрын тос ¹	55.0	56.0	56.0	56.0

Тайлбар:¹Газрын тосны хэмжилтийн нэгж нь баррель, алтны үнэ болно.

Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсөөлөл

Алтны үнэ ирэх 3 жилд өсөх төлөвтэй байна. Харин зэсийн зах зээлийн үнэ 2018 оноос эхлэн буурах төлөвтэй байна. Төмрийн хүдэр, жонш болон түүхий нефтийн үнэ тогтмол байх төлөвтэй байна.

5.4 ОУ дэх төрийн оролцоо

5.4.1 ОУ-тэй холбоотой ЗГ-ын байгууллагууд

5.4.1.1 ЗГ-ын байгууллагын тодорхойлолт

ОУ нь олон төрлийн чиг үүрэг бүхий ЗГ-ын байгууллагуудын хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг зохицуулалт бүхий салбар юм. Түүнчлэн, ОУ-д үйл ажиллагаа явуулж буй компаниуд нь уг салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, орлого олохын тулд харъяа ЗГ-ын байгууллагуудад олон төрлийн төлбөр төлдөг. Нэгтгэлийн зорилгоор МОҮИТБС-ын Үндэсний Зөвлөлийн шийдвэрийн дагуу ОУ-ийн компаниудаас материаллаг хэмжээний төлбөрийг хүлээн авдаг ЗГ-ын байгууллагуудыг нэгтгэлд хамруулахаар сонгосон. ОУ-ийн үйл ажиллагаанд хамгийн их оролцоотой ЗГ-ын байгууллагуудын нэрсийг, ажил үүргийн ерөнхий чиглэлийн хамт дор харуулав.

Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам (УУХҮЯ)

УУХҮЯ-ны үндсэн үүрэг нь ЗГ-тай хамтран Монгол Улсын ашигт малтмалын нөөцийг бүрэн дүүрэн, үр ашигтай ашиглан уул уурхайн салбарыг Олон Улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх уул уурхайн нарийвчилсан тогтвортой төсвийн бодлогоор хангахад оршино.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.mmhi.gov.mn/> цахим хаягаас авна уу.)

Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (АМГТГ)

АМГТГ нь 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Улсын Их Хурлын 4 тоот тогтоолын дагуу Ашигт малтмалын газар болон Газрын тосны газрыг нэгтгэсэнтэй холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төрийн өмчит байгууллага юм. АМГТГ нь тусгай зөвшөөрлийн өргөдөл шийдвэрлэж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгодог. Мөн уг байгууллага нь геологийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай орчинг бүрдүүлэх зорилт тавьж ажилладаг.

Түүнчлэн, АМГТГ-ын Газрын тосны ашиглалт болон Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсүүд нь Газрын тосны тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудын дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэгтэй.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <https://mgram.gov.mn/> цахим хаягаас авна уу.)

Цөмийн Энергийн Комисс

2014 онд Цөмийн Энергийн Агентлаг татан буугдан үүрэг хариуцлагууд нь Цөмийн Энергийн Комисст шилжсэн. Монгол Улсын Цөмийн Энергийн Комисс нь анх 1962 онд байгуулагдсан бөгөөд үндсэн үйл ажиллагаанууд нь цацраг идэвхит ашигт малтмал болон цөмийн энергийн ашиглалтыг зохицуулах Засгийн Газрын бодлогыг хэрэгжүүлэх; цөмийн байгууламж, материал, цацраг идэвхит ашигт малтмалтай холбоотой тусгай зөвшөөрлийг олгох эсвэл цуцлах; Монгол Улсын цөмийн энергийн салбарын шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагааг зохицуулах, хянах; цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

2015 оны 3 дугаар сард Цөмийн Энергийн Комиссын шинэ бүтэц, чиг үүрэг батлагдаж, Цөмийн Энергийн Комиссын ажилчдын тоо 33 байхаар хязгаарлагдсан ба комиссын ахлагчаар Монгол Улсын Ерөнхий Сайд томилогдсон.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.nea.gov.mn> цахим хаягаас авна уу.)

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)

БОАЖЯ-ны үндсэн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой үндэсний бодлого, хууль журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, жам ёсоор

нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалахад оршино. Түүнчлэн, БОАЖЯ нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой тусгай асуудлуудын хүрээнд нийслэлийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын дагаж мөрдвөл зохих дүрэм журам, бодлогыг боловсруулж батлах, түүнтэй холбогдох шийдвэрийг гаргадаг.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.mne.mn/> цахим хаягаас авна уу.)

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ)

ХНХЯ-ны үндсэн үүрэг нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах явдал бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэх явдал юм. ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцөл ба амьжиргааны өртгийн асуудлыг сайжруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн ажил эрхлэлтийн асуудал болон гадаад улсад хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг зохицуулах үүрэгтэй. ХНХЯ-ны эрхэм зорилго нь хөдөлмөрлөх таатай орчин болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэх явдал юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.mlsp.gov.mn/> цахим хаягаас авна уу.)

Татварын Ерөнхий Газар (ТЕГ)

Татварын ерөнхий хуульд зааснаар Үндэсний татварын алба нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ТЕГ), аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. ТЕГ нь ЗГ-ын санхүүгийн асуудал хариуцсан байгууллага болох Сангийн Яамны харьяа байгууллага бөгөөд түүний удирдлагад ажилладаг.

ТЕГ-ын үндсэн чиг үүрэг нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх явдал юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.mta.mn/> цахим хаягаас авна уу.)

Гаалийн Ерөнхий Газар (ГЕГ)

Монгол Улсын Гаалийн үйл ажиллагааг гаалийн төв байгууллага болох ГЕГ удирдан чиглүүлдэг бөгөөд түүний харьяанд аймаг, нийслэлийн гаалийн албадууд хамаарна. ГЕГ нь гаалийн хууль тогтоомжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага бөгөөд Сангийн Яамны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг.

ГЕГ-ын үндсэн чиг үүрэг нь гаалийн хуулийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, түүний нийцлийг хянах, гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, гаалийн алба хэлтсийн үйл ажиллагааг зохицуулах, Гаалийн Хөгжлийн Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.ecustoms.mn/> цахим хаягаас авна уу.)

Эрүүл Мэнд, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар (ЭМНДЕГ)

ЭМНДЕГ нь Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар (НДЕГ) болон орон нутгийн салбар, нэгжүүдээс (байцаагч, төлөөлөгч нар) бүрдэнэ. Монгол Улсын нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу НДЕГ нь нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн ЗГ-ын харьяа байгууллага бөгөөд орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагууд нь орон нутгийн засаг захиргааны харьяа эсвэл зохих дээд түвшний Нийгмийн Даатгалын байгууллагын харьяа байгууллага юм.

ЭМНДЕГ-ын зорилго нь тэтгэвэр, эрүүл мэнд, үйлдвэрийн ослын нөхөн төлбөр, ажилгүйдлийн даатгалыг хариуцах явдал юм. Мөн нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах зэрэг үйл ажиллагааг хамарна. ЭМНДЕГ нь ЗГ-аас хэрэгжүүлж буй

нийгмийн хамгааллын бодлого ба нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.ndaatgal.mn/> цахим хаягаас авна уу.)

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар (ТӨБЗГ)

Улсын Их Хурлын 12 тоот тогтоолыг үндэслэн ТӨБЗГ-ыг байгуулсан. ТӨБЗГ-ын цахим хуудсан дахь мэдээллийн дагуу ТӨБЗГ нь төрийн эзэмшлийн эсвэл ихэнх хувь нь төрийн эзэмшил бүхий 82 байгууллага, аж ахуйн нэгжийг хамаардаг.

ТӨБЗГ нь захиргааны алба, худалдан авалт, төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсүүдээс бүрддэг. ТӨБЗГ нь төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны ил тод байдал болон хувьчлалын ил тод байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.pcsr.gov.mn/> цахим хаягаас авна уу.)

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй. Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлогыг боловсруулан хэрэгжүүлэгч хамгийн дээд түвшний зөвлөл байгууллага юм.

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг хадгалан хамгаалах гадаад ба дотоод таатай нөхцлийг баталгаажуулж буй үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр тулгуурласан. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 1994 онд батлагдсан өмнөх үндэсний аюулгүй байдлын зарчмыг 2010 оны 7 дугаар сарын 25-ны өдөр ЗГ-аас шинэчлэн хэрэгжүүлж эхэлсэн.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.nsc.gov.mn/>-с авна уу.)

Үндэсний Аудитын Газар (ҮАГ)

Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль нь 2003 оны 01 дүгээр сард батлагдсан. Уг хууль нь ҮАГ болон аймаг, нийслэлийн аудитын газруудыг хууль, эрх зүйн үндсээр хангаж өгдөг. Ерөнхийдөө уг хууль нь төсвийн орлого, зарлага болон аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийх ЗГ-ын хөндлөнгийн аудитын эрх бүхий байгууллагын үүрэг хариуцлагыг зохицуулдаг. ҮАГ нь аудитын үйл явц, аргачлалыг зохицуулах, аудитын бодлого, төлөвлөлт, чанарын хяналт болон баталгаажуулалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй. ҮАГ нь хөгжлийн хэлтэс, нийцлийн аудитын газар, гүйцэтгэлийн аудитын газар, санхүүгийн аудитын газар, дэмжих үйлчилгээний хэсэг гэсэн таван газар, хэлтсээс бүрддэг. Нийслэлийн аудитын газар, орон нутгийн аудитын газар гэсэн хоёр хэрэгжүүлэгч нэгжтэй.

Одоогийн байдлаар ҮАГ болон аливаа орон нутгийн аудитын байгууллагуудаас төрийн байгууллагуудын тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг ямар нэгэн баталгаажуулалтаар хангахад чиглэсэн горимыг хийж гүйцэтгээгүй. Бидний ойлгосноор МОУИТБС-ын Ажлын алба төрийн байгууллагуудаас тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг баталгаажуулах журмын төслийг боловсруулж ҮАГ-т албан ёсоор танилцуулсан ба 2018 оноос туршилтаар уг журмын дагуу баталгаажуулахаар бэлтгэж байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.audit.mn/> цахим хаягаас авна уу.)

5.4.1.2 ЗГ-ын ОУ-ийн талаарх хэвлэл мэдээлэл (ША 5.3в)

2011 оны 6 дугаар сард батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу төрийн оролцоотой бүхий л ЗГ-ын агентлагууд болон хуулийн этгээдүүд өөрсдийн үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв болон санхүүгийн баримтууд, мөн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний талаар мэдээлэл хийж, мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулан, байнга шинэчилж байх хэрэгтэй.

Төсөв болон санхүүгийн ил тод байдлын хувьд Монгол Улсын УИХ-аас улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид “шилэн данс” гэх/-г бүрдүүлэх зорилгоор Шилэн дансны тухай хуулийг баталсан. Уг хууль нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Төрийн оролцоотой бүх ЗГ-ын агентлагууд болон хуулийн этгээдүүд нь төсөв, санхүүгийн асуудлаар мэдээлэл хийж, санхүүжилт болон бусад ЗГ-ын өрийн эх үүсвэрийн зарцуулалтыг олон нийтэд танилцуулах үүрэгтэй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Сангийн Яам нь “шилэн данс”-ны үндсэн вэб хуудас болох (<http://www.shilendans.gov.mn>)-г эзэмших бөгөөд бусад хуулийн хүрээнд хамрагдах байгууллагууд нь дансны тусгай хэсгийн нэмэлт мэдээлэл болон санхүүгийн мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам (УУХҮЯ)

Уул уурхайн салбарын тухай статистик мэдээллийг УУХҮЯ өөрийн цахим хуудаснаа сар бүр нийтлэдэг (<http://www.mmhi.gov.mn/public/file/id/277>). Мөн өмнөх сарын экспортлосон уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийг цахим хуудсаар сар бүр тайлагнадаг (<http://www.mmhi.gov.mn/public/files/id/37>).

АМГТГ

Уул уурхайн салбарын ил тод байдлыг сайжруулахын тулд АМГТГ-аас Уул уурхайн статистик мэдээллийг сар тутамд хэвлүүлдэг. Статистик мэдээлэл нь Уул уурхайн үйдвэрлэлийн эдийн засагт өгч буй үр нөлөө болон уул уурхайн ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон байдаг (<https://mrapam.gov.mn/article/83/>).

ТЕГ

ТЕГ нь “ТЕГ-ын төсөвлөсөн санхүүгийн тайлан болон нэгтгэсэн санхүүгийн байдлын системийн тайлан” – г улирал тутамд нийтэлдэг. Мөн ТЕГ-ын төсвийг жил бүр тайлагнадаг (<http://www.mta.mn/pages/164>).

СЯ

Улсын төсөв болон түүний гүйцэтгэлийг СЯ-ны албан ёсны цахим хуудсаар цаг тухай бүрт нь тайлагнадаг. Түүнчлэн, Шилэн дансны хуулийн дагуу СЯ нь улсын төсвийг жилд 2 удаа, ЗГ-ын үнэт цаас гаргах замаар бий болсон санхүүжилтийн зарцуулалтыг улирал бүр нийтлэх ёстой (<http://www.shilendans.gov.mn>).

ГЕГ

ГЕГ нь гаалийн орлогын төсвийн гүйцэтгэл болон зарцуулалтын хуваарилалтыг сар бүр тайлагнах ёстой. (<http://customs.gov.mn>).

5.4.2 ТӨААН-үүдийн хураангуй танилцуулга (ША 2.6б)

Доорх хүснэгтэд ОУ-ийн салбарт оролцож байгаа төрийн болон орон нутгийн өмчит компани болон ТӨААН-ийн бенефициар өмчлөгчийн мэдээллийг харуулав: (Тайланд багтсан компаниудын бенефициар өмчлөгчийн мэдээллийг 5.5.1-ээс харна уу)

Шаардлага 2.6.б дагуу ТӨААН гэдэг нь засгийн газрыг төлөөлөн олборлох үйл ажиллагаа эрхэлдэг бүхэлдээ эсхүл ихэнх нь төрийн эзэмшлийн компани байна.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд			
ААН-ийн нэр	Өмчийн хэлбэр	Ашигт малтмал	Нэгтгэлд багтсан
Төрийн өмчит			
Эрдэнэс Монгол ХХК	100% төрийн өмчит	Төрөл бүрийн	Тийм
Эрдэнэс Таван Толгой ХК	Эрдэнэс Монгол ХХК 100%	Нүүрс	Тийм
Эрдэнэс Оюу Толгой ХХК	Эрдэнэс Монгол ХХК 100%	Зэс, алт	Үгүй
Шивээ Овоо ХК	Эрдэнэс Монгол ХХК 90%, бусад - 10%	Нүүрс	Тийм
Багануур ХК	Эрдэнэс Монгол ХХК 75%, бусад - 25%	Нүүрс	Тийм
Мон Атом ХХК	Эрдэнэс Монгол ХХК 100%	Уран	Үгүй
Эрдэнэт Үйлдвэр ХХК	Монгол Улсын ЗГ 51%, хувийн өмч 49%	Зэс, молибден	Тийм
Монголросцветмет ХХК	Монгол Улсын ЗГ 51%, хувийн өмч 49%	Алт, хайлуур жонш, нүүрс, мөнгө	Тийм
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК*	Монгол Улсын ЗГ 100%	Төмрийн хүдэр	Тийм
Булган аймгийн Хорих 443-р анги	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Нүүрс	Үгүй
ШТН ТӨҮГ	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Барилгын материалууд	Үгүй
Авдрант Хайрхан ТӨҮГ	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Боржин чулуу	Үгүй
Булган аймгийн Хорих 439-р анги	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Барилгын материал	Үгүй
Уул уурхайн аврах анги	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Нүүрс	Үгүй
Хэнтий аймгийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Барилгын материал	Үгүй
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	Төрийн өмчит аж ахуйн нэгж	Барилгын материал	Үгүй
Орон нутгийн өмчит			
Тавантолгой ХК	Орон нутгийн өмч 51%, хувийн өмч 49%	Нүүрс	Тийм
Могойн Гол ХК	Орон нутгийн өмч 51%, хувийн өмч 49%	Нүүрс	Тийм
Баянтээг ХК	Орон нутгийн өмч 70%, хувийн өмч 30%	Нүүрс	Тийм


Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, Эрдэнэс Монгол ХХК, ТӨБЗГ, аймгууд болон бусад олон нийтэд нээлттэй мэдээлэл
Тайлбар: * Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК 2015 онд удирдлагын хувьчлалд орсон.

Дээр дурдсан 19 ТӨААН-үүдээс 2016 онд ОУ-ийн нийт орлогод оруулсан хувь нэмэр дээр нь үндэслэн 9 ТӨААН-үүдийг материаллаг гэж үзсэн. Хараат бус хянагч-нэгтгэгчийн эхлэлтийн үе шатанд ОТАХ нийт 213 компаниудыг хамгийн их материаллаг төлбөр төлсөн учир нэгтгэлд хамруулахаар зөвшилцсөн. Эдгээр 9 ТӨААН-үүд эдгээр 213 компанийн тоонд багтсан.

Эрдэнэс Монгол ХХК (100% төрийн өмчит)

Эрдэнэс Монгол ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг боловсруулах болон эзэмшихэд ЗГ-ын хувьцааг төлөөлөх зорилгоор байгуулагдсан тусгай зориулалтын компани юм. Тус компани нь Монгол Улсын уул уурхайн хамгийн том хөрөнгө болох дөрвөн компанийн хувьцааг эзэмшдэг ба үүнд: Оюу Толгой ХХК (Эрдэнэс Оюу Толгой ХХК-аар дамжуулан шууд бусаар), Эрдэнэс Таван Толгой ХК, Багануур ХК болон Шивээ Овоо ХК орно. Мөн түүнчлэн, Эрдэнэс Монгол ХХК нь Мон-Атом ХХК болон Гашуун Сухайтын Зам ХХК-уудын 50%-аас илүү хувийг эзэмшдэг. 2016 онд Эрдэнэс Монгол ХХК нь 3 охин компани байгуулсан. Үүнд: Эрдэнэс

Ассет Менежмент ХХК болон Эрдэнэс Метан ХХК-ийг 100% эзэмшдэг бол Эрдэнэс Шивээ Энержи ХХК-ийн 50%-ийг эзэмшдэг.



Эх сурвалж: Эрдэнэс Монгол

Эрдэнэс Монгол ХХК-ийн үүсгэн байгуулалт

Эрдэнэс Монгол ХХК өөрийн охин компаниудаараа дамжуулан зэс, алт, молибден, мөнгө, коксжуулсан хүдэр, цайрын баяжмал, төмрийн хүдэр, холимог металл болон фосфорит үйлдвэрлэх зэргээр уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг. Компани нь 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн Газрын 266 тоот тогтоол болон 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн Өмчийн Хорооны (хуучнаар) 52 тоот тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан ба Улаанбаатар хотод байрладаг.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг тодорхойлсон УИХ-ын 27 тоот тогтоолтой холбогдуулан эдгээр стратегийн орд газраас олсон уул уурхайн салбарын орлогыг хуримтлуулж, Монгол Улсын иргэн бүрт тэгш хуваарилах тухай Хүний хөгжлийн сангийн тухай хуулийг 2009 онд баталсан. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг ТӨААН-үүд хэрэгжүүлнэ гэж тусгасан. Стратегийн ач холбогдол бүхий ордод үндэсний аюулгүй байдал болон орон нутаг, улсын түвшинд тухайн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлж чадахуйц хэмжээний хангалттай том ордыг хамруулдаг.

Компанийн дүрмийг 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн ЗГ-ын 347 тоот тогтоолоор өөрчлөн баталсан болно.

Эрдэнэс Таван Толгой ХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)

Эрдэнэс Таван Толгой ХК нь 2010 онд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд стратегийн ач холбогдол бүхий нүүрсний орд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилготойгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компаниар үүсгэн байгуулагдсан. Таван Толгойн орд газар нь коксжуулсан нүүрсний нөөцөөр дэлхийд дээгүүрт орох бөгөөд одоогоор нийт 7.4 тэрбум тонн эрчим хүчний болон коксжих нүүрсний

нөөцтэй гэж бүртгэгдсэн. Эрдэнэс Таван Толгойн уурхай нь Улаанбаатар хотоос 540км урагш, БНХАУ-ын хилээс 270км зайтай байршдаг.

Эрдэнэс Оюу Толгой ХХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)

Эрдэнэс Оюу Толгой ХХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани юм. Эрдэнэс Оюу Толгой нь 2011 оноос хойш Оюу Толгой ХХК-ийн 34 хувийг эзэмшиж байна. 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Рио Тинто компанитай (Туркойз Хилл компанийн толгой компани) байгуулсан гэрээний дагуу Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК нь ЗГ-ын нэрийн өмнөөс Оюу Толгой ХХК-ийг эзэмшиж байсан.

Шивээ Овоо ХК (Эрдэнэс Монгол ХХК 90%-ийг эзэмшдэг)

Шивээ Овоо хүрэн нүүрсний уурхайн орд газар анх 1990 онд Говьсүмбэр аймагт байгуулагдсан. ЗГ нь компанийн хувьцааны 90%-ийг эзэмшдэг бөгөөд үлдсэн хувийг хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшдэг байна. 2013 онд ЗГ өөрийн эзэмших хувийг Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлснээр Шивээ Овоо ХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болсон. Одоогоор Шивээ Овоо ХК-ийн нүүрсний нөөцийг 2,708.7 сая гаруй тонн гэж тооцоолсон.

Багануур ХК (Эрдэнэс Монгол ХХК 75%-ийг эзэмшдэг)

Багануур ХК нь анх 1978 онд Төвийн Эрчим Хүчний Системийн харьяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан. 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдөр ЗГ өөрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлснээр Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болсон. Одоогийн байдлаар геологийн нөөцийг 812 сая гаруй тонн гэж тооцоолсон.

Тавантолгой ХК (Орон нутгийн эзэмшил 51%, хувийн эзэмшил 49%)

ЗГ-ын өмч хувьчлалын хурлын комиссын 42 тоот тогтоолын дагуу 1994 онд төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК үүсгэн байгуулагдсан. 1995 оноос эхлэн Тавантолгой ХК нь орон нутгийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймагт, Хятад – Монголын хилээс ойролцоогоор 270 км-ийн зайтай байрладаг.

Мон Атом ХХК (100% Төрийн өмчит)

Мон Атом ХХК нь 2009 онд “Төрийн өмчит компани үүсгэн байгуулах” тухай ЗГ-ын 45 тоот тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт уран болон бусад цацраг идэвхит ашигт малтмалын геологийн судалгаа хийх явдал юм. Мон Чех Уран ХХК-ийн 51%-ийг Мон-Атом ХХК эзэмшдэг.

Гашуун Сухайтын Зам ХХК

2011 онд Монголын хувийн хэвшлийн Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын Засгийн Газрын “2013 онд Газрын Нүүрс Экспортлох Тухай” 299 тоот тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-д замыг шилжүүлж өгсөн. 2014 онд Гашуун Сухайтын Зам ХХК нь гол нүүрс экспортлогчид болох Энержи Ресурс ХХК, Эрдэнэс Таван Толгой ХК болон Тавантолгой ХК-ийн хамтарсан компани хэлбэрээр байгуулагдсан. Эрдэнэс Монгол ХХК нь одоогийн байдлаар замын хариуцагчаар ажиллаж байна.

Эрдэнэс Метан ХХК

Эрдэнэс Метан ХХК нь 2016 оны 02 дугаар сард уламжлалт болон уламжлалт бус байгалийн хий, газрын тос хайх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тэвэрлэлтийг зохицуулах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн 100% өмчлөлтэй охин компани болон байгуулагдсан.

Эрдэнэс Шивээ Энержи ХХК

Тус компани нь дотоодын болон Хятад улсын зах зээл, цаашлаад Зүүн хойд Азийн эрчим хүчийг нийлүүлэх, экологид ээлтэй, хэмнэлттэй нүүрс болон сэргээгдэх эрчим хүчний цахилгаан станц барих зорилгоор байгуулагдсан.

Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ХХК (ЗГ-ын эзэмшил 51%)

Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ХХК нь дэлхийд томоохонд тооцогддог эзсийн уурхай, баяжуулах үйлдвэр юм. Анх 1978 онд Монгол – Орос хоёр орны Засгийн Газар хоорондын гэрээний дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн. 2016 онд Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49% Монгол улс дахь хувийн эзэмшилд шилжсэн байна. Хэдийгээр энэхүү хэлэлцээр нь олон нийтийн дунд маргаантай байгаа боловч энэхүү тайланг бэлтгэх үед Монгол Улсын Засгийн Газрын эзэмшлийн хувь өөрчлөгдөөгүй 51% хэвээр байна. 2016 оны байдлаар тус үйлдвэр нь 657.3 сая тонн хүдэр эзсийн баяжмал үйлдвэрлэн боловсруулсан байна.

Монголросцветмет ХХК (ЗГ-ын эзэмшил 51%)

Монголросцветмет ХХК нь хайлуур жоншны уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд одоогийн байдлаар гурван далд уурхайн орд, хоёр ил уурхайн орд болон боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай компани юм. Компани нь хүчил болон төмөрлөгийн хайлуур жоншны, мөн алтыг баяжуулан боловсруулах үйл ажиллагаа явуулдаг. Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэрийн адилаар Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49% Монгол улс дахь хувийн эзэмшилд шилжсэн байна. Хэдийгээр, энэхүү хэлэлцээр нь олон нийтийн дунд маргаантай байгаа боловч энэхүү тайланг бэлтгэх үед Монгол Улсын Засгийн Газрын эзэмшлийн хувь өөрчлөгдөөгүй 51% хэвээр байна.

Могойн Гол ХК (Орон нутгийн эзэмшил 51%, хувийн эзэмшил 49%)

Могойн Гол ХК нь 1970 онд үүсгэн байгуулагдсан нүүрс олборлодог компани юм. Уурхай нь Хөвсгөл аймагт байрладаг бөгөөд 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

Баянтээг ХК (Орон нутгийн эзэмшил 70%, хувийн эзэмшил 30%)

Баянтээг ХК нь 1961 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд нүүрсний уурхайн орд газар нь Өвөрхангай аймагт буюу Улаанбаатар хотоос 560 км зайтай байрладаг. 1995 онд хувьцаат компани болж дахин зохион байгуулагдсан ба хувьцааны 70% нь төрийн эзэмшилд байдаг. 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК (100% төрийн өмчит)

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр нь 1990 онд Дархан-Сэлэнгийн төмрийн хүдрийн уурхайн үйлдвэрт суурилан үүсгэн байгуулагдсан. Төмөрлөгийн хүдрийн стратегийн ач холбогдол бүхий орд газрын нөөц нь ойролцоогоор 230 сая тонн байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд төмрийн хүдрийн нойтон соронзон боловсруулах цогц үйлдвэрийг 2014 онд байгуулсан. 2015 онд Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр удирдлагын хувьчлалд орсон.

Бусад ТӨААН-үүд

АМГТГ-аас ирүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээлэлд үндэслэн бид ТӨААН-үүдээр дамжуулан ОУ-ийн салбар дахь бусад төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн талаар олж мэдсэн. Гэвч эдгээр аж ахуй нэгжүүд нь 2016 онд материаллаг төлбөр хийгээгүй учраас нэгтгэлийн хүрээнд хамрагдаагүй. Эдгээр ТӨААН-үүдэд Хорих 439-р анги, ШТН, Авдрант Хайрхан, Булган аймгийн Хорих 439-р анги, Уул уурхайн аврах анги, Хэнтий аймгийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба, болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нар багтаж байна. Өмнөх жилүүдийн тайланд багтаж байсан Сүхбаатарын уул уурхай компани нь 2015 онд хувьчлагдсан тул энэхүү тайлангийн ТӨААН-ийн жагсаалтнаас хасагдсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

ТӨААН-үүдээс нийт 7 байгууллага нь ТУЗ-ийн мэдээллээ ирүүлсэн бөгөөд ТУЗ-ийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 24.а-с харна уу.

Газрын тосны салбар дахь төрийн оролцоо

2014 оны 7 дугаар сард Монгол Улсын УИХ-аас Газрын тосны тухай шинэчилсэн хуулийг баталж, 5.1.2 хэсэгт дурьдсаны дагуу 1991 оны хуулийг хүчингүй болгосон. Уламжлалт газрын тосны бүтээгдэхүүнээс гадна, энэхүү хуульд занарын элс, нүүрсний давхаргын метан хий болон байгалийн битум зэрэг бусад ашигт малтмалын нөөцүүд хамрагдсан. Гол зохицуулагчийн хувьд АМГТГ болон УУХҮЯ нь БХГ-г байгуулах (ЗГ-ын зөвшөөрөлтэй), жилийн төлөвлөгөө батлах болон хураамжийн төлөлтөд хяналт тавих зэрэг асуудлуудыг хариуцна. Тухайн асуудлыг хариуцах төрийн байгууллагуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг 5.1.4-с харна уу.

5.4.3 ЗГ ба ТӨААН-үүдийн санхүүгийн харилцаа (ША 2.6а)

Засгийн Газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм журам

ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль болон хуулийн дагалдах Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмуудаар зохицуулдаг. Энэхүү хуульд тусгайлан заагаагүй бол ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Компанийн тухай хууль болон тухайн төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн дүрмээр зохицуулдаг.

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтад төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ гэж заасан.

ТӨААН-ийн төрийн өмчийн төлөөллийг Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмаар зохицуулан томилдог. Энэхүү журмын 2 дугаар зүйлд олборлох салбарын төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар тогтоож өгсөн байна.

- Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дарга болон гишүүдийг Засгийн Газрын 2016 оны 104 тоот тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 7.1, 8.2-т заасны дагуу Засгийн Газар томилж, чөлөөлнө.
- Төрийн өмчийн төлөөлөл болон Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн хурал нь Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын чиглэл болсоны дагуу Эрдэнэс Оюу Толгой ХК зохицуулагдах ба Эрдэнэс Оюу Толгой ХК нь Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн хурлыг томилж, чөлөөлнө.
- Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компаниуд болох Эрдэнэс Таван Толгой ХК, Эрдэнэс Оюу Толгой ХК, Багануур ХК, Шивээ-Овоо ХК болон Мон-Атом ХК зэрэг төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн дарга болон гишүүдийг Засгийн Газрын 2016 оны 104 тоот тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн компанийн дүрмийн 11.8-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.
- Эрдэнэт Үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-ийн ТУЗ-ийн дарга болон гишүүдийг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газраас чиглэл болгосны дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.
- Төрийн Өмчийг Хэрэгжүүлэх журмын 2.4-2.9-т зааснаас бусад тохиолдолд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-д төрийн өмчийн төлөөллийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 13 дугаар заалтад Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана. Харин Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ (эсвэл Хувьцаа эзэмшигчдийн хурал ТУЗ-ийг орлож) ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг тогтооно гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16 дугаар заалтад Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана гэж заасан бөгөөд тус зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглодог.

Засгийн Газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцааг зохицуулах практик

5.4.2 хэсэгт дурдсан 19 ТӨААН-үүдээс 2016 онд ОУ-ийн нийт орлогод оруулсан хувь нэмэр дээр нь үндэслэн 9 ТӨААН-үүдийг материаллаг гэж үзсэн. Хараат бус хянагч-нэгтгэгчийн эхлэлтийн үе шатанд ОТАХ нийт 213 компаниудыг хамгийн их материаллаг төлбөр төлсөн учир нэгтгэлд хамруулахаар зөвшилцсөн. Эдгээр 9 ТӨААН-үүдэд эдгээр 213 компанийн тоонд багтсан юм.

Хараат бус хянан-нэгтгэгчийн ажлын эхлэлтийн үеэр Кэй Пи Эм Жи нь Эрдэнэс Монгол ХХК болон ТӨБЗГ-тай уулзаж Засгийн Газар болон төрийн өмчит компаниудын хоорондох санхүүгийн харилцааны талаарх дүрэм журам, практикын талаар хэлэлцсэн. Үүнээс гадна, ОУИТБС-ын стандартын ТӨААН-үүдтэй холбоотой шаардлагуудыг багтаасан тусгай маягтыг Засгийн Газарт материаллаг төлбөр хийсэн 9 ТӨААН –үүд рүү явуулсан. Энэ маягтад ТӨААН болон Засгийн Газрын хоорондын санхүүгийн харилцаа, зээл болон зээлийн баталгаа, шилжүүлэг болон төсвийн шинжтэй зарцуулалт гэх мэт стандарт шаардлагуудыг багтаасан.

Үүнээс гадна, ОТАХ-тэй тохиролцсоны дагуу бид стандартад шаардсан гүйлгээг нарийвчлан тодруулахын тулд аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг (АСТ) ТӨААН-үүдээс хүссэн. ТӨААН-үүд нь АСТ-г өгөөгүй тохиолдолд бид эдгээрийг ҮАГ-аас авсан болно. Ихэнх ТӨААН-үүд нь хоёр АСТ-тай ба нэг нь ҮАГ-ын тайлан бол нөгөө нь хөндлөнгийн аудиторын гаргасан тайлан байдаг. ҮАГ-аар аудитласан санхүүгийн тайлан нь хөндлөнгийн аудитороор аудитласан тайлантай харьцуулахад илүү ерөнхий, товч байдаг. Нийт 9 ТӨААН-ийн зургаа нь ҮАГ-аар аудитлагдсан тайлангаа явуулсан байна.

Төсвийн шилжүүлэг, ногдол ашиг хуваарилах гэх мэт тодруулах шаардлагатай асуудлууд гарсан тохиолдолд Кэй Пи Эм Жи шууд ТӨААН-үүдтэй холбогдож байсан. Бид Гурвансайхан ХХК-тай холбоо барьж чадаагүй.

Төсвийн шилжүүлэг

Дэлгэрэнгүй мэдээллийг 5.4.5-с харна уу.

Хуримтлагдсан ашиг

ҮАГ-ын Хүний хөгжлийн сангийн аудитын тайланд дурьдсанаар 2016 онд 3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэрээс хүний хөгжлийн санруу шилжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэвч Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэрийн удирдах зөвлөл 2015 болон 2016 онд хуралдаагүй бөгөөд ногдол ашгийн төлбөрийн талаар ямар нэгэн шийдвэр гаргаагүй учраас Хүний хөгжлийн санд ногдол ашиг хуваарилаагүй байна. Хэдийгээр, ногдол ашиг хуваарилаагүй боловч, практик дээр ногдол ашиг хуваарилах шийдвэр нь дээр тайлбарласан дүрэм журмын дагуу явагддаг юм байна гэж бид үзлээ.

ТӨААН-үүдийн мэдээлснээр ногдол ашгийг дээр дурьдсан дүрмийн дагуу зарлаж хуваарилдаг байна. Тухайлбал, Багануур ХК-ийн мэдээлснээр Багануур ХК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг зарлах болон хуваарилах шийдвэр гаргахдаа 2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Ногдол Ашгийн бодлогыг ашигладаг. Хэдийгээр компани нь тухайн онд ашигтай ажилласан боловч компанийн эдийн засаг, санхүүгийн үзүүлэлт нь ногдол ашиг хуваарилсаны дараа төлбөрийн чадвартай байх гэсэн нөхцлийг хангахгүй байгааг харгалзан Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 4 тоот тогтоолоор 2016 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Мөн Эрдэнэт Үйлдвэр ХХК ногдол ашгийг компанийн дүрмийн 12.1 болон 12.2 заалт болон Зөвлөлийн 2007 оны 37 дугаар хуралдааны протоколын 6.2 заалтаар баталсан “Ногдол ашиг хуваарилах журам”-ыг баримталж хуваарилдаг гэж мэдээлсэн.

2016 оны эцсийн байдлаар ТӨААН –үүдийн хуримтлагдсан ашиг, цэвэр ашиг болон ногдол ашгийг доорх хүснэгтэд харуулав.

Цэвэр ашиг (алдагдал) болон ногдол ашиг					сая төг.
No	Регистрийн дугаар	Компанийн нэр	2016 онд хуримтлагдсан ашиг	Цэвэр ашиг (алдагдал)	Ногдол ашиг
1	2008572	Багануур ХК	8,108	1,342	-
2	2014491	Баянтээг ХК	1,695	922	25
3	5124913	Эрдэнэс Монгол ХК	(48,780)	52	-
4	5435528	Эрдэнэс Таван Толгой ХХК	(416,563)	(198,840)	-
5	2074192	Эрдэнэт Үйлдвэр ХХК	614,285	(126,781)	-
6	2034859	Могойн гол ХК	997	109	41

Цэвэр ашиг (алдагдал) болон ногдол ашиг					сая төг.
No	Регистрийн дугаар	Компанийн нэр	2016 онд хуримтлагдсан ашиг	Цэвэр ашиг (алдагдал)	Ногдол ашиг
7	2550466	Монголросцветмет ХК	(33,875)	(14,458)	-
8	2004879	Шивээ-Овоо ХК	5,021	2,090	130
9	2016656	Таван Толгой ХК	78,403	54,042	40,342

Эх сурвалж: Компануудын нэмэлт мэдээллийн хүснэгтээр ирүүлсэн болон АСТ-аас авсан цэвэр ашиг болон ногдол ашгийн талаарх мэдээлэл

ТӨААН-үүдийн улсын болон орон нутгийн засаг захиргаанд шилжүүлсэн ногдол ашиг нь тулган баталгаажуулалтад орох боломжтой орлогын урсгал юм. Хараат бус хянан-нэгтгэгчийн эхлэлтийн үе шатанд ОТАХ-тэй зөвшилцсөн аргачлалд зөвхөн материаллаг орлогын урсгалыг тулган баталгаажуулахаар хэлэлцсэн. Энэхүү аргачлалаар ТӨААН-үүдийн улсын болон орон нутгийн засаг захиргаанд шилжүүлсэн ногдол ашиг нь материаллаг бус хэмээн тодорхойлогдсон. Тиймээс дээрх ногдол ашгууд нь тулган баталгаажуулалтад ороогүй болно.

Дахин хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт

Багануур ХК-ийн мэдээлснээр компани нь Багануур Пауэр ХХК-тай 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдөр нүүрс худалдах концессийн гэрээ байгуулсан байна. Худалдан авагч тал 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Монгол Улсын Засгийн Газартай барих, ашиглах, шилжүүлэх нөхцлөөр “Багануур Цахилгаан Станц” төслийг хэрэгжүүлэх концессийн гэрээг байгуулсан. Худалдан авагч тал концессийн гэрээний хугацаанд Багануур ХК-аас нүүрс худалдан авна гэдгээ мэдэгдсэн.

ТӨААН-үүдээс хүлээн авсан мэдээллүүд, аудитлагдсан санхүүгийн тайлангууд, Эрдэнэс Монгол болон ТӨБЗГ-ээс авсан мэдээллүүд дээрээс харахад 2016 онд дахин хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилтийн тухай мэдээлэл байхгүй байна.

5.4.4 ЗГ-ын эзэмшлийн түвшин, зээл болон зээлийн баталгаа (ША 2.6б)

ЗГ-ын эзэмшлийн түвшин

ОУИТБС-ын стандартын дагуу тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад болон ТӨААН-үүдийн охин компаниуд, хамтарсан үйлдвэрүүдэд Засгийн Газар болон ТӨААН-үүдийн эзэмших хувь эзэмшлийн түвшинг ил тод болгохоос гадна эзэмшлийн түвшинд тайлант хугацаанд ямар нэгэн өөрчлөлт гарсан бол түүнийг тайлагнана.

ТӨААН-үүдийн ирүүлсэн нэмэлт мэдээллүүд болон тэдгээрийн аудитлагдсан тайлангуудаас үзэхэд Засгийн газрын эзэмшлийн түвшин болон өөрийн хөрөнгийн хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр болон Монголросцветмент ХХК-ийн ЗГ-ын эзэмшлийн 51%-д өөрчлөлт гараагүй боловч, Оросын төрийн өмчит Ростехнологи Корпораци өөрийн эзэмшлийн 41%-ийн хувьцааг 2016 оны 6 дугаар сард Монголын Зэс Корпораци ХХК-д борлуулсан. Энэхүү хэлэлцээр нь олон нийтийн дунд ихээхэн маргаантай байгаа бөгөөд одоогоор шийдвэрлэгдээгүй үргэлжилж байна. Энэхүү тайланг бэлтгэх үед уг хэлэлцээрийн нөхцлүүд албан ёсоор олон нийтэд ил тод болоогүй байна.

2016 онд Эрдэнэс Монгол ХХК 3 охин компани байгуулсан. Үүнд: 100%-ийн эзэмшилтэй Эрдэнэс Ассет Менежмент ХХК болон Эрдэнэс Метан ХХК, мөн 50%-ийн эзэмшилтэй Эрдэнэс Шивээ Энержи ХХК хамаарна. Одоогийн байдлаар эдгээр компаниудын аль нь ч олборлох үйлвэрлэлийн салбарын тусгай зөвшөөрөл эзэмшээгүй байна. Эдгээр охин компаниудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 5.4.2-с харна уу.

Зээл болон зээлийн баталгаа

Хэрэв Засгийн Газар болон ТӨААН-үүд нь тухайн улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудад зээл эсвэл зээлийн баталгаа гаргасан бол эдгээр гүйлгээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгодог.

ТӨААН-үүдийн ирүүлсэн нэмэлт мэдээллүүд болон компаниудын аудитлагдсан тайлангуудаас харахад дараах зээл болон зээлийн баталгааг Засгийн Газраас олгосон эсвэл ТӨААН-үүд өөрсдөө гаргасан байна.

ТӨААН	Зээл/Зээлийн баталгаа	Гэрээ эхэлсэн өдөр	Зээлийн дүн (сая)	Гэрээний нөхцөл/агуулга	Гэрээний хугацаа	Оролцогч талууд	Тайлбар
Засгийн Газраас олгосон зээл болон зээлийн баталгаа							
Эрдэнэс Таван Толгой ХК	Чалко зээл	2011.07.26	350 ам.доллар	Чалкотай хийсэн гэрээ Жилийн 3%-10.4% хүүтэй		Чалко, ЗГ	Эрдэнэс Таван Толгой ХХК нь 2011 оноос хойш Чалкод 350 сая ам.долларын зээлийн төлбөрийг хийж байсан ба 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр энэхүү зээлийг бүрэн төлж дууссан.
	3-TZ-B-2012-144 тоот гэрээ	2012	100 ам.доллар	Төмөр замын тээврийг дэмжих	36 сар	ХБ	
	Contract No. 3-ET-НО-2012-12-162	2012	100 ам.доллар	Экспортыг дэмжих	36 сар	ХБ	
Багануур ХК	Төсвийн зээл	2016.10.04	16,800 төгрөг	Төсвийн зээлийн гэрээ		Эрчим Хүчний Яам	Багануур ХК нь энэхүү зээлийг 2016-2017 онд өвлийн бэлтгэлийг хангахын тулд өөрсдийн найдвартай үйл ажиллагааг сайжруулах, техник тоног төхөөрөмжөө засахад зориулж авсан. Төсвийн зээлийг зориулалтын дагуу зарцуулан, тухайн ондоо багтаан эргүүлж төлсөн.
	3-BN-НО 2013-11 тоот гэрээ	2013.04.23	18,634 төгрөг	ХБ зээлийн гэрээ		ХБ	Багануур ХК нь ХБ-аас технологио шинэчлэх зорилгоор энэхүү зээлийг авсан. 2016 онд 4,740 сая төгрөгийг зээлийн төлбөрт зарцуулсан.
	MOG-2854 тоот гэрээ	1996.07.17	31,127 ам.доллар	СЯ-ны зээлийн баталгаагаар Олон Улсын Хөгжлийн Ассоциациас авсан зээлийн дагуу СЯ-тай хийсэн дамжуулан зээлдүүлэх гэрээ	12 сар	СЯ	Монгол нүүрс төслийн хүрээнд Багануур ХК нь Дэлхийн Банк болон Японы Засгийн Газраас СЯ-ны баталгаагаар авсан зээл. 2016 онд 3,283 сая төгрөгийг зээлийн төлбөрт зарцуулсан.

ТӨААН	Зээл/Зээлийн баталгаа	Гэрээ эхэлсэн өдөр	Зээлийн дүн (сая)	Гэрээний нөхцөл/ агуулга	Гэрээний хугацаа	Оролцогч талууд	Тайлбар
Засгийн Газраас олгосон зээл болон зээлийн баталгаа							
	MON-P4 тоот гэрээ	1997.07.31	2,276 иен	СЯ-ны зээлийн баталгаагаар Японы Олон Улсын Хамтын ажиллагааны банкнаас авсан зээлийн дагуу СЯ-тай хийсэн дамжуулан зээлдүүлэх гэрээ		СЯ	
	MON-P5 тоот гэрээ	1997.07.31	92 иен			СЯ	
Шивээ Овоо ХК	01-2016 тоот гэрээ	2016.10.04	3,200 төгрөг	Төсвийн зээлийн гэрээ	3 сар	СЯ	Шивээ Овоо ХК нь энэхүү зээлийг 2016-2017 онд өвлийн бэлтгэлийг хангахын тулд өөрсдийн найдвартай үйл ажиллагааг сайжруулах, техник тоног төхөөрөмжөө засахад зориулж авсан. Төсвийн зээлийг зориулалтын дагуу зарцуулан, тухайн ондоо багтаан эргүүлж төлсөн.
	MONP 4 тоот гэрээ		34,302 төгрөг	Засгийн Газар хоорондын гэрээ		СЯ	2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 25,593 сая төгрөг байна.
	MONP 5 тоот гэрээ		44,688 төгрөг	Засгийн Газар хоорондын гэрээ		СЯ	2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 41,583 сая төгрөг байна.
Эрдэнэс Монгол ХХК	АХБ зээл	2016	35 ам.доллар	АХБ-тай байгуулсан зээлийн гэрээ, СЯ-тай хийсэн Засгийн Газрын баталгаат зээлийн хэлэлцээрийн гэрээ	144 сар	АХБ, СЯ	2016 онд Эрдэнэс Монгол компани СЯ-ны баталгаагаар АХБ-аас зээл авах гэрээнд гарын үсэг зурсан. Энэхүү зээл нь санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааны эрсдлийг сайжруулах зорилготой бөгөөд 2016 онд зээлийн хэсэг болох 5.2 сая ам.долларыг хүлээн авсан.
	2/800 тоот гэрээ	2015.12.31	170,595 төгрөг	Гэрээний дагуу зээл нь 2 үе шаттай 2019 болон 2020 онд төлөгдөх бөгөөд хуримтлагдсан хүүг 2017 онд бүрэн төлж дуусгана. Үндсэн хүү нь хуваарийн дагуу төлөгдөнө.	72 сар	ХБ, СЯ	2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар үндсэн зээлийн үлдэгдэл 170,595 сая төгрөг, хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл 13,107 сая төгрөг байна.

Эх сурвалж: ТӨААН-үүдээс ирүүлсэн мэдээлэл болон аудитлагдсан санхүүгийн тайлангууд

Доорх хүснэгтээс ТӨААН-үүдийн Хөгжлийн Банкнаас авсан зээлтэй холбоотой мэдээллийг харна уу:

ТӨААН	Зээл/Зээлийн баталгаа	Гэрээний эхлэх огноо	Дүн (сая)	Гэрээний нөхцөл/ агуулга	Оролцогч талууд
Багануур ХК	ХБ зээл	2013	18,634 төгрөг	12 сар, жилийн хүү 9.6%	ХБ, Багануур ХК
Геологийн төв лаборатори	ХБ зээл	2013	379.9 төгрөг	12 сар, жилийн хүү 9.0%	ХБ, Геологийн Төв Лаборатори
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	ХБ зээл	2014	585.5 төгрөг	12 сар, жилийн хүү 10.0%	ХБ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Эх сурвалж: Хөгжлийн банк

5.4.5 ТӨААН-тэй холбоотой гүйлгээ (ША 4.5)

ОУИТБС-ын стандартын дагуу ОТАХ нь газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал олборлох компаниудын зүгээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн төлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгж болон бусад төрийн байгууллагууд хооронд хийгдэж буй материаллаг төлбөрийг тайлагнах үүрэгтэй.

Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын эхлэлтийн үед шатанд, ОТАХ нь улсын болон орон нутгийн удирдлагуудад шилжүүлсэн төлбөрүүдийг цогцоор нь харгалзан дараах тодорхойлолтуудыг баталсан байна:

- ТӨААН-үүдийн улсын болон орон нутгийн удирдлагуудад албан журмын дагуу төлөх Засгийн Газар болон аймаг, сумдад төлсөн татвар, төлбөрүүдийг багтаасан. Материаллаг төлбөрийн урсгалуудын дэлгэрэнгүй жагсаалт болон тэдгээрийн тулган баталгаажуулалтыг тайлангийн 4 дүгээр хэсгээс харна уу.
- Засгийн Газар болон орон нутгийн засаг захиргаанаас хүлээн авсан ТӨААН-үүдийн төсвийн шилжүүлэг нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдана. Харин ТӨААН-үүдийн төсвийн шинжтэй зарцуулалт нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдаагүй боловч ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагддагаараа төсвийн шилжүүлгээс ялгаатай юм. ТӨААН-үүдийн төсвийн шилжүүлгийн төрөлд зөвхөн Засгийн Газраас шилжүүлсэн нүүрсний татаас байгааг олж тогтоолоо. Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 5.4.6 хэсгээс харна уу.
- Орон нутгийн шилжүүлэг гэдэг нь Засгийн Газраас аймгууд руу, аймгаас сумдууд руу шилжүүлсэн шилжүүлгийг хэлнэ. Иймд, ТӨААН-үүд нь орон нутгийн шилжүүлэг хийдэггүй. Орон нутгийн шилжүүлгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 5.3.4 хэсгээс харна уу.
- Дээр дурьдагдсан ангилалд тодорхойлогдоогүй бусад төлбөр, шилжүүлэг нь ТӨААН-үүдийн төсвийн бус төлбөр, шилжүүлэг гэж тодорхойлогдоно. Бид ТӨААН-үүдээс ирсэн нэмэлт мэдээллийн маягтууд болон аудитлагдсан санхүүгийн тайлангууд дээр үндэслэн 2016 онд хийгдсэн зарим шилжүүлгүүдийг олж илрүүлсэн. Нийт 9 ТӨААН-үүдээс 6 нь ийм төрлийн шилжүүлэг хийсэн гэж мэдээллэсэн. Үлдсэн ТӨААН-үүд нь ийм төрлийн гүйлгээ хийгээгүй гэж мэдээллэсэн эсвэл ямар нэгэн холбоотой мэдээлэл өгөөгүй байна.

ТӨААН-үүдтэй холбоотой гүйлгээ						Сая төгрөг		
№	Регистрийн дугаар	Компанийн нэр	ТӨААН хүлээн авсан шилжүүлэг			ТӨААН-үүдийн төлсөн төлбөр		
			Гүйлгээний утга	Шилжүүлэгч	Дүн	Гүйлгээний утга	Хүлээн авагч	Дүн
1	2004879	Шивээ-Овоо ХК	Нүүрсний төлбөр	ДЦС 4	44,302	Удирдлагын зардал	Эрдэнэс Монгол ХХК	1,405
			Нүүрсний төлбөр	Налайх ДЦС	346	Аудитын актны төлбөр	Холбогдох төрийн байгууллага	73
			Нүүрсний төлбөр	Ус Ду	248			
2	2008572	Багануур ХК	Төсвийн зээл	Эрчим хүчний яам	16,800	Зээл төлөлт	Эрчим хүчний яам	3,000
						Зээл хаалт	Эрчим хүчний яам	13,650
3	2034859	Могойн Гол ХК	Нүүрсний төлбөр	Хөвсгөл ДЦС	707			
4	2074192	Эрдэнэт Үйлдвэр ХХК				Цахилгааны төлбөр	Эрдэнэт булган цахилгаан түгээх сүлжээ ХК	158,290
5	5124913	Эрдэнэс Монгол ХХК				Хөрөнгө оруулалт	Эрдэнэс Монгол ХХК болон түүний охин компаниуд	751
6	5435528	Эрдэнэс Таван Толгой ХК	Хөрөнгө оруулалт	Эрдэнэс Монгол ХХК	300			

Эх сурвалж: ТӨААН –үүдээс ирүүлсэн мэдээлэл болон аудитлагдсан санхүүгийн тайлангууд

5.4.6 Төсвийн шинжтэй зарцуулалт (ША 6.2)

ОУИТБС-ын стандартын дагуу төсвийн шинжтэй зарцуулалтад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хүлээн зөвшөөрсөн нийтийн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, Засгийн Газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд орно.

Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын эхлэлтийн үед, ОТАХ төсвийн шинжтэй зарцуулалтын тодорхойлолтыг баталж эхлэлтийн тайланд тусгасан. Мөн зарцуулалтын материаллаг босгыг 100 сая төгрөг гэж тохиролцсон. Энэ босго дүнг ОТАХ урьд жилүүдийн туршлага дээр үндэслэн гаргасан. 2014 оноос 2016 оны анхны тайлангийн мэдээллээс ТӨААН-үүдийн хандив дэмжлэгийн мэдээллийг шүүж үзсэн. Эдгээр мэдээллүүдээс төсвийн шинжтэй зарцуулалт гэж үзэж болохуйц хандивыг түүвэрлэн үзэхэд 38.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байсан. Мөн 2014 оны ОУИТБС-ын нэгтгэл тайланд Шивээ овоо ХХК-аас төсвийн шинжтэй нийт 860 сая төгрөгийг зарцуулсан гэж мэдээлсэн байсан. Харин 2015 оны нэгтгэл тайланд ийм төрлийн зарцуулалт байхгүй гэж мэдээлжээ. Иймд ОТАХ 2016 оны тайланд туршилт байдлаар ТӨААН-үүдийн төсвийн шинжтэй зарцуулалтад 100 сая төгрөгийн материаллаг босгыг тогтоохоор шийдвэрлэсэн.

Төсвийн шинжтэй зарцуулалт: Төсвийн тухай хуульд заасан зардлын төрлүүдийн үнийн дүнгийн Төсвийн гүйцэтгэлийн тайланд ороогүй боловч ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд тусгагдсан дүнг “төсвийн шинжтэй зарцуулалт” гэж ОТАХ тодорхойлсон.

Төсвийн шинжтэй зарцуулалт нь 4 бүлэгт хуваагдах ба ОТАХ-ийн хүлээн зөвшөөрсөн тодорхойлолтоор:

- Нийгмийн үйлчилгээ - тухайн төлбөр, дэмжлэг нь Төсвийн тухай хуульд орсон зардлын бүлэглэлд орсон зардлууд бол уг дүнгийн улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд багтаагүй боловч ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд тусгагдсан хэсгийг нийгмийн үйлчилгээний чиглэлийн төсвийн төсвийн шинжтэй зарцуулалт гэнэ.
- Дэд бүтэцтэй холбоотой төлбөрүүд - авто зам, гүүр барих, цахилгааны шугам тавих, бусад дэд бүтэц барьж байгуулан, зохих эзэмшлийг улсын болон орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгсөн тохиолдолд тухайн зардлын төсвийн гүйцэтгэлд ороогүй боловч ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд тусгагдсан хэсгийг дэд бүтэцтэй холбоотой төсвийн шинжтэй зарцуулалт гэнэ. Бусад дэд бүтэцтэй холбоотой зам гүүр болон цахилгааны шугамын засвар үйлчилгээний зардлуудыг нийгмийн үйлчилгээний зарцуулалт буюу хандив дэмжлэгт хамааруулна.
- Түлшний татаас - улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд багтаагүй боловч ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд тусгагдсан татаасын дүнг төсвийн шинжтэй зарцуулалт гэнэ.
- Засгийн Газрын өрийн төлбөр - Засгийн Газрын тавьсан өрийн төлбөрийг ямар нэг байдлаар төлж байгаа бол улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд багтаагүй боловч ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд тусгагдсан хэсгийг засгийн газрын өрийн төлбөртэй холбоотой төсвийн шинжтэй зарцуулалт гэнэ. Үүнд ЗГ-ын баталгаагаар авсан зээлийн төлбөрийн төлөлтийг бас оруулна.

Кэй Пи Эм Жи нь сонгогдсон 9 ТӨААН-үүдээс (Багануур, Баянтээг, Эрдэнэс Монгол, Эрдэнэс Таван Толгой, Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр, Могойн Гол, Монголросцветмент, Шивээ-Овоо, болон Таван Толгой) төсвийн шинжтэй зарцуулалтын талаарх мэдээллийг нэмэлт мэдээллийн маягтаар хүссэн. Маягтуудад дээр дурьдсан төсвийн шинжтэй зарцуулалтын ангилал тус бүрийн тодорхойлолтуудыг оруулсан. Түүнчлэн, мэдээлэл цуглуулахаас өмнө Кэй Пи Эм Жи нь ОУИТБС-ын Ажлын Албатай хамтран төсвийн шинжтэй зарцуулалт болон бусад хамаарах ОУИТБС-ын Стандарт шаардлагуудын талаар ТӨААН-үүдэд сургалт зохион байгуулсан.

Нийт 9 ТӨААН-үүд төсвийн шинжтэй зарцуулалтын талаарх мэдээллээ ирүүлсэн боловч зөвхөн Багануур, Шивээ-Овоо болон Эрдэнэс Монгол компаниуд нь төсвийн шинжтэй зарцуулалт байгаа гэж тайлагнасан ба бусад 6 компаниуд нь төсвийн шинжтэй зарцуулалт байхгүй гэж тайлагнасан.

Шивээ Овоо ХК нь цэцэрлэгийн засварын ажилд 990 мянган төгрөг зарцуулсан гэж тайлагнасан. Мөн бид Эрдэнэс Монгол ХХК-ийн ҮАГ-аар аудитлагдсан санхүүгийн тайланг хянаж үзэхэд 8,856 сая төгрөгийн зам засвартай холбоотой дэд бүтцийн зардал гарсныг олж мэдсэн.

Мөн бид иймэрхүү төрлийн зардал тайлагнасан эсэхийг эдгээр ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлангуудаас шалгасан.

ТӨААН	Зардал	Гэрээ эхэлсэн өдөр	Дүн (сая. төг)	Төлбөрийн төрөл	Улсын төсөвт орсон эсэх?	Компаний санхүүгийн тайланд орсон эсэх?	Эх сурвалж
Нийгмийн үйлчилгээ							
Шивээ Овоо ХК	Цэцэрлэгийн шинэчлэлт	2016.08.22	0.9	Бэлэн мөнгө	Үгүй	Тийм	ТӨААН-үүдийн ирүүлсэн мэдээлэл
Дэд бүтэцтэй холбоотой төлбөрүүд							
Эрдэнэс Монгол ХХК	Замын засвар		8,856	Бэлэн бус	Үгүй	Тийм	Аудитлагдсан санхүүгийн тайлан

Эх сурвалж: ТӨААН-үүдийн ирүүлсэн мэдээлэл болон ҮАГ-аар аудитлагдсан санхүүгийн тайлан

Эрдэнэс Таван Толгой ХК (ЭТТ) нь 2011 оноос хойш 350 сая ам.долларын зээлийн төлбөрийг Чалко (Хятадын Алюминиум Корпораци)-д төлж байгаа гэж тайлагнасан. Олон нийтэд ил тод мэдээллээр энэхүү зээлийн зарим хэсэг нь Хүний хөгжлийн сан руу шилжиж, Монгол Улсын иргэдэд бэлэн мөнгөөр дахин хуваарилагдсан бөгөөд үүнд иргэн бүрд сар болгон олгосон 21,000 төгрөг орсон байна. Тиймээс бид үүнийг Засгийн газрын өрийн төлбөр байж болох юм гэж үзэж байсан. Гэвч ЭТТ-ийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцахад энэхүү зээл нь зөвхөн ЭТТ-н дотоод хэрэгцээний зээл байсан бөгөөд Чалкод өгөх нүүрсний урьдчилгаа төлбөр хэлбэрээр авсан гэсэн. ЭТТ-н мэдээлснээр улсын төсвөөр дамжуулан Хүний Хөгжил Санд шилжүүлсэн хэсгээ татварын суутгал хэлбэрээр нөхөн авсан байна. 2017 оны 7 дугаар сард ЭТТ уг зээлийг Чалкод бүрэн төлж дуусгасан байна.

Түлшний татаасын хувьд Багануур ХК нь дулааны нүүрсийг хөнгөлөлттэй үнээр нийт 6 төрийн өмчит дулааны станцуудад борлуулсан гэж тайлагнасан. Харин Шивээ Овоо ХК нь дулааны нүүрсний борлуулалтандаа хөнгөлөлттэй үнийг ашигладаггүй гэж тайлагнасан. Доорх хүснэгтээс Багануурын түлшний татаасын дэлгэрэнгүй мэдээллийг харна уу. Багануур ХК-ийн мэдээлснээр компани нь 2,588 сая төгрөгийн төсвийн шинжтэй зарцуулалт хийсэн бөгөөд энэхүү зардал нь улсын төсөвт тусгагдаагүй боловч компанийн санхүүгийн тайланд орсон байна.

Татаас											
ТӨААН	Татаасын төрөл	Үйлчилгээ хүлээн авсан байгууллага	Нүүрсний нийлүүлэлт						Төсвийн хоронгийн зарцуулалттай адил төстэй төлбөр Сая. төг	Холбогдох хууль	Тайлбар
			Нийт нийлүүлэлтэнд эзэлж буй хувь	Мян. Тн	Сая. төг	1 тн нүүрсний дундаж үнэ	1 тн нүүрсний дундаж өртөг	1 тн нүүрсний дундаж үнэ ам.доллар			
Багануур ХК	Нүүрсээ өртгөөс нь бага үнээр нийлүүлсэн.	ДЦС 4 ТӨХК	50-60%	1,660	47,615	28,684	29,259	11.75	955	Эрчим хүчний тухай хууль	Дулааны нүүрс үйлдвэрлэдэг ТӨААН-үүд нь төрийн өмчит дулааны станцуудад нүүрсээ хөнгөлөлттэй үнээр буюу зах зээлийн үнэ ба өртгөөс нь бага үнээр борлуулдаг. Багануур ХК нь 2016 онд улсын төсвөөс ямар нэгэн татаас аваагүй.
		ДЦС 3 ТӨХК	100%	1,285	36,941	28,741	29,259	11.75	666		
		ДЦС 2 ТӨХК	100%	244	6,588	26,978	29,259	11.75	557		
		Дархан ДС ТӨХК	50-60%	107	2,929	27,381	29,259	11.75	201		
		Амгалан ДС ТӨХК	40%	39	1,133	29,014	29,259	11.75	10		
		Багануур ДС ТӨХК	100%	53	1,349	25,502	29,259	11.75	199		
Нийт				3,388	96,555				2,588		

Эх сурвалж: ТӨААН-үүдийн ирүүлсэн мэдээлэл

5.4.7 Орон нутагт хийгдэж буй төлбөр (ША 4.6)

ТӨААН-үүдийн орон нутагт хийсэн төлбөр

Хэсэг 5.4.5-д дурьдсанчлан, ОТАХ-тэй тохиролцсоны дагуу орон нутагт төлөх төлбөр гэж аймаг болон сумдын Засгийн Газарт төлөгдөх төлбөр, татварыг хэлнэ. Орон нутагт төлсөн материаллаг төлбөрүүдийг ил тод болгож тулган баталгаажуулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 4 дүгээр хэсгээс харна уу.

2016 онд ТӨААН-үүдийн орон нутагт төлсөн материаллаг төлбөрийн хураангуйг доорх хүснэгтэд харуулав. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 11-с харна уу.

ТӨААН-үүдийн орон нутгийн төлбөр								
Компанийн нэр	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	Газрын төлбөр	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	Түгээмэл тархацтай АМНАТ	Ус ашигласны төлбөр	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	Нийт
Багануур	25	-	253	-	-	247	102	627
Баянтээг	1	-	1	-	-	1	14	17
Эрдэнэс Монгол	2	-	-	-	-	-	-	2
Эрдэнэс Таван Толгой	8	-	240	-	-	87	26	361
Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр	54	-	8,078	99	47	11,181	5,868	25,327
Могойн Гол	1	10	3	-	-	-	10	24
Монголросцветмет	19	-	40	-	-	861	53	973
Шивээ-Овоо	3	-	3	35	-	895	74	1,010
Таван Толгой	4	-	39	-	-	19	25	87
Нийт	117	10	8,657	134	47	13,291	6,172	28,428

Эх сурвалж: ТӨААН-үүдээс ирүүлсэн мэдээлэл

5.5 Бусад асуудлууд

5.5.1 Бенефициар өмчлөгч (ША 2.5)

5.5.1.1 Бенефициар өмчлөгчийн ил тод байдал

ОУИТБС-ын Стандарт 2.56 (i)-ын дагуу ОТАХ нь нэгтгэлд сонгогдсон компаниудаас бенефициар өмчлөгчийн мэдээллийг ил тод болгохыг хүссэн нэмэлт мэдээллийн маягт илгээхээр шийдвэрлэсэн. Бенефициар өмчлөгчийг ил тод болгохтой холбоотой Засгийн Газрын тусгай бодлого байхгүй боловч 2013 оны ОУИТБС-ын тайлан гарч эхэлсэн үеэс уг мэдээллийг ил тод болгосоор ирсэн.

ОУИТБС-ын Стандарт 2.5-ын дагуу боловсруулсан бенефициар өмчлөгчийн мэдээллийн хүсэлтийн маягтыг нэгтгэлд сонгогдсон 213 компаниудад хүргүүлсэн. Мэдээллийн маягтад бенефициар өмчлөгчийн тухай мэдээлэл, эзэмшлийн түвшин, мөн улс төрийн нөлөө бүхий этгээдийн талаарх мэдээлэл багтсан. Нийт 46 компани ОУИТБС-ын цахим тайлангийн системд бенефициар өмчлөгчийн мэдээллийг тайлагнасан байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 25.а-с харна уу.

Түүнчлэн, ОУИТБС-ын цахим хуудсанд бенефициар өмчлөгчийн мэдээллийг бүртгэн, ил тод болгож байна (<http://www.citimongolia.mn/en/beneficial-owners>).

5.5.1.2 Бенефициар өмчлөгчийн мэдээллийн Замын зураг

ОУИТБС-ын Стандартын 2.56 (ii)-д ОТАХ нь бенефициар өмчлөгчийн талаар мэдээллийг ил тод болгох Замын зургийг хэвлэн нийтлүүлэхийг шаарддаг. Тухайн шаардлагыг үндэслэн ОТАХ замын зургийн төслийг боловсруулахаар УУХҮЯ, Хууль зүй дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар, АМГТГ, ҮСХ, Оюуны өмчийн болон Улсын бүртгэлийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Банк, Нээлттэй Нийгэм Форум, Хил Хязгааргүй Алхам төрийн бус байгууллага, Хөвсгөл Далайн Эзэд төрийн бус байгууллага, Байгалийн Баялагийн Засаглалын Хүрээлэн, Эрдэнэс Монгол ХХК, Энержи Ресурс ХХК, Бороо Гоулд ХХК-ийн гишүүдээс бүрдсэн дэд хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан.

Замын зураг боловсруулах төслийн хүрээнд 2016 онд хэд хэдэн бүлэг ажлууд зохион байгуулсан. Үүнд, дэд хэсгийн 2 удаагийн хуралдаан зохион байгуулсан (2016 оны 5 болон 10 дугаар сар), Нээлттэй Нийгэм Форумгаас эрх зүйн орчны урьдчилсан судалгаа хийсэн (2016 оны 7 дугаар сараас 9 дүгээр сар), Байгалийн Баялагийн Засаглалын Хүрээлэнгээс бенефициар өмчлөгчийн ил тод байдлын талаарх сургалтыг зохион байгуулсан (2016 оны 8 дугаар сар), Замын зургийн төслийг боловсруулсан (2016 оны 10 дугаар сараас 11 дүгээр сар) зэрэг үйл ажиллагаанууд багтсан.

Замын зургийн төслийг ОТАХ-ийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Үндэсний Зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар танилцуулан баталсан.

Замын зурагт 2020 он хүртэл 7 зорилтын хүрээнд 32 үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

2017 оны зорилт

- Зорилт 1: Бенефициар өмчлөгчийн ил тод байдлыг үндэсний бодлоготой уялдуулна. Тухайлбал, Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөлийн уулзалт зохион байгуулах, УИХ-ын холбогдох байнгын хороонд төлөвлөсөн ажлаа танилцуулах, сонсгол зохион байгуулна.
- Зорилт 2: Бенефициар өмчлөгчийн ил тод байдлын талаарх институтын хүрээг тодорхойлно. Тухайлбал, төрийн байгууллагуудад семинар зохион байгуулж, хуулийн ажлын хэсэг байгуулж, холбогдох хуулиудад болон Засгийн Газрын 222 тоот тогтоол, ОУИТБС-ын хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.
- Зорилт 3: Нэр томъёо, тодорхойлолт, материаллаг босго, тайлагналын хугацаа, үечлэлийг тогтооно. Тухайлбал, судалгаа хийж, ОТАХ-т цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд үр дүнг танилцуулна.

- Зорилт 4: Бенефициар өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах үүднээс ОУ-ийн компани нь улс төрд нөлөө бүхий этгээдийн эзэмшилд байгаа эсэх мэдээллийг бүрэн тайлагнана. Тухайлбал, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн маягтыг шинэчлэнэ.
- Зорилт 5: Компаниудын дунд хэлэлцүүлэг, иргэний нийгмийн байгууллага, эрэн сурвалжлах сэтгүүлчдийн сургалт, урамшууллын тогтолцоо, хэлэлцүүлэг гэх мэт нөлөөллийн ажил зохион байгуулна.

2018 оны зорилт

- Зорилт 6: Бенефициар өмчлөгчийн мэдээллийг туршилтаар цуглуулах, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах зорилгоор төрийн байгууллага, агентлагуудын мэдээллийн системд холбогдох, мэдээлэл солилцох тухай холбогдох журам маягтыг шинэлэх.

2019 оны зорилт

- Зорилт 7: Бенефициар өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг ОУИТБС-ын 2018 оны нэгтгэлийн тайланд тайлагнаж олон нийтэд нээлттэй хүргэх.

Замын зургийн дэлгэрэнгүйг Хавсралт 25.б-с харна уу.

2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаануудад 2016 оны 12 дугаар сараас 2017 оны 6 дугаар сарын хооронд ОТАХ болох компанийн удирдлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн байгууллагууд болох Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, АМГТГ, СЯ, УАГ, Оюуны өмчийн болон Улсын бүртгэлийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагуудын дунд цуврал хэлэлцүүлгүүд зохион байгуулах ажлууд багтсан.

2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаануудын дагуу цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, дор дурьдсан үр дүнд хүрсэн:

- Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд оруулж батлуулсан.
- Нээлттэй засаглалын түншлэлийн ажлын хэсэг болон УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулга хүргүүлсэн.
- ЗГ-ын 2012 онд батлагдсан 222 тоот тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох хуулийг боловсруулж, 2017 оны Засгийн Газрын чуулганаас өмнө өргөн барихыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд үүрэг болгосон.
- УУХҮЯ-нд хуулийн дэд хэсэг байгуулах хүсэлтийг тавьсан. Энэхүү хүсэлтэд нааштай хариу ирэх төлөвтэй байна.

5.5.1.3 Нээлттэй Нийгэм Форумаас бенефициар өмчлөгчийг ил тод болгохоор хэрэгжүүлсэн судалгааны дүгнэлт

Нээлттэй Нийгэм Форум нь ОУИТБС-ын бенефициар өмчлөгчийн талаарх стандартын хэрэгжилтийг дэмжих, ОУ-т үйл ажиллагаа явуулж буй компаниудын бенефициар өмчлөгчдийг ил тод болгох арга замыг тодорхойлох зорилготойгоор 2016 оны 6 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд бенефициар өмчлөгчдийн ил тод байдлын судалгааг хийсэн байна. Энэхүү судалгаанд УУХҮЯ, АМГТГ, Улсын бүртгэлийн газар, Авилгатай тэмцэх газар, ОТАХ-ийн бусад гишүүд оролцсон.

Судалгааны хүрээнд үндэсний хууль тогтоомж, журмууд, бүртгэлийн тогтолцоог олон улсын жишиг болон ОУИТБС-ын стандарттай харьцуулан үнэлэлт өгсөн. Үүний үр дүнд, бенефициар өмчлөгчийн талаарх тодорхойлолт, хамрах хүрээ, бенефициар өмчлөгчийн талаарх хууль тогтоомж, бүртгэлийн тогтолцоог сайжруулах зөвлөмжүүд гарсан.

Судалгааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас харна уу (http://eitimongolia.mn/sites/default/files/attachments/BO_Report.pdf).

5.5.2 Гэрээний ил тод байдал (ША 2.4)

5.5.2.1 Гэрээ ил тод байдлын талаарх төрийн бодлого (ША 2.4б)

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу ЗГ-ын байгууллагууд хөрөнгө оруулалтын компаниудтай төрөл бүрийн гэрээ, хэлэлцээр байгуулдаг⁵. Эдгээр гэрээнүүд нь хэд хэдэн хуулиар зохицуулагддаг ба гол хуулиудаас жишээ болгон доорх хүснэгтэд харуулав.

ОУ-ийн гэрээг зохицуулах хууль		
Гэрээний төрлүүд	Зохицуулах хууль	Зүйл(с)
БХГ	Газрын тосны тухай хууль	17.3
Орд ашиглах гэрээ	Цөмийн энергийн тухай хууль	29
Хөрөнгө оруулалтын гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	5.3-5.5
	Цөмийн энергийн тухай хууль	30
Концессын гэрээ	Концессын тухай хууль	20
Орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	42.9
Хамтарсан гэрээ (жишээ нь: газар болон ус ашиглалтын гэрээ)	Ашигт малтмалын тухай хууль	35.3.7

Эх сурвалж: Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон Концессын тухай хууль

Монгол Улсын ЗГ нь гэрээ болон тусгай зөвшөөрлийн мэдээллийг толилуулах талаар хэд хэдэн арга хэмжээ авсан. Түүний дотор хөрөнгө оруулалтын гэрээ болон газрын тосны БХГ-тэй холбоотой мэдээлэл, үүнд тэдгээрийн хэрэгжилт, бүтээгдэхүүний борлуулалт болон экспортын хэмжээний ил тод байдлыг сайжруулах ажил хамаарсан ба уг арга хэмжээг хэрэгжүүлэхийг Эрдэс баялаг эрчим хүчний сайд Д. Зоригт-д үүрэг болгосон⁶. Монгол Улсын ЗГ-ын зүгээс БХГ-г олон нийтэд нээлттэй болгох журмыг баталж,⁷ нийтлэг БХГ-ний загварыг баталсан⁸. Үүний үр дүнд, газрын тосны хайгуул болон олборлолтын үйл ажиллагааны БХГ-ний загварыг 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдөр ЗГ-аас баталсан. Нийтлэг нэг БХГ-ний загвартай болсноор өмнө нь байсан БХГ-нүүдийг гуравдагч этгээдэд ил тод болгохыг хязгаарласан нууцлалын заалтыг хассан ба өмнө нь байгууллагын нууцын зэрэглэлд байсан гэрээний зарим нөхцлүүд нийтэд нээлттэй, ил тод болсон. Эдгээр нөхцлүүдэд нийтлэг үндэслэл, нэр томъёо, төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, гэрээлэгчийн эрх үүрэг, гэрээлэгч эрх үүргээ бусдад шилжүүлэх, цуцлах, талбай буцааж өгөх, хайгуул, ашиглалт, эдгээр үйл ажиллагаа эрхлэн явуулах, хэмжилт болон хэмжилтийн залруулга, мэдээ тайлан, нягтлан бодох бүртгэл, бусад ашигт малтмал илрэх, талбай давхцах, эд хөрөнгө өмчлөх болон шилжүүлэх, татвар, валют солилцооны эрх, нөхөн төлбөр даатгал, маргаан шийдвэрлэх, хариуцлага, онц байдал гэх мэт нөхцлүүд орсон байна. Гэвч зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваах тухай заалт (12 дугаар зүйл) болон урамшуулал, үйлчилгээний хөлс бусад төлбөрүүдийн тухай заалт (13 дугаар зүйл) нь ил тод бус хэвээр байна. Иймд, БХГ-ний ил тод байдлын түвшин хязгаарлагдмал хэвээр байгаа юм.

2015 оны 11 дүгээр сард орон нутгийн засаг захиргаа болон газрын тосны лиценз эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 430 тоот тогтоолоор баталсан. 2016 оны 3 дугаар сард орон нутгийн засаг захиргаа болон ашигт малтмалын хайгуул, олборлолтын лиценз эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 179 тоот тогтоолоор баталсан.

⁵ Эх сурвалж: МОУИТБС ОУ-ийн гэрээг нийтэд нээлттэй болгох IV дэд ажлын хэсэг

⁶ Эх сурвалж: ЗГ-ын 222 дугаар тогтоол 8

⁷ Загвар: <http://www.pam.gov.mn/content/БҮТЭЭГДЭХҮҮН-ХУВААХ-ГЭРЭЭ--4782.shtml>

⁸ Эх сурвалж: МОУИТБС ОУ-ийн гэрээг нийтэд нээлттэй болгох IV дэд ажлын хэсэг (Монгол хэл дээрх)

Энэхүү маягтыг хэрэгжүүлэх гол зорилго нь төрийн захиргааны байгууллага болон ААН дэх хөрөнгө оруулагчдын эрх зүйгийг нарийн тодорхойлон, хайгуул болон олборлолтын үйл ажиллагааг сайжруулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино. 2014 оны Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу гэрээ болон тусгай зөвшөөрөл нь УИХ, ЗГ, АМГТГ болон бусад шаардлагатай орон нутгийн засаг захиргааны байгууллагаар батлагдсан байх ёстой гэж заасан.

ЗГ-аас хэрэгжүүлсэн бас нэг алхам нь 2014 оны 01 дүгээр сард УИХ-ын 18 тоот тогтоолоор батлагдсан ашигт малтмалын салбарт хэрэгжүүлэх ЗГ-ын бодлого юм. Энэхүү бодлогын зорилго нь нээлттэй, ил тод, хариуцлагатай ашигт малтмалын салбарыг хөгжүүлэхэд оршино. Энэхүү ЗГ-ын бодлогын 2.1.6-д заасны дагуу хуулиар хориглосноос бусад тохиолдолд төрийн болон хувийн хэвшлийн геологийн хайгуул, олборлолт болон ашиглалтын бүх шатны мэдээлэл нь олон нийтэд нээлттэй толилуулах ба ил тод байх ёстой. Түүнчлэн 3.5.2-г зааснаар хөрөнгө оруулагч компани болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд хийгдсэн орон нутгийн хөгжлийн гэрээ нь ил тод байна⁹. Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тухай хууль гэх мэт олборлох үйлдвэрлэлийн салбарын бусад хуульд тухайн гэрээний ил тод байх заалтыг тодорхойлон тусгаагүй байна¹⁰.

УИХ нь 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэргийг зохицуулах тухай хууль гаргасан (5.1.2 хэсгийг харна уу). АМГТГ нь өөрийн цахим хуудсанд¹¹ хүчинтэй байгаа тусгай зөвшөөрлүүд болон тэдгээрийн өөрчлөлтүүдийн жагсаалтыг сар бүр шинэчлэн байршуулдаг.

5.5.2.2 Гэрээний нөхцлийн ил тод байдал (ША 2.4a)

Монгол Улсын Уул Уурхайн Хөгжлийн Төвөөс гэрээ болон тусгай зөвшөөрлийн нөхцлийг толилуулахтай холбоотой хууль, эрх зүйн орчныг тодорхой бус хэмээн дүгнэжээ. Ашигт малтмалын салбар дахь ЗГ-ын бодлого (өмнөх хэсэгт дурьдсан)-оос бусад тухайн салбарын хууль тогтоомж нь гэрээний мэдээллийн толилуулах талаар цөөн хэдэн хязгаарлагдмал заалттай байдаг. Жишээлбэл, 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн 6.4 болон 6.5.9 дүгээр зүйлүүдэд "Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд нь концессын болон дагалдах гэрээний дагуу мэдээллээ олон нийтэд толилуулах ёстой" гэж заасан нь гэрээг бүхэлд нь бус¹² зөвхөн гэрээний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохыг шаардсан.

Ашигт малтмалын салбарт байгуулсан гэрээг олон нийтэд нээлттэй болгох, түүний үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлох, мөн оролцогч талуудын ойлголтыг нэг түвшинд хүргэх зорилготойгоор 2015 оны 5 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд МОҮИТБС-ын IV дэд ажлын хэсгээс хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг ажлын хэсгийн эцсийн шатанд гарсан гэрээ болон мэдээллийг цаасан болон электрон байдлаар цуглуулан МОҮИТБС-ын өөрийн цахим хуудсанд байршуулсан¹³. 2015 оны 11 дүгээр сард мэдээллийн санг идэвхжүүлсэн. Энэхүү тайланг бэлтгэх үед орон нутгийн захиргаа болон уул уурхайн компаниудын хооронд байгуулагдсан нийт 25 гэрээг олон нийтэд толилуулсан ба үүнээс 11 нь хамтын ажиллагааны гэрээ, 10 нь нийгмийн хариуцлагын тухай гэрээ байсан. Дараах холбоосоор орж илүү дэлгэрэнгүй мэдээлэл авна уу. <https://eitimongolia.mn/en/node/4875>.

Түүнчлэн, холбогдох Монгол Улсын хуулиудаас үүссэн маргаантай асуудлууд нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай болон Байгууллагын нууцлалын тухай хуультай холбогдон гарсан. Эдгээр хуулиудын 21 болон 3.2 дугаар заалтууд нь мэдээлэл ил тод болгосон нь ААН-үүдийн хууль ёсны эрх ашиг болон тэдгээрийн зах зээлд өрсөлдөх давуу талд сөргөөр нөлөөлж болохуйц байна эсвэл мэдээлэл

⁹ Эх сурвалж: Ашигт малтмалын салбарын тухай ЗГ-ын бодлого <http://www.legalinfo.mn/law/details/9756>

¹⁰ Эх сурвалж: Монголын Уул Уурхайн Хөгжлийн Төвийн "Өнөөгийн асуудлууд ба Монгол Улсын ашигт малтмалын салбарын гэрээний ил тод байдалтай холбоотой хууль эрх зүйн хүрээ"

¹¹ http://www.mram.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=14&Itemid=34&lang=mn

¹² Эх сурвалж: Монголын Уул Уурхайн Хөгжлийн Төвийн "Өнөөгийн асуудлууд ба Монгол Улсын ашигт малтмалын салбарын гэрээний ил тод байдалтай холбоотой хууль эрх зүйн хүрээ"

¹³ <http://www.eitimongolia.mn/en/node/4875>

нь ААН-ийн өвөрмөц болон нууцлалтай үйл ажиллагаатай холбоотой гэсэн үндэслэлээр тухайн мэдээллийг ил тод болгохоос татгалзаж буй ААН-үүдэд хамгаалалт болж өгдөг.

Тиймээс нууцын зэрэглэл бүхий мэдээлэл, техник технологийн ололт, төсөл, судалгааны баримт болон бусад мэдээллүүдийг толилуулахдаа тухайн ААН-ийн хариуцсан албан тушаалтнаас бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай¹⁴. Энэ нь тухайн компанийн зөвшөөрлийн дагуу гэрээний нөхцлийг олон нийтэд толилуулах боломжийг олгодог. Гэсэн хэдий ч, олон нийгийн ашиг сонирхлыг үндэслэн хууль тогтоомжийн тууштай бус байдалтай холбоотойгоор компаниуд мэдээллийг толилуулахаас татгалзах эрх байх ёсгүй гэсэн байр суурийг илэрхийлсэн¹⁵.

Нээлтэй Нийгэм Форумгаас гаргасан "Эрдэс баялагийн салбарын гэрээнд захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагааны журмыг хэрэгжүүлэх нь" гэсэн судалгааны ажилд олборлох үйлдвэрлэлийн гэрээг захиргааны гэрээ гэж үзэж болох тул Захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдана гэж мэдээлсэн. Энэхүү тайлангийн 5.1.2-т дурьдсанчлан, захиргааны байгууллагууд нь аливаа шийдвэр гаргахдаа "сонсох ажиллагаа" зохион байгуулж, хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдэд уг шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно гэсэн нэмэлт шинэ журмыг Захиргааны ерөнхий хуульд оруулсан. Тайланд мэдээлснээр энэхүү шинэ журам нь олборлох үйлдвэрлэлийн гэрээг боловсруулах үйл явцын ил тод байдалд эерэг нөлөө үзүүлж, олон нийтэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, эсвэл тодорхой бүлэгт эерэгээр нөлөөлөх гэрээний нөхцлүүдийн ил тод бус байдлыг хязгаарлах юм. Тайланг дараах холбоосоор орж харна уу: http://forum.mn/res_mat/2017/Zahirgaanii%20gerее XXIV.pdf

Уул уурхайн үндсэн гэрээгээр батлагдсан маягтуудыг ашигласнаар ирээдүйд гэрээ болон тусгай зөвшөөрлүүдийн нөхцлүүдийн толилуулалт сайжирна гэж хүлээгдэж байна. Үүнтэй холбогдуулан холбогдох төслүүд нь хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар гүйцэтгэлийн шатанд явж байна. Маягтыг бэлтгэх болон багтах эрх бүхий байгууллагууд нь тухайн гэрээний төрлөөс хамаарна.

Мөн түүнчлэн Сентерра Гоулд Монголиа ХХК болон Монгол Улсын Засгийн Газар хооронд хийгдэх Гачууртын орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээнүүд нь хэлэлцэх шатандаа явагдаж байна. Талууд 2016 оны 3 дугаар сард Канад болон Монгол Улсад уулзаж хэлэлцсэн боловч эцсийн шийдвэрт хүрээгүй байна. 2017 оны 01 дүгээр сард Сентерра Гоулд ХХК-тай хийх хэлэлцээрээ үргэлжлүүлэхээр ажлын хэсэг томилсон бөгөөд үүнээс хойш ямар нэгэн арга хэмжээ аваагүй болно.

2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Нээлтэй нийгэм форум, ОУИТБС болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран олборлох үйлдвэрлэлийн гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилгоор Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн цахим санг байгуулсан. Энэхүү мэдээллийн цахим сан нь олон нийт, сэтгүүлчид, эрдэмтдэд эрдэс баялагийн гэрээнүүд болон бусад холбогдох баримт бичгүүдийг бүрэн эхээр нь нээлтэй болгож өгсөн. Одоогийн байдлаар энэхүү мэдээллийн санд 35 гэрээг байршуулсан бөгөөд үүнд бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар, 1 бүтээгдэхүүн хуваах гэрээ (ДМЖ Петролиум АГ), 22 хамтын ажиллагааны гэрээ, 7 газрын болон ус ашиглалтын гэрээ болон бусад гэрээнүүд байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор орж харна уу: <http://www.iltodgerее.mn/>

Түүнчлэн, Ресурс Контракт Датабэйз мэдээллийн цахим санд бүтээгдэхүүн хуваах 2 гэрээ ил тод байна. Эдгээр нь ДМЖ Петролиум болон Сторм Кат Энержи Корпораци компаниудын ГТГ-тай хийсэн гэрээнүүд юм.

Энэ тайланг бичих үед ДМЖ Петролиум-ийн эзэмшиж буй 2 БХГ нь тус компанийн 2016 оны 10 сард гаргасан хүсэлтийн дагуу цуцлах шатандаа явж байна. Түүнчлэн, Сторм Кат Энержи корпорацийн БХГ нь дуусгавар болсон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкээр орж харна уу:

¹⁴ Эх сурвалж: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хууль <http://legalinfo.mn/law/details/374?lawid=374>

¹⁵ Монголын Уул Уурхайн Хөгжлийн Төвийн "Өнөөгийн асуудлууд ба Монгол Улсын ашигт малтмалын салбарын гэрээний ил тод байдалтай холбоотой хууль эрх зүйн хүрээ"-г харна уу.

http://www.resourcecontracts.org/search?q=&country%5B%5D=mn&contract_type%5B%5D=Production+or+Profit+Sharing+Agreement

Кэй Пи Эм Жи-ийн нэмэлт мэдээллийн маягтаар ил тод болсон гэрээнүүд

Кэй Пи Эм Жи нь сонгогдсон 213 компаниудаас нэмэлт мэдээллийн маягтын дагуу төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай, 21 аймгууд тус бүрээс олборлох үйлдвэрлэлийн компаниудтай хийсэн гэрээг ил тод болгохыг хүссэн. Энэхүү маягтаар гэрээний эхлэх болон дуусах огноо, зорилго, улсын болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан загвар гэрээний дагуу гэрээ байгуулахад Хамтын ажиллагааны хороо байгуулсан эсэх, хамтын ажиллагааны хорооны бүрэлдэхүүн, гэрээ байгуулахад Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа зохион байгуулсан эсэх, гэрээг ил тод болгосон цахим хуудасны линк, компаниудын гарын үсэг зурсан албан тушаалтнууд болон уг гэрээ нь дуусгавар болоход үнэлгээ хийгдсэн эсэхийг тодруулсан.

Нийт 213 компаниас 90 компани 161 гэрээг тайлагнасан. Түүнчлэн, 17 аймаг бидний нэмэлт маягтад хариу ирүүлсэн ба Архангай, Дорноговь, Говь-Алтай болон Орхон гэсэн 4 аймаг хариу ирүүлээгүй байна. Нийт 17 аймгаас Булган, Баян-Өлгий, Дархан, Дорнод, Говьсүмбэр, Хөвсгөл, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв, Баянхонгор болон Завхан гэсэн 11 аймаг ОУ-тэй гэрээ байгуулаагүй гэж тайлагнасан бол Дорнод, Дундговь, Хэнтий, Ховд, Сүхбаатар, Өмнөговь болон Увс гэсэн 7 аймаг 15 гэрээ тайлагнасан. Эдгээр 176 гэрээний тодруулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 26-аас харна уу.

5.5.3 Дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцоо (ША 4.3)

Зарим тохиолдолд улс орны байгалийн нөөц баялагийг ашиглах эрх олох зорилгоор олборлох үйлдвэрлэлийн компаниуд мөнгөн бус хэлбэрээр бараа болон үйлчилгээ үзүүлэх (дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх) гэрээг төрийн байгууллагуудтай хийдэг. Эдгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтын жишээнд зам, төмөр зам, цахилгаан станц, сургууль болон эмнэлгүүд багтана. Тухайн компаниудад ирэх өгөөж нь газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмалын нөөц бөгөөд газар, эрчим хүч болон усны нөөц ашиглах эрх гэх мэт бусад элементээс бүрддэг. Ийм гэрээг бартерын солилцооны гэрээ эсвэл “дэд бүтцийг ашигт малтмалаар солилцох гэрээ” гэж нэрлэдэг¹⁶.

Кэй Пи Эм Жи нь ОУИТБС-ын стандарт ША 4.3-т заасны дагуу ОТАХ-с тогтоосон материаллаг босго болох 500 сая төгрөгөөс дээш үнэ бүхий дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын солилцооны гэрээ хийсэн эсэх талаарх мэдээллийг нэгтгэлд сонгогдсон 213 компаниас нэмэлт мэдээллийн маягтаар хүссэн. Уг маягтад холбогдох гэрээний нөхцөл, оролцогч талууд, ЗГ-аас барьцаанд тавьсан нөөц баялаг, тухайн орлогын балансад эзлэх (дэд бүтцийн) үнэ цэнэ, болон хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй гэх мэт мэдээллийг оруулж өгсөн.

Нийт гурван компани дэд бүтцийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллээ илгээсэн боловч тухайн хөрөнгө оруулалт нь шинж чанарын хувьд нийгмийн хөрөнгө оруулалт юм гэж бид үзлээ. Учир нь уг гэрээнүүдэд ЗГ-аас барьцаанд тавьсан нөөц баялаг байгаагүй гэж тайлагнасан байна. Нийгмийн хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 5.5.4-өөс харна уу.

Сая төгрөгөөр

Компаниудын дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын солилцооны мэдээлэл						
Компанийн нэр	Хөрөнгө оруулалтын нэр	Хөрөнгө оруулалт хийгдсэн огноо	Гэрээний нөхцөл	Хөрөнгө оруулалтын хэмжээ	ЗГ-аас барьцаанд тавьсан нөөц баялаг	Оролцогч талууд
Жавхлант орд ХХК	100 хүүхдийн цэцэрлэг	2016 оны 12-р сарын 30	Өөрийн хөрөнгө	980	Байхгүй	Өмнөговь аймгийн Гурван Тэс сум, ИТХ
И-Транс ХХК	Тэвш нуурын шохойн чулуун уурхай	2016 оны 6-р сарын 15	-	4,100	-	-
Оюу Толгой ХХК	Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх зам	2014 оны 4-р сарын 1	Зам барих, ашиглалтанд оруулах	-	-	Очир Төв ХХК, Мон Рөүд ХХК
Оюу Толгой ХХК	Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх зам		Зам барих, ашиглалтанд оруулах	-	-	Очир Төв ХХК, Мон Рөүд ХХК
Оюу Толгой ХХК	Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх зам		Зам барих, ашиглалтанд оруулах	-	-	Очир Төв ХХК, Мон Рөүд ХХК

Эх сурвалж: Компаниудаас ирсэн мэдээлэл

Түүнчлэн, бид аймгуудаас дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын солилцооны гэрээний талаарх мэдээллийг ирүүлэхийг хүссэн. Үүнээс, Дундговь, Өмнөговь аймгууд 2016 онд дэд бүтцийн хөрөнгө оруулалтын гэрээ хийсэн гэж тайлагнасан бол Дорнод, Дархан-Уул, Булган, Говьсүмбэр, Орхон, Сэлэнгэ аймгууд дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын солилцооны гэрээ хийгээгүй гэж тайлагнасан. Ирсэн мэдээллийн шинж чанарыг харахад энэ нь мөн л бартерын гэрээ биш харин нийгмийн хөрөнгө оруулалт байхаар байна. Учир нь ЗГ-аас барьцаанд тавьсан нөөц баялаг байгаагүй гэж тайлагнасан байна. Нийгмийн хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 5.5.4-өөс харна уу.

¹⁶ <https://guide.eiti.org/ru/node/86#def>

Аймгуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын гэрээний мэдээлэл							
Компанийн нэр	Аймаг	Хөрөнгө оруулалтын төрөл	Хөрөнгө оруулалт хийгдсэн огноо	Гэрээний нөхцөл	Хөрөнгө оруулалтын хэмжээ	Засгийн Газраас барьцаанд тавьсан нооц баялаг	Оролцсон талууд
Санжат ХХК	Дундговь	Дэд бүтэц болон замын бүтээн байгуулалт	2017 он 9-р сар	Өлзийт сумд хучилттай зам барих	808	Байхгүй	Барилга хот байгуулалтын яам, Дундговь аймгийн Засаг дарга, Өлзийт сумын засаг дарга
Оюу Толгой ХХК	Өмнөговь	2-р дунд сургуулийн Спорт цогцолборт	2016	Орон нутгийн шууд өмчлөлд шилжүүлэх	796.8	-	Оюу толгой ХХК, Говь-Оюу Хөгжлийг Дэмжих Сан, Засаг даргын тамгын газар
Оюу Толгой ХХК	Өмнөговь	Баян-Овоо сумын 10 хүний ортой эмнэлэг	2016	Орон нутгийн шууд өмчлөлд шилжүүлэх	1,088	-	Говь-Оюу Хөгжлийг Дэмжих Сан, Засаг даргын тамгын газар
Оюу Толгой ХХК	Өмнөговь	Ханбогд сумын Малын төв эмнэлэг	2016-2017	Орон нутгийн шууд өмчлөлд шилжүүлэх	1,465	-	Говь-Оюу Хөгжлийг Дэмжих Сан, Засаг даргын тамгын газар
Жавхлант Орд ХХК	Өмнөговь	Гурвантэс сумын 28-р хүүхдийн цэцэрлэг	2016	Орон нутгийн шууд өмчлөлд шилжүүлэх	980	-	Гурван тэс сумын засаг даргын тамгын газар, Жавхлант орд ХХК

Эх сурвалж: Аймгуудаас ирсэн мэдээлэл

5.5.4 Нийгмийн хөрөнгө оруулалт (ША 6.1)

Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын Эхлэлтийн үеэр ОТАХ нь зайлшгүй тайлагнах болон сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын тодорхойлолтыг гаргаж Эхлэлтийн тайланд тусгасан.

ОТАХ-ийн зөвшилцсөнөөр зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт гэдгийг мөнгөн болон мөнгөн бус шилжүүлгийг хууль тогтоомж эсхүл Засгийн Газартай байгуулсан гэрээнд тусгасан тохиолдолд ил тод болгож тулган баталгаажуулах ёстой гэж тодорхойлсон. Хуулиар Засгийн Газрын байгууллагуудад өгсөн нийгмийн хөрөнгө оруулалтуудыг заавал ил тод болгох ёстой байдаг. Мөн зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтаас бусад мөнгөн болон мөнгөн бус зарцуулалтуудыг сайн дурын нийгмийн хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон.

Компаниуд зайлшгүй тайлагнах болон сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтаа МОУИТБС-ын цахим тайлангийн системд тайлагналаг. Зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтыг ил тод болж тулган баталгаажуулсан ба материаллаг босго тэг байхаар ОТАХ тохирсон.

Сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын материаллаг босгын хувьд ТӨААН-үүдийн нийгмийн хөрөнгө оруулалт 1 сая төгрөгөөс дээш, хувийн компаниудын нийгмийн хөрөнгө оруулалт 5 сая төгрөгөөс дээш байхад тайлагнахаар тохирсон. ОТАХ нь Шилэн дансны хуулинд үндэслэн холбогдох материаллаг босго хэмжээг тогтоосон. Шилэн дансны хуулийн дагуу төрийн байгууллагууд болон ТӨААН-үүд 5 сая төгрөгөөс дээш зардлуудыг заавал ил тод болгох шаардлагатай байдаг. Энэ дүнг компаниудын тодруулгад оруулж, харин ТӨААН-үүдээс илүү нарийн мэдээлэл авахын тулд ТӨААН-үүдийн босгыг 1 сая төгрөг болгон бууруулсан байна.

Тулган баталгаажуулалт хийгдсэний дараах дүнг авч үзвэл зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын хүрээнд Засгийн Газар 18,595 сая төгрөг хүлээн авч, компаниуд 18,596 сая төгрөг өгсөн гэж тайлагнасан.

Зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт

Зайлшгүй тайлагнах мөнгөн болон мөнгөн бус нийгмийн хөрөнгө оруулалтын 96%-ийг дараах компаниуд бүрдүүлсэн байна. Компаниудын тайлагнасан зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 27-с харна уу.

Сая төгрөгөөр

Зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт /топ 15 компани/						
Компанийн нэр	Боловсрол	Гэрээ	Эрүүл мэнд	Соёл болон спорт	Бусад	Нийт хөрөнгө оруулалт
Оюу Толгой ХХК	61	13,805	174	-	345	14,385
Энержи Ресурс ХХК	103	964	133	-	61	1,261
Жавхлант Орд ХХК	-	980	-	-	-	980
Жамп Алт ХХК	1	215	-	2	-	218
МоЭнКо ХХК	1	84	111	-	-	196
Жи Пи Эф ХХК	-	121	-	-	3	124
Улз Гол ХХК	-	104	-	-	-	104
Эрдэнэт Үйлдвэр ХХК	-	99	-	-	-	99
Кожеговь ХХК	-	-	-	-	92	92
Бороо Гоулд ХХК	1	84	2	-	4	91
Болдтөмөр Ерөө Гол ХХК	-	72	-	19	-	91
Саусгоби Сэндс ХХК	0.4	45.6	-	-	26	72
Платинум Ланд ХХК	-	60	-	-	7	67
Эрдэнийн Цахирмаа Тал ХХК	-	-	65	-	-	65
Монгол Майнинг энд Эксплорэйшн ХХК	-	-	-	-	65	65
Нийт	167.4	16,633.6	485	21	603	17,910

Эх сурвалж: Компаниас ирсэн мэдээлэл (тулган баталгаажуулалтын дараах дүн)

Мөнгөн бус зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт

Нийт 30 компанийн 7,003 сая төгрөгийн үнэ бүхий хандив нь мөнгөн бус зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт гэж ангилагдсан ба дийлэнх хэсэг нь Засгийн Газартай байгуулсан нийгмийн хөрөнгө оруулалтын гэрээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Сая төгрөгөөр

Компаниудын зайлшгүй тайлагнах мөнгөн бус нийгмийн хөрөнгө оруулалт		
Компани	Зорилго	Нийт хөрөнгө оруулалт
Оюу Толгой ХХК	Гэрээний дүнгээр иргэдийн Хөгжлийн төвийн байр, тоноглол Ханбогд сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн	3,727
	Өмнөговь аймгийн Ханбогд сумын дунд сургуульд Ланд-78 хандивласан	174
	Мөнхөттрейд ХХК-д шилжүүлсэн мөнгөн дүнгээр эмнэлгийн төвд хүүхдийн эмнэлэгийн ор, тоног төхөөрөмж хандивласан	9
	Нийт	3,910
Энержи Ресурс ХХК	Цахилгаан эрчим хүчээр хангах	964
	Цэвэршүүлсэн усаар хангах	61
	Нийт	1,025
Жавхлант Орд ХХК	Гэрээний дагуу 100 хүүхдийн цэцэрлэг барьсан	980
Жамп Алт ХХК	Галуут сумын хөгжилд түлш хандивласан	195
МоЭнКо ХХК	Аруитгалын пост барьсан	111
	Цэцэрлэгийн засвар	1
	Нийт	112
Улз гол ХХК	Гудамжны гэрэлтүүлэг	104
Кожеговь ХХК	Сумын усны сав газар луу цахилгааны шугам татсан	25
	Багийн төвд байрлах байгууламж	24
	3 багийн 12 механик худгийн засвар	24
	Цэцэрлэгийн дээврийн урсгал засвар	9
	Ойн шугам байгуулалт	7
	Сумын наадам, арга хэмжээний шагналууд	3
	Нийт	92
Эрдэнэт Үйлдвэр ХХК	Орон нутгийн иргэдэд өгөх хандив	92
Саусгоби Сэнде ХХК	Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа #13779, #5267, #9449-ийг хандивласан	4
	Өвс хандивласан	21
	Сумын өвөлжилтөнд 2,957.4 тонн нүүрс хандивласан	42
	Нийт	67
Платинум Ланд ХХК	Нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хандивласан	60
	Шаралгын аппарат хандивласан	7
	Нийт	67
Эрдэнийн цахирмаа тал ХХК	Эмнэлгийн өргөтгөл барьж өгсөн	65
Бороо Гоулд ХХК	Баянгол сумын хөгжлийн хүрээнд трактор хандивласан	51
	30 км замын засвар үйлчилгээ	9
	Loader-980-аар хогийн цэг цэвэрлэх 21 цагийн ажил	4
	Нийт	64
Мондулаан трейд ХХК	Орон нутгийн үйл ажиллагааг дэмжих	50
Эс Би Эф ХХК	Дугуйт ачигч хандивласан	40
Заамар Гоулд ХХК	Сумын төвийн захиргааны буудлыг шинэчлэн засварласан	32
Илт Гоулд ХХК	Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын гэрээний дагуу	29
Жи Пи Эф ХХК	Ачааны машин	3
	Гурвансайхан сумын багийн төвд хандив өгсөн	15
	Нийт	18

Компаниудын зайлшгүй тайлагнах мөнгөн бус нийгмийн хөрөнгө оруулалт		
Компани	Зорилго	Нийт хөрөнгө оруулалт
Оргилмоунт ХХК	Өвс хандивласан	9
Уулсаамаар ХХК	Нэн ядуу өрхөд шаардлагатай 5 ханатай 4 ширхэг гэр хандивласан	7
Гангар Инвест ХХК	Тусгай зөвшөөрөлтэй газрын орон нутгийн захиргааны засварын ажилд	6
Монвольфрам ХХК	Соёлын төвийг тохижуулах	6
Монполумет ХХК	Орон сууц хөтөлбөр	6
БМНС ХХК	Барилгын засварт материал, эмнэлгийн төвд цахилгаан халаагуур болон эм тариа хандивласан	5
Хүдэр Эрдэнэ ХХК	Хүүхдийн эмнэлгийн төвд ор хандивласан	5
Талын гал ХК	Өвлийн бэлтгэл, ойн арга хэмжээ, шинэ жилийн баяр, чимэглэл, цагаан сарын золголт	5
Дрэйпэр Капитал Монголиа ХХК	Сэтгүүл хэвлүүлсэн; компьютер, принтер авсан	5
Андын тэмүүлэл ХХК	Сумын 70 жилийн ойн арга хэмжээнд	2
Адуунчулуун ХК	40 тн нүүрс хандивласан	1
Шарын гол ХК	Ойн баярт	1
Хос Хас ХХК	Ахмадуудын цагаан сарын бэлэг	1
Эс Жи Майнинг Эрдэс ХХК	Хүүхдийн баярын бэлэг	0.4
Шар Нарет ХХК	Бичиг хэргийн материал	0.4
Капкорп Монголиа ХХК	Байгаль орчин, боловсролд оруулсан хандив	0.3
Зөв Зүг ХХК	Түргэн тусламжийн тэрэг хандивлав	0.1
Бүти ХХК	Дүүргийн тохижилтонд хандивлав	0.5
Нийт		7,003

Эх сурвалж: Компаниас ирсэн мэдээлэл (тулган баталгаажуулалтын дараах дүн)

Зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын Засгийн Газрын бус хүлээн авагчид

Оюу Толгой ХХК

Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа болон Оюу Толгой төслийн хөгжлийн дэмжлэгийн хүрээнд Оюу Толгой ХХК Өмнөговь аймагтай хамтын ажиллагааны гэрээг 2015 оны 4 дүгээр сард байгуулсан. Энэ гэрээний 8.3-г зааснаар Оюу Толгой ХХК жил болгон Хөгжлийг дэмжих санд 5 сая ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэж дурьдсан. Энэ нөхцлийн дагуу, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” -г 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр бие даасан хуулийн этгээд болгон байгуулсан. Оюу Толгой ХХК-ийн гишүүд болон Өмнөговь аймгийн удирдлагын гишүүд бүхий уг сан нь дээр дурьдагдсан гэрээний хэрэгжүүлэлтийн хүрээнд бий болсон санхүүжилтийн удирдамжийн дагуу санхүүжилт болон хуваарилалтыг хийдэг болно.

2016 онд Оюу Толгой ХХК нийт 10,418 сая төгрөгийг Говийн оюу хөгжлийг дэмжих санд нийгмийн дэд бүтцийн төслийн хүрээнд хуваарилсан.

Оюу Толгой ХХК болон бусад компаниудын Засгийн Газрын бус хүлээн авагчдад өгсөн нийгмийн хөрөнгө оруулалтыг доор харуулав.

Сая төгрөгөөр

Зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын Засгийн Газрын бус хүлээн авагчид					
Компани	Бенефициар	Гэрээ	Соёл болон спорт	Бусад	Нийт хөрөнгө оруулалт
Оюу Толгой ХХК	Говийн оюу хөгжлийг дэмжих сан	10,024	-	394	10,418
АГМ Майнинг ХХК	Батмөнх	-	0.8	-	0.8
СаусгобиСэндс ХХК	Монгол Тэмээ 999	-	-	5	5
Нордвинд ХХК	Монголын Залуучуудын Холбоо	-	-	1	1
Нийт		10,024	0.8	400	10,424.8

Эх сурвалж: Компаниас ирсэн мэдээлэл (тулган баталгаажуулалтын дараах дүн)

Сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт

2016 оны байдлаар нийт 24 компани болон ТӨААН-үүд 664 сая төгрөгийг дараах салбаруудад хандивласан байна. Сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 28-с харна уу.

Сая төгрөгөөр

Компани болон ТӨААН-ийн сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт					
Компани	Боловсрол	Гэрээ	Соёл болон спорт	Бусад	Нийт хөрөнгө оруулалт
Шивээ Овоо ХК	11	-	18	5	34
Болдтөмөр Ерөө Гол ХХК	150	-	-	176	326
Баянтээг ХК	4	-	-	-	4
Андын Тэмүүлэл ХХК	-	35	-	-	35
Спэйшлмаймз ХХК	-	50	-	-	50
Жи Пи Эф ХХК	-	68	-	-	68
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК	-	12	10	-	22
Зон Хэн Юу Тиан ХХК	-	-	-	5	5
Дрэйпэр Капитал Монгол ХХК	-	7	-	-	7
Монголболгаргео ХХК	-	-	-	25	25
Саусгоби Сэндс ХХК	-	-	50	-	50
Бороо Гоулд ХХК	-	7	-	-	7
МоЭнКо ХХК	-	5	-	-	5
Тод Ундарга ХХК	3	-	-	-	3
Цайртминерал ХХК	-	-	-	5	5
Петро Чайна Дачин Тамсаг ХХК	-	-	-	2	2
Билэгт Хайрхан Уул ХХК	-	3	-	-	3
Платинум Ланд ХХК	-	2	-	-	2
И-Транс	-	2	-	-	2
Багатаян ХХК	-	2	-	-	2
Хүдэр Эрдэнэ ХХК	-	4	-	-	4
Адуунчулуун ХК	-	-	1	-	1
Уулсзаамар ХХК	-	1	-	-	1
Макс Импекс ХХК	1	-	-	-	1
Нийт	169	198	79	218	664

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

5.5.5 Тээвэрлэлтийн орлого (ША 4.4)

ОУИТБС-ын стандартын дагуу газрын тос, байгалийн хий, байгалийн баялагийн тээвэрлэлтээс олох орлого нь ОУ-ийн томоохон орлогын эх үүсвэрүүдийн нэг болдог бол ЗГ болон ТӨААН-үүд үүнийг ил тод болгох шаардлагатай. Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын эхлэлтийн үед тээвэрлэлтийн орлогын хүрээнд ямар нэгэн материаллаг босгыг тодорхойлж батлаагүй болно.

Кэй Пи Эм Жи нь газрын тос, байгалийн хий, байгалийн баялагийн тээвэрлэлтээс олсон орлогын мэдээллийг ил тод болгохоор нэгтгэлд сонгогдсон 9 ТӨААН-үүд рүү нэмэлт мэдээллийн маягт илгээсэн.

Дараах ТӨААН-үүд тээвэрлэлтийн орлогын мэдээлэл болох тээвэрлэсэн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй, татварын хувь хэмжээ, тээвэрлэлтийн орлогыг хүлээн авагч төрийн байгууллагуудын талаар тайлагнасан байна:

Төгрөг

ТӨААН-ийн тээвэрлэлтийн орлогын мэдээлэл						
Компанийн нэр	Тээвэрлэсэн бүтээгдэхүүн	Тээвэрлэлтийн хэмжээ	Нэгж	Тээвэрлэлтийн татварын хувь	Орлогыг хүлээн авагч төрийн байгууллага, ТӨААН	Нийт үнэ
Шивээ Овоо ХК	Нүүрс	-	-		Улаанбаатар ТЭЦ-4	44,301,771
	Нүүрс	-	-	Хөнгөлөлттэй татварын хувь	Налайх Дулааны Станц	345,729
	Нүүрс	-	-		Ус-Ду орон нутгийн өмчийн газар	248,489
Багануур ХК	Нүүрс	1660.01	т		Улаанбаатар төмөр зам	47,615
	Нүүрс	1285.31	т		-	36,940
	Нүүрс	244.18	т	Хөнгөлөлттэй татварын хувь	-	6,587
	Нүүрс	106.97	т		-	2,928
	Нүүрс	39.07	т		-	1,133
	Нүүрс	52.91	т		-	1,349
Тавантолгой ХК	Нүүрс	-	-	Хөнгөлөлттэй татварын хувь	-	-
Могойн Гол ХК	Нүүрс	-	-	Хөнгөлөлттэй татварын хувь	Улаанбаатар ТЭЦ-4	-
Эрдэнэт Үйлдвэр ХХК	Нүүрс	-	-	Хөнгөлөлттэй татварын хувь	Улаанбаатар ТЭЦ-4	-
УБТЗ Чулуун Завод ХК	Нүүрс	-	-	Хөнгөлөлттэй татварын хувь	Улаанбаатар ТЭЦ-4	-

Эх сурвалж: Компаниас ирсэн мэдээлэл

5.5.6 Уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт болон нөхөн сэргээлт

Тойм мэдээлэл

Энэхүү тайлангийн хүрээнд нөхөн сэргээлтийг эвдэрсэн газрын эдийн засгийн үнэ цэнэ, үр шимийг нэмэгдүүлэх байгаль орчны багц үйл ажиллагаа, арга хэмжээ бөгөөд бусад олон нийтийн ашиг сонирхолд нийцэх орчин тойрны сайжруулт гэж тодорхойлсон¹⁷. Энэ нь 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн БОАЖНХЯ-ны (хуучнаар) сайдын А/138 тоот тушаалтай нийцсэн. Тус тушаалаар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалыг тогтоосон.

Нөхөн сэргээлтийн хувьд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид Байгаль орчны тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр заалтуудыг дагаж мөрдөх ёстой. Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар заалт нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах үүргийг тодорхойлсон бол 39 дүгээр заалт нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг (БОХТ) тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн боловсруулах ёстой. БОХТ-д хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх ба эвдэгдсэн газрыг буцаан өмнөх байдалд нь оруулж нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг оруулах хэрэгтэй. БОХТ нь тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргаар батлагдаж хуулбарыг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх ёстой. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид БОХТ-г жил бүр ирүүлсэн байх ёстой. Түүнчлэн, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ашигласан шинэ техник, технологи, бусад байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн нэмэлт өөрчлөлтийн саналыг жил бүрийн БОХТ-д тусган холбогдох сум, дүүргийн Засаг даргаар батлуулах шаардлагатай.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) хийж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах ёстой. БОНБУ нь тухайн уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд болон байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг тодорхойлж, түүнийг арилгах, багасгах арга хэмжээг тодорхойлно. БОХТ-д уурхайн ажлыг байгаль орчинд хохирол багатай явуулах бөгөөд агаар мандал, усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээнүүд тусгагдсан байх ёстой. БОНБУ болон БОХТ-г жил бүр БОАЖЯ-д хүргүүлнэ. Төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОНБУ болон БОХТ-ий хуулбарыг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлнэ. Хэрэв тусгай зөвшөөрлийн хүчинтэй үед шинэ техник, технологи ашигласнаар байгаль орчинд нөлөөлөх байдал өөрчлөгдвөл тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөгдсөн БОНБУ болон БОХТ-г БОАЖЯ, холбогдох аймаг, сум болон дүүргийн Засаг дарга ба байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх ёстой.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг хамгаалах шаардлага хангуулах зорилготойгоор хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид аль аль нь холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд өөрсдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд шаардагдсан тухайн жилийн төсвийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг шилжүүлэх үүрэгтэй. Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОХТ-д тусгагдсан үүргүүдээ биелүүлсэн тохиолдолд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцааж олгоно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид БОНБУ болон БОХТ-д тусгагдсан үүргүүдээ бүрэн биелүүлсэн бол байршуулсан мөнгөн хөрөнгийг уурхайн хаалтын үе шатанд буцааж олгоно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОХТ-д тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглан шаардлагатай арга хэмжээг нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Ийм тохиолдолд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд нэмж шаардагдах мөнгөн дүнг тусгай зөвшөөрөл эзэмшигч маргаангүй

¹⁷ Эх сурвалж: Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, БОНХАЖЯ

олгох ёстой. Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй байгууллагуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 5.5.6.2-с харна уу.

Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уулын ажил эхлээд нэг жил болсоны дараах нэг сарын дотор шаардагдах хөрөнгийг шилжүүлээгүй бол холбогдох сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй. Түүнчлэн, тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхийг хориглох эрхтэй¹⁸.

Нөхөн сэргээлт нь 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн БОАЖНХЯ-ны (хуучнаар) сайдын А/138 тоот тушаалын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт гэж ангилагдана.

- Техникийн нөхөн сэргээлт нь эвдэгдсэн газрыг ашиглаж дууссаны дараа эхэлдэг. Техникийн нөхөн сэргээлтэнд дүүргэлт, талбайн тэгшлэлт болон хэлбэржүүлэлт, налуу гадаргууг тэгшлэх зэрэг бусад төстэй үйл ажиллагаанууд хамрагдана.
- Биологийн нөхөн сэргээлт нь техникийн нөхөн сэргээлт дуусч, хөрс тогтворжсоны дараа эхэлдэг. Биологийн нөхөн сэргээлтийн гол зорилго нь талбайн хөдөө аж ахуйн үр ашиг, загас агнуур, ургамал болон байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, талбайн биологийн байдлыг нөхөн сэргээж хөгжүүлэх юм. Биологийн нөхөн сэргээлтийн үед шаардагдах ургамалжуулалтыг тодорхойлохын тулд уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчин болон биологийн урьдчилсан шинжилгээ хийх ёстой¹⁹.

Кэй Пи Эм Жи сонгогдсон 213 компаниудаас нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны мэдээллийг нэмэлт мэдээллийн маягтаар ирүүлэх хүсэлт гаргасан. Нийт 100 компани 2016 онд хийсэн нөхөн сэргээлтийн мэдээллээ тайлагнасан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 29-с харна уу.

Байгаль орчныг хамгаалах тусгай данс

БОАЖЯ-ны мэдээлснээр 2016 онд нийт 1,093 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн зардал Байгаль хамгаалалтын тусгай дансанд төвлөрсөн ба буцаан олголт байгаагүй байна. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл нь 11,300 сая төгрөг байна:

Сая төгрөгөөр

Байгаль орчныг хамгаалах тусгай данс			
Он	Шилжүүлгүүд (сая төгрөг)		
	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
2006	22	-	22
2007	612	-	634
2008	566	(21)	1 179
2009	385	(126)	1 438
2010	942	(1)	2 379
2011	1 216	(5)	3 590
2012	2 014	(16)	5 588
2013	1 545	(225)	6 908
2014	2 273	(1)	9 180
2015	1,027	(0)	10,207
2016	1,093	0	11,300

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

¹⁸ Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль, 38, 39 дүгээр заалт

¹⁹ Эх сурвалж: Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, БОНХАЖЯ

5.5.6.1 2016 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн мэдээлэл

АМГТГ-ын 2016 оны ашигт малтмалын статистикийн тайланд дурьдсанаар нийт 1,615 га талбай газар уулын ажилд хамрагдсанаас 96% буюу 1,556 га талбай газарт нөхөн сэргээлт хийгдсэн байна. 2016 онд нөхөн сэргээлтийн нийт зардал нь 99,248 сая төгрөг болсон байна²⁰.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэл								
	Нэгж	Өмнөх жилүүд	2012	2013	2014	2015	2016	Нийт
Уулын ажилд хамрагдсан талбай	га	22,168	1,430	1,038	1,561	871	1,615	28,683
Нөхөн сэргээлт хийгдсэн талбай	га	16,146	1,402	807	960	750	1,556	21,621
Нөхөн сэргээлтийн харьцаа	%	73%	98%	78%	61%	86%	96%	75%
Нөхөн сэргээлтийн зардал	сая төгрөг	57,458	14,808	7,382	9,212	4,019	6,369	99,248

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, статистик-2016

2010 оноос 2016 оны хооронд уулын ажилд хамрагдсан талбай болон нөхөн сэргээлт хийгдсэн талбайн харьцуулалт:



Эх сурвалж: Статистик 2016, Ашигт малтмал, газрын тосны газар

Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл (нүүрс олборлогчдоос бусад)

АМГТГ-ын мэдээлснээр 2016 онд нийт 159 компаниуд уулын ажил болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хэрэгжилтээ тайлагнасан байна. Компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 30-с харна уу. Уул ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн хураангуйг дараах байдлаар харуулав:

²⁰ Ашигт малтмал, газрын тосны газар. Статистик Мэдээ 2016

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл										
Ашигт малтмалын төрөл	Нийт компанийн тоо	Уулын ажил				Нөхөн сэргээлт				
		Талбай(га)		Эзлэхүүн ('000 м³)		Талбай(га)		Эзлэхүүн ('000 м³)		Нийт зардал (сая төгрөгөөр)
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
Зэс	1	151	-	-	-	115	110	-	-	-
Алт	48	742	715	41,145,496	1,611,847	11,421	11,467	821,759	77,876, 775	5,500,718
Манган	1	88	49	-	-	-	0	-	240,000	2
Мөнгө	1	Мэдээ ирүүлээгүй								
Жонш	24	49	23	54,070	6,188	5	11	150	188,384	74
Төмөр	7	20	5	500,000	20,090	15	26	28,030	3,480,821	62
Гөлтгөнө	3	151	1	-	6,603	118	113	6,600	44	68
Цагаан тугалга	2	16	6	6,542	35,295	1	6	6,542	228,012	6
Гөлтгөнө	3	4	2	240,786	-	-	-	-	154,303	-
Цайр	7	1	1	-	-	4	4	-	-	-
Бар/М	58	15,687	13,555	1,301,183	111,397	5,020	5,047	54,514	905,312	104
Цеолит	1	1	0	-	-	-	0	-	-	-
Гянтболд	3	14	2	44,000	1	2	3	1	11,420	15
Нийт	159	16,924	14,359	43,292,077	1,791,421	16,701	16,787	917,595	83,085,071	5,501,049

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Нүүрс олборлогчдын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Нүүрсний асуудлыг АМГТГ-т тусдаа хэлтэс зохицуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан нь бусад ашигт малтмалын тайлангаас ялгаатай гардаг. Нийт 17-н нүүрс олборлогч компаниуд уулын ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээг тайлагнасан байна.

Нүүрс олборлогчдын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл										
Компанийн нэр	Лицензийн дугаар	Уулын ажил			Нөхөн сэргээлт					
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Нийт зарцуулалт (Сая төгрөгөөр)	
		га	га	000'м³	га	га	000'м³	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Хотгор	MV-001441	0.5	0.2	55,625	0.9	0.3	28, 000	10.5	10.5	
	MV-014442	0.3	0.3	0.3	0.7	0.4	0.4	69.3	35.8	
Шарын Гол	MV-001498	50	42.6	100	45.6	23.8	-	16.5	16.5	
Эрчим	MV-005696	0.2	0.6	-	0.2	0.2	27, 344	10.5	10.5	
Найнгэ	MV-001364	3.5	3.5	1,007	11	10.7	100,380	29.4	65.8	
Штайнколе	MV-011281	5.2	11.3	1,004	10	1	500	25	2	
Андын Илч	MV-012307	4.5	-	3,511	2.1	-	500	19.5	0.5	
Чинхуа МАК Нарийн Сухайт	MV-005459	12.7	12.7	25,360	35,381	12.7	25,360	15.1	8.9	
Өсөх Зоос	MV-017317	-	4.8	4,563	6.5	6.5	26,750	42	38.5	
Баялаг Орд	MV-000222	0.5	1.1	4,563	1.6	1.6	140,010	6.1	15.6	
Монголын Алт МАК	MV-002545	-	3.9	564,362	-	10.6	572,404	6.1	15.6	
	MV-000227	56.1	50.2	30,056	3	2.5	33,536	3.1	4.1	
Си Өү Эй Эл	MV-016865	0.7	0.7	2,037	-	0.7	2, 044	22.5	13.1	
Цагаан Өвөлжөө	MV-017162	-	-	-	-	-	-	-	-	

Нүүрс олборлогчдын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл										
Компанийн нэр	Лицензийн дугаар	Уулын ажил			Нөхөн сэргээлт					
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл 000'м³	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Нийт зарцуулалт (Сая төгрөгөөр)	
		га	га		га	га	000'м³	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Багануур	MV-001371	78	18	22,617	20.2	21.8	29,380	124.6	115	
Петроколе	MV-012475	0.1	1	74.1	-	0.6	3,960	3	7	
Энержи Ресурс	MV-011952	245.8	253.6	15,333	2.3	2.3	-	-	46.9	
Саусгоби Санде	MV-012726	50	26	51	4	3.2	-	165	165	
Бэрх Уул	MV-004590	0.3	0.6	145	0.9	0.4	27	8	4.8	
Эрдэнэс Тавантолгой	MV-011943	120	141.1	35,381	1.6	1.6	43,000	20	46,761	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг дор харуулав:

Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл (000* баррель)			
Талбайн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн %
Тосон-Уул XIX	5,180	3,819	73.72
Тамсаг XXI	4,320	3,885	89.92
PSA-97	428	358	83.64
Нийт	9,928	8,062	81.20

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг дор дурьдсан хүснэгтээр харуулав:

Ажил	Нэгж үнэ (доллар)	Төлөвлөгдсөн хэмжээ	Тайлбар	Гүйцэтгэл
Тосон-Уул талбай XIX				
Өрмийн хаягдал шингэний саармагжуулалт, нөхөн сэргээлт	3,800	86 цооног	2015 оны 86 сан	36 цооног
Газрын хөрсний дээж авах, авсан дээжинд лабораторын шинжилгээ хийх	600	30		Гэрээ хийгдсэн
Байгаль орчны үнэлгээний ажил	20,000	2	2016 оны төсөв	Хийгдсэн
Биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт	300,000	1	2016 оны төсөв	Хөрс сийрэгжүүлсэн
Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг				-
Тамсаг талбай XXI				
Өрмийн хаягдал шингэний саармагжуулалт, нөхөн сэргээлт	3,800	164	74 сан, 2014, 90 сан, 2015	90%
Газрын хөрсний дээж авах, авсан дээжинд лабораторын шинжилгээ хийх	600	30		30%
Байгаль орчны үнэлгээний ажил	45,000	30	2016 оны төсөв	30%
Биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт	20,000	2		1
Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг	35,000	1	2015 оны төсөв	1

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбай		
Төлөвлөгдсөн ажил	Гүйцэтгэгч	Ажлын тайлан
Орчны хяналт шинжилгээ	ЕНКО ХХК	илгээсэн
Талбайн хөрсний дээж шинжилгээ	Хатан Далай ХХК	илгээсэн
Нөхөн сэргээлт	Цээх Консалтинг ХХК	илгээсэн

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

5.5.6.2 Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд, тэдгээрийн байршил

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нь уул уурхайн компаниуд эсвэл уурхай байрлах холбогдох дүүрэг, аймгийн Засаг дарга нартай гэрээ хийж шаардагдах ажлыг гүйцэтгэдэг.

БОАЖЯ-ны мэдээлснээр 2016 онд нийт 96 компани нөхөн сэргээлтийн зөвшөөрөл авсан эсвэл зөвшөөрлөө сунгасан байна. Үүнээс нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй гэж тайлагнасан 75 компаниуд Улаанбаатар хотод байршилтай бөгөөд үлдсэн 21 компаниуд Дорнод, Булган, Баянхонгор гэх зэрэг нийт 10-н аймагт байршилтай байна. Ихэнх нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нь уул уурхайн компаниудтай гэрээ хийж ажилладаг болохыг БОАЖЯ мэдээлсэн ба нөхөн сэргээлтийн компаниудын байршил нь тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй байршилыг тодорхойлохгүй болно.

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниудыг байршлаар нь ангилж доорх хүснэгтэд харуулав. 96 компанийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 31-с харна уу.

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд (байршлаар)		
Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Компаниуд
Улаанбаатар	Баянгол дүүрэг	18
	Сонгинохайрхан дүүрэг	10
	Сүхбаатар дүүрэг	13
	Баянзүрх дүүрэг	18
	Хан-Уул дүүрэг	5
	Чингэлтэй дүүрэг	11
Сэлэнгэ аймаг	Мандал сум	1
Өвөрхангай аймаг	Арвайхээр сум	2
Баянхонгор аймаг	Баянхонгор сум	2
	Номгон сум	1
	Бөмбөгөр сум	1
Орхон аймаг	Баян-Өндөр сум	2
Увс аймаг	Улаангом сум	1
Говьсүмбэр аймаг	Сүмбэр сум	1
Дорнод аймаг	Хэрлэн сум	4
Дундговь аймаг	Өлзийт сум	1
Ховд аймаг	Жаргалант сум	2
Булган аймаг	Хялганат сум	1
Өмнөговь аймаг	Даланзадгад сум	2
Нийт		96

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

6 Зөвлөмжүүд

6.1 Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжилт (ША 7.3)

МОУИТБС-ын 2015 оны тайлангаар БХГ-ний ил тод байдал, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, ТӨААН-үүдтэй холбоотой асуудлууд, мэдээллийн баталгаажуулалт, цахим тайлагналын систем зэрэгт зөвлөмж өгсөн байсан. Эдгээр зөвлөмжүүдийг ОТАХ 2016 оны үйл ажиллагаандаа аль болох боломжтой хэмжээнд хэрэгжүүлэхээр зорин ажилласан байна.

МОУИТБС-ын 2015 оны тайлангаар өгсөн зарим зөвлөмжүүд хэсэгчлэн хэрэгжсэн бөгөөд зарим нь хэрэгжих шаардлагатай хэвээр байна. Хэдийгээр цахим тайланд суурилсан төлбөрийн тайлагналын систем нэгтгэлийн үйл явцад дэмжлэг болж байгаа ч ОУ-ийн эдийн засагт үзүүлэх чухал ач холбогдол, байр суурийг тооцож үзэхэд нэгтгэлийн үйл явц нь нарийн төвөгтэй бөгөөд цаг хугацаа шаардсан хэвээр байна.

Доорх хүснэгтээр 2015 оны зөвлөмж болон түүний хэрэгжилтийн хураангуйг харуулав.

Зөвлөмжүүд	МОУИТБС-ын 2015 оны тайлангийн заалт	2015 оны тайлангийн төлөв байдал
Бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгох	7.2.1	Одоо ч хамааралтай
Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл: - Тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдлын талаарх стандартын хамгийн наад захын шаардлагыг хангуулах - АМГТГ-аас гаргаж буй тусгай зөвшөөрлийн статистик мэдээллүүдийн нийцэлтэй байдлыг хангах	7.2.2	Хэсэгчлэн хэрэгжсэн
ТӨААН-үүд нөхөн сэргээлтийн зохистой, иж бүрэн төлөвлөгөөтэй болох	7.2.3	Хэсэгчлэн хэрэгжсэн
СЯ болон ТӨААН-үүдтэй ТӨААН-үүдийн аудитын тайлангийн хязгаарлалттай дүгнэлтийн талаар ОТАХ ярилцах	7.2.4	Хэсэгчлэн хэрэгжсэн
Баталгаажуулалт - Засгийн Газар: ОУИТБС-ын мэдээллийн баталгаажуулалтад УАГ-ыг оролцуулах - Компаниуд: Компаниудын зүгээс аудитлагдсан санхүүгийн тайлангаа танилцуулах үйл ажиллагааг сайжруулах талаар зохих арга хэмжээг авах - Удирдлагын баталгаажуулалт: Компаниудын зүгээс удирдлагын төлөөллийн захидлыг илгээх үйл ажиллагааг сайжруулах талаар зохих арга хэмжээг авах	7.2.5	Хэсэгчлэн хэрэгжсэн
Цахим тайлагналын систем - Цахим тайлагналын системийн хэрэглээ: Тайлагнагч компаниуд болон төрийн байгууллагуудыг цахим тайлагналын системд мэдээллээ тайлагнах байдлыг нэмэгдүүлэх - Олборлох үйлдвэрлэлийн бус компаниуд: Цахим тайлагналын систем хэрэглэгч компаниудыг шалгаж, олборлох үйлдвэрлэлийн бус компаниудыг хасах - Мэдээллийн Технологийн Ерөнхий Хяналт (МТЕХ): Цахим тайлагналын системийн МТЕХ-тай холбоотой тодорхой зөвлөмжүүд	7.2.6	Одоо ч хамааралтай
Хараат бус хянагч-нэгтгэгчийг эрт томилох	7.2.7	Хэрэгжсэн
Төслийн түвшин дэх тайлагнал	7.2.8	Одоо ч хамааралтай

6.2 Хараат бус хянан-нэгтгэгчийн цаашдын МОУИТБС-ын тайланд өгөх зөвлөмжүүд

6.2.1 Төрийн байгууллагуудаас тайлагнасан мэдээллийн баталгаажуулалт

Одоогийн байдлаар ҮАГ болон аливаа орон нутгийн аудитын байгууллагуудаас төрийн байгууллагуудын тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг ямар нэгэн баталгаажуулалтаар хангахад чиглэсэн горимыг хийж гүйцэтгээгүй. Бидний ойлгосноор МОУИТБС-ын Ажлын алба төрийн байгууллагуудаас тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг баталгаажуулах журмын төслийг боловсруулж ҮАГ-т албан ёсоор танилцуулсан ба 2018 оноос туршилтаар уг журмын дагуу баталгаажуулахаар бэлтгэж байна.

Үүнээс гадна, энэ оноос эхлэн төрийн байгууллагуудын тайлагнасан ОУИТБС-ын мэдээлэлд СЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга нар гарын үсэг зурах шинэ журам хэрэгжиж байна. Энэ журмыг хэрэгжүүлснээр өнгөрсөн онтой харьцуулахад төрийн байгууллагуудын тайлагнасан мэдээллийн баталгаажуулалт нэмэгдэж байгаа болно.

Зөвлөмж

Цаашид, төрийн байгууллагуудаас тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг баталгаажуулах журмыг амжилттай хэрэгжүүлэх ажлыг ҮАГ-тай хамтран зохион байгуулах нь зүйтэй.

Түүнчлэн, ҮАГ-т ОУИТБС-ын ажлын хүрээнд тайлагнасан мэдээллийн баталгаатай байдлыг хангахад хангалттай хугацаа бүрдүүлэх, жилийн эцэст аудит хийх хөтөлбөртөө багтаах боломжийг бий болгох үүднээс ҮАГ-тай уг асуудлын талаарх хэлэлцүүлгийг ойрын хугацаанд эхлүүлэх нь зүйтэй бөгөөд энэхүү хэлэлцүүлгийг нэн даруй буюу 1 дүгээр сараас эхлүүлбэл зохино.

6.2.2 ОУИТБС-ын тайлангийн ач холбогдлыг төрийн байгууллагуудад онцлох

Бидний ажигласнаар төрийн байгууллагуудын ОУИТБС-ын үйл явц дахь оролцооны цар хүрээ жилээс жилд буурах хандлагатай байна. Энэ нь төрийн төв байгууллагуудаас тулган баталгаажуулах явцад шаардлагатай мэдээллийн дэлгэрэнгүйг авах, салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүдийг авах зэрэг үйл явцад илүү ажиглагдсан. Бид зарим агентлагуудаас салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон мэдээллийн тодруулга авахад нилээдгүй саад бэрхшээлүүдтэй тулгарсан. Энэ нь нэг талаас 2016 болон 2017 оны хооронд төр солигдсонтой холбоотойгоор боловсон хүчин болон мэдлэгийн залгамж байдлын талаарх асуудал, нөгөө талаас санаачилгын ач холбогдлын талаарх мэдээлэл дутмаг байгаа зэргээс үүдэлтэй байна.

Зөвлөмж

ОУИТБС-ын ач холбогдол болоод ОУИТБС-ын мэдээллийг бэлтгэдэг Засгийн Газрын агентлагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг таниулах ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөс батлах нь зүйтэй.

Засгийн Газрын байгууллагуудыг ОУИТБС-тай холбоотой баримт материал, ОУИТБС-ын үйл явцыг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллээр хангах ажлыг Засгийн Газрын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй. Ингэснээр ОУИТБС-ын шаардлагуудтай холбоотой лавлагаа мэдээллийн тогтвортой залгамж шинж чанар бий болж, Засгийн Газар, аливаа боловсон хүчин өөрчлөгдсөн ч ОУИТБС-ын шаардлагын талаарх мэдээллийг дараагийн томилогдсон хүмүүс шилжүүлэн авч, тасралтгүй байдлыг хангах боломжтой болох юм.

6.2.3 ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартуудын талаарх ТӨААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх

ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын санхүүгийн харилцаа, төсвийн шинжтэй зарцуулалт, нийтийн дэд бүтэц зэрэг нэмэлт мэдээллүүдийг ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу ТӨААН-үүд ил тод болгох ёстой байдаг. ОУИТБС-ын стандартын эдгээр шаардлагын нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан ТӨААН-үүдийн уг шаардлагад нийцсэн мэдээллүүдийг тайлагнах түвшин бага байдгийг Хараат бус хянагч-нэгтгэгч бид ажигласан. 2016 оны тайлангийн хувьд эдгээр шаардлагуудын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор бид зохих сургалтыг зохион байгуулсан. Мөн мэдээлэл цуглуулах явцад үргэлжлүүлэн

ТӨААН-үүдтэй нэг бүрчлэн холбогдож туслалцаа үзүүлсэн. Цаашид, ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартын эдгээр шаардлагуудын талаарх ТӨААН-үүдийн чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх нь зүйтэй.

Зөвлөмж

ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартын тухайлсан шаардлагуудын талаарх сургалтыг ОТАХ болон МОУИТБС-ын Ажлын албаны (эсвэл хөндлөнгийн мэргэжилтнүүдийн) зүгээс Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажил эхлэхээс тодорхой хугацааны өмнө зохион байгуулах, сургалтын гарын авлага танилцуулах гэх мэтээр ТӨААН-үүдийн чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх нь зүйтэй. Ингэснээр, ОУИТБС-ын стандартын шаардлагуудын дагуу мэдээллийг ил тод болгох үйл явцыг сайжруулж, ил тод болгох үйл явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаарх ойлголтыг илүү тодорхой болгоно.

Лавлагаа материалуудыг сургалтын материалуудтай харилцан уялдаатай боловсруулах хэрэгтэй бөгөөд энэ нь дээрхи “ОУИТБС-ын тайлангийн ач холбогдлыг төрийн байгууллагуудад онцлох” талаарх зөвлөмжийн нэгэн адил ТӨААН-үүдийн боловсон хүчин өөрчлөгдсөн ч мэдлэгийн тасралтгүй залгамж шинж чанарыг бий болгох ач холбогдолтой.

6.2.4 Цахим тайлагналын системээр дамжуулан цуглуулах орлогын урсгал

Хараат бус хянагч-нэгтгэгчийн тулган баталгаажуулах ажлын үйл явцад НӨАТ-ын орлогын урсгалын тайлагнал дээр нилээдгүй хүндрэл бэрхшээл үүссэн. НӨАТ-ыг Татварын алба болон Гаалийн албанд компаниуд тус тусад нь төлдөг бөгөөд МОУИТБС-ын цахим тайлагналын системд НӨАТ-ыг нэг орлогын урсгалаар тайлагнадаг. Хараат бус хянагч-нэгтгэгч НӨАТ-ын уг нийлбэр дүнг хүлээн авагчаар нь задлахад нилээдгүй хугацааг зарцуулдаг ба зарим тохиолдолд задлах боломжгүй байдаг.

Зөвлөмж

МОУИТБС-ын цахим тайлангийн системд НӨАТ-ын орлогын урсгалыг дараах 2 байдлаар ялган тайлагнах боломжтой байхаар загварчилах нь зүйтэй:

- Татварын албанд төлөгдөх НӨАТ; болон
- Гаалийн албанд төлөгдөх НӨАТ

Мөн компаниуд цахим тайлангийн системд Татварын албанд төлсөн НӨАТ, Гаалийн албанд төлсөн НӨАТ-ыг тус бүрээр нь тайлагнах боломжтой байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

Энэ нь МОУИТБС-ын цахим тайлангийн системийн хүрээнд хийгдэх ажил юм. НӨАТ-ын орлогын урсгалын найдвартай байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад тайлагнал, нэгтгэлийн үйл явцыг сайжруулах үүднээс дэлгэрэнгүй мэдээлэл, сургалтыг оролцогч талуудад хүргэх нь зүйтэй.

6.2.5 ОУ-ийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагааны бусад төрлөөс ялгах тухай

Тайлангийн 4.2.3-д дурьдсанчлан, аливаа компани хайгуул болон олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол ЗГ эдгээр компаниудыг ОУ-т багтаан ОУ-ийн салбараас гадна эрхэлж буй бусад төрлийн үйл ажиллагаанаас олсон орлогыг үл харгалзан тухайн компанийн бүх орлогын урсгалыг ЗГ-ын тайлагнасан мэдээлэлд багтаадаг. Үүнээс шалтгаалан, ЗГ-ын тайлагнаж буй ОУ-ийн мэдээлэл нь бодит байдлаасаа илүү илэрхийлэгддэг. Бид ЗГ-ын тайлагналд ОУ-ийн төлбөр болон бусад төлбөрийг ялган харуулах боломж хязгаарлагдмал байгааг ойлгож байгаа.

ЗГ-ын мэдээллийг нэгтгэлийн зорилгоор ашиглаж болох хамгийн иж бүрэн мэдээлэл гэж үзсэн тул бид нэгтгэлд хамрагдах компаниудыг ЗГ-ын тайлагнасан мэдээлэлд үндэслэн сонгосон. Тухайн компанийн үйл ажиллагаа эсвэл төлбөрийг үүсгэж буй бизнесийн салбараас үл хамааран төлбөрийн мэдээлэл нь компанийг бүхэлд нь хамарсан нийт төлбөрийг илэрхийлж байна. Түүнчлэн, компанийг бүхэлд нь хамарсан төлбөрийн мэдээлэл нь ямар компаниуд нэгтгэлд сонгогдохыг шийдвэрлэхэд нөлөөлдөг бөгөөд үүнээс үүдэн ОУ үндсэн үйл ажиллагааных нь багахан хэсгийг бүрдүүлдэг, олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг томоохон

компаниуд нь энэхүү нэгтгэлд хамрагдаж, ОУ-ийн төлбөрийн мэдээлэл бодитой бус гарах нөхцөл байдал үүсэхээр байна. Тиймээс тэдгээрийг нэгтгэлийн түүвэрт хамруулахгүй байх нь илүү тохиромжтой юм. ИМ

Зөвлөмж

ЗГ-ын түвшинд бизнесийн олон үйл ажиллагаа эрхэлдэг аливаа аж ахуйн нэгжийн олборлох үйлдвэрлэл эсвэл бусад бизнесийн үйл ажиллагаанаас орсон орлогын урсгалуудыг хооронд нь ялгаж, тайлагнах шинэ тогтолцоо бий болгон түүнийг хэрэгжүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй. Тайлагналын хүрээнд аж ахуйн нэгжийн олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой орлогын урсгалыг бусад төрлийн бизнесийн үйл ажиллагааны орлогын урсгалаас хэрхэн оновчтой ялган зааглах талаар тооцон үзэж, зохистой практик шийдлийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Үр дүнтэй, хэрэгжихүйц шийдэл нь Засгийн Газар мэдээллийг өнөөгийн байдлаар хэрхэн цуглуулж байгаа, ялангуяа мэдээлэл цуглуулах арга барил болоод эдгээрийн тогтолцооны талаарх дэлгэрэнгүй мэдээллээс шууд хамааралтай.

6.2.6 Кадастрын мэдээлэл

ОУИТБС-ын стандартын 2.3 дугаар хэсэгт шаардагддаг тусгай зөвшөөрлийн талаарх зарим мэдээллүүдийг АМГТГ-ын Кадастрын албанаас одоог хүртэл ил тод болгоогүй байна. Бид өөрсдийн хүлээсэн үүргийн хүрээнд АМГТГ-аас ил тод болгох ёстой дутуу мэдээллүүдийг хүсэлт гарган авч 2016 оны тайландаа оруулсан.

Гэвч стандартаар шаардсан уг тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллүүдийг нэмэлт хүсэлтгүйгээр ил тод болгох үйл явц хэвшсэн байх нь зүйтэй. Ялангуяа, тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноо болон бүтээгдэхүүн хуваах гэрээний талбайн солбицлын мэдээллийг жил бүр шинэчилж байх нь зүйтэй.

Үүнтэй ижил асуудал МОУИТБС-ын 2015 оны тайлангийн үеэр гарч байсан.

Зөвлөмж

ОУИТБС-ын стандартаар шаардсан наад захын шаардлагуудад нийцсэн мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлэх үүднээс тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг АМГТГ-ын зүгээс сайжруулах арга хэмжээг авах нь зүйтэй. ОУИТБС-ын стандартаар шаардсан БХГ-ний талаархи мэдээллийг олон нийт цахим орчинд харах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Мөн ОУИТБС-ын стандартын холбогдох шаардлагыг дагаж мөрдөхөд үр дүнтэй шийдэл, зохистой арга хандлагыг тодорхойлох үүднээс ОТАХ нь АМГТГ-ын төлөөлөлтэй тулгарч буй асуудлын талаар цаашид хэлэлцэх нь зүйтэй.

6.2.7 Бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдал

Хэдийгээр Засгийн Газар БХГ-ний ил тод байдлыг дэмжих тал дээр зохих арга хэмжээ авч ажилласан ч бид бүтээгдэхүүн хуваах зөвхөн гурван гэрээ олон нийтэд ил тод байгааг олж тогтоосон. 2014 болон 2015 оноос хэрэгжиж буй хууль тогтоомжуудын дагуу БХГ-нүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэхээр өмнө нь байсан нууцлалын заалтуудыг хасч, өмнө нь нууцлалд байсан мэдээллүүдийг ил тод болгох БХГ-ний загварыг гаргасан ч энэ нь бодитоор БХГ-ний ил тод байдалд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна.

Үүнээс гадна өртөг, нөхөн олговор, бүтээгдэхүүн хуваах, урамшуулал гэх мэт олон чухал заалтууд ил тод бус хэвээр байсаар байна.

Үүнтэй ижил асуудал МОУИТБС-ын 2015 оны тайланд мөн гарч байсан.

Зөвлөмж

Үндэсний зөвлөл эсвэл ОТАХ нь энэ асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тавьж, одоогоор хүчин төгөлдөр байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ОУИТБС-ын стандартын дагуу олон нийтэд ил тод болгох нь зүйтэй. Засгийн Газрын бодлогын хүрээнд БХГ-г ил тод болгох, ил тод болгохыг дэмжих алхамуудыг холбогдох яамдуудтай үргэлжлүүлэн хэлэлцэх шаардлагатай.

6.2.8 Төслийн түвшин дэх тайлагнал

Тайлангийн 3.2 дугаар хэсэгт дурьдсанчлан, ОУИТБС-ын стандарт нь төслийн түвшинд тайлагнахыг тодорхой нөхцөл бүрдсэн үед шаарддаг бөгөөд уг шаардлагын нэг нь АНУ болон Европын Холбооны шаардлагуудын аль алинтай нь нийцсэн байх шаардлага юм. 2016 оны ОУИТБС-ын тайланд төслийн түвшин дэх тайлагнал ороогүй бөгөөд дээр дурьдсаны дагуу төслийн түвшинд тайлагнаагүй байдал нь ОУИТБС-ын стандартыг мөрдөөгүйд тооцогдохгүй болно. Уг асуудлыг Эхлэлийн семинарын үеэр хэлэлцсэн гэдгийг дурьдах нь зүйтэй.

Засгийн Газрын байгууллагууд болон компаниуд нь орлогын урсгалыг төслийн түвшинд хуваарилдаггүй нь ажиглагдсан бөгөөд энэ нь төслийн түвшний тайлагналыг хэрэгжүүлэхэд томоохон сорилт, бэрхшээлийг бий болгож байна.

ОУИТБС-ын стандартын дагуу ОТАХ нь мэдээллийг хэвлэн нийтлэхэд зохих мэдээллийн задаргааны түвшинд санал нэгдэх шаардлагатай байдаг.

Зөвлөмж

Одоогийн тайлан нь ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангаж байгаа хэдий ч, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд хэрэв боломжтой гэж үзвэл төслийн түвшинд орлогын гол урсгалыг хэрхэн задлах талаар ирэх жилийн эхлэлийн семинарын үеэр авч үзэхийг зөвлөж байна.

6.2.9 Тусгай зөвшөөрөл олгох, баримтжуулахтай холбогдох журмыг дагаж мөрдөх

ОТАХ-тэй тохиролцсоны дагуу тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх явц хууль тогтоомж, дүрэм журамтай нийцсэн эсэхийг бид эрсдэлд суурилсан аргачлалаар шалгасан. 2016 онд олгосон, шилжүүлсэн лицензүүдийн хувьд холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөх, бичиг баримтуудыг хадгалах тал дээр зарим зөрчил дутагдлууд илэрсэн. Түүвэрчилсэн шалгалтын явцад илэрсэн дутагдлуудын ихэнх нь бүрдүүлсэн баримт бичгүүд шаардлагад бүрэн нийцэж байгаа эсэхэд Засгийн Газрын агентлагууд хангалттай хяналт тавьдаггүй, эсвэл тэдгээр баримт бичгүүдийг зохистой хадгалдаггүй байгаагаас үүдэлтэй байна. Жишээ нь, өргөдөл гаргахтай холбоотой мэдээлэл, хувийн хэргийн мэдээллүүд болон холбогдох байгууллагуудад хүргүүлэх мэдэгдэл гэх мэт бичиг баримтууд мэдээллийн бүртгэлд байхгүй байсан. Баримт бичиг байхгүй байсан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, эсвэл мэдээллийн сангийн бүртгэлийг сайн хийгээгүйн чухам алинаас шалтгаалсан нь тодорхойгүй байна.

Зөвлөмж

Үндэсний Зөвлөл нь уг асуудлыг холбогдох Засгийн Газрын агентлагуудад тавьж, хэрхэн холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх болон баримт бичгүүдийг хэрхэн зөв зохистой бүрдүүлж, хадгалах тал дээр шаардлага тавьж ажиллах нь зүйтэй.

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөх, уг хууль тогтоомжоор шаардсан дэмжих баримтуудыг бүрдүүлж, хадгалах нээлттэй, ил тод орчинг бүрдүүлэх, аливаа баримтжуулалт дутуу тохиолдолд зохих тайлбарыг авах, хууль тогтоомж мөрдөөгүй үед хориг арга хэмжээ авах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

6.3 ОТАХ-ээс өгөх зөвлөмжүүд

Доор дурьдсан зөвлөмжүүдийн хураангуй нь ОТАХ-ийн хүсэлтээр хараат бус хянан-нэгтгэгчийн тайланд орсон болно. Эдгээр зөвлөмжүүд нь хараат бус хянан-нэгтгэгчийн санаачилсан зөвлөмжүүд биш тул уг тайланд хураангуй хэлбэрээр танилцуулсан ба дэлгэрэнгүй мэдээллийг ОТАХ-ээс авах боломжтой юм.

6.3.1 Мэдээлэл ирүүлээгүй компаниуд болон ТӨААН-үүд

ОТАХ нь МОУИТБС-ын шаардсан анхны тайланг ирүүлээгүй, цаашлаад Хараат бус хянан-нэгтгэгчийн шаардсан мэдээллийг танилцуулаагүй эсвэл аудитлагдсан тайлангаа ил тод болгоогүй компаниудад авах хариуцлагын арга хэмжээг тодорхой болгох нь зүйтэй гэж үзсэн ба ингэснээр мэдээллийн ил тод байдлыг сайжруулах болон ОУИТБС-ын шаардлагуудтай нийцүүлэх үйл явцыг дэмжих юм. Стандарт мөрдөхийг дэмжсэн хатуу арга хэмжээ авах, түүний биелэлтэнд хяналт тавих ажлыг сайжруулах шаардлагатай.

6.3.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилт

Гар аргаар уул уурхайн олборлолт хийх үйл ажиллагааг албажуулах зорилготой Засгийн Газрын 151 дүгээр тогтоолоор (хуучнаар 2010 оны ЗГ-ын 308 дугаар тогтоол) батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг сайжруулах нь зүйтэй.

6.3.3 Гэрээний ил тод байдал

Гэрээний ил тод байдлын талаархи ОУИТБС-ын стандартуудын хэрэгжилтийг сайжруулах, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй. Энэхүү зөвлөмж нь БХГ болон Монгол Улсын Олборлох Үйлдвэрлэлийн салбарууд дахь гэрээнүүдийн ил тод байдлын цар хүрээний талаарх тодорхой бус эрх зүйн орчноос үүдэлтэй болно.

7 Хавсралтууд

Хавсралтын жагсаалт	
Хавсралт 1	Компаниудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц
Хавсралт 2	Төрийн байгууллагуудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц
Хавсралт 3	Гол орлогын урсгал
Хавсралт 4	Компаниудын ирүүлсэн мэдээлэл
Хавсралт 5	ЗГ-ын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл
Хавсралт 6	Шийдвэрлээгүй зөрүү (компаниудаар)
Хавсралт 7	Анхны нэгтгэл, залруулга болон залруулгын дараах нэгтгэл (Компаниудаар)
Хавсралт 8	МОҮИТБС-ын 2016 оны тайланд хамрагдсан компаниудын мэдээлэл
Хавсралт 9	Нэгтгэлийн дараах төрийн байгууллагуудын мэдээлсэн хандив, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл
Хавсралт 10	Нэгтгэлийн дараах компаниудын тайлагнасан улсын хэмжээний гол орлогын урсгалууд
Хавсралт 11	Нэгтгэлийн дараах компаниудын тайлагнасан орон нутгийн хэмжээний гол орлогын урсгалууд
Хавсралт 12	Компаниудын аудитын дүгнэлтийн мэдээлэл
Хавсралт 13	Олборлох үйлдвэрлэлийн ажил эрхлэлт
Хавсралт 14	Компаниудын ашигт малтмалын борлуулалт болон олборлолт
Хавсралт 15.а	Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг 2016 онд олгосон хайгуулын зарим тусгай зөвшөөрлүүдэд шалгасан байдал
Хавсралт 15.б	Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг 2016 онд олгосон олборлолтын зарим тусгай зөвшөөрлүүдэд шалгасан байдал
Хавсралт 15.в	Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг 2016 онд шилжүүлсэн зарим тусгай зөвшөөрлүүдэд шалгасан байдал
Хавсралт 16.а	Хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрлийн жагсаалт (2016.12.31-ний байдлаар)
Хавсралт 16.б	Хүчин төгөлдөр ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалт (2016.12.31-ний байдлаар)
Хавсралт 17.а	2016 онд олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүд
Хавсралт 17.б	2016 онд олгосон олборлолтын тусгай зөвшөөрлүүд
Хавсралт 18.а	2016 онд сонгон шалгаруулалтын журмаар олгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл
Хавсралт 18.б	Сонгон шалгаруулалтад шалгараагүй компаниудын мэдээлэл (ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд)
Хавсралт 18.в	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд
Хавсралт 19	2016 онд шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд
Хавсралт 20	Тусгай зөвшөөрлүүдийн өргөдөл гаргасан огноо
Хавсралт 21.а	Хүчин төгөлдөр БХГ-нүүдийн жагсаалт (2016.12.31-ний байдлаар)
Хавсралт 21.б	Хүчин төгөлдөр БХГ-нүүдийн солбицлын цэгүүд
Хавсралт 21.в	Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг 2016 онд хийсэн БХГ дээр шалгасан байдал
Хавсралт 21.г	Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдол байсан эсэхийг 2016 онд шилжүүлсэн БХГ дээр шалгасан байдал
Хавсралт 22.а	Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлийн жагсаалт (2016.12.31-ний байдлаар)
Хавсралт 22.б	Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлүүдийн солбицлын цэгүүд
Хавсралт 23.а	Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт (аймгуудын мэдээлснээр)
Хавсралт 23.б	Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт (www.tusuv-oronnutag.mof.gov.mn -аас авсан мэдээлэл)
Хавсралт 24.а	Төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэл (ТӨААН-үүд)
Хавсралт 24.б	Төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэл (компаниуд)
Хавсралт 25.а	Бенефициар өмчлөгчийн мэдээлэл
Хавсралт 25.б	Бенефициар өмчлөгчийн Замын зураг

Хавсралтын жагсаалт	
Хавсралт 26.а	Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээ (аймгуудаас ирсэн мэдээлэл)
Хавсралт 26.б	Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээ (компаниудаас ирсэн мэдээлэл)
Хавсралт 27	Заавал тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт
Хавсралт 28	Сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалт
Хавсралт 29	Нөхөн сэргээлтийн мэдээлэл
Хавсралт 30	Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл
Хавсралт 31.а	Нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй компаниуд
Хавсралт 31.б	Нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй компаниудын 2016 онд хийсэн нөхөн сэргээлтийн ажлууд
Хавсралт 32	Нэгтгэлд хамрагдсан компаниудын санхүүгийн тайлангийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эх сурвалжууд
Хавсралт 33	Ном зүй ба эх сурвалж